



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
НИЙГМИЙН УХААНЫ ФАКУЛЬТЕТ

ПОЛИТОЛОГИ



2002

1



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

НИЙГМИЙН УХААНЫ ФАКУЛЬТЕТ

Эрдэм шинжилгээний бичиг

№ 189 (15)

ПОЛИТОЛОГИ

Улаанбаатар

2002

Өмнөх үг

АГУУЛГА

МУИС-ийн НУФ-ын Улс төр судлалын салбараас эрхэлж уг сэтгүүлийн анхны дугаарыг та бүхэнд толилуулж байна.

Цаашид бид монгол орны хувьд харьцангуй шинэ тутам мөртөө эрчимтэй хөгжүүлэх шаардлагатай улс төрийн шинжлэх ухааны бие даасан сэтгүүлийг үргэлжлүүлж тогтмол гаргаж байх зорилготой юм. Эл сэтгүүлд нийгмийн улс төрийн амьдралын олон талт асуудлуудыг онол, практикийн амьд холбоонд нь авч үзэж, улмаар тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар асуудал дэвшүүлэн тавьсан өгүүлэл, материалыг хэвлэж байх болно.

Таны судалгааны үр дүн, бүтээлийг өргөн олон уншигчдад хүргэхэд манай сэтгүүл нээлттэй байх болно. Сэтгүүлийн талаар санал хүсэлтээ МУИС-ийн улс төр судлалын тэнхимд ирүүлнэ үү.

Сэтгүүлийн зөвлөл

Эрхлэгч: Ш.Содном

Гишүүд: Д.Содномгомбо

А.Юндэндорж

Ё.Довчин

А.Жамбал

Хаяг: МУИС-ийн НУФ

Улс төр судлалын тэнхим

Утас: 312659, 328890

Факс: 976-11-328890

E-mail: foss@num.edu.mn

А.Юндэндорж.

Улс төрийн шинжлэх ухааны төлөвшлийн чиг хандлага

3

Ё.Довчин.

Т.Гобсс: төр, иргэний харилцаа

10

С.Базарпүрэв.

Дэвид Истоны улс төрийн системийн онол

16

И.Лхам.

Нээлттэй нийгмийн үзэл санааг үндэслэгч

18

Ш.Содном.

Посткоммунист шилжилт: үзэл баримтлал ба үйл явц

24

Д.Ганбат.

Ардчиллах үйл явцын судалгааны арга зүйд

30

С.Данаажав.

Нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтэд мэдээллийн хэрэгслийн үүрэг

41

Ч.Өлзийсайхан.

Шинэ элитийн төлөвшлийн асуудалд

46

Ч.Ядамсүрэн.

Монголд нийгмийн иргэнлиг харилцааг хөгжүүлэх нь

49

Ц.Мөнхцэцэг.

Улс төрийн манипуляци

52

Н.Лүндэндорж.

Үндсэн хуульт төр ёсны хөгжил

58

Ж.Төртогтох.

Монголын үндсэн хуульт ёс: уламжлал, орчин үе

64

Д.Содномгомбо.

Монголын уламжлалт төр ёс, түүний шинэчлэлийн зарим асуудал

72

Д.Болд-эрдэнэ.

Төрийн засаглалын тогтолцоон дахь ерөнхийлөгчийн институт

82

А. Жамбал.

Ислам шашин ба хүчирхийллийн тухайд

90

Д.Цолмон, А.Амарсанаа.

Олон улсын харилцааны онол, орчин үе

102

Лха А.Юндэндорж

Доктор, профессор

Улс төрийн шинжлэх ухааны төлөвшлийн чиг хандлага

Улс төрийн шинжлэх ухааны төлөвшлийн үйл явц өөрийн гэсэн өвөрмөц онцлог шинжийг агуулдаг хэдий ч ерөнхий зүй тогтлыг нь нийгмийн бусад шинжлэх ухаанаас салангид авч үзэхийн аргагүй. Америкийн судлаач К.Дойчийн тэмдэглэсэнчлэн нийгмийн ямар ч ухаан, тэр тусмаа улс төрийн шинжлэх ухаан үүсэл хөгжлийнхөө гурван үе шат болох философийн үе, эмпирик үе, рефлексийн буюу эмпирик байдлыг хянан засварлах үе шатыг дамждаг гэж үздэг. К.Дойчийн загварын талаар ОХУ-ын профессор В.П.Пугачев болон МУИС-ийн профессор Ш.Содном нар нилээд дэлгэрүүлж судалсан байгаа.

Дээрх эрдэмтдийн санал дүгнэлттэй ойролцоо загварыг тухайн үедээ францын социологч М.Дюверже дэвшүүлж байсан талаар судалгааны материалуудад тэмдэглэсэн байх юм. Тэрбээр нийгмийн шинжлэх ухааны үүсэл, өсөлт, хөгжлийн үйл явцыг мөн гурван үе шатаар ангилж үзжээ. Эхний үе нь эртний үеэс XVIII зууны эцэс хүртэл, хоёр дахь үе нь XIX зууныг бүхэлд нь, гуравдахь нь орчин үе буюу XX зууны эхээс өнөөг хүртэлх хугацааг хамарсан байна.

Эрт үеийн улс төрийн сургаалийг өнөөгийн улс төрийн шинжлэх ухаантай шууд утгаар нь адилтган авч үзэж болохгүй ч түүний залгамж чанар болон тэдгээрийн хоорондын генетик холбоог үгүйсгэх аргагүй билээ. Эртний Грек, Ромын болон Хятадын агуу их сэтгэгч Гераклит, Демокрит, Платон, Аристотель, Күнз нарын улс төр, эрх зүйн сургаалиуд нь "Улс төрийн бодлого", "Төр", "Хуулиуд", "Бүгд найрамдах улс" зэрэг бүтээлүүд болон тэдний үлдээсэн гар тэмдэглэл, лекц, захидал, сургамж, захиасуудад тэмдэглэгджээ.

Улс төрийн шинжлэх ухааны цаашдын төлөвшилд чухал үүрэг гүйцэтгэсэн үе нь шашин сүм хийдийн суртал нөлөөнөөс улс төрийн бодлого болон улс

төрийн сэтгэлгээ бүхэлдээ ангижирсан явдал юм. Энэ үйл хэрэгт Джон Мильтоны "Үг хэлэх эрх чөлөөний тухай", Томас Гобссын "Левиафан", Джон Локкын "Төрийн засаглалын талаархи хоёр санал", Ш.Л.Монтескьегийн "Хуулиудын үзэл санааны тухай", Ж.Ж.Руссогийн "Нийгмийн зөвшилцлийн тухай", А.Фергюсоны "Иргэний нийгэм", Т.Пейны "Эрүүл санаа бодол" болон А.Гамильтон, Дж.Медисон, Дж.Джей нарын бүтээлүүд чухал хувь нэмрээ оруулжээ.

Соён гэгээрүүлэлтийн үе болон францын хувьсгал, Америкийн тусгаар тогтнолын төлөөх тэмцлийн үеүдэд улс төрийн шинжлэх ухааны төлөвшилд дорвитой түлхэц өгсөн онолын үндсүүд боловсруулагджээ. Үндсэн хуульт тогтолцооны талаархи үзэл санаа, бүгд найрамдах болон либерал ардчилсан засаглалын талаарх онол номлол дээрх үед боловсрогдож, тэдгээр зарчимд тулгуурлан төр, улс төрийн институтуудыг төлөвшүүлж бэхжүүлэх алхам хийгдсэн. Ийм хандлага Англи, Америк, Францын уламжлалт улс төрийн сургуулиуд болох О.Контын позитивизм, А.К.Сен-Семоны социализм, Ж.де Местр, Л.де Бональд нарын консерватизмд түлхүү илэрч байжээ.

Хүн төрөлхтний түүхийн шинэхэн үед хамрагддаг XVIII зууны хоёрдугаар хагасаас XIX зууны эхийг хүртлэх хугацаанд улс төрийн шинжлэх ухааны хөгжил шинэ эрч хүчийг авчээ. Улс төрийн онол, эрин үеийн үзэл баримтлалын тулгуур зарчмууд боловсрогдох эхлэл чухамхүү энэ үед тавигдсан гэж үздэг. Гариг ертөнц дээр өрнөж буй улс төрийн үйл явдлуудыг мэргэжлийн нүдээр харж үнэлэлт дүгнэлт өгөх үүднээс улс төрийн шинжлэх ухааныг бие даасан шинжлэх ухааны хэмжээнд тавин хөгжүүлэх шаардлага, хэрэгцээ байгааг чухамхүү энэ үеэс эхлэн хаана хаанаа хүлээн зөвшөөрөх болжээ. Улс төрийн шинжлэх ухааны ойлголтын аппарат төлөвшиж, арга зүйн үндсэн зарчим, системчлэлийн арга зүй боловсрогдож, нийгэм хүмүүнлэгийн шинжлэх ухааны олон салбар чиглэлүүдэд энэ нь анзаарагдаж эхэлсэн.

Реке Декартын рационализм, Томас Гоббсын рационализм ба абсолютизмын нэгдмэл байдлаар илэрч болох тухай ойлголт, Дэвид Юмын улс төрийн конфликтыг зөөлрүүлж зохицуулах арга механизмын тухай онол арга зүйн үндэслэлүүд дээрхид эерэгээр нөлөөлсөн гэж үздэг.

XIX зуунд улс төрийн шинжлэх ухааны хөгжилд гарсан ахиц өөрчлөлтийг тусгайлан дурьдахгүй байхын аргагүй. Түүхэн үйл явдлаар арвин баялаг энэ зуунд төр эрхийн онол, хууль зүйн шинжлэх ухаанд зарчмын эргэлт гарах эхлэл мөн тавигдсан байна. Үүнтэй уялдан төр эрхийг захиргааны эрхээс зааглах, эрүүгийн эрхийг иргэний хэргээс тусгайлан авч үзэх болсон байна. Эрхийн олон школууд (түүхэн, позитивист, реалист г.м) шинээр гарч ирсэн. Хууль зүйн формализмыг эргэж харах шаардлага гарсны дээр төр, эрхийн чиглэлийн олон асуудлуудыг улс төр, социологийн утга санааны үүднээс тайлбарлах болов.

Улс төр, эрх зүйн судлалд улс төрийн төлөөллийн онол, хууль зүйн позитивизм, социологийн юриспруденц, эрх зүйт төрийн онол, харьцуулсан эрх зүй зэрэг чиглэлүүд шинээр гарч ирсэн. Эдгээрт судлаач Р.Еринг, С.А.Муромцев, Э.Дюркгейм, М.Вебер, И.Бентам, А.де Токвиль нарын дэвшүүлсэн онол арга зүйн үндэслэлүүд тодорхой үүрэг гүйцэтгэсэн байна.

XIX зууны эцэс XX зууны эхэн гэхэд улс төрийн шинжлэх ухаан социал болон хүмүүнлэгийн шинжлэх ухаанаас тусгаарлагдан бие дааж хөгжих эхлэл бодитой тавигдсан гэж үздэг. Энд Европ, өрнөдийн эрдэмтэд сэтгэгчдийн онолын үндэслэл, судалгааны урсгал, чиглэлүүд тодорхой үүрэг гүйцэтгэжээ. Юуны урьд Германы эрдэмтэд И.Кантын "эрх зүйн сургууль" болон Г.В.Гегелийн "эрхийн философ"-ийг энд дурьдаж болох байна.

Францын судлаач П.Фаврын үзсэнээр улс төрийн шинжлэх ухааны төлөвшилд дорвитой түлхэлт өгсөн хоёр чухал үйл явдал хагас зууны дотор шинжлэх ухаанд анзаарагджээ. Энэ нь 1871 онд Э.Бутли "Улс төрийн шинжлэх ухааны «чөлөөт» сургууль"—иа байгуулсан болон 1913 онд А.Зигфридийн "III республикийн үе дэх баруун францын улс төрийн зураглал" хэмээх бүтээл хэвлэгдэн гарч нийтийн хүртээл болсон явдал юм. Түүхэн энэ хоёр үеийн хооронд улс төрийн шинжлэх ухааны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн олон бүтээл хэвлэгджээ. Тухайлбал: П.Жане "Улс төрийн шинжлэх ухааны түүх болон ёс суртахуунтай түүний холбогдох нь" (1851 он); Э.де Парье "Улс төрийн шинжлэх ухааны зарчмууд" (1870 он); Э.Шеврьер "Улс төрийн шинжлэх ухааны элементүүд" (1871 он); Э.Акола "Улс төрийн шинжлэх ухааны философи" (1877 он) болон улс төрийн шинжлэх ухаанд сонгодог бүтээлүүд гэж алдаршсан А.Эрсаны "Төрийн «үзэл санаа»" (1896 он) болон А.Мишлегийн "Ардчилсан улс төрийн номлол" (1901 он) зэрэг бүтээлүүд ордог.

Англид XIX зууны төгсгөлөөс Лондоны их сургуулийн дэргэд "Эдийн засаг, улс төр судлалын сургууль" байгуулагдсан үеэс улс төрийн шинжлэх ухаан бие даасан чиглэл болж төлөвших эхлэл тавигдсан гэж үздэг судлаачид цөөнгүй байдаг. Лондоны их сургуулийн дараагаар Оксфорд, Кембриж, Манчестер, Ливерпулийн их сургуулиудад улс төрийн үйл явдлуудын талаар тусгайлан үзэх болж, Э.Баркер, Д.Коул, Г.Ласки, Ч.Мэннинг, У.Робсон, Г.Файнер зэрэг эрдэмтэд сургалтыг нь удирдан явуулж байжээ.

Америкт Ф.Либерийг улс төрийн бодлогод хийх системчилсэн судалгааны үндсийг тавигч гэж бас үздэг. Тэрээр 1857 онд Колумбын коллежийн (хожим нь их сургууль болсон) профессороор томилогдон "улс төрийн философи" гэсэн лекц уншиж эхэлсэн бөгөөд түүндээ төр эрхийн онол болон "улс төрийн ёс зүй"-н асуудлыг голлох байранд тавьж байжээ. Д.Бержесийн "Улс төрийн шинжлэх ухаан болон Үндсэн хуулийн харьцуулсан эрх зүй" (1890 он) бүтээлийг улс төрийн шинжлэх ухааны төлөвшилд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж Америкчууд бас үздэг. Улс төрийн шинжлэх ухаанаар

дагнасан мэргэжилтэн бэлтгэх, нэгэн сэдэвт зохиол бичиж эрдмийн зэрэг хамгаалах систем анхлан энд төлөвшсөн.

Америкт 1903 онд улс төрийн шинжлэх ухааны холбоо байгуулагдсан. Энэ үеэс эхлэн "Америкийн улс төр, социал шинжлэх ухааны академийн мэдээ" (1903 он), Америкийн улс төрийн шинжлэх ухааны тойм" (1906 он); "Улс төрийн шинжилгээ" (1939 оноос хойш тасралтгүй гарч байгаа) зэрэг эрдэм шинжилгээний сэтгүүлүүд нийтлэгдэх болов.

Орос оронд хамжлагат ёсыг халсан болон нийгмийн амьдралын бусад хүрээнд хийгдсэн реформууд, шүүх тогтолцоо, арми, нутгийн захиргааны реформ зэрэг нь эрх зүйт төр, иргэнлиг нийгмийн тогтолцоог бүрдүүлэх анхны эх суурийг тавьсан гэж үздэг. Энэ үед К.Д.Кавелины "Орос оронд тариачдыг чөлөөлөх тухай дурсамж" (XIX зууны дунд үе); Б.Н.Чичерины "Хамжлагын нөхцөл байдлын тухай" өгүүллэг болон "Улс төрийн сургаалын түүх" (5 ботиор 1877 оны үед), "Эрхийн философийн талаарх дурсамжууд" (1901 он), "Ардын төлөөллийн тухай" зэрэг бүтээлүүд нийтлэгдсэн нь олны улс төрийн ухамсар сэргэхэд хүчтэй нөлөөлсөн. Тэрчлэн И.В.Михайловский, Л.И.Петражицкий, П.И.Новгородцев, И.А.Ильин, Б.П.Вышеславцев, К.Н.Алексеев, С.Л.Франк, С.И.Гессен, М.М.Ковалевский болон эрхийн философийн чиглэлд Е.Н.Трубецкий, Н.А.Бердяев, В.С.Соловьев нарын бүтээлүүд нийтлэгдсэн нь улс төрийн шинжлэх ухааны хөгжилд эерэг нөлөө үзүүлжээ.

Улс төрийн шинжлэх ухаан гэдэг ойлголт маань өөрөө өргөн утга агуулгыг илэрхийлдэг бөгөөд заримдаа тодорхой бус утгыг илэрхийлдэг ч тал бий. Түүний хүрээнд улс төрийн философи, эрх зүй, улс төрийн түүх, төр эрхийн болон улс төрийн институтын шинжилгээ, түүгээр ч зогсохгүй улс төрийн эдийн засгийг хамруулж үздэг. Үүнтэй холбогдуулан зарим нэгэн сонирхолтой баримтыг хэлбэл, 1903 оны 6 дугаар сард францын философийн нийгэмлэгт нэрт сэтгэл зүйч Г.Тард нэгэн сонирхолтой илтгэл тавьжээ. Түүндээ шинжлэх ухааны ангиллын талаарх О.Конт, А.-А.Курно нарын байр сууринд харьцуулсан шинжилгээ хийхийг оролджээ. Г.Тардын үзсэнээр О.Конт гаван үндсэн суурь шинжлэх ухаан байна гээд, тэдгээрийн дэс дарааллыг тогтоохдоо: 1) математик; 2) физик-хими; 3) асторонсми; 4) биологи; 5) социологи гэжээ. Гэвч А.-А.Курно: 1) математик; 2) физикийн шинжлэх ухаанууд; 3) биологийн шинжлэх ухаанууд; 4) сэтгэлгээний тухай шинжлэх ухаанууд; 5) улс төрийн шинжлэх ухаанууд гэсэн байгаа юм. Энэ бол улс төрийн шинжлэх ухааныг бусад шинжлэх ухаантай адил түвшинд авч үзсэн бас нэг жишээ билээ.

Нэрт философич, социологич О.Конт, Г.Спенсер, Л.Уорд болон улс төрийн философич М.Вебер, Э.Дюркгейм, В.Парето нар төр, улс төрийн институтыг шинжлэн судлах явцдаа хийсэн дүгнэлтэндээ улс төрийн шинжлэх ухааныг философи, юриспруденц, улс төрийн эдийн засаг мэтийн классик шинжлэх ухаануудын "охин" шинжлэх ухаан гэж үзсэн байна. Үнэхээр ч улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн нам, парламентат ёс, засаглал хуваарилалт, сонгуулийн систем зэргийг түлхүү авч үзэж байгаа нь бусад шинжлэх ухаануудаас ялгарах гол онцлог шинж бөгөөд чухамхүү үүгээрээ ч социологи, улс төрийн эдийн засаг, түүх, юриспруденц зэрэг шинжлэх ухаанаас ангид байхыг шаардаж байгаа юм.

М.Вебер үзэхдээ: "улс төрийн үйл явдлууд бол өөрийн түүх, өөрийн гэсэн өвөрмөц хөгжлийн логик бүхий бодит үзэгдэл" гэжээ. Улс төрийн бодлого бол үйлдвэрлэлийн харилцаа, хөдөлмөрийн хувиарт нөлөөлөөд зогсохгүй, засаглалын бүтцүүдэд адил хэмжээгээр нөлөөлдөг гэсэн санааг тэр мөн анхлан гаргаж тавьсан. Бюрократын онол, ардчилсан тогтолцооны үндсэн парадигмыг ч М.Вебер анхлан томъёолжээ. К.Маркс, М.Вебер нарын дараагаар гарч ирсэн В.Вильсон, Ж.Брайс, В.Парето, Р.Михельс, Г.Моска зэрэг улс төрийн сэтгэлгээний алтан үеийнхэн улс төрийн үйл ажиллагаа өөрийн гэсэн хөгжлийн онолоор тодорхойлогдоно гэдгийг нэгэнт хэлцгээжээ.

Г.Москагийн "Засаглалын онол ба парламентын засаглал" (1884 он), "Улс төрийн шинжлэх ухааны үндсүүд" (2 дэвтрээр: нэгдүгээрх нь 1896 онд, хоёрдугаарх нь 1923

онд нийтлэгдсэн) бүтээлүүд, түүний шавь В.Паретогийн идэвхитэй залгамжилсан байр суурь болон Р.Михельсийн "элитийн циркуляцийн онол", "олигархийн төмөр хуулиуд" зэрэг нь аль ч улс төрийн системд бодит улс төр нь янз бүрийн элит бүлэглэлүүдийн хоорондын засгийн эрхийн төлөөх өрсөлдөөн, тэмцэлдээн болон эрх мэдэл солилцоор тодорхойлогдоно гэдгийг шинжлэх ухааны үүднээс нотолсон.

Тийм ч учраас улс төрийн шинжлэх ухааны үндсэн зорилго бол элит судлал, засаглалын эрх мэдэл солигдолтын зүй тогтлын онцлогийг гаргаж тавих явдал гэж тэд үзжээ.

Цаг хугацааны хувьд дээрхи үйл явдлуудтай зэрэгцэн орчин үеийн улс төрийн социологийн шинжлэх ухааны үндэс тавигдаж эхэлсэн. Түүнд М.Веберийн бүтээлүүд болон Р.Михельсийн "улс төрийн намуудын социолог", М.Я.Острогорскийн "Ардчилал ба улс төр намууд" (1878 онд 2 дэвтрээр нийтлүүлсэн суурь судалгааны эмхтгэл), А.Бентлийн "бүлгийн онол" зайлшгүй орно. Төр, нийгмийн харилцааны хуульчлагдсан эрх зүйн цаана халхавчлагдан нөхцөлдсөн бүлгүүдийн үйл ажиллагаа нь тухайн нийгмийн улс төрийн амьдралыг бодитойгоор тодорхойлогч хүчин зүйл гэдгийг А.Бентли бүлгийн онолдоо дэвшүүлсэн бол судлаач П.Одегард, Э.Херринг, Ф.Поллак, Э.Шатшнайдер, Э.Лейзерсон нар түүний үзэл санааг амжилттай үргэлжлүүлснээр алдартай "сонирхлын бүлгийн онол"-ыг нээсэн байна.

М.Я.Острогорский, Ж.Брайс, В.Вильсон нар ардчиллын онол, засаглалын үндсэн хуульт тогтолцоо, төлөөллийн ардчилал, сонгуулийн систем, олон намын тогтоцлоо зэрэг улс төрийн шинжлэх ухааны тулгуур чиглэлүүдийг цаашид хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулжээ.

Энэ бүхний үр дүнд XIX зууны эцэс гэхэд байгал, нийгмийн шинжлэх ухааны зааг ялгааны үндсэн шалгуурууд тодорхойлогдсон байна. Улс төрийн шинжлэх ухааны хувьд Европын орнуудад эмпирик болон онолын шалгуурын синтез байдлаар хөгжсөн байхад Англисаксоны орнууд ялангуяа Америкт позитивизмын чиглэлийг барьж хөгжин байгалын "тодорхой" шинжлэх ухааны хэлбэрээр төлөвших боломжтой болжээ.

Германы хувьд улс төрийн шинжлэх ухаан улс төрийн институтын социолог гэдэг утгаараа давуутай төлөвшжээ. Судалгааны объект нь төр гэдэг утгаар нь улс төрийн шинжлэх ухааныг төрийн социолог байдлаар үзэх хандлага ч түгээмэл байдаг. Гэхдээ энд улс төрийн шинжлэх ухааны хөгжилд Германы сонгодог философийн уламжлал нөлөөлсөн тал бий байх.

Улс төрийн шинжлэх ухааны төлөвшилд Н.Макиавеллийн болон Аристотелийн гэсэн хоёр үндсэн чиглэл (школа) байсан талаар Г.Люббе, К.Байме нар асуудал анхлан дэвшүүлсэн. Н.Макиавеллийн сургуулийнхны зорилтыг Ф.Бэкон амжилттай хэрэгжүүлсэн гэх бөгөөд эл чиглэлийг баримтлагчид хамгийн идэвхитэй үйл ажиллагаатай засаглалыг төлөвшүүлэхэд судалгаа шинжилгээний ажлаа чиглүүлэн иржээ. Тэгвэл Аристотелийн сургуулийнхны гол төлөөлөгчид Т.Гоббсыг нэрлэдэг. Эл чиглэлийг баримтлагчид нийгмийн дэвшилттэй тогтолцоог төлөвшүүлэхэд үйл ажиллагаагаа зориулж иржээ. Зарчмын хувьд ялгаатай ч аль алиныг нь буруутгахын аргагүй энэ хоёр үндсэн чиглэлийн аль нэгийг барин эрдэмтэд судлаачдын олон үеийнхэн ажилласан нь ойлгомжтой.

Т.Гоббсын бас нэгэн тэмдэглэлээс харахад Ньютон, Коперник, Кеплер, Галилей нарын байгалын шинжлэлийн ололт, нээлтүүдтэй эн зэрэгцэхүйц (байгалын нууцыг танин мэдэхийн хувьд) улс төрийн шинжлэх ухааны оновчтой тодорхой (нийгмийн процессыг танин мэдэхийн хувьд) санал дүгнэлт гаргахын чухлыг цохон хэлж байжээ.

Их сэтгэгч П.Лилиенфельд 1872 онд нийтлүүлсэн "Социал шинжлэх ухааны ирээдүйн талаарх сэтгэмж" хэмээх бүтээлдээ хязгаарлалтай нийгмийн онолын загварыг боловсруулах оролдлого хийжээ. Эдийн засгийн амьдрал бол нийгмийн физиолог нь,

эрхийн институтын систем бол нийгмийн морфолог нь, засгийн газар бол нийгмийн мэдрэлийн систем нь гэсэн эрэгцүүлэн бодууштай нэн сонирхолтой санаа ч энд бий.

Германы судлаач Р.Михельс "явцуу олигархийн гарт засаглалын эрх мэдэл төвлөрөх хандлагатай" гэсэн санааг дэвшүүлж байсан бол Английн эрдэмтэн нийгмийн сэтгэл зүйч Ж.Уоллес "Үндэсний мэдрэмж, соёл болон социал бусад факторуудаар илрэх хүний төрөлх чанар болон түүний улс төрийн үйл байдлын хооронд органик холбоотой болохыг анхлан тогтоожээ. Г.Ласки, Э.Баркер, Коул нар хожим хойно нь (XX зууны 50-иад онд) улс төрийн үйл ажиллагаан дахь ухамсарлагдсан болон зорилгогүй сэдлүүдийн зааг ялгааны тухай асуудлыг хөндсөн байдаг.

Америкийн судлаач Ч.Мерризм, Г.Ласуэлл нар улс төрийн шинжилгээндээ психолог, психоанализ, эмпирик болон социологийн шинжилгээний зарим аргыг авч хэрэглэсэн нь тухайн шинжлэх ухааны хөгжилд чухал ахиц өгчээ. Ч.Мерризм удирдлагын процесст үрдүнтэй ажиглалт хийхийн тулд эдийн засаг, статистик, түүх, антрополог, газарзүй, сэтгэл зүйн судалгааны аргыг улс төрийн шинжилгээнд хэрэглэх санал дэвшүүлсэн байна. Ч.Мерризм улс төрийн шинжилгээний төлөвшил хөгжлийг 3 үе шатаар ангилж авч үзжээ. Үүнд: Нэгдүгээр үе нь 1850 оныг хүртэлх буюу-априор дедуктив үе, хоёрдугаар үе нь 1850-1900 он хүртлэх буюу түүхэн-жишилтийн үе, гуравдугаар үе нь 1900-аад оноос XX зууны 20-иод он хүртэлх үе буюу ажиглалт, хэмжилтэнд шилжих үе.

XX зууны 20-30 оныг хүртэл АНУ-д улс төрийн бодлого, үйл ажиллагааны талаар бусад шинжлэх ухааны үнэлэмж, хэмжүүрт нөлөөлөгдөхгүй "цэвэр" шинжлэх ухаан бий болгох санал дэвшигдэж байжээ. Тийм ч учраас дэлхийн II дайны төгсгөл хүртлэх хугацаанд улс төрийн шинжилгээ нийтийн засаглал, нийтийн эрх зүй, улс төрийн намууд ба шахалтын бүлэг, конгресс болон гүйцэтгэх засаг, штатын болон нутгийн удирдлага гэсэн салбаруудаар дамжин хэрэглэгдэж байсан. Гэтэл эл байр суурийг шүүмжлэгчид ч бас цөөнгүй байжээ. Тэдний нэг нь Ж.Кэтлин байв. Тэрбээр "Улс төрийн бодлогын шинжлэх ухаан ба арга зүй" (1927 он) гэсэн номондоо "цэвэр" шинжлэх ухааныг төлөвшүүлэх тухай санааг эрс шүүмжилжээ. Энэ үед Америкийн улс төрийн шинжлэх ухааны төлөвшилд сциентич хэлбэрийн позитивизм давамгайлж байсан талаар А.Соумит, Ж.Таненхауз нарын бүтээлд тэмдэглэгджээ.

Тодорхой нөхцөл байдлын улмаас 1923-1938 онуудад их дээд сургуулийн багш нарын тэн хагасаас илүү нь болон эрдэм оюуны олон шилдэг төлөөлөгчид Германыг орхин оджээ. Тэдний дотор алдарт З.Фрейд, К.Левин, Г.Маркузе, К.Мангейм, Э.Фромм, Т.Адорно нар байсан гэдэг. Иймэрхүү хувь заяаг бусад орны сэтгэгчид түүний дотор Орос орны эрдэмтэд эдэлжээ. Н.А.Бердяев, О.Н.Лосский, С.Л.Франк, П.Б.Струве, В.В.Зиновьевский, П.Сорокин нар Орос орноо орхин гарахад хүрч, бас олонхи нь ГУЛАГ-ийн лагериудад цөлөгдөж байжээ.

Дэлхийн II дайны дараах үед улс төрийн шинжлэх ухаан огцом өсч хөгжих шатандаа оржээ. Ингэснээр түүний үндсэн бүтцэд дараах чиглэлүүд шинээр хамрагдах болов.

Үүнд:

- улс төрийн системүүд
- улс төрийн үйл явдлууд (процессууд)
- улс төрийн намууд
- сонирхлын бүлэг болон улс төрийн хөдөлгөөн
- улс төрийн үйл байдал ба улс төрийн соёл
- улс төрийн процесс дахь олон түмний санаа бодол ба олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
- улс төрийн хошуучлал ба элитүүд
- корпоративизм ба неокорпоративизм
- улс төрийн үзэл суртал ба улс төрийн сургаалын түүх
- улс төрийн философи ба бусад чиглэлүүд

1948 онд Парижид ЮНЕСКО-гийн санаачлагаар улс төрийн шинжлэх ухааны тулгуур асуудлаар олон улсын бага хурлыг хуралдуулжээ. Энэ хурлаас улс төрийн шинжлэх ухааны үндсэн чиглэлүүдийг тодорхойлох оролдлого хийж 4 үндсэн блок (багц) асуудлыг дэвшүүлжээ. Үүнд:

- I. Улс төрийн онол:
 - а) улс төрийн онол ба үзэл баримтлалын түүх
- II. Улс төрийн институтууд:
 - а) Үндсэн хууль;
 - б) Төв удирдлага;
 - в) Мужийн болон орон нутгийн удирдлага;
 - г) Нийтийн засаглал;
 - д) удирдлагын эдийн засгийн болон социал функцүүд;
 - е) улс төрийн институтуудын харьцуулсан шинжилгээ;
- III. Нам, бүлэг, олон нийтийн санаа бодол:
 - а) улс төрийн намууд;
 - б) бүлэг, холбоод;
 - в) захиргаа, удирдлагад иргэдийн оролцоо;
 - г) олон нийтийн санаа бодол
- IV. Олон улсын харилцааны асуудал:
 - а) Олон улсын бодлого;
 - б) Улс төрийн бодлого ба олон улсын байгууллага;
 - в) Олон улсын эрх зүй

1949 онд ЮНЕСКО-гийн ивээл дор олон улсын политологчдын холбоо байгуулагдсан бөгөөд жил бүр болдог холбооны хурлаар зарчмын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ирсэн нь улс төрийн шинжлэх ухааныг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Үүнтэй уялдан Францад Үндэсний захиргааны сургууль, Парижийн их сургуулийн дэргэдэх улс төрийн шинжилгээний институт, улс төрийн шинжлэх ухааны үндэсний фонд, францын улс төрийн шинжлэх ухааны холбоо зэрэг мэргэжлийн байгууллагууд бий болж М.Дюверже, Б.де Жувенел, Ж.Бюрдо, Ж.Ведел, М.Прело, П.Фавр нарын шилдэг эрдэмтэд улс төрийн шинжлэх ухааны тодорхой чиглэлүүд болох конституционализм, төр ба засаглал, улс төрийн систем ба дэглэм, нам, намын системээр түлхүү мэргэжин судалгаа явуулж эхлэв.

Англид улс төрийн шинжлэх ухаан түүх-философийн чиглэлийг даган хөгжсөн. 1950 онд Г.Лоска, Д.Брюген, Ч.Уильсон, М.Оукшат болон бусад нөхдийн санаачлагаар Нэгдсэн гүрний улс төрийн шинжилгээний нийгэмлэг (АПИСК) байгуулагдаж, "Улс төрийн шинжилгээ" (одоо ч нийтлэгдэж байгаа), "Британы улс төрийн сэтгүүл", "Засгийн газар ба сөрөг хүчин", "Улирал тутмын улс төрийн сэтгүүл" зэрэг тогтмол хэвлэлүүд байнга гарч эхэлжээ.

Америкт: улс төрийн шинжлэх ухааны уламжлалт чиглэлүүд амжилттай хөгжсөний дээр бусад олон салбар чиглэлүүд шинээр төлөвшиж, судалгааны аргууд нь нэмэгдэж олширсон. Тухайлбал: Д.Трумэн, Д.Истон, Р.Тейлор нарын "Улс төрийн хүчнүүдийн тэнцвэржилтийн онол", Р.Даль, Ж.Сартор нарын "Ардчиллын онол", Г.Ласуэлл, Р.Миллс нарын "Элит ба элитизмын онол", Ж.Кэтлин, Ч.Мерризм, Г.Моргентау нарын "Засаглалын үзэл, хяналт, нөлөөний тухай концепци", Д.Истон, К.Фридрих, К.Дойч, Г.Шилс, Р.Арон "Орчин үеийн улс төрийн системийн шинжилгээний асуудал", М.Дюверже, У.Берихэм, Ж.Сандквист, К.Байм нарын "Намын системийн онол" Т.Парсонс, Ч.Бернард, Р.Мертон нарын "Улс төрийн ертөнцөд хийх бүтэц-үүргийн шинжилгээ", С.Липсет, Л.Коузер нарын "Улс төрийн бодлого дахь зөрчил, зөвшилцлийн үзэл баримтлал" дэвшигдэн гарсан нь улс төрийн шинжлэх ухаан орчин үеийн төрхөө олоход чухал үүрэг гүйцэтгэжээ.

Өнөө үед улс төрийн шинжлэх ухааны хүрээнд улс төрийн социологи, харьцуулсан улс төр судлал зэрэг нь бие даасан чиглэлүүд болж хөгжиж байна. Постсоциалист орнуудад XX зууны 90-ээд оноос эхлэн улс төрийн шинжлэх ухааныг сонгодог утгаар нь судалж эзэмших боломж нээгдэв. Улс төрийн шинжлэх ухааны үндсэн аспектиудыг үзэхийн зэрэгцээ судалгаа шинжилгээний ажлыг өндөр түвшинд хийх боломжтой болоод байна. Энэ нь манай орон ардчилалд хөл тавьсан богино хугацаанд олсон үндсэн ахиц ололтын нэг билээ.

Ё.Довчин
Доктор (PhD)

Т.Гоббс : төр, иргэний харилцаа

Томас Гоббсын улстөрийн гүн ухааны өв санг харилцан адилгүй үнэлэх нь бий. Зарим судлаачид түүнийг "Левиафан" зохиолоороо орчин үеийн тоталитаризмын үүдийг нээсэн гэж байхад нөгөө хэсэг нь засаглалын уг чанарыг хүн, хүний мэдрэмжтэй холбон тавьсанаараа либерализм, ардчиллын суурийн чулууг тавилцсан хэмээн үздэг байна. Гэсэн хэдий ч ямарч атугай хүн, засаглалын хоорондын харилцаа, түүний механизмын тухай Гоббсын гүн ухааны сэтгэмж эргэцүүлэл нь улс төрийн түгээмэл нөхцөл байдлыг гүнзгий шинжлэн судалсны үр дүн байсан нь эргэлзээгүй.

Иймд Гоббсын үзэл сургаал ямагт үе үеийнхний анхаарлыг татсаар ирсэн бөгөөд нэн ялангуяа шилжилтийн үеийг туулж байгаа аливаа улс орны хувьд бүр ч ач холбогдолтойг эрдэмтэд цохон тэмдэглэжээ.

Гоббс төр угаас бурхан тэнгэрээс бус, харин хүнээс эхтэй, хүний бүтээл хэмээгээд түүний үүссэн шалтгаан, арга замыг жам ёсны эрх, нийгмийн гэрээний онолдоо гаргаж тавьсан юм.

Төр зайлшгүйг жам ёсны эрх, тухайлбал, хүмүүс төрөлхөөс бүгд тэгш эрхтэй, хязгааргүй эрх чөлөөтэй гэдгээс ургуулан тайлбарласан нь тодорхой билээ. Хүний угийн өөрийгөө хамгаалах зөнд нь зохицуулж байгаль түүнд хүссэн бүхнээ хийх эрхийг харамгүй хайрласан ажээ. Төр үүсэхээс өмнөх тэр цагт хүн бүхэн хэмжээгүй эрх чөлөө, төгс тэгш эрхтэй, нэг үгээр, чи эрхтэй бол би бас эрхтэй гэсэн зарчим ноёрхож байсан болохоор ямар нэг засаглалын талаар ярих үндэсгүй нь илэрхий. Хязгааргүй эрх чөлөө, тэгш эрхээ хүмүүс ханатлаа эдэлж байсан ч мөн л тэр хэмжээгээр айн чичирч байсан нь бас тэр цагийн онцлог байжээ. Иймд тэрхүү эрх чөлөө нь аврал, ашиг тус авч ирэхээсээ аюулт тулалдаан тэмцэлдээнд хүргэдэг нь гэм биш зан болжээ. Эл байдлыг Гоббс "Нийгэмд нэгдэхээс өмнөх үеийн хүмүүсийн жам ёсны байдал нь дайн, дайн дажиндаа бүр бүгдийн эсрэг бүхний дайн байлаа" гэж тодорхойлсон нь зүйн хэрэг.¹

Дэг журам, эмх замбараагүйн хөлд автсан газар орон бол хүн бүхэн "ганцаардмал, ядуу даржин, хүйтэн зэвүүн, зэрлэг бүдүүлэг" амьдралаар амь зогоосон айдас хүйдсийн ертөнц байжээ. Эл учир олзлон булаалдах дайн байлдааны үргэлжийн айдас түгшүүр, сайн сайхныг эрмэлздэг хүн бүрийн уг чанар ийм байдлаас гарах гарц, энх амгаланг хүсэн эрэлхийлэхэд хүргэсэн байна.

Гэвч хүмүүсийг нэгдэж нийлэхэд хүргэдэг айдас хүйдэс дан ганц аймшиг биш, аюулаас дайжих төдий бус бас болзошгүй муу явдлыг урьдчилан харах, болгоомжлох, сэрэмжлэх талыг давхар агуулж байдаг гэдгийг Гоббс онцлосныг анхаарахгүй байж болохгүй.²

Гоббсынхоор дайн дажины хүнд хэцүү байдлаас гарах гарц нь "Бүхнийг хийх бүгдийн эрх хадгалагдах ёсгүй, зарим эрхээ бусдад шилжүүлэн өгөх, эсвэл тэдгээрээс татгалзах хэрэгтэй болно".³ Эрхээсээ татгалзах, бусдад шилжүүлэх нь харилцан итгэлцэл, хэлэлцээр тохиролцоход суурилсан байх учиртай. Гэрээ нь жам ёсны байдалд биш гагцхүү төрийн нөхцөлд л хүчин төгөлдөр болно. Нэг үгээр, жам ёсны эрхээсээ аль нэгэн этгээдэд ашигтайгаар татгалзана гэсэн үг. Гэхдээ тэрхүү этгээд хэрэг дээрээ ямар ч шинэ эрх авч байгаа хэрэг биш бөгөөд ердөө л өөртөө нэгэнт байгаа эрхээ бусад хүмүүсийн зүгээс учруулах ямарваа нэг саад тотгоргүйгээр

¹ Гоббс Т. Соч. 1. 291-р тал

² Гоббс Т. 1. 287-р талд үз

³ Гоббс Т. Соч. Т. 1. 295-р тал.

хэрэгжүүлэх болно. Яагаад гэвэл, хэлэлцээр байгуулах үед тэдгээр хүмүүс түүний хүсэл зоригийг үл эсэргүүцэх үүрэг хүлээсэн билээ.

Ийнхүү шударга ёс, аюулгүй байдлыг ганцхан замаар хангаж болно. Тухайлбал, бүх эрх мэдэл, хүчийг нэг хүнд (хуралд) төвлөрүүлэн тэрбээр иргэд тус бүрийн хүсэл зоригийг нэгэн нэгдмэл хүсэл зориг болгон хувиргах ёстой. "Дурдсан хүн эсвэл хурал өөрт төвлөрсөн асар их хүч, засаглах эрх мэдлийг ашиглах бөгөөд энэ хүч, эрх мэдлээс айн сүрдэх явдал бүх хүмүүсийн хүсэл зоригийг дотоодын энх амьдралын төлөө, гаднын дайсны эсрэг тэмцэхэд харилцан туслахад чиглүүлэх чадварыг энэ хүн, эсвэл энэ хуралд бий болгодог"⁴ Ингэж төр үүсдэг. Төрийн үүслийг шударга ёс, хувийн өмчтэй холбож өмчгүй газарт шударга байдал үгүй, төр үгүй бол өмч ч үгүй, бас шударга ёс ч үгүй гэдгийг Гоббс тэмдэглээд хэрэв олон хүмүүс айлган сүрдүүлэх засаг үгүй нөхцөлд шударга ёс, байгалийн бусад хуулиудыг сахин биелүүлж чаддагсан бол төр, захирах ёс гэж байх ямар ч шаардлагагүй тухай өгүүлсэн байдаг.⁵

Төрийн гол шинж төр баригч, албат болон тэдний харилцаагаар илрэн гарна. Ийнхүү нэг хүний эрх мэдэл дор нэгдсэн олон хүн төр үүсгэх бөгөөд улмаар онцгой шинж чанар, зан араншин, ноёлох арга хэрэгсэл бүхий аварга Левиафан болон хувирч төр, нийгэм, хувь хүний харилцааг тодорхойлох болжээ. Иймэрхүү дүр зургаар төрийн эрх мэдэл Гоббст төсөөлөгдөж байсанд түүний төрийн тухай үзэл баримтлалын мөн чанар оршино.

Төрийн дээд эрх баригчид хэмжээгүй эрх мэдэл төвлөрөх ёстой хэмээн Гоббс хэдийгээр үзэж байсан ч тийм засаглал бас базаахгүй үр дагаварт хүргэж болохыг тэрбээр ойлгож байсан гэхэд хилсдэхгүй биз. Гэхдээ эрх чөлөө, дэг журам хоёрын сонголтын өмнө тулгарахдаа тэрбээр хүмүүн төрөлхтөн айх аюулгүй амьдрах нь юу юунаас үнэ цэнэтэй гэдэг үүднээс сүүлчийнхийг нь илүү чухалчлан үзсэн бололтой. "Ийм хэмжээгүй эрх мэдэлтэй засаглал олон муу үр дагаварт хүргэх болно хэмээн хүмүүс дүрслэн бодож болох хэдий ч харин ийм засаглал үгүй бол гагцхүү бүгдийн эсрэг бүхний тасралтгүй дайн илүү хөнөөлт үр дагаварт хүргэх болно".⁶

Үүний зэрэгцээ Гоббс хожимоо ардчилсан нийгэм, засаглал тогтнохын үндэс болсон улстөр дэх хэлэлцээ зөвшилцөл, гэрээний харилцааны талаар зарчмын санаа дэвшүүлсэн юм. Тухайлбал, ардчилсан дэг ёсны чухал бүрдэл - олонхи цөөнхийн харилцаанд онцлон анхаарчээ. Төрийг нийгмийн бүх гишүүд сайн дураар зөвшөөрөх нь зүйн хэрэг. Гэхдээ тодорхой нөхцөлд бүх хүн биш юмаа гэхэд тэдний дийлэнх олонхи хэлэлцэн тохиролцоход хангалттай. Ийм тохиолдолд зөвшөөрөхгүй байгаа хэсгийн байр сууриас үл хамааран төр байгуулагдаж, энх амгаланг сахиулах үүргээ гүйцэтгэх ёстой ажээ.

Гоббс төрийн засаглалын дээд эрх мэдэл, түүнийг дагаж бишрэх ёсыг иргэдийн зүгээс хүлцэнгүй, дуулгавартай байхтай (иргэд шилжүүлэн өгсөн эрхээ ашиглахгүй, төрийн хуулийг зөрчихгүй, төрд эсэргүүцэл үзүүлэхгүй байх үүрэг хүлээсэн) холбон үзэхийн хамт иргэний нийгмийн талаар шинэлэг санаа хэлсэн гэж болох юм. Төр иргэдийн хэргийг шийтгэн явуулах цорын ганц этгээд бас биш. Тодорхой хэлэлцээр байгуулсан хүмүүсийн ямар ч нэгдэл иргэний бие төлөөлөгч байж болно.⁷ Гэхдээ иймэрхүү эвсэл холбоог төр гэж үзэх аргагүй. Учир нь түүний гишүүд хамтын эрх ашгийн төлөөнөө өөрсдийн бүх эрхээсээ татгалзаагүй агаад түүнд санал шаардлагаа байнга тавьж эсвэл гэрээгээ цуцалсан ч болох бөлгөө. Харин төрийн хувьд ийм байж болохгүй.

Иргэний нийгэм нь түүний олонхи гишүүд ашиг сонирхолдоо нийцсэн, ухаалаг зохицуулсан, шударга хуулийг дуулгавартай даган биелүүлэх болсон тэр цагт л өөдөлж мандана гэж Гоббс үзсэн.

⁴ Гоббс Т. Соч. Т.2. 133-р тал.

⁵ Гоббс Т. Соч. Т.2. 131-р талд үз.

⁶ Гоббс Т. Соч. Т.2. 162-р тал.

⁷ Гоббс Т. Соч. Т.1. 331-р талд үз.

Байгалийн хууль бол хүн өөртөө хөнөөлтэй, халгаатай бүхнийг үйлдэхээс цээрлэх явдал байдаг.⁸ Гэвч байгалийн хууль тэр бүр биелэгдэх баталгаа байхгүй. Энэ нь 1-рт, аюулгүй байдал олон олон хүний зөвшилцөл, зөвшөөрлийн үр дүн байдаг; 2-рт, хүнийг угаас билэг оюун төдийгүй бас хүсэл шунал, уур хилэн, атаа жетөө, хардалт сэрдэлт гэх мэт хоёрдмол чанартай байдагтай холбон тайлбарласан байна. Учир иймд дан эл хуулиар явсан хүн хууль үл тоомсорлогчдын олз золиос болох нь ердийн үзэгдэл.

Дээрхээс үндэслэж Гоббс хүчирхэг засаглалын тухай санаагаа лавшруулан тайлбарласан. Энх амьдралыг төвшитгэн тогтооход байгалийн хуулийг мөрдлөг болгох нь зайлшгүй. Үүний тулд аюулгүй байдал хэрэгтэй. Эндээс үүдэн албадлагын засаглалыг хэрэгжүүлэх үүрэг төрд ногдоно. Гэхдээ төр ийм үүрэг хүлээснээр иргэдийн аюулгүй байдлыг бүрэн дүүрэн баталгаажуулж хараахан чадахгүй бөгөөд бусдын зүгээс гэнэт халдах, хохирол учруулах заналхийлэл байсаар байх болно. Нэгэнт хүмүүс эрх барих дээд засаглал тогтоосны зорилго нь аюулгүй байдал байдаг учир давын өмнө айх аюулыг зайлуулах зорилт төрийн өмнө тулгарна. Аюулгүй байдал ямар нэг хэрэг үйлдэхгүй байх талаар хүмүүсийн аман тохиролцоо төдийгөөр бүтэхгүй. Иймд хэлэлцэн тохиролцсоноо чанд мөрдөх журмыг хууль зөрчигчдийг шийтгэх явдлаар батжуулж өгвөл зохино. Үүний тулд албат олонд айдас төрүүлэхүйц сүр хүчтэй, бат чанга засаг төр хэрэгтэй болдог. Энэ нь засгийн бүх эрх мэдлийг нэг гарт (эсвэл хурлын) зангидсан үед боломжтой. Өөрөөр хэлбэл, "шударга ёсны илд", "дайн байлдааны илд".⁹ бүхнийг гартаа атгасан цагт сая засгийн дээд эрх мэдлийг эзэгнэн захирагч байх ажээ. Тодруулбал, хууль тогтоох, түүнийг хэрэгжүүлэх эрх мэдэл нэгэн өндөрлөгт төвлөрч байгаа хэрэг. Эндээс ажиглахад Гоббс засаглал хуваарилах асуудлыг төдийлөн ойшоож үзээгүй бололтой.

Гоббс улс оронд амгалан тайван байдал албадлагын хүчээр төдийгүй иргэдийн хооронд алив маргаан зөрчил үүсэхээс сэрэмжилж чадсаны үр дүнд тогтнох ёстой гэж үзэж байв. Бүх мөргөлдөөн хямралдаан нь шударга, шударга бус, сайн муу, зөв буруугийн талаар хүмүүсийн зөрүүтэй бодол төсөөллөөс үүдэлтэй. Иймд төрөөс нийтээр нэг мөр дагаж мөрдөх үйл байдлын хэм хэмжээг иргэдэд гирган өгч түүнийг баримтлан тэд хоорондоо харилцаж байх учиртай. Төр энэ үүргээ нийтээрээ заавал биелүүлэх иргэний хуулийн тусламжтай хэрэгжүүлэх болно.

Хууль мөн чанараараа шийтгэлийг агуулж байдаг учир иргэний хууль мөн иймэрхүү байх нь мэдээж. Хууль, Гоббсынхоор, нэг талаас ял шийтгэлийн хэмжээ хязгаарыг тодорхойлохоос гадна нөгөө талаас улс орны тогтвортой байдлын зайлшгүй бүрдэл хэсэг болж өгдөг. Учир нь аль нэг хууль зөрчвөл цаад талд нь хэзээ, юу хүлээж байгааг иргэд эрхбиш гадарлаж байдаг аж. Иймд айдас нь хоосон айж бэмбэгнэх төдий бус харин болзошгүй айдас түгшүүрийг урьдаас мэдэж түүнээс зайлсхийж болох тухай Гоббс онцлон тэмдэглэсэн байдлыг дээр дурдсан билээ. Тэгэхлээр тэрбээр "улстөрийн хүн" санамсаргүй, гэнэтийн халдлага, аюулаас айж эмээх явдлаас ангижирч чаддагаараа "байгалийн хүн"-ээс ялгардаг гэсэн санааг хэлж байна.

Иргэний хууль гарч ирээгүй байсан тэр цагт юу зөв, юу шударга вэ гэдгийг хүмүүс өөр өөрсдийнхөөрөө толгой даан шийддэгээс жам ёсны байдалд шударга ёс ч, гэмт явдал ч аль аль нь байсангүй. Юуг муу муухай, юуг сайн сайхан гэж үзэх талаар хүн бүр өөр өөр санаа бодол өвөрлөж байдгаас болж бүгд нэг дуугаар зөвшөөрөн иргэний хуулийг гаргаж үл чадна. Иймд ямар үйлдлийг гэмт хэрэг гэх, түүнд хэрхэн шийтгэл ногдуулахыг зөвхөн төр тодорхойлох эрхтэй гэж Гоббс үзжээ.

Байгалийн хуулиудыг биелүүлэх нь сайн дурын шинжтэй байдаг бол иргэний хуулиуд хүмүүсийн зохистой гэх зан байдлыг хатуу тогтоож өгдөг. Эдгээр хууль агуулгын хувьд адил ч байгалийн хууль билэг оюунд, иргэний хууль хүчинд

⁸ Гоббс Т. Соч. Т.2. 98-р талд үз.

⁹ Гоббс Соч. Т.1. 333-р талд үз.

тулгуурлана гээд эндээс Гоббс эрх зүй, хууль гэсэн ойлголтуудыг анх зааглан үзсэн гэдэг. " Хууль бол хүлээс, эрх бол эрх чөлөө ".¹⁰

Түүнчлэн иргэний хууль байгалийн хуулийн үйлчлэлийг бас үгүйсгэдэггүй байна. Тухайлбал, "хууль ёсны засагт эсэргүүцэл үзүүлэхгүй" гэсэн заалтыг иргэний хууль болгох нь утгагүй бөгөөд учир нь энэ бол төр үүсгэх талаар хэлэлцээр байгуулах үед бүх иргэдээс төрд дэвшүүлсэн үндсэн шаардлага юм.

Хууль биелүүлэх үүрэгтэй хэн боловч хуулийн агуулгыг төдийгүй хаанаас хэн гаргасныг сайн мэдэх ёстой. Хууль заавал хууль тогтоогчоос эх авч гарсан байх, хуулийг хэвлэн нийтэлж бүх ард түмэнд зарлан мэдээлэх нь үүнтэй холбоотойг Гоббс тэмдэглэсэн.

Байгалийн хийгээд иргэний хууль нь жам ёсны эрхийг дэс дараатай алхам алхмаар хязгаарлах учиртай байв. Байгалийн хууль хэмжээгүй эрх чөлөөг хазаарлаж өгдөг бол үлдсэн бусад эрхэнд эхлээд төрийн ерөнхий хууль, дараа нь хот, орон нутгийн хууль хэмжээ тогтоодог байна.

Ийнхүү Гоббсын төрийн тухай үзэл баримтлалд эрх, эрх чөлөөний тухай асуудал чухал байр эзэлдэг. Хүмүүс эхлээд засаглалын сүр хүчин дор өөрсдийгөө дэг ёсны тодорхой хүрээнд барьж байх "хиймэл гинж"-иргэний хуулийг зохионо. Ингэх нь зайлшгүй болдог. Гэвч хүн бүрийн алхаж гишгэх, хэлж ярих бүхнийг нэгбүрчлэн заасан хуультай төр улс гэж хаана ч үгүй. Иймээс албатуудын эрх чөлөө нь хэлэлцээрт заагдаагүй бүхнийг хийж болох эрх чөлөө юм. Ингэж төр хуулиар төдийгүй бас тусгай дүрэм журам, чимээ "шуугиан" гаргалгүйгээр давхар удирдан зохицуулж байдаг байна. " Аливаа үйл үйлдэхдээ энэ талаар хууль дүрэм чимээгүй өнгөрсөн байвал хүмүүс өөрсдийн билэг ухаан алийг нь хамгийн ач тустай хэмээн болгооно түүнийгээ хийх эрх чөлөөтэй байдаг"¹¹

Хуульд зааж хориглоогүй бүхнийг хийх, эсвэл хийхгүйгээ хүн өөрийн үзэмжээр шийддэг эрх чөлөө нь үндсэндээ иргэний хуулиар иргэдэд олгосон жам ёсны эрхийн хэсэг юм. Ийм учраас хууль хүний үйл ажиллагааг тасалдуулахын тулд бус харин түүнийг чиглүүлэхийн тулд зохиогддог гэдгийг Гоббс анхааруулсан байдаг.¹² үзэс

Ийнхүү эрхээ шилжүүлэн өгсний дараа ч хүнд тодорхой тооны "эрх чөлөө" үлддэг байна. Бүх эрх дээд засаглалд шилждэг ч хэрэг дээрээ тэрбээр зөвхөн улс орны аюулгүй байдлыг хангахад нэн түрүүн шаардлагатай эрхүүдийг л хүлээн авдаг ажээ. Иймд хууль нь эрхээ шахаж байрыг нь эзэлж байна гэж үзэж болохгүй. Төр баригч өөрийн эрх мэдлийн үндсэн дээр биш, гагцхүү урьд батлагдсан хуулийн үндсэн дээр чухам хуулийн дагуу юуг заавал биелүүлэх ёстойг л шаардахаас биш түүнээс илүүг шаардах учиргүй.

Иргэдийн салшгүй эрхтэй холбогдуулан Гоббс төрийн гол үүргийг товойлгож гаргасан байна. Төр албатуудаа хамгаалах үүргээ биелүүлж байгаа нөхцөлд л хязгааргүй эрхээ эдэлнэ. Хэлэлцээрийн дүнд хүмүүс өөрийн бүх эрхээс татгалзаж үүний хариуд гадна, дотнын халдлагаас иргэдээ хамгаалж аюулгүй байдлыг хангах үүргийг төр хүлээдэг. Харин төр энэ үүргээ биелүүлээгүй, биелүүлэх чадваргүй болсон нөхцөлд түүний засаглал дор дуулгавартай байх шаардлага иргэдэд аяндаа үгүй болно гэснээрээ Гоббс төр иргэний харилцааны суурь чухал асуудлыг хөндөн тавьсан юм. Ийнхүү тэрбээр эрх ашигт нь харш засаглалыг албатууд эсэргүүцэж болохыг үгүйсгээгүй боловч нөгөө талаас хувьсгалаас ихэд болгоомжилж нийгэмд дэг журам сахиулж буй гэрээг эвдэн сүйтгэх аюултайг сануулж байв.

Гоббсын хувьд **гэрээ** төрийн мөн чанарыг нээн гаргахад иш үндэс болсон ойлголт бөгөөд гэхдээ бусад нийгмийн гэрээний онолын төлөөлөгчдөөс ялгагдах онцлог нь

¹⁰ Гоббс Т. Соч. Т.1.415-р тал.

¹¹ Гоббс Т. Соч. Т.2. 165 - р тал.

¹² Гоббс Т. Соч. Т.2. 410 - р талд үз.

түүнийхээр бол гэрээ хүмүүсийн хооронд хийгдэх ёстой байв. "Ер нь иргэн, ард түмэн хооронд хэлэлцээр байдаггүй, тэгэхлээр ийм гэрээ хэлэлцээр иргэд хооронд байгуулагдана. Өөрөөр хэлбэл, чи миний төлөө эрхээ ард түмэнд шилжүүлэн өгөхийн тулд би өөрийн эрхийг чиний төлөө ард түмэнд шилжүүлж өгч байна гэсэн байдлаар хүмүүс хандсан тэр нөхцөлд иргэн бүр өөрийн хүсэл зоригийг олонхийн хүсэл зоригт захируулах үүргийг хүлээх болно" хэмээн тэр бичсэн байдаг¹³

(Гоббс гагцхүү аюулгүй байдлыг хангах явдлаар төрийн үүрэг дуусахгүй гэж үзэж байсныг тэмдэглэх хэрэгтэй.) "Ард түмний сайн сайхан-дээд хууль мөн".¹⁴ Иймд ард түмний эрх ашгийг хөсөрдүүлсэн төр засаг ихээхэн хор уршиг тарих бөгөөд иргэдээ хавчин гадуурхаж өөрийн үндсэн үүргээ умартан үл биелүүлвээс улсын хүч чадал суларч түүний оршин тогтнол улам бүр хэврэгшинэ. Ийм байдалд хүргэхгүйн тулд амгалан тайван аж төрөх гадаад дотоод нөхцлийг иргэддээ хангаад зогсохгүй нийгмийн аюулгүй байдалд заналхийлэхгүй хүрээнд илүү сайн амьжиргаа, эрх чөлөөг эдлүүлэх үүрэгтэйг сургажээ.

Дотоод гадаад аюулгүй байдлыг хангах нь ямарч улсын хувьд хурц асуудлын нэг байдаг. Иймээс эрх баригчид өөрсдөө, мөн бусдаар дамжуулан нөгөө гүрнийхээ зан төлөвийг урьдаас таньж мэдэж чаддаг байх, цэрэг, зэр зэвсэг, хамгаалах байгууламж, батлан хамгаалахад зориулсан мөнгө хөрөнгөтэй байх шаардлагатай. Мөн дотооддоо амгалан тайван байдлыг хадгалах нь дээрхээс дутахааргүй нарийн ээдрээтэй зорилт байдлыг тэрбээр цохож заасан байна. Засаг, иргэдийн эрх үүрэг, тэдний хоорондын харилцааны талаархи буруу ташаа төсөөллөөс үүддэг дотоодын үймээн самуунаас болж төр мөхөлд хүрнэ. Иймд засаглалын нэг үүрэг нь төр засагт харшлах алив төөрөгдлийг иргэдийн ухамсраас "шахан зайлуулахад" оршино. Энэ үүднээс улс даяар боловсролын системийг бий болгох нь зайлшгүй хэмээн Гоббс үзэж байв.

Түүнээс гадна нийгмийн хэмжээний алба татварын хүнд дарамт гэхээсээ тэдгээрийг тэгш биш хуваарилдаснаас нэлээдгүй шалтгаалдаг хүн амын ядуурал гуйланчлал эсэргүүцэл хөдөлгөөний сурвалж болох нь цөөнгүй. Иймээс алба гувчуурыг тогтоохдоо ачааг нийт иргэдэд адил тэгш үүрүүлэх нь төр засгийн анхаарвал зохих эмзэг асуудал бөлгөө.

Төр улсын амьдралд төвөг бэрхшээл учруулдаг бас нэгэн үзэгдэл бол Гоббсынхоор эрх тушаалд шунан тэмүүлэх хүний заяагдмал чанар юм. Үүний олиггүй үр дагавраас зайлсхийхийн тулд төрөөс журамтай сайн иргэдийг урамшуулж шагнах, дуулгаваргүйг шийтгэн баалах тогтолцоо бий болгох нь зүйтэй. Үүний дүнд эл үзэгдэл засаглалыг сөрөн эсэргүүцэхэд бус харин дэмжин хүлээн авахад илэрлээ олох учиртай аж.

Төрөөс хөдөлмөр, арвич хямгач занг хөхүүлэн дэмжихийн хамт залхуурах, гар хумхин зүгээр суухыг цээрлэснээр иргэдийн амьдрал, аж байдлыг өөд татаж болохыг их сэтгэгч сургасан байна. Эдгээр үүргийг үр дүнтэй ажил хэрэг болгохын тулд төр иргэддээ эрх чөлөөг байх хэмжээнд нь саадгүй олгох ёстой. Энэхүү эрх чөлөөг өөрт үлдсэн эрхүүдээ айдас түгшүүргүй ашиглах боломж хэмээн ойлгож болно. Айдас нь жам ёсны байдлын зонхилох мэдрэмж, хүмүүс иргэний нийгэмд нэгдэн орсны гол шалтгаан болохын хувьд төр үүссэн цагт ч алга болохгүй, гагцхүү өөрчлөгдөж, тухайлбал, түүний хамгийн ноцтой гэнэтийн шинж үгүй болдог байна. Тодорхой гэмт үйлдлийг зохих шийтгэл заавал дагалдаж байдлыг хэзээ ч мэдэж байдгаараа иргэн хүн байгалийн хүнээс ялгаатайг Гоббс нэг биш удаа давтан хэлсэн байдаг.

Гоббсын төрийн үзэл сургаалд иргэний нийгэм, төр хоёр адилсаж байдаг хэдий ч тэрбээр төрийг өвөрмөц байр сууринаас авч үзсэнээрээ онцлог гэж болно. Гоббс төр, ард түмний хооронд нэг ёсны тэгш байдал тогтоож, тэдгээрийн хоорондын харилцааны тодорхойлогч хүчин зүйл нь харилцан бие биеэ нухчин дарах бус, харин

¹³ Гоббс Т. Соч. Т.1. 334 - р тал.

¹⁴ Гоббс Т. Соч. Т.1. 401 - р тал

харилцан эрх чөлөөтэй байхад оршино гэсэн санаа дэвшүүлсэн юм. Төр засгийн зүгээс хүч хэрэглэх нь гол төлөв улс оронд энхийг тогтооход л чиглэгдэнэ. Учир нь Гоббсынхоор энх тайван бол хүн байгалиас өөрт заяагдсан авьяас чадвартаа түшиглэн хөгжих боломж олгодог тулгуур үнэт зүйл мөн.

С.Базарпүрэв.

Доктор (PhD), дэд профессор

Дэвид Истоны улс төрийн системийн онол

Нийгмийн улс төрийн амьдралыг тогтвон шинжлэн, улс төрийн системийн онолыг боловсруулан, түүний үйл ажиллагааны зарчмыг тайлбарлан хялбарчилсан загварыг бүтээсэн судлаач бол америк-канадын эрдэмтэн Дэвид Истон юм. «Улс төрийн систем», «Улс төр шинжлэлийн хүрээ», «Улс төрийн амьдралыг системтэй судлах нь» хэмээх гол бүтээлүүдээ улс төрийг системтэй судлах аргуудын тухай үзэл бодлоо тусгажээ. Хэдийгээр дээрх бүтээлүүд нь он цагийн хувьд ялгаатай ч нэг үзэл бодлыг номлосноороо нийтлэг юм.

Өрнөдийн улс төрийн социологт системийн аргыг түүнээс өмнө түгээмэл хэрэглэж байсан бөгөөд Истон нь удирдлагын «сонгодог» онол дээр тулгуурлан гарч ирсэн «нийгмийн системийн» сургуулийн нэгэн төлөөлөгч юм. «Нийгмийн системийн» тухай үзэл санаа нь Т.Парсонс, Р.Мертон нарын бүтээсэн бүтэц-үүргийн онолын шууд нөлөөнд төлөвшсөн бөгөөд Л.Берталанфи, А.Раппопорта нарын ерөнхий системийн онол дээр суурилсан байна. «Нийгмийн системийн» онолын чухал зарчмуудыг улс төрийн амьдралыг судлахад анх хэрэглэснээр Истон улс төрийн шинжлэх ухааны хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан. Системийн онолын ерөнхий үр дүнг улс төр, улс төрийн институт, улс төрийн системийн онолыг боловсруулахад үр бүтээлтэй оновчтой ашиглаж системийн улс төрийн онолыг бий болгосон.

Уг онол нь улс төрийн шинжлэх ухаанд хүлээн зөвшөөрөгдөж, өөрийн гэсэн байр суурийг олж авсан юм. Үүний цаад учир нь хэр нөхцөлтэй холбоотой. Юуны өмнө улс төрийн системийн оршин тогтнож, хадгалагдан үлдэж байхад нөлөөлж, үйлчилж байдаг хүчин зүйлсийг түүний онол тодорхойлж өгсөн явдал юм. Тухайн нөхцөлийг Истон улс төрийн системийн онолын амин чухал зүйл гэж онцлон үзсэн байдаг. Үүнээс гадна улс төрийн системд аюул учруулж болох сурвалжуудыг судлах нь улс төрийн шинжлэх ухааны нэг гол зорилго гэж тэрээр үзжээ. Нөгөө талаар, улс төрийн системийг тогтворжуулах замаар түүнийг сахин хадгалж болох боломжийн талаар санал дэвшүүлжээ.

Улс төрийн системийг **«Нийгмийн үнэт зүйлсийг захиран хуваарилах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч»** хэмээн Истон тодорхойлсон. Улс төрийн системийн гол зорилт нь үнэт зүйлсийг хуваарилах, үүнээс гадна тодорхой хугацаанд ийм хуваарилалт зайлшгүй гэдгийг нийгмийн гишүүдэд ойлгуулан, итгүүлэхэд оршино. Чухамхүү улс төрийн системийн дээрх хоёр үүрэг нь нийгмийн бусад системээс түүнийг ялгадаг. Хэрэв улс төрийн систем нь өөртөө ноогдсон үүргээ «урагштай» гүйцэтгэж чадахгүй тохиолдолд оршин тогтноход хүндрэл учирч, хямрал нүүрлэн системийн задрал явагдаж улмаар мөхөлд хүрч болох эрсдэлтэй.

Истон улс төрийн системийг «нээлттэй системд» хамааруулж, «хүрээлэн байгаа орчинд хандаж, түүнтэй идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг тухайн орчны нөлөөг өөр дээрээ байнга мэдэрч, мөн түүнд эргээд нөлөөлдөг» тогтолцоо юм гэжээ. Хүрээлэн байгаа орчинд байгаль, физик, нийгэм, сэтгэл судлалын гэх мэтчилэн олон хүчин зүйлсүүд багтдаг бөгөөд гадаад (экстрасоциетар), дотоод (интрасоциетар) хэмээн хуваагддаг. Дотоод орчин нь (эдийн засгийн, нийгмийн г.м.) тухайн нийгмийн дэд системүүдээс бүрдэг бөгөөд улс төрийн систем ч гэсэн бас түүний нэг бүрдэл юм. Гадаад орчин нь тухайн улс төрийн системд «ахадсан» супер систем юм (жишээлбэл: олон улсын эдийн засаг, улс төр, соёлын болон бусад нийгэмлэгүүд). Гадаад, дотоод орчин нь улс төрийн системд хүчтэй нөлөө үзүүлж байдаг. Улс төрийн систем ч өөрийгөө хүрээлэн байгаа орчинд хариу нөлөөлдөг. Гэвч түүнд дасан зохицох бус харин өөртөө ашигтайгаар өөрчлөх үйл ажиллагааг улс төрийн систем идэвхтэй явуулдаг. Үүний үр дүнд систем нь өөртөө үзүүлэх ямар ч нөлөөнд хангалттай хариу өгөх чадварыг төлөвшүүлэхийг зорьдог.

Улс төрийн систем нь «оролт», «гаралт»-аар дамжин хүрээлэн байгаа орчинтой харьцдаг. Ямар нэгэн боломжтой арга хэрэгслээр системд нөлөөлж, өөрчлөлт хийх санаа бүхий чиглэлтэй, системээс ангид үйл ажиллагаа бүрийг **«оролт»** хэмээх ойлголтонд багтаадаг.

«Гаралт» нь тодорхой үр дүн, эцсийн гэмээр үйлдэл юм. Тэр нь тодорхой шийдвэр, үйл ажиллагаа гэсэн хоёр хэлбэрээр биежин хэрэгждэг. Хүрээлэн байгаа орчны нөлөөлөлд хариу өгөх нь улс төрийн системийн чадвар гэж үзэж болно. Улс төрийн системд орж ирсэн мэдээлэл дээр тулгуурлан шийдвэр гаргахыг **улс төрийн үйл явц** гэж тодорхойлдог.

Хүрээлэн байгаа орчин нь улс төрийн системд хоёр янзаар нөлөөлдөг. Системд тодорхой шаардлага тавьдаг, мөн түүнд зохих дэмжлэг үзүүлдэг. Нийгэмд хийгдсэн оновчтой буюу өгөөжгүй хуваарилалтын талаар засгийн эрх баригч байгууллагад хандсан санал бодлыг **«шаардлага»** гэж тооцдог.

«Дэмжлэг» нь «нээлттэй» (хувь хүний болон бүлэг хүмүүсийн үйл ажиллагаагаар илэрхийлэгддэг) «хаалттай» (хүмүүсийн хувийн дотоод бодол) гэсэн хэлбэртэй байдаг. «Дэмжлэг» нь улс төрийн системд чухал үүрэг гүйцэтгэдэг. Учир нь **нэгд**, засгийн эрх барьж буй байгууллагын тогтвортой үйл ажиллагааг хангаж байдаг, **хоёрт** улс төрийн дэглэмийг жигд оршин тогтнох зайлшгүй нөхцөл нь болдог, **гуравт** аль нэг улс төрийн байгууллагад багтаж байгаа гишүүдийн эв нэгдлийг бэхжүүлдэг. Иймээс «дэмжлэг» гэдэг нь зөвхөн улс төрийн системд тус нэмэртэй зүйл төдийгүй мөн нийгэмд ч гэсэн ач холбогдолтой гэсэн чухал дүгнэлтийг Д.Истон хийжээ.

Улс төрийн системийн үндсэн бүрдэл хэсэг болох **засаглал, дэглэм, улс төрийн нэгдлийг** нийгмийн зүгээс дэмждэг.

Улс төрийн шийдвэр гаргасны төлөө хариуцлага хүлээх эрх мэдэл бүхий төр, засгийн газраас гадна гүйцэтгэх засаглалын болон иргэний, нийгмийн тодорхой албадуудыг нийгмийн гишүүд дэмжиж байдаг. Тухайн дэглэмийн хүрээнд тодорхой улс төрийн үйл ажиллагаа бүрэн эрхтэй хэрэгжиж байдаг бөгөөд нийгэм түүнд ямар нэгэн найдлага тавьж их зүйл хүсэж дэмждэг.

Улс төрийн нэгдэл гэдэг нь хөдөлмөр хуваарилалтын үр дүнд нэг улс төрийн үйл ажиллагаа эрхлэх болсон хүмүүсийн бүлэг юм. Нийгмийн бусад нэгдэлтэй харьцуулах юм бол улс төрийн нэгдэлд багтаж буй гишүүд нь нийтлэг эв санаатай байх албагүй.

Улс төрийн ямар нэгэн бүтэц нь өөрчлөгдсөнөөр тухайн систем бүхэлдээ өөрчлөгдөх хандлагатай болдог. Гэвч системийн бүрэн хувиралт нь түүнийг бүрдүүлэгч бүх элемент нэгэн зэрэг өөрчлөгдсөнөөр явагдана.

Хүрээлэн буй орчинд дасан зохицох, өөрийн үйл ажиллагааг зохицуулах, өөрийн дотоод бүтцээ боловсронгуй болгох боломж бүхий олон тооны арга механизмыг улс төрийн систем эзэмшиж байдаг. Тэдгээрийн тоонд улс төрийн системийн тогтмол хийж байдаг гурван төрлийн үйл ажиллагаа багтана. **Нэгт**, хэрэгцээг (санал бодол, шалтгаан, хүсэл найдвар, сонирхол, үзэл суртал) шаардлага болгон хувиргах. **Хоёрт**, шаардлагыг ангилж, шүүн тунгаах. **Эцэст** нь шаардлагыг шийдвэр болгох үйл ажиллагаа орно. **Эдгээр ажиллагаа жигд тогтвортой хийгдэж байгаа тохиолдолд улс төрийн систем нь өөрөө өөрийгөө сахин хадгалж, оршин тогтнох чадвараа бататган бэхжүүлэх гэсэн үндсэн гол зорилтоо хэрэгжүүлэх бүрэн боломжтой** гэж Д.Истон үзжээ.

Истон нийгмийн хүрээнд өрнөж буй үйл явцаас улс төрийн системийг тусгайлан авч үзэж, түүний талаар онол боловсруулсан байна. **Улс төрийн системийн үйл ажиллагаа, оршин тогтнох үйл явцыг судалдаг шинжлэх ухаан гэж улс төрийн шинжлэх ухааныг Истон тодорхойлсон байна.** Байгальд буй системүүдийн нэгэн

адил улс төрийн системийн зорилго нь өөрийнхөө амьдрах чадвар, оршин байж, үйл ажиллагаа явуулахад хэрэгцээтэй нөөц хүчийг ханган төлөвшүүлж, арвижуулж байх явдал юм. Улс төрийн шинжлэх ухааны судлах зүйлийг ийнхүү тодорхойлсноор улс төрийн систем судлалыг чанарын шинэ түвшинд гаргасан гэж үздэг байна.

Истон нь ангийн тухай марксист онолыг үгүйсгэж, улс төрийн системд олон түмний эзлэх байр суурийг доогуур үнэлсэн байдаг. Зохион байгуулалтгүй өргөн олноос үзүүлэх дэмжлэгээс оюуны чадвартай цөөнхийн дэмжлэг илүү их өгөөжтэй хэмээн Истон онож дүгнэсэн байна.

Улс төрийн системийн үйл ажиллагаа нь Истоны үзэж байгаагаар тийм ч амар жигд явагддаг зүйл биш гэж тодорхойлжээ. Улс төрийн шийдвэр гарах үе шат болгонд бэрхшээл үүсдэг бөгөөд улмаар улс төрийн системд аюул заналхийлдэг байна. Үүнээс үүдэн уг аюулыг зогсоох, үгүй хийх зорилго улс төрийн системийн өмнө тулгардаг.

Истоны бий болгосон улс төрийн системийн загвар нь цаг хугацаа, орон зай, нийгмийн төрөл ангиас үл хамааран, түүхийн он жилүүдэд үл захирагдан ямар ч нийгэмд хамаатуулж болох төгс загвар юм. Үүнээс үүдэн ямар ч нийгэм улс төрийн системгүйгээр оршин тогтнох боломжгүй гэсэн дүгнэлтийг хийж болохоор байгаа юм.

Ишжамцын Лхам.

Доктор (PhD)

“Нээлттэй нийгэм”-ийн үзэл санааг үндэслэгч

Нээлттэй нийгмийн үзэл санаа нь ардчилал хөгжсөн олон оронд, түүний дотор Монгол Улсад өргөн дэлгэрээд байгаа билээ. Гэтэл нээлттэй нийгмийн үзэл санаа гэж юу болох, тэр нь онолын ямар үндэслэлтэй бөгөөд хэн түүнийг боловсруулсан болохыг тэр бүр монголчууд мэддэггүй билээ. Иймд “нээлттэй нийгэм”-ийн үзэл санааг үндэслэгч Английн философич К. Попперийн намтар, зохиол бүтээл, үзэл санааг судалж олон түмэнд сурталчилах болон нийгмийн практикт амжилттай хэрэгжүүлэх явдал чухал зорилт болж байна.

Карл Раймунд Поппер 1902 онд Австрийн Вена хотноо эрх зүйн профессорын гэр бүлд төржээ. Тэрээр 16 настайдаа Венийн их сургуульд элсэн орж, математик, физик, сэтгэл зүй, хөгжмийн түүх судалж, үүнийхээ зэрэгцээ дунд сургуульд тоо, физикийн багш, мужаан зэрэг ажил хийж байжээ. К.Поппер философийг бие даан судалснаараа онцлог юм.

К.Поппер бага залуудаа Оросын болон Төв Европын хувьсгалын нөлөөгөөр марксизмыг сонирхон судалж, марксист, бүр коммунист болсон байна. Гэвч тэрээр марксизмын зорилго нь хэдийгээр маш хүнлэг ариун боловч тэрхүү зорилгодоо хүрэхийн тулд гэм буруугүй олон хүмүүсийг золиосолдог сургаал болохыг ойлгосны үндсэн дээр марксизмыг ёс суртахууны үүднээс голох болжээ. Ийнхүү 17 наснаасаа эхлэн Поппер марксизмыг хүлээн зөвшөөрөхөө больсон байна. Марксизмын алдааг үндэслэхэд түүний нийгмийн философийн нэлээд бүтээлүүд зориулагдсан байна.

Попперийн анхны нэг сэдэвт зохиол нь 1933 онд герман хэл дээр гарсан “Шинжлэх ухааны судалгааны логик” юм. Поппер уг зохиолдоо шинжлэх ухааны мэдлэгийн өсөлт ямар болохыг урьдчилан хэлэх аргагүй учир хүн төрөлхтний түүхийн явцыг угтан өгүүлж чадахгүй. Түүхэн угтан өгүүлэхүйн үндэс болж чадах шинжлэх ухааны ямар ч онол байх боломжгүй гэж тэрээр үзжээ. Гэхдээ Поппер нийгмийн элдэв төрөл угтан өгүүлэхүй байх бололцоог бүрэн үгүйсгээгүй бөгөөд гагцхүү түүхэн өөрчлөлтийг мэдлэгийн өсөлтөөс хамаарах тэр л хэмжээгээр угтан хэлэх бололцоог няцаасан юм.

Поппер нацизмын эсрэг үзэлтэй байсан тул Австрид амьдрахад аюултай болсон. Энэ үед түүнд Кембрижийн их сургуулийн ёс зүйн ухааны факультет болон Шинэ Зеландын Кембергийн их сургуулийн коллежоос ажиллахыг урьсан хоёр урилга ирсэн ажээ. Поппер 1937 онд Австрийг орхин, Шинэ Зеланд руу цагаачилж, Кентербергийн их сургуулийн коллежид багшлах болсон байна. Тэрээр багшлахын зэрэгцээ фашизмын эсрэг тэмцэлд, тухайлбал тоталитар үзэл суртлын эсрэг идэвхтэй тэмцсэн юм.

1937 онд Шинэ Зеландын Кентербергийн их сургуульд уншсан лекцийнхээ үндсэн дээр “Диалектик гэж юу вэ?” өгүүллээ бичиж, 1940 онд Английн философийн “Mind” сэтгүүлд хэвлүүлсэн байна. Поппер энэ өгүүлэлдээ тоталитар сэтгэлгээний янз бүрийн хувилбаруудын арга зүй, үзэл баримтлалыг авч үзсэн юм. Диалектик бол танин мэдэхүйн түгээмэл логик хэрэгсэл ба хүч болж чадахгүй хэмээн Поппер шүүмжлээд, диалектикийн улмаас марксизм нь догматизм болж хувирчээ. Попперийн үзлээр “шинжлэх ухааны хөгжилд иймэрхүү догматизмаас илүү саад байхгүй. Бодол сэтгэлийг уралдуулахгүй бол шинжлэх ухааны хөгжил байж чадахгүй. Сэтгэхүйн чөлөөт байдалгүй бол шинжлэх ухааны үзэл чөлөөтэй уралдаж чадахгүй.

К.Поппер “Нээлттэй нийгэм ба түүний дайснууд” зохиолоо 1938-1943 онуудад Шинэ Зеландад бичсэн байна. “Нээлттэй нийгэм ба түүний дайснууд” зохиолын англи хэл дээрх эхний хэвлэл нь 1945 онд гарчээ. К.Поппер энэхүү зохиолдоо Гераклит,

Платонаас эхлэн Гегель, Марксыг хүртлэх үеийн нийгмийн болон улс төрийн философид түүхчлэх үзлийн нөлөөлсөн байнгын бөгөөд хөнөөлт нөлөөг илтгэн харуулсан байна. Поппер бүтээлдээ иргэд нь тайван амьдардаг, эрх чөлөөг өндрөөр үнэлдэг, хариуцлагатай сэтгэдэг, энэ хариуцлагыг баяр баясгалантай хүлээн авч биелүүлдэг ардчилсан нийгмийн даруухан хэлбэрийг хамгаалан бичжээ. Поппер "нээлттэй нийгэм" гэсэн ойлголтыг францын философич Анри Бергсоны 1935 онд хэвлүүлсэн "Ёс суртахуун ба шашны хоёр уг сурвалж" зохиолоос өвлөн авсан байна. Гэхдээ "нээлттэй нийгэм"-ийн тухай Бергсон болон Поппер нарын үзэл санаа нь их ялгаатай юм. Попперийн үзлээр "хаалттай нийгэм нь ид шидийн хориг цээр оршдогт итгэж, түүнд сүсэглэж байдгаар тодорхойлогдоно. Харин нээлттэй нийгэм бол хүмүүс нь хориг цээрт шүүмжлэлтэй хандаж, өөрсдийнхөө шийдвэрийг оюун ухааны бололцоо, хамтын зөвшилцөлд үндэслэн гаргаж сурсан нийгэм юм (3). Поппер янз бүрийн нийгэм-улс төрийн байгуулал бүхий Спарт, Прусс, хаант Орос, нацист Герман, ЗХУ зэрэг улсыг хаалттай нийгмийн, харин эртний Афин, орчин үеийн барууны ардчилсан орнуудыг нээлттэй нийгмийн жишээ болгон авч үзсэн. "Нээлттэй нийгэм бол иргэд нь тайван амьдардаг, эрх чөлөөг өндрөөр үнэлдэг, хариуцлагатай сэтгэдэг, энэ хариуцлагыг баяр баясгалантай хүлээн авч биелүүлдэг ардчилсан нийгэм бөгөөд ийм нийгэмд энхтайван, эрх чөлөө, найрамдлыг өндөр үнэлж, тэдгээрийг бодитой хэрэгжүүлэх боломж бүрдсэн байдаг. Нээлттэй нийгэм бол нийгмийн амьдралын бүх хүрээнд монополийг үгүйсгэж, олон ургальч үзлийг хэрэгжүүлдэг нийгэм юм. Чөлөөт зах зээл бол нээлттэй нийгэмд зайлшгүй байх бүрэлдэхүүн хэсэг мөн. Зах зээлийн эдийн засаг хөгжиж, хуулийг дээдлэн хүндэтгэдэг, ардчилсан замаар сонгогдсон засгийн газартай, иргэдийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцох бололцоог бүрэн хангасан, цөөнхийн санаа бодлыг хүндэтгэсэн байдаг зэрэг нь нээлттэй нийгмийн ерөнхий хэв шинжийг тодорхойлно. Попперийн үзлээр нээлттэй нийгмийн гол үзэл санаа нь хуулийн засаглалын үзэл санаа юм. Зах зээлийн харилцаанд үндэслэсэн, чөлөөт сонголт хийх өргөн боломж олгодог нийгмийг эрх зүйн системгүйгээр сэтгэхийн аргагүй юм.

Попперийн үзлээр дэлхий нийтийг хамарсан зөгнөл бололцоогүй. Хэдий тийм боловч Поппер "хэрэв бид хүн хэвээр үлдэхийг хүсч байвал бидний өмнө нээлттэй нийгэмд шилжих—цорын ганц зам байна" (4) гэсэн эрс дүгнэлт хийснээрээ өөрөө дэлхий нийтийг хамарсан нэгэн зөгнөл дэвшүүлсэн юм. Попперийн энэ зөгнөлийн гол агуулга нь хаалттай нийгмээс нээлттэй нийгэмд зайлшгүй шилждэг гэсэн баталгаа мөн. Учир нь: а) Поппер нийгмийн өөрчлөлт, хөгжилд ямар ч зүй тогтол үйлчлэхгүй, иймээс түүний хэтийн төлөвийн талаар урьдчилан төсөөлөл гаргах нь боломжгүй зүйл гэж үзэж ирсэн. Гэтэл хүн төрөлхтний хөгжлийн хандлагатай холбогдуулж өөрөө цорын ганц зам" —ын тухай дүгнэлт хийсэн нь хэрэг дээрээ зүй тогтлыг ч, хөгжлийн ирээдүйг ч хүлээн зөвшөөрсөн хэрэг болж байна. б) Танин мэдэхүйн онолын хувьд Поппер аливаа онол, онолын шинжтэй дүгнэхүйн үнэ цэнийг түүний рациональ шүүмжлэлээр няцаагдах боломж гэж үздэг. Гэтэл түүний "цорын ганц зам"-ын тухай дүгнэлт нь рациональ шүүмжлэлээр няцаагдах боломжоор хязгаарлагдмал байна.

К.Поппер нээлттэй нийгэмд шилжих арга замын талаар зориуд тусгайлан үндэслэсэн зүйл үгүй юм. Харин тэрээр нээлттэй нийгэмд саад болж буй үзэл санаа, улс төрийн хүчин зүйлийг тодорхой шүүмжилж тайлбарласан зүйл их бий. Тийм үндэслэл, нотолгоонууд нь чухамдаа нээлттэй нийгэмд шилжих онол, арга зүйн асуудалд холбогддог юм. Түүхчлэх үзлийн талаархи Попперийн шүүмжлэлт задлан шинжилгээ нь үндсэн агуулгаараа нийгмийн хөгжил өөрчлөлтийн арга, арга зүйн талыг хөндөж байгаа учраас Попперийн үзэл баримтлалын нэгдсэн системд түүнийг буулгаж үзвэл, яах аргагүй нээлттэй нийгэмд шилжих арга замын тухай асуудалд хамаарч байгаа юм.

"Нээлттэй нийгэм"-д шилжих гол арга зам бол "хаалттай нийгэм"-ийг инженерчлэх явдал гэж Поппер үзжээ. Иймээс нийгмийн өөрчлөлтийн талаархи Попперийн арга зүйн сургаалын нэг чухал ойлголт нь "нийгмийн инженерчлэл" юм. "Нийгмийн инженерчлэл"-ийн зорилт нь нийгмийн институтуудыг шинээр бий болгох, байгаа институтуудыг

өөрчлөн байгуулах, тэдгээрийг удирдах аргыг өөрчлөх зэрэгт оршино. Нийгмийн "нээлттэй" гэсэн ойлголт нь олон талт шинжтэй. Нээлттэй нийгмийн аспект бүр нь нийгмийн олон тооны институтуудыг шаардаж болдог. Энэ нь нийгмийн инженерчлэлийн хувьд хязгааргүй олон зорилтыг бий болгоно гэсэн үг.

Поппер бол нийгмийн хэсэгчилсэн буюу аажим, шаталсан инженерчлэлийн талыг баримтлагч юм. Попперийн үзлээр нийгмийн хэсэгчилсэн буюу аажим, шаталсан инженерчлэлийн давуу тал нь: нэгдүгээрт, хэсэгчилсэн инженерчлэлийн төслүүд нь нийгмийг бүхэлд нь бус, харин нийгмийн ямар нэгэн байгууллагын асуудлыг хөнддөг учраас харьцангуй хялбар, хоёрдугаарт, төслүүд үр дүн өгөхгүй бол түүнээс гарах хохирол бага, гуравдугаарт, гарсан хохирол, алдааг засаж залруулахад хялбар, дөрөвдүгээрт, ийм төслүүд нь эрсдэл багатай байдаг, тавдугаарт, "хэсгийн" аргыг хэрэглэснээр засаглалыг хуваарилах, рациональ шүүмжлэлийг өрнүүлэх бололцоотой болдог, зургадугаарт, олон хүний дэмжлэгийг хүлээдэг явдал юм.

Орчин үед нээлттэй нийгэмд шилжих шилжилт нь модернизацийн үйл явцаар дамжин хэрэгжиж байна. Модернизаци нь XX зууны дунд үеэс эхлэн уламжлалт нийгмийг орчин үеийн нийгэм болгох үйл явцыг тэмдэглэх агуулгатайгаар үүссэн бөгөөд өнөө үед модернизацийн үйл явц нь нийгмийн амьдралын олон талыг цогцолбор хамарсан үйл явц болон өрнөж, нийгэм нээлттэй, ардчилсан төлөв байдлыг олж хөгжих үндсэн механизм болоод байна.

Поппер 1946 онд Лондонгийн эдийн засаг-улс төрийн сургуулийн урилгаар Англид ирж, 1970-аад оны дунд үеэр тэтгэвэртээ гарах хүртлээ тус сургуульд багшилсан байна.

Поппер 1955 онд нийтлүүлсэн "Олон нийтийн санал ба либерализмын зарчмууд" өгүүлэлдээ олон нийтийн саналын талаархи хэд хэдэн домгийн зүйлийг ялган шинжилсэн байна. Хүмүүс янз бүрийн асуулга, санал асуулт, сонгууль зэрэгт оролцохдоо үнэхээр сайтар бодсон хувийн саналаа илэрхийлдэг гэсэн баталгааг зөвшөөрч болохгүй гэж Поппер үзсэн. Учир нь, олон нийтийн саналыг залилан залж болох юм. Олон нийтийн санал эзэн биегүй, хариуцлага хүлээдэггүйн улмаас зарим тохиолдолд аюултай гэдгийг Поппер цохон тэмдэглэсэн. Иймд хүмүүс саналаа чөлөөтэй илэрхийлэх нь нээлттэй нийгэмд зайлшгүй чухал боловч олон нийтийн саналыг зөвхөн харгалзан үзэх нь хангалттай биш гэсэн дүгнэлтийг Поппер хийсэн. Хүмүүс саналаа чөлөөтэй илэрхийлэх нь нээлттэй нийгэмд зайлшгүй чухал боловч энэ нь хангалттай биш. Хүн бүр ямар ч саналыг илэрхийлэх эрхтэй. Хэний ч санаа алдаатай байж болно. Гэтэл ард түмний санал алдаатай байвал яах вэ? Ард түмэн дарангуйлал тогтоохын төлөө саналаа өгвөл яах вэ? гэсэн асуулт зүй ёсоор гарч ирнэ. Хэрэв санал хураалтыг чөлөөтэй хийх юм бол ийм явдал тохиолдоно гэхэд хэцүү. Ийм тохиолдолд үндсэн хуульд нэмэлт буюу өөрчлөлтийн журмаар жирийн олонхиос илүү олны санал авсан байх ёстойгоор оруулах шаардлагатай.

Түүхэнд ард түмэн дарангуйллын төлөө саналаа өгөх явдал тохиолдож байсныг бид мартаж болохгүй. Өнөө үед олон хүн Гитлерийг хүч хэрэглэн, хүчирхийллийн замаар засгийн эрхэнд гарч ирсэн гэж ойлгодог. Гэтэл Гитлер ардчилал байхгүйгээс биш, ардчиллын бүтээгдэхүүн болж гарч ирсэн. Тэрээр ардчилсан сонгуулиар засгийн эрхэнд гарч ирсэн. Бусад ард түмнийг боолчлох үзэл нь түүнийг ард түмнийхээ дунд нэр хүндтэй болгосон. Гитлерийн хувьд ардчилал нь өнөөгийн олон хүмүүсийн адил зөвхөн засгийн эрхийг авах хэрэгсэл байсан. Германчууд хорон санаатайдаа Гитлерийг сонгосон юм биш, харин ардчилсан үйл явцад зайлшгүй шаардагдах нарийн ажиглах, бодож байж зөв сонголт хийх шалгуурыг давж чадаагүй юм. Энэ бол ардчиллын "цоорхой" буюу ардчиллын сул тал нь юм.

Попперийн харьцангуй сүүлийн үед бичсэн нэг өгүүлэл нь "Ардчилал ба ардын эрхт ёс" юм. Уг өгүүлэлдээ Поппер нээлттэй нийгмийн улс төрийн хэлбэрийн хувьд ардчиллын тухай өөрийн ойлголтоо хураангуйлан илэрхийлсэн байна. Попперийн ардчиллын тодорхойлолт нь олон зуун жил тогтсон ардчиллын онолоос эрс ялгаатай

юм. Платонаас эхлээд Маркс болон тэдний дараах үеийн хүмүүсийн хувьд төрийн эрхийг хэн барих вэ? гэдэг нь гол байсан. Платон бол "шилдэг сайчууд" (язгууртнууд) төрийн эрх барих ёстой гэж үзсэн. Маркс энэ асуултыг засгийн эрхийг хэн барих ёстой вэ? сайн санаатан уу, хорон санаатан уу, ажилчид уу, капиталистууд уу? гэсэн байдлаар тавьж байв. Поппер чухамхүү энэ асуудлыг өөр асуудлаар сольсон. Поппер энэ асуудлыг олиггүй эрх баригчаас цус урсгалгүй, хүч хэрэглэлгүй салахын тулд төрийг хэрхэн зохион байгуулах ёстой вэ? гэсэн байдлаар томъёолсон байна. Поппер уг өгүүлэлдээ: "Миний онол бол үзэл санааг бус, ажил практикийг тодорхойлон өгүүлэхийг хичээдэг. Иймд түүнийг "ардчиллын онол" гэж нэрлэж бүрэн болно. Гэхдээ энэ бол "ардын эрхт ёсны" онол огт биш, засгийн газрыг жирийн олонхийн саналаар цус урсгалгүй тараахыг үндэс болгодог хууль эрх барих онол юм" (5) гэж бичжээ. Попперийн хувьд ардчилал бол засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих хэрэгслийн цогц болохоос биш, олонхийн ноёрхол биш юм. Мөн тэрээр, чөлөөт институтууд болон засгийн газраа огцруулах, хүчирхийлэл хэрэглэхгүйгээр шинэчлэл хийх, чөлөөт сонгууль зэргийг ардчилалд багтаан үзсэн.

К.Поппер нь 1978 онд Венийн их сургуулийн байгалийн ухааны доктор цол, Английн хатан хаанаас тайж хэргэм хүртэж, 1992 онд Их Британи даяар Попперийн 90 насны ойг тэмдэглэсэн билээ.

Попперийн үзэл санааг орчин үед сурталчилах, дэлгэрүүлэх үйлсэд Нээлттэй Нийгэм Хүрээлэнг үүсгэн байгуулагч Жорж Сорос ихээхэн хувь нэмэр оруулж буй хүн юм. Сорос 1947 онд Будапештаас Англид цагаачлан гарч Лондоны эдийн засгийн сургуулийг төгсчээ. Тэрээр Лондонд оюутан байхдаа философич Карл Попперийн бүтээлийг уншиж судалсан нь түүнд ихээхэн нөлөөлж, хожим багшийнхаа үзэл санааг, түүний дотор нээлттэй нийгмийн санааг хэрэгжүүлэн олны хүртээл болгох үйл хэрэгт нь чухал түлхэц болсон байна. Соросын сан нь нээлттэй нийгмийг хөгжүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх нийтлэг зорилготой юм. Нээлттэй Нийгэм Хүрээлэн өөрийн үзэл санааг "Нээлттэй нийгэм нь үнэний монополий хэнд ч байдаггүй, хүмүүс өөр өөрийн ялгаатай үзэл бодол, сонирхолтой байх эрхтэй бөгөөд тэдэнд энх амгалан хамтдаа аж төрөх бололцоо олгох, хүний эрхийг хамгаалах бүтцийг бий болгох шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр байгуулсан нийгмийн зохион байгуулалтын нэгэн хэлбэр юм. Өөр утгаараа нээлттэй нийгэм гэдэг нь хуулийг хүндэлсэн, ардчилсан замаар сонгогдсон засгийн газартай, цөөнхийн эрх ашиг, санал бодлыг хүндэтгэсэн олон ургальч үзлийн зарчимд тулгуурласан нийгмийн зохион байгуулалтыг хэлнэ" хэмээн олон түмэнд сурталчилдаг юм.

Попперийн архивыг хадгалж хамгаалах, хэвлүүлж амжаагүй бүтээлүүдийг хэвлэж олны хүртээл болгоход Будапешт дэх Төв Европын Их сургуулийн Поппер төслийн ажилтан Марк Ноттурно, Кира Викторова (6) нар их ажил хийж байгаа юм. Попперийн нээлттэй нийгмийн үзэл санааг задлан шинжлэх, дэлгэрүүлэхэд Оросын нийгэм судлаачид тухайлбал, В.А.Лекторский, Н.В.Овчинников, Н.С.Розов, В.Н.Садовский, Н.С.Юлина нар их хувь нэмэр оруулжээ (7).

Монголын философичид, судлаачид 90-ээд оноос өмнөх үед Попперийн философид марксизмыг хамгаалах байр сууринаас хандаж ирсэн бол түүнээс хойшхи хугацаанд түүний эерэг болон зөрчилтэй талыг илрүүлэхэд илүү анхаарах болсон. Манай оронд Попперийн зохиол бүтээлийг орчуулж олон нийтэд толилуулах, сурталчлах ажил ижил түвшний хөгжилтэй бусад оронтой харьцуулахад илүү ахицтай явагдаж байна. Тухайлбал, Попперийн "Ардчилал ба ардын эрхт ёс" (Бодрол бясалгал. 1993. №1-2), "Түүхчлэх үзлийн гуйланчлал" (1996. Ү.Нямдорж, Д.Баттөмөр нарын орч.), "Диалектик гэж юу вэ?" (Эрх чөлөө ба философи. УБ., 1999. IV. Д.Баттөмөрийн орч.), "Бие оюун ухаан хоёрын харилцан үйлчлэлийн асуудал хийгээд мэдлэг" (I бүлэг. Эрх чөлөө ба философи. УБ., 1998. III. М.Отгонбаярын орч.), "Математик дахь төгсгөлгүй прогресс" (1997. Д.Баттөмөрийн орч.) зохиолууд монгол хэлнээ гарсан юм.

Үүнээс гадна Попперийн философи, нийгэм-улс төрийн үзэл баримтлалыг тайлбарласан нэлээд хэдэн өгүүлэл нийтлэгдсэн байна. Тухайлбал, Д.Баттөмөр "К.Попперийн фальсификацийн зарчим" (Шинэ толь. 1994. №4), Д.Баттөмөр "Объектив

мэдлэгийн тухай К.Попперийн үзэл баримтлалын эхлэл" (Шинэ толь. 1994. №2), Д.Баттөмөр "К.Попперийн боловсруулсан арга зүйн зарчмын эх сурвалж, түүний философийн нөлөө" (Эрх чөлөө ба философи. УБ., 1999. II) Д.Баттөмөр "Логик ба диалектик" (Эрх чөлөө ба философи. УБ., 1999. IV) зэргийг дурьдаж болох юм. К.Попперийн философийн үзэл баримтлалд дүн шинжилгээ хийх, бүтээлээс нь орчуулах, тэдгээрийг олон түмэнд сурталчлах үйлст манай судлаачдын дотроос философийн ухааны доктор асан Д.Баттөмөр их зүйл хийснийг энд онцлон тэмдэглэмээр байна.

Ишлэл авсан ном

- [1] К.Поппер. Диалектик гэж юу вэ? Эрх чөлөө ба философи. УБ. 1999. IV. 26 дахь тал
- [2] К.Поппер. Түүхчлэх үзлийн гуйланчлал. УБ., 1996. 14 дэх тал
- [3] К.Поппер. Открытое общество и его враги. т. I. М., 1992. с. 251
- [4] К.Поппер. Открытое общество и его враги. т. I. М. 1992. с. 220.
- [5] К.Поппер. Ардчилал ба ардын эрхт ёс. Бодрол бясалгал. 1993. №1. 26 дахь тал
- [6] М. Ноттурно. Критика К.Поппером научного социализма или Р.Карнап и его сотрудники. М., "Вопросы философии" 1995. №12, Notturmo. M. Science and open society. Budapest. 1997, Kira Viktorova. Translating Piecemeal Engineering. Popper Work shop. 1995
- [7] В.А.Лекторский. Открытое общество и принципы либерализма. Вопр. филос. 1996. №5, Н.В.Овчинников. Карл Поппер наш современник, философ XX века. Вопр. филос. 1992. №2, Н.С.Розов. Возможность теоритической истории: ответ на вызов Карла Поппера. Вопр. филос. 1995. №2, В.Н.Садовский. О Карле Поппере и судьбе его учения в России. Вопр. филос. 1995. №10, В.Н.Садовский. Карл Поппер, Гегелевская диалектика и формальная логика. Вопр. филос. 1995. №1, Н.С.Юлина. "Эмерджентный реализм" Карла Поппера. М., 1981.

Ш.Содном

Доктор (PhD), профессор.

Посткоммунист шилжилт: үзэл баримтлал ба үйл явц

Нийгмийн дэвшлийн динамик шинж чанар нь нийгэм эдийн засгийн нэг тогтолцооноос нөгөөд хувьсалын хийгээд хувьсгалын замаар шилжих хөдөлгөөнөөр илүү тодорхой илэрдэг. Үүнийг нийгмийн шилжилт, шилжилтийн үе хэмээх ойлголтоор илэрхийлдэг нь түгээмэл зүйл. Өнөөдөр энэ үйл явцыг судалдаг транзитологи (шилжилт судлал) хэмээх мэдлэгийн тусгай салбар нэгэнт бий болсон байна. Транзитологи бол тоталитар болон авторитар дэглэмээс ардчилалд шилжиж буй улс орнууд дахь улс төрийн үйл явцыг судалдаг улс төрийн шинжлэх ухааны салбар юм. Тэрээр улс төрийн модернизацийн онолын зарим сул талыг залруулан засах зорилгоор 70-аад оны эхэн үед үүссэн боловч онол, арга зүйн ерөнхий зарчмын хувьд түүнтэй ойролцоо юм.

Гэвч улс төрийн модернизацийн онол "гурав дахь ертөнцийн" хөгжиж буй орнуудын нийгмийн шинэчлэлтийн асуудлыг голлон авч үздэг бол транзитологи нь орчин үеийн нийгмийн үндсэн бүтэц бүхий бөгөөд ардчилалд дахин шилжиж буй улс орнууд дахь улс төрийн үйл явцыг шинжлэн судалдаг. Ардчилсан дэглэм урьд нь оршин тогтож байсан улс орныг ардчилах тухай асуудал дэлхийн хоёрдугаар дайны дараа Герман, Итали дахь тоталитар фашист дэгмэм, Японы авторитаризм, милитаризмын үр дагаварыг арилгах, нийгмийг дахин шинэчлэх шаардлагатай холбогдон анх тавигдсан байна. Ийм асуудал мөн авторитар засаглалын үеийн дараа ардчилсан зарчимд буцаж шилжсэн Өмнөт Европын Испани, Португали ба Грек улсуудад давтагдсан юм. Тэрчлэн цэргийн диктатур ардчилсан сонгуулиар гарч ирсэн засгийн газруудад байраа тавьж өгсөн Латин Америкийн орнуудад ч иймэрхүү шилжилт хэрэгжсэн билээ. Энэ нь Ази-Африкийн орнуудад уламжлалт тогтолцоог халж ардчилал цоо шинээр үүсэн тогтож нийгмээ барууны хэв загвараар шинэчлэх үйл явцаас зарчмын хувьд өөр асуудал бөгөөд өөрөө хэлбэл ардчилсан тогтолцоонд эргэж шилжих, нийгмийг дахин ардчилах тухай асуудал юм. Юрген Хабермас үүнийг "хоцорсныгоо нөхөх" хувьсгал хэмээн нэрлэсэн байдаг.

XX зууны 70-аад оны дунд үеэс чухамдаа дэлхийн бараг бүх тив, бүс нутгийг хамарч байсан ардчилсан бус дэглэм нуран унах үйл явц эрч хүчээ авч глобалъ шинжтэй боллоо. С. Хантингтон "Ардчиллын гурав дахь давалгаа" гэж нэрлэсэн энэ үйл явцын оргил нь болж 80-90 оны заагаар ЗХУ болон социалист системийн орнуудад коммунист дэглэм задарч унав. Энэ үеэс посткоммунист хөгжлийн үйл явц нь транзитологийн судалгааны гол объект болсоор байна. Эхэн үедээ социалист байсан орнуудад ардчилсан дэглэм тогтон бүрэлдэх, зах зээлийн харилцаанд шилжих тухай асуудлыг улс төрийн модернизацийн онолын үзэл баримтлалын уламжлалт хандлагуудад тулгуурлан судлаж байлаа. Эдгээр нь хамгийн ерөнхий байдлаараа улс төрийн ардчилал, зах зээлийн эдийн засаг хоёр органик, салшгүй холбоотой; ардчилалд шилжихийн тулд техник технологийн хийгээд нийгэм соёлын, нийгэм эдийн засгийн хөгжлийн тодорхой түвшин зайлшгүй чухал; ардчилалын нийгмийн бааз суурь нь нийгэмд зонхилох байдалтай дунд анги мөн; иргэний нийгэм бүрэлдэн төлөвшихгүйгээр ардчилал үүсэн тогтнох бололцоогүй хэмээн үздэг онолын баримтлалууд байв. Посткоммунист орнуудад эдийн засаг, улс төрийн шинэ институтууд батжин бэхжих хэтийн төлөвийг Герман, Итали, Өмнөт Европ ба Латин Америкийн орнуудын посттоталитар, поставторитар хөгжлийн туршлагаар тайлбарлаж байлаа.

Харин өнөөдөр посткоммунист шилжилтийн үйл явцыг судалж буй барууны улс төр судлаачдын дунд үзэл баримтлалын зарим ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, А.Лейпхарт, Ф.Шмиттер нарын эрдэмтэд Дорнод Европын орнууд болон посткоммунист орон зайд өнөөдөр явагдаж байгаа үйл явц хичнээн онцлогтой байлаа ч тэр нь

"ардчилалын гурав дахь давалгаанд" татагдан орсон бусад бус нутгууд дахь үйл явц, үзэгдлүүдтэй адил юм гэж үзэж байна.¹ Харин Америкийн судлаач В.Барнс, С.Терри нар дорнод Европ дахь үйл явц Латин Америкийнхаас ч ялгаатай, тэнд ардчилалыг сэргээн тогтоох тухай ауудал яригдахгүй. Посткоммунист орнуудад эрх зүйт төр болон ардчиллын бусад институтуудыг сэргээн тогтоож байгаа биш харин цоо шинээр бий болгож байна. Эдийн засгийн хүрээнд ч мөн адил эдийн засгийн өмнөх тогтолцоог засаж сайжруулж байгаа бус харин зах зээлийн эдийн засгийн шинэ тогтолцоог бүрдүүлж байна гэжээ.

Америкийн улс төр судлаач С.Терри посткоммунист орнуудад тулгарч байгаа асуудлууд нь урьд өмнө тоталитаризм, авторитаризмаас ардчилалд шилжсэн орнуудад хэрэгжүүлсэн зорилтуудаас наад зах нь дараах зүйлээр ялгаатай гэж үзжээ.² **Нэгдүгээрт**, посткоммунист орнуудад зах зээлийн эдийн засаг, плюраль ардчилал хоёрыг нэгэн зэрэг бий болгохыг эрмэлзэж байна. Өнөөг хүртэл нэг ч авторитар ба тоталитар систем коммунист улсуудынх шиг эдийн засгийн нийгэмчлэл, хэт төвлөрөлийг үзээгүй. Зах зээлийн аж ахуй, ардчилалын тогтвортой системийг нэгэн зэрэг бүрдүүлэх гэсэн эрмэлзэл нь посткоммунист шилжилтийн дотоод зөрчилт байдлыг бий болгож байна. Ардчилал, зах зээл хоёр түүхэн хэтийн төлөвийн хувьд харилцан бие биенээ нөхөн бэхжүүлж баталгаажуулдаг ч социалист байсан орнуудын шинэтгэлийн өнөөгийн шатанд тэдгээр нь өөр хоорондоо зөрчилдөж нэг нь нөгөөдөө бэрхшээл хүндрэл учруулж байна. Тухайлбал, эдийн засгийн радикаль шинэтгэл хүн амын амьжиргааны төвшин ихээхэн буурахад хүргэж, зах зээлд шилжих шилжилтийн эхэн үеийн бэрхшээл зовлон нь улс төрийн тогтворгүй байдлыг бий болгож тэр нь улмаар эдийн засгийн цаашдын шинэтгэлийн эрх зүйн хийгээд институциональ үндэс суурийг буй болгоход бэрхшээл учруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад саад болж, эдийн засгийн уналтын үргэлжлэх хугацааг уртасгаж байна. Эдийн засгийн уналт эргээд улс төрийн хурцадмал байдлыг гүнзгийрүүлж байна.

Хоёрдугаарт, эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжлөөр хоцрогдсон улс орнууд ардчилалд шилжихэд улс ардын аж ахуйн салбаруудыг шинээр бий болгох зорилт тавигддаг. Харин посткоммунист орнуудад олон үйлдвэр аж ахуйн газруудыг өөрчлөн байгуулах, техник технологийн хувьд шинэчлэхийн зэрэгцээ аж үйлдвэрийн салбарын нэлээд хэсгийг бүрэн задлах асуудал тавигдсан юм.

Гуравдугаарт, америкийн судлаач С.Терри поставторитар, посткоммунист шилжилтийн үйл явцуудын хоорондын ялгааг иргэний нийгмийн асуудалтай холбож үзсэн байна. Тэрээр Дорнод Европ болон хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улс орнуудын өнөөгийн бодит байдалд иргэний нийгэм гэсэн ойлголтыг хэрэглэх нь ихээхэн эргэлзээтэй зүйл. Иргэний нийгэм нь улс төр, олон нийтийн байгууллагууд төрөөс тусгаар, бие даасан байдалтай оршин байхыг төдийгүй тэдгээр нь тодорхой хүрээ хязгаарын дотор харилцан үйлчлэх чадвартай байхыг шаарддаг. Үйл ажиллагааны хууль ёсны болж институтжсэн хүрээ хязгааргүй, нийгмийн бүлгүүд ба лидерүүд нийтлэг дүрэм журмыг дагаж мөрдөхөд бэлэн биш байгаа цагт улс төрийн тогтолцоо тогтворгүйжин тамирдаж үйл ажиллагаа явуулах боломжгүй болдог гэжээ.

Посткоммунист орнуудад иргэний нийгэм бодитойгоор бүрэлдэн төлөвшихөд үлэмжхэн саад бэрхшээл учирч байна. Эдгээр орны дийлэнхэд нь коммунист дэглэм тогтохоос өмнө иргэний нийгмийн зарим элементүүд байсан хэдий ч тэр нь боловсронгуй хэлбэрээ олоогүй байв. Нөгөө талаас өмнөх үеийн оппозиц бүлгүүдийн улс төрийн бодит практик болон коммунист засаглалын жилүүдийн улс төрийн туршлага нь улс төр бол "хамтын боломжийг хэрэгжүүлэх урлаг" гэсэн ойлголтыг нийгэмд бий болгож чадаагүй. Иймээс ч посткоммунист орнууд дахь улс төрийн үйл явц нэгдмэл бус, хэсэг бусад бөгөөд хэт бодгальчлагдсан, урьдын адил зөрчил мөргөлдөөн

¹ Лейпхарт А. Демократия в многосоставных обществах: сравнительное исследование. М., 1997; Arend Lijhart. Democracies. Patterns of Majoritarian and Consensus Government in Twenty-One Countries. New Heaven-London, 1984. p.1-20.

² Политология (проблемы теории). Санкт-Петербург, 2000. Стр. 337-339.

нь эвлэрэл зөвшилөөс давамгайлсан, сонгогч олон түмэн итгэл алдаж хүнийссэн байдалтай байна.

Дөрөвдүгээрт, посткоммунист ихэнх орнуудын үндэстэн угсаатны бүтэц нэг төрлийн бус, олон янз байдалтай юм. Энэ нь коммунист дэглэмийн дараах үзэл суртлын хоосон орон зайд үндэсний үзэл санаа өргөн тархахад хүргэсэн. Национализмын ямар ч хэлбэр ардчилалтай төдийлөн зохицдоггүй тиймээс ч нэг үндэстнийг нөгөөгөөс нь дээгүүр тавих, ялгаварлах, угсаатны шинжээрээ нийгэм задрах, салан туслах процесс хүчтэй явагдсан байна.

Тавдугаарт, посткоммунист шилжилтийн үйл явц олон улсын нөхцөл байдлын хувьд ч ялгаатай юм. Дайны дараах үеийн Герман, Итали 70-аад оны үеийн Өмнөд Европын улс орнуудын хувьд нөхцөл байдал илүү таатай байв. Эдгээр орнууд шилжилтийн үеийн хүндрэлтэй асуудлууд, ялангуяа эдийн засаг санхүүгийн бэрхшээлийг шийдвэрлэхдээ барууны өндөр хөгжилтэй орнуудын тусламжинд тулгуурласан бол посткоммунист орнууд зайлшгүй шаардлагатай гаднын тусламж дэмжлэг төдийлөн авч чадахгүй байна гэж үзсэн байна.

Посткоммунист орнууд дахь шилжилтийн үргэлжлэх хугацаа, үе шатны талаарх анхны ойлголт төсөөлөл ч чухамдаа өмнөх үеийн поставторитар шилжилтийн туршлага дээр тулгуурлаж байлаа. Тийм ч учраас аж үйлдвэр харьцангуй өндөр хөгжсөн Дорнод Европын орнууд болон Зөвлөлт Холбоот Улсын хувьд зах зээлийн эдийн засаг, тогтвортой ардчилалд шилжих үйл явц богино хугацаанд хэрэгжихээр таамаглаж байв. Энэ шилжилт нь Модернизацийн онолын уламжлалт үзэл баримтлалаар бол "ардчилалд шилжих", "ардчиллыг баталгаажуулж бэхжүүлэх" гэсэн хоёр үндсэн үе шаттай байх ёстой байлаа. Эдгээр ойлголт, дүгнэлтүүд өнөөдөр посткоммунист орнуудад хэрэгжиж буй эдийн засаг, улс төрийн шинэчлэлтийн бодит практикаар тодотгогдон шинэчлэгдэж байна.

Америкийн судлаач Л.Шин посткоммунист нийгмийн шилжилтийн дөрвөн үе шатыг нэрлэсэн байна. Үүнд: 1) тоталитар тогтолцоог эвдэн нураах, 2) ардчилсан тогтолцоонд шилжих, 3) Ардчилсан тогтолцоог бататган бэхжүүлэх, 4) ардчилсан институтууд төгс боловсронгуй болох үе шатууд байна гэжээ.³ Д.Растоу ардчилалд шилжих шилжилтийг : 1) "бэлтгэл шат", гол онцлог нь энэ үед плюрализм биш харин ашиг сонирхлын ялгарал хүчтэй байна. 2) "шийдвэр гаргах шат"-ардчилсан тохиролцоонд хүрч хэм хэмжээ, дүрэм журмаа батлан гаргаж, шинэчлэлтийг хэрэгжүүлэх, 3) "хэлбэршин төлөвших шат"-ардчилсан үнэт зүйлс, институт батжин бэхжих шат байна гэж үзжээ. Д.Растоугийн үзэж байгаагаар ардчилах үйл явцыг хэрэгжүүлэхэд хамгийн гол нь улс төрийн элитүүд зөвшилцөлд хүрсэн байх явдал юм. Ийм ч учраас тэрээр ардчилсан тогтолцоонд шилжих үйл явцын үе шатуудын дарааллыг "үндэсний эв нэгдэлээс, зөвшил, дасал зохицлоор дамжин ардчилалд хүрэх байдлаар тогтоосон байна."⁴

Г.Доннел, Ф.Шмиттер⁵ нар ардчилсан шилжилтийг мөн гурван үе шаттайгаар төсөөлж байв. Үүнд: 1) Либеральчлах-засаглалын аппаратыг өөрчлөхгүйгээр иргэдийн эрх чөлөө институтжих, үүний үр дүнд "асрамжийн ардчилал" /засаглалын хуучин аппарат ялангуяа цэргийнхний халамж хамгаалалтын дор ардчилсан институтууд бүрэлдэн/ бий болох үе, 2) Ардчилах - ардчилсан хэм хэмжээ, дүрэм журам институтжих үе. Энэ нь нэг талаас авторитар дэглэмийг задалж, улс төрийн хүчнүүд ардчилсан институт ба процедурыг ухамсартайгаар сонгох явдлаас, нөгөө талаас, ардчилах үйл явцад улс төрийн засаглалын өмнөх бүтэц бүрэн өөрчлөгдөж чөлөөт, өрсөлдөөнт сонгуулиар улс төрийн ардчилсан системийн үндэс суурь тавигдах явдлаас

³ Политология (проблемы теории). Санкт-Петербург, 2000. Стр. 339.

⁴ Растоу Д.А. Переходы к демократии: попытка динамической модели // Полис. Г.2000, 1996. № 5-14.

⁵ O' Donnell G., Schmitter Ph. Transition from Authoritarian Rule. Tentative Conclusions About Uncertain Democracies. Baltimore, 1986.

хамаарна, 3) Иргэд дахин нийгэмших-шинээр ардчилсан хэм хэмжээ, үнэт зүйлсийг эзэмших үе байна гэж үзсэн байна.

Судлаач А.Пшеворски⁶ хоёр үе шат бүхий загварыг санал болгосон байна. Нэгдүгээр үе шат болох либеральчлал нь нийгмийн амьдралын тогтворгүй байдал, үйл явцын олон чиглэлт /доороос, дээрээс үүдэлтэй/ шинжээр тодорхойлогдоно. Үйл явцын өрнөлтөөс шалтгаалан авторитар дэгмэм дахин хүчтэй болох эсвэл ардчилалын эхний алхам хийгдэх нь энэ үе шатны үр дүн мөн. Хоёрдахь үе шат болох ардчилах үйл явц нь "авторитар дэглэмээс ангижрах", "ардчилсан засаглалыг хуульчлан баталгаажуулах" гэсэн хоёр хэсэгтэй байна. Авторитар шинэчлэгчид ба сөрөг хүчин дотооддоо болон өөр хоорондоо зөвшилд хүрч чадсанаар ардчилах үйл явц харьцангуй зовлон бэрхшээл багатай хэрэгжих бололцоотой гэсэн байна.

3.Бжезинский посткоммунист шилжилтийн улс төр, эдийн засгийн талыг харгалзан үзэх үндсэн дээр нийгмийг ардчилах, зах зээлийн эдийн засаг бүрэлдэн бий болох үйл явцыг гурван шаттайгаар авч үзсэн байна. **Нэгдүгээр шат нь** коммунист дэглэм нуран унах үйл явцаар эхлэх бөгөөд энэ үеийн гол зорилт бол улс төрийн засаглалын дээд бүтцэд шинэчлэл хийх, эдийн засгийн уналтыг сааруулах, тогтворжуулах анхны алхамуудыг хэрэгжүүлэх явдал юм. **Хоёрдахь шат** бол ардчилсан тогтолцоо бүрэлдэн бий болж баталгаажих үе байна. Шинэ үндсэн хуулийг батлан гаргах, сонгуулийн шинэ системийг баталгаажуулж мөрдөх, нийгмийн практикт ардчилсан процедур, хэм хэмжээг нэвтрүүлэх нь энэ үеийн тулгамдсан зорилт болно. Улс төрийн шинэчлэлтэй уялдаад эдийн засгийн хүрээнд ихээхэн өөрчлөлт гарна. Юуны өмнө банкны сектор бий болж, өмчийн эрхийг хуулиар баталгаажуулах үндсэн дээр төрийн өмчийн монополь байдлыг устгаж бага, дунд хувьчлал хийгдэнэ гэж үзсэн байна. Тэрээр ардчилсан соёлд тулгуурлан улс төрийн институтууд хэлбэршин төлөвшиж, эдийн засгийн өсөлт тогтворжсоноор шилжилтийн гуравдахь шат эхлэнэ. Шилжилтийн нэгдүгээр шат 1-5 жил, хоёрдахь шат 3-10 жил, гуравдахь шат нь 5-15 жил түүнээс ч илүү хугацаанд үргэлжилж болох юм гэжээ.

Авторитар, тоталитар дэглэмээс ардчилалд шилжих шилжилтийн дээрх загварууд нийтлэг давуу ба сул талтай юм. Тэдгээрийн давуу тал нь, **нэгдүгээрт**, ардчилсан шинэчлэлтийн хувилбаруудыг томъёолж, тэдгээрийн хэрэгжих нөхцөл боломжийг ямар нэг хэмжээгээр тодорхойлсон, **хоёрдугаарт**, нийгэм, улс үндэстний дотоод эв нэгдэл, улс төрийн элитүүдийн зөвшилцлийг шилжилтийн аль нэг үе шатны нэн чухал нөхцөл, гол агуулга гэж үзсэн явдал юм. Гэвч онолын ихэнх загварууд тухайлсан нэг орны юмуу цөөн хэдэн орны /ихэвчлэн Төв ба Дорнод Европын/ жишээн дээр боловсрогдсон учир ардчилсан бус засаглалаас ардчилалд шилжих шилжилтийн универсал загвар болж чадахгүй юм.

Пост коммунист орнууд дахь шилжилтийн үеийн эдийн засаг, улс төрийн шинэтгэлийн харьцааны асуудал, барууны судлаачдын анхаарлыг ихээхэн татаж байна. Асуудлын гол нь зах зээлийн эдийн засаг ба ардчилалд нэгэн зэрэг шилжих "хосолмол шилжилт" юм. Нилээд судлаачид тэдгээр орны хүн амын үндсэн хэсэг нь коммунист дэглэмийг эсэргүүцэн тэмцэхдээ үзэл санаа, улс төрийн шинжтэй асуудлаас илүү нийгэм эдийн засгийн шалтгааныг гол болгосон. Тиймээс амьжиргааны түвшингийн бууралт, хүн амын өргөн давхаргын материаллаг аж байдлын доройтол нь постсоциалист орнуудад нийгэм улс төрийн системийн нь хувьд ардчилалд итгэл алдах, үл итгэх байдлыг бий болгож байна.

Энэ нь **нэгдүгээрт** ардчиллын эсрэг барууны болон зүүний хүчнүүд идэвхжих, **хоёрдугаарт**, эрх баригчдын зүгээс ард олны дотор үүсч болох тэмцэл хөдөлгөөнөөс болгоомжилж ардчиллын эрх, эрх чөлөөг хязгаарлах, **гуравдугаарт**, шинэ авторитар дэглэм тогтоход хүргэх аюултай гэж үзэж байна. Нийгэм улс төрийн ийм тааламжгүй

⁶ См: Przeworski A. Democracy and the Market: Political and Economic Reforms in Eastern Europe and Latin America. Cambridge, 1991. Ch.2.

нөхцөл байдлаас зайлсхийж эдийн засгийн эмх замбараагүй байдлын үеийг түргэтгэхийн тулд нэг бол "муужруулах эмчилгээний" аргыг хэрэглэх эсвэл үйлдвэрлэл уналтын доод цэгтээ хүртэл эдийн засгийн реформыг хойшлуулахыг санал болгож байлаа. Мөн улс төр, эдийн засгийн шинэ реформыг нэгэн зэрэг явуулахаас татгалзахыг зөвлөмж болгодог хандлага ч байсаар байна. Тэд 1) ардчилах үйл явцаас урьтаж эдийн засгийн реформ хийх; 2) эхлээд улс төрийн иж бүрэн реформ хийж, түүнийгээ инсититужин бэхжсэний дараа эдийн засгийн өөрчлөн байгуулалтыг хэрэгжүүлэх гэсэн хоёр арга замын аль нэгийг нь сонгож болно гэж үздэг.

Нэг дэх арга замыг дэмжигчид эдийн засгийн реформ нь хүчтэй авторитар засаглалын үед боломжтой бөгөөд төрөөс эрс шургуу, шийдвэртэй, онцгой үйл ажиллагааг явуулахыг шаарддаг гэдгийг иш үндэс болгодог. 70-аад оны үеийн улс төрийн модернизацийн онолын консерватив чиглэлд тусгалаа олж байсан ийм үндэслэл өнөөдөр маргаантай байна.

Европ, Латин америк, Азийн орнуудын ардчилал, зах зээлд шилжсэн туршлагыг харьцуулан судалсан судалгаа ч эдийн засгийн модернизацийн авторитар арга зам үр ашигтай эсэх тухай асуудалд нэгдмэл утгатай хариулт өгч чадахгүй байна. Мэдээжээр авторитар дэглэмийн үед зах зээлийн өөрчлөн байгуулалтыг амжилттай хийх, улмаар энэ дэглэмийг либералчлах, ардчилах боломжийг үгүйсгэх аргагүй. Зарим судлаачид зах зээлийн эдийн засгийн харилцааг бий болгох талаар ихээхэн амжилт олж буй коммунист Хятад улс нь коммунист дэглэмийг халсан боловч эдийн засгийн дорвитой амжилт олж чадаагүй байгаа улс орнуудаас хэтийн төлөвийн хувьд илүү ардчилсан улс төрийн тогтолцоог бий болгох боломжтой байна. Коммунист эдийн засгийн хүрээнд уналт эхэлж байх үед коммунист дэглэмийг либералчлахаар Горбачевийн санаачилсан өөрчлөн байгуулалт нь зах зээлийн реформ хийх нарийн бодож боловсруулсан төлөвлөгөөгүйн улмаас л амжилтанд хүрч чадаагүй гэж үздэг байна.

Гэвч эдийн засгийн либералчлалыг авторитар аргаар хэрэгжүүлэх асуудлын тухайд өрнөдийн гол гол улс төр судлаачид, эдийн засагчид үүнээс зарчмын өөр байр суурьтай байна. Тэд **нэгдүгээрт**, ихэнх авторитар засгийн газрууд практик дээр эдийн засгийн либералчлалыг хэрэгжүүлэх чадваргүй юм; **хоёрдугаарт**, авторитар дэглэм бүхий ямар ч засгийн газар хүний эрх, чөлөөт үйл ажиллагаа, ардчиллын хөгжилд түлхэц үзүүлэх чадваргүй. Тиймээс улс төрийн өөрчлөлт бол төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих чухал урьдач нөхцөл гэж үздэг. Тухайлбал АНУ-ын судлаач Х.Линц, А.Штепан⁷ нарын үзэж байгаагаар Оросод улс төрийн шинж чанар бүхий өөрчлөлтөөс эдийн засгийн шинэчлэлтийг чухалчилж, Үндсэн хуулиа шинэчлэх, парламентын шинэ сонгууль хийх, улс төрийн ардчилсан шинэ нам байгуулах зэрэг улс төрийн тулгуур өөрчлөлтүүд хийлгүй цаг алдсанаар Оросын ерөнхийлөгч Б.Ельцин түүний талынхан 1991 онд ноцтой алдаа гаргасан. Үүний үр дүнд Оросын эдийн засаг ч, төр ч, ардчилал ч суларсан. Посткоммунист Оросын орчин үеийн хөгжлийн удаа дараагийн хямралууд нь улс төрийн мэдлэг, туршлагаар бага, залуу эдийн засагчдын гэнэн алдаатай тогтолцооноос болж ардчиллын хөгжлийн алс хэтийн зорилт хохирсноос үүссэн байна.

Транзитологи ардчилалд шилжих шилжилтийг нэг чиглэлт, шугаман бус харин эргэлт буцалт ч тохиолдож болох бэрхшээлтэй нарийн төвөгтэй үйл явц гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Энэ шилжилтийн үед олон нийтийн үнэлэмжийн өөдрөг шийдэмгий байдал, бас гутрангуй, үл итгэх үзлийн аль ч давамгайлах хандлагатай байж болно гэж үздэг. Барууны транзитологичдын үзэж байгаагаар посткоммунист нилээд оронд ардчилсан ирээдүйнхээ талаар пессимист үнэлэмж давамгайлж байна. Үүнээс болж тэдгээр оронд ардчилсан хөгжлийнхөө чиг баримжаанаас татгалзаж, коммунист дэглэм эргэн тогтох аюул учирч болохоос гадна авторитаризмын элементүүдийг өөртөө агуулсан үндэсний (дарангуйлал) диктатур нилээд урт хугацаагаар оршин тогтнох боломжтой гэж үздэг. Тухайлбал Ф.Шмиттер посткоммунист орнуудад баталгаажаагүй,

⁷ Linz J., Stepan a. Problems of Democratic Transition and Consolidation: Southern europe, South America and Post-Communist Europe. Baltimore-London, 1996. P.3.

тогтонги байдалтай, бүрэн бус ардчилал бий болох нь илүү магадлалтай. Өөрөөр хэлбэл өнөөгийн шилжилтийн нөхцөл байдал харьцангуй урт хугацаанд хадгалагдаж үлдэнэ гэж үзэх нь бодитой бөгөөд энэ нь посткоммунист орнуудад капиталист зах зээлийн эдийн засаг анхлан бүрэлдэх үеийн тааламжгүй шинж чанар, өмнөх үеийн нь тоталитар уламжлалын сөрөг шинж хосолж байгаатай холбоотой гэжээ.

Социалист систем задран унаснаар эхэлсэн посткоммунист шилжилтийн үйл явц анхнаасаа орон бүрд өөр өөрийн шинж, онцлогтой байлаа. Польшид хувьсгал удаашралтай, хүндрэлтэй гэвч цус асгаруулахгүй явагдаж байсан Румынд гэнэт ямар ч бэлтгэлгүй, олон хохирогчтой, Чехословак ба Ардчилсан Германд төрийн зүгээс далайсан мунатай учирсан боловч хурдан, гүн явагдсан. Зөвлөлт улсад хувьсгал нь төвөгтэй, санаанд оромгүй байдалд болж түүний төгсгөл нь тодорхойгүй байв.

Өнөөдөр хуучин социалист орнууд нийгэм, улс төрийн нэг хэв загварын байхаа нэгэнт больж тэдгээр орны посткоммунист хөгжлийн үйл явцад ялгарал гүнзгийрч байгааг транзитологчид тэмдэглэж байна. Америкийн улс төр судлаач Ч.Гати⁸ Төв Европын коммунист байсан нилээд орон, Балтын орчмын хуучин Зөвлөлтийн Бүгд Найрамдах улсуудад ардчилалд шилжих шилжилт, зах зээлийн эдийн засгийн шинэчлэлт амжилттай хэрэгжиж дуусах боломжтой байна гэжээ. Харин энэ бүлэгт ороогүй дорнод Европын бусад улсууд болон Орос, Украин, Белорусс, Молдавыг хагас авторитар дэглэмтэй улсуудын тоонд оруулжээ. Эдгээр оронд зах зээлийн эдийн засгийн шинэтгэл аажим “алгуур” шинжтэй бөгөөд төр засаг нь чөлөөт хэвлэлийг хүлээн зөвшөөрдөг, сонгууль өнгөн талаасаа чөлөөт байдалтай мэт боловч төдийлөн шударга бус явагддаг. Транзитологийн хэвшин тогтсон ойлголтоор бол энд “төлөөлөгчдийн ардчилал” буюу засаглалын бодит эрх мэдэл нэг төвд, өөрөөр хэлбэл ерөнхийлөгчдийн гарт төвлөрсөн ардчилсан систем тогтсон гэжээ.

Ч.Гати гуравдахь бүлэг оронд Хуучин Зөвлөлтийн Төв ба Дундад Азийн 8 бүгд Найрамдах улсыг оруулжээ. Эдгээр оронд тоталитаризмын оронд авторитари дэглэм тогтсон бөгөөд ойрын ирээдүйд ардчилсан улс төрийн тогтолцоо бүрэлдэн төлөвших хэтийн төлөв харагдахгүй байна гэжээ.

Посткоммунист хөгжлийн талаархи энэ ангилал үйл явцын өнөөгийн төрх байдлыг тусгаж байгаа боловч өнгөц бөгөөд субъектив шинжтэй юм. Тухайлбал үндсэн бус хүн амын нь эрх зүйн асуудал шийдвэрлэгдээгүй хурцадмал хэвээр байгаа Балтын орчмын хуучин бүгд найрамдах улсуудыг ардчилах үйл явц хамгийн амжилттай хэрэгжиж буй орнуудын тоонд оруулсан байна.

Өрнөдийн судлаачид Монгол улс дахь шилжилтийн үйл явцыг анзааран судалсан нь харьцангуй бага юм. Дэлхийн нэр хүнд бүхий судалгааны байгууллага Freedom House-ийн 2000 оны судалгааны дүнгээс үзэхэд улс төрийн ба иргэний эрх чөлөөг хангаж буй байдлаараа чөлөөт ангилалд багтдаг нийт 88 улсын дотор Монголыг оруулсан байдаг. Хүний эрхийн олон улсын болон дотоодын байгууллага, эрдэмтдийн судалгаанаас үзэхэд улс төрийн эрх чөлөө Монгол улсад харьцангуй эерэг үнэлгээтэй байгаа боловч иргэний эрхийн хэрэгжилт нилээд хоцрогдонгуй байдалтай байна.

Эцэст хэлэхэд посткоммунист хөгжлийн үзэл баримтлал бүрэн боловсрогдож чадаагүй байна. Энэ нь нэг талаас ардчилсан шилжилтийн тухай транзитологийн онол, арга зүй боловсронгуй болоогүй, нөгөө талаас хуучин социалист орнууд дахь улс төр, эдийн засгийн шинэчлэлтийн үйл явцын онцлог, нарийн төвөгтэй байдалтай холбоотой байна.

⁸ Политология. (проблемы теории). Санкт-Петербург. 2000. Стр.343-344.

Д. Ганбат
Доктор (PhD)

Ардчиллах үйл явцын судалгааны арга зүйд

Хүн төрөлхтний түүхэнд ХХ зуун онцгой байр суурь эзэлнэ. Нэг бус, нэг хэсэг улс нэгэн цаг хугацаанд ардчиллын үнэт зүйл, үнэлэмжинд суурилсан хөгжлийг сонгон, хувьслын болон хувьсгалын замаар түүнд шилжиж эхэлжээ. Энэхүү үйл явц ХХ зуунаас эхтэй бөгөөд ардчиллын давалгаа эдүүгээ даяарших түвшний асуудал болон судлагдаж эхэлсэн билээ. Ардчиллын эхний хоёр давалгааны үед ардчилалд шилжсэн улс орнууд ерөнхий байдлаараа эдийн засаг, улс төрийн ижил нөхцөлөөс гарагаа эхэлсэн бол ХХ зууны 10-аад оноос эхлэн эдүгээ үргэлжиж буй ардчиллын гурав дахь давалгааны үед байдал өөр болсныг ажиглаж болохоор байна. Үүнийг тухайлбал, С.Хантингтон дараахи байдлаар тайлбарлажээ.

1. *Ардчилалд шилжих нь глобал үйл явц юм. Өөрөөр хэлбэл, ардчиллын янз бүрийн хэлбэр, түүнд шилжих үйл явц нь түгээмэл шинжтэй хийгээд энэ бүгд нь дэлхий нийтийн улс төрийн үйл явцын тодорхой илрэл болно. Ардчилалд шилжих үйл явцын хэлбэр, эрч болон бусад шинж чанарт түүх, эдийн засаг, социал ба соёлын зэрэг зөвхөн үндэсний бус мөн олон улсын хүчин зүйлс нөлөөлж эхэлжээ. Өнөөдөр аль ч улс орон, ардчилсан бус улс төрийн дэглэмтэй ч гэсэн нийтийн ардчилсан хөдөлгөөний нөлөөллөөс ангид байх аргагүй байдлаар ардчилсан үйл явцын глобаль шинж илэрч байна. Ардчиллын гурав дахь давалгаа нь олон улсын харилцааны хүрээг мөн хамарч түүнийг илүү ардчилсан агуулгатай болгож байна.*

2. *Ардчиллыг тодорхой үнэлэмж, үнэт зүйлс хэмээн үзэж байгаагаар холбоотой. Өөрөөр хэлбэл, ардчиллыг тогтоох асуудлыг зөвхөн түүнд хүрэх прагматик хэрэгслийн талаас бус харин байх ёстой хэрэгцээ гэдэг талаас нь илүү тодорхойлжээ. Ардчилсан байгууллыг практик дээр эдийн засаг, социал асуудлыг шийдвэрлэх явдалтай холбодог. Гэтэл ардчиллыг өнөөгийн нөхцөл байдалд илүү тохирсон улс төрийн дэглэм гэхээсээ илүү хүмүүсийн хэрэгцээ юм гэж үзжээ. Тийм ч учраас эдийн засгийн хямралын нөхцөлд ч гэсэн ардчилал харьцангуй тогтвортой байдаг нь батлагдсан билээ.*

3. *Ардчилсан дэглэм олон хувилбартай байж болно гэж үздэг. Үүнтэй холбоотой дараах асуудал гарч ирсэн. Эдүүгээ дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, баримтлаж ирсэн либерал ардчиллын давуу ба сул талыг шүүн тунгаах. Хоёрт, ардчиллын бусад хэлбэрийн илрэлийг судалж, тэдгээрт хүлээцтэй хандах.*

4. *ХХ зууны эцэст болсон улс төрийн өөрчлөлт нь ардчиллах үйл явцаар дуусч байгаа биш бөгөөд ардчиллын түүх үүгээр эцэслэхгүй. Энэ утгаараа ардчиллын үйл явц бол уналт, сэргэлтийг хосолсон үзэгдэл гэсэн санаанд тулгуурлана. Өөрөөр хэлбэл, зарим улс ардчилалд шилжиж байхад, зарим улс ардчилаас буцаж авторитар дэглэм рүү ухрах магадлал байдаг байна. Гэхдээ ХХI зуунд ардчиллын дөрөв дэх давалгаа илрэх болоцоотой ч үгүйсгэхгүй юм. Тийм ч учраас, улс төрийн онолд ардчиллын шинэ хэлбэрийн хөгжлийг урьдчилан харах хандлага давамгайлах болно.*

5. *Ардчилалд хүрэх үйл явц эргэж буцалтгүй үзэгдэл болсон гэдэгт бүрэн итгэлтэй байна. Энэ үүднээс хүний ардчилсан мөн чанар, агуулгын тухай үзэл санааг тэрээр гаргаж тавьжээ.¹*

Гэтэл өнөөдөр дэлхийн ихэнхи улс ардчилагдсан уу гэвэл хараахан тийм биш байна. Дэлхийн нэр хүнд бүхий судалгааны байгууллага болох Freedom House -ийн 2000 оны судалгааны дүнгээр тусгаар тогтносон нийт 195 орны 88 (45 орчим хувь) нь

¹ Huntington S. Democracy's Third Wave. Journal of Democracy. Spring 1991.

чөлөөт, 59 (30 орчим хувь) нь хагас чөлөөт, 48 буюу 25 орчим хувь нь чөлөөт бус гэсэн ангилалд багтаж байна². Уг нэр хүнд бүхий байгууллагын баримтладаг хэмжүүр, арга зүйд ардчиллын хөгжил, хүний улс төрийн ба иргэний эрх чөлөө, эрх хэрхэн хангагдаж байгаа зэрэг асуудал орж байгаа нь ойлгомжтой. Өнөөдөр ардчиллын үзэл санаа, онол нь тухайн улсын бодит амьдрал, онцлогоос үл хамааран түгээмэл шинжтэй зүйл мөн үү, тухайн улсын шашин, соёл, эдийн засгийн хөгжил, үндэс угсаа, нийгмийн бүтэц зэрэг нь ардчиллын хөгжилд нөлөө үзүүлдэг эсэх, бүхэлдээ ардчиллын хөгжлийг ямар төвшинд хүрсэнээр нь нийгмийн хөгжлийг тодорхойлогч болсон эсэхийг хэрхэн хэмжих зэрэг асуудал ганц онолын биш олон орны практик асуудал болсоор байна. Бүр XIX зууны эхэнд францын түүхч, улс төрийн философч Алекс Токвиль (Alexis de Tocqueville, 1805-1859) өөрийн алдарт "Америк дахь ардчилал" бүтээлдээ ардчилал бол эргэж буцалтгүй үйл явц мөн³ гээд үүнийгээ хэд хэдэн нөхцөлтэй уялдуулан тайлбарласан байдаг. Эдгээрийн дотор, эдийн засгийн өсөлт, хувийн өмч, технологи, батлан хамгаалах, гэгээрэл болон христын үзэл зэргийг онцлон, тэдгээрийн утга учрыг ерөнхийн ба америкийн ардчиллын хөгжилтэй хамааруулан харуулсан ажээ.

Ардчиллын нөхцөл байдлын асуудлыг гаргахдаа баримтласан А.Токвилийн логик, арга зүй бүхэлдээ ач холбогдлоо алдаагүй ч XX-XX I зууны хөгжлийн үзүүлэлтийн чанарын түвшнийг XIX зууны эхэн үетэй харьцуулах аргагүй юм. Ямар ч байсан ардчилал ба түүнийг нөхцөлдүүлж буй болон харилцан хамаарч байгаа асуудлыг дараахи гурван ерөнхий бүлэгт хувааж үзэх боломжтой гэж үзэж байна.

Ардчиллын хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийн асуудалд. Дээр дурьдсан Freedom House судалгааны байгууллагын дүнгээс үзэхэд судалгаанд нь хамрагдсан 195 улсын 45 гаруй хувь л улс төрийн ба иргэний эрх чөлөөг хангаж буй байдлаараа чөлөөт ангилалд багтаж байна. Эдгээрийн дотор эдийн засгийн өндөр хөгжилтэй улс байгаагийн зэрэгцээ энэ үзүүлэлтээрээ чөлөөт бус ангилалд багтдаг улсаас хамаагүй доогуур байгаа Монгол, Намиби, Гана, Мали зэрэг улс орсон байна. Тэгэхлээр, ардчиллын хөгжил эдийн засгийн хөгжилтэй хэрхэн уялддаг вэ? хоорондоо хамааралтай юу? эсвэл, ардчилал эдийн засгийн өсөлтөнд хүргэдэг юм уу? зэрэг асуудал гарч ирдэг нь үүнтэй холбоотой.

Ардчилал ба эдийн засгийн хөгжил: Франсис Фукуямагийн (Francis Fukuyama) саяхны нийтэлсэн нэгэн өгүүлэлд, хөгжлийн аль ч төвшинд байгаа улс ардчилалд шилжиж болно гэхдээ ардчилсан хэвээр үлдэх нь тухайн улс илүү чинээлэг болохоос ихэд хамарна гэжээ⁴. Адам Пшеворски (Adam Przeworski) ардчилсан хөгжил нь тогтвортой болох эдийн засгийн түвшнийг тооцоолохдоо нэг хүнд ногдох ДНБ 6000 ам. долларт хүрсэн байх учиртай гэсэн байдаг⁵. Үүний эсрэг ч тайлбар байдаг ба энэ нь эдүүгээ Сингапур улсын ерөнхийлөгч асан Ли Куан Еүгийн (Lee Kuan Yew) нэртэй холбоотой яригддаг. Тэрээр, харин ч ардчилсан бус дэглэм нь эдийн засгийн өсөлтийг хангах хамгийн боломжит систем юм хэмээн "таамаглал" дэвшүүлж байсныг бид мэднэ.

Ардчиллын хөгжил ба эдийн засгийн өсөлт, түвшний хооронд хамаарал байгааг эрдэмтэдийн дийлэнхи нь хүлээн зөвшөөрдөг. Энэ нь ч ерөнхий судалгаанаас харагддаг. Тухайлбал, газрын тосоор баян улсыг оролцуулалгүй үзэхэд дэлхийн чинээлэг бүх улс ардчилсан бөгөөд Энэтхэг зэрэг ганц хоёр улсаас бусад бүх ядуу улс ардчилсан бус хэвээр байна. Эдийн засгийн дундаж хөгжилтэй улсууд гэхэд зарим нь ардчилсан, зарим нь ардчилсан бус байх жишээтэй. Freedom House-ийн 2000 оны судалгааны дүнг жишээ болгож үзэхэд чөлөөт ардчилсан улсын (дээд) ангилалд багтаж буй улсын ДНБ-ийн нэг хүнд ногдох дундаж үзүүлэлт 18927 ам. доллартай тэнцэж байхад чөлөөт бус (доод) ангилалд багтдаг улсын хувьд уг үзүүлэлт 3763 ам. доллартай тэнцэж байна. Ерөнхий шугаман корреляцийн хувийг гаргаж үзэхэд 0,37 буюу харьцангуй сул хамаарал харагдаж байна. Энэ нь чөлөөт бус ангилалд орж буй

² <http://www.freedomhouse.org/research/2000/>

³ Alexis de Tocqueville. Democracy in America. New York, 1958, p. 5-7.

⁴ Francis Fukuyama. The March of Equality. Journal of democracy, Volume 11, #1, 2000, p. 13.

⁵ Francis Fukuyama. The March of Equality. Journal of democracy, Volume 11, #1, 2000, p. 13.

улсуудын тоонд ДНБ-ний нэг хүнд оногдох үзүүлэлтээрээ нэлээд дээгүүрт ордог Кувейт (25314 ам. доллар), Сингапур (24210 ам. доллар), Катар (20987 ам. доллар), Арабын Нэгдсэн Эмират (17719 ам. доллар) зэрэг улс орж байгаатай холбоотой⁶.

Өөрөөр хэлбэл, улс төрийн ба иргэний эрх чөлөө гэсэн үзүүлэлтээр “чөлөөт” ангиллын дээд хэсэгт багтаж буй улсуудын хувьд эдийн засгийн хөгжил, хүн амын амьжиргаа нь өндөр үзүүлэлттэй байх нь шууд хамааралтай байгаа бол “чөлөөт бус” улсуудын хувьд эдийн засгийн үзүүлэлт доогуур байх хамаарал ажиглагдахгүй байна. Гэхдээ чөлөөт улсуудын ДНБ-ийн жилийн дундаж өсөлт 2,56 %, хагас чөлөөт улсуудын хувьд 1,81%, чөлөөт бус улсуудынх 1,36% байгаа нь⁷ улс төрийн эрх чөлөөт байдал ба эдийн засгийн өсөлтийн хооронд тодорхой хамаарал байгааг гэрчлэх юм. Энэ үзүүлэлт “чөлөөт”, “хагас чөлөөт” ба “чөлөөт бус” ангилал тус бүрийн дотор багтаж буй ДНБ-ийн нэг хүнд ногдох хэмжээ нь 5000 ам. доллараас доогуур байгаа улсуудын хувьд 3,23% (чөлөөт улсын хувьд), “хагас чөлөөт” улсад 1,47% болон “чөлөөт бус” улсын хувьд 1,41 %-тай тэнцэж байна⁸.

Бүхэлд нь авч үзэхэд, эдийн засгийн хөгжил ба нийгмийг ардчиллах үйл явц хоёр хамааралтай байх магадлал өндөр юм. Үүнийг товчоор илэрхийлбэл, ардчиллыг бий болгохын тулд эдийн засгийн хөгжлийг хангах хэрэгтэй. Учир нь, эдийн засгийн өсөлт нь хотжих, бичиг үсэгт тайлагдах, боловсролын төвшин нэмэгдэх зэрэгт нөлөөлнө. Ингэснээр, ажил мэргэжлийн бүтцэд өөрчлөлт орж, дунд анги эсвэл хотын ажилчин ангийн шинж чанарт нөлөөлдөг. Ангиуд нь тэдгээрт хандаж буй улс төрийн бодлогод оролцох, нөлөөлөл үзүүлэхийг илүү сонирхох болно. Боловсролын өндөр төвшинтэй үед тэд өөрсдийн үйлдвэрчний эвлэл, улс төрийн нам, бусад иргэний сонирхлын байгууллага байгуулах боломжтой болно. Нөгөө талаас, эдийн засгийн өсөлт нь түүнийг зохицуулах механизмд өөрчлөлт оруулдаг бөгөөд захиран тушаах системийн жишээнээс үзэхэд төр хяналт тавьж чадахаа бүр больдог байна. Төр хяналтаа сулруулж эхлэхэд санхүү, технологи, харилцаа холбоо зэрэг асуудлыг хянадаг бие даасан засаглалын төвүүд үүсдэг. Энэ байдлыг мэдэрсэн эдийн засгийн бүлэглэл улс төрийн системд өөрийн нөлөөллийг нэмэгдүүлж, цэргийн, нэг намын эсвэл нэг дарангуйлагчийн нөлөөллийг сулруулахыг эрмэлзэж эхэлнэ. Хамгийн гол нь төр засгийн эрх мэдлийг бодит утгаар нь хуваарилах, эрх мэдлийн тодорхой хэсгийг гартаа атгасан хараат бус субъектүүд байх бололцоог эдийн засгийн хөгжил харууллаа. Хөгжил гэдэг нь зөвхөн баялгийн хэмжээнээс гадна эдийн засгийн харилцааны шинж чанарыг өөртөө багтаана. Эхний үед орлогын тэгш бус байдал бий болдог ч алсдаа эл байдалд өөрчлөлт орон тэгш байдал руу чиглэх хандлага ихэнхи тохиолдолд ажиглагдсан байна. Ардчилал эдийн засгийн бүрэн төгс, тэгш байдлыг хангах боломжгүйн адил аж байдал, орлогын хувьд тэгш бус их зөрүүг бас бий болгодоггүй. Эдийн засгийн өсөлт нь өөрөө энэ тэгш бус байдлыг багасгаж ардчилалд учирч болзошгүй аюулыг ямар нэг хэмжээгээр зайлуулна.

Энд дараахь зүй тогтол ажиглагдана. Эдийн засгийн өсөлт дундаж төвшинд ойртох тусам улс төрийн системийг илүү нээлттэй, ардчилсан болгоход нөлөөлдөг байна. Нобелийн шагналт Амартя Сэнийн (Amartya Sen) тэмдэглэсэнчлэн хэдхэн жилийн өмнө болсон Зүүн Өмнөд Азийн эдийн засгийн хямралд өртсөн Өмнөд Солонгос, Тайланд, Индонези зэрэг улсад санхүү, төсөв мөнгөний бодлого нь олон түмнээс хаалттай явж ирснээр асуудал илүү хүндрэхэд нөлөөлсөн гэсэн нь үүнийг давхар нотлохуйц болжээ⁹. Heritage Foundation (AHU) болон The Wall Street Journal хоёрын хамтран явуулсан эдийн засгийн эрх чөлөөт байдлын талаархи 150 улсыг харьцуулсан 2001 оны судалгааны дүгнэлтэд дарангуйлалт дэглэм бүхий улсад нэг хүнд ногдох жилийн орлогын дундаж нь 2800 ам. доллар байхад хагас чөлөөт эдийн засаг бүхий улсад 11054 ам. доллар, чөлөөт эдийн засагтай улсад 21206 ам. долларын үзүүлэлт

⁶ <http://www.freedomhouse.org/2000,raitings of freedom/>

⁷ Adrian Karatnycky. The 2000-2001 Freedom House Survey of Freedom. (Internet information)

⁸ Adrian Karatnycky. The 2000-2001 Freedom House Survey of Freedom. (Internet information)

⁹ Amartya Sen. Democracy as a Universal Value. Journal of Democracy, 1999, July, p.7.

гарч буйг тэмдэглээд **ядуурал ба чинээлэг байдлын хоорондын ялгаа нь эрх чөлөөтэй холбоотой** гэдгийг онцложээ.¹⁰

Ардчилал ба соёл. А. Токвиль соёл, гэгээрлийн хөгжил нь төрийн үйл хэрэгт орчин үеийн хэллэгээр “хүний хүчин зүйлсийг” нэмэгдүүлж тэр нь улмаар ардчиллын хөгжилд таатай орчныг бүрдүүлнэ гэжээ¹¹. Цөөн хүмүүсийн хүртээл болж, байсан соёл нь бүх нийтийнх болсноор олон авьяастнууд тодрох үүд хаалга нээгдэж энэ нь хүмүүсийн эрх чөлөөт сэтгэлгээнд асар их нөлөө үзүүлж нийгмийн хөгжил, дэвшилд үсрэнгүй өөрчлөлт орж ирснийг түүхийн олон баримт гэрчилнэ. Боловсрол, гэгээрэл бол ардчилсан нийгмийн байвал зохих учиртай нэг үнэт зүйл, тэр тусмаа ардчилсан нийгмийн зарчим гэхэд хүмүүс эргэлзэхгүй. Ж.Локк, Ж-Ж. Руссо, Ж.С. Миллээс эхлэн ардчиллын бүх онолчид боловсрол зөвхөн гэгээрсэн иргэд бий болох явцуу зорилготой биш юм. Боловсролын хүчин зүйл үр ашигтай ардчиллыг хөгжүүлэх нэг гол хөшүүрэг болно гэдгийг байнга онцолж байсан билээ. Ардчилалд гэгээрсэн иргэд хэрэгтэй гэсэн санаа нь түгээмэл утгатай ба үүнд өрнөд, дорнодод ялгаа байдаггүй нь хүн төрөлхтний түүхээс харагдсан. Улс төрийн амьдралд оролцох энгийн хэлбэр болох сонгуульд хүн сонголт хийнэ. Сонголт хийхийн тулд тэрээр дор хаяж бичиг үсэг тайлагдсан байх учиртай. Гэгээрэл боловсролгүй хүн бусдын аясыг илүү дагаж, өөрийн сонирхол, зорилгоо ойлгон илэрхийлэх боломжоор хязгаарлагдмал байна¹². Гэтэл ардчилал бол ард түмний засаглал учраас эцсийн сонголтыг харанхуй бүдүүлэг бус ухамсартай ард түмэн хийх бөгөөд боловсролын ачаар хүмүүс болон нийгмийн бүлгүүд сонирхлын артикуляци хийх мэдлэг, чадвартай болж энэ нь эргээд ардчилал, энэ утгаараа нийгмийн хөгжил дэвшилд чухал нөлөө үзүүлэх учиртай билээ.

Ардчилсан бүх улсын иргэд бүрэн боловсорч гэгээрсэн үү гэхэд бас тийм биш юм. Тэгэхлээр, боловсрол хөгжиж байж л ардчилсан нийгэм үүсэх боломжтой гэж үзэх нь бас буруу болно. Энэ хоёр зүйлс хоорондоо маш уялдаатай байдаг хийгээд **ардчилал хөгжих нь боловсролын төвшин дээшлэхэд нөлөөлөхтэй адил боловсрол хөгжих тусам ардчилал бэхжих зүй тогтолтой ажээ.**

Боловсрол, гэгээрлийг нийгмийн улс төрийн нөхцөл байдлын өөрчлөлттэй холбож судалхад түүнээс илүү хүрээний улс төрийн соёлын асуудал зайлшгүй хөндөгдөнө. Улс төрийн соёлын либерал тайлбарыг Габриэл Алмонд (Gabriel Almond), Сидней Верба (Sidney Verba) нар “Иргэний соёл” (The Civic Culture, 1963) хэмээх бүтээлдээ анх гаргасан гэж үздэг¹³. Ардчиллын суурь үнэлэмж нь нэг боловч нийгмийн зохион байгуулалт, засаглалын үйлчлэлийн механизм зэргээрээ ялгагдах АНУ, Их Британи, Баруун Герман, Итали, Мексик улсууд дээр тулгуурлан явуулсан судалгааны дүнгээр тэд улс төрийн соёлын **өвгийн** (parochial), **захирагдмал** (subjective) болон **оролцооны** (participant) гэсэн гурван хэв маяг байдаг гэсэн дүгнэлтэнд хүрсэн билээ. Ардчиллын хөгжил тогтвортой байх нь тухайн нийгэмд оролцооны улс төрийн соёл нөгөө хоёр хэв маягийн тэнцвэржүүлэх байр сууринд байж, олонхийг хамарсан эсэхээс хамаарах юм гэдэг нь тэдний дэвшүүлсэн гол санаа болсон. Энэхүү улс төрийн соёлын “холимог” байдлыг Алмонд, Верба нар **иргэний соёл** (civic culture) хэмээн нэрлэсэн юм¹⁴. Энэ соёлын нөхцөлд төр, засгийн талаар өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх иргэдийн идэвхи нь харьцангуй өндөр боловч эрх баригчдын гаргасан тодорхой шийдвэрийг эсэргүүцэх зэрэг үйлдэлд хамрагдах нь харьцангуй багаар илэрхийлэгддэг байна. Иргэд засгийн зүгээс өөрсөддөө нөлөө үзүүлэх явдлыг ерөнхийдөө таашаадаггүй боловч харьцангуй тайван хүлээж авдаг учраас энэ нь төрийн үйл ажиллагаа ямар хэмжээнд уян хатан байх асуудлыг төр өөрөө шийдэх боломж бүрдүүлдэг ажээ.

¹⁰ 2001 Index of Economic Freedom. www.heritagefoundation.org

¹¹ Alexis de Tocqueville. Democracy in America. New York, 1958, p. 52-55.

¹² А. Юндэндорж. Нийгэм иргэнлэг, ардчилсан хэв шинжийг олоход төрийн институтын гүйцэтгэх үүрэг. УБ, 2001, 123-126 дахь тал.

¹³ А. Цанжид. Улс төрийн шинжлэх ухаан. УБ, 1999, 119-120 дахь тал.

¹⁴ R. Hague, M. Harrop, S. Breslin. Political Science: A Comparative Introduction. New York, 1992, p. 136-137.

1950-1960 оны зааг дээр гаргасан Алмонд, Верба нарын судалгааны дүгнэлтүүд өнөөдөр ч ач холбогдолтой байгааг эрдэмтэд тэмдэглэж байна. Тухайлбал, Инглхарт (Inglehart R.) 1988 онд европын зарим улсыг хамарсан судалгаанаас гаргасан дүгнэлтэндээ үүнийг тэмдэглэсэн байна.¹⁵ Гэхдээ, Алмонд, Верба нарын дүгнэлтүүдтэй мэтгэлцэх асуудал бас байгаа ажээ. Тухайлбал, ардчилсан нийгэмд иргэд төрийн үйл ажиллагааг шүүмжилж, бүр солих эрхтэй байдаг, тэгвэл ардчилалаас дарангуйлалд эргэж орсон улсын жишээнээс үзэхэд иргэний соёл нь эргээд алга болдоггүй байна. Энэ жишээ Алмонд, Верба нарын хэлсэнчлэн иргэний соёл нь ардчиллын тогтвортой байдлыг нөхцөлдүүлэгч биш харин ардчиллын үр дүн биш үү? гэсэн асуудлыг тавихад хүргэжээ. Хоёрт, тухайн нийгэм дэх үндэстэн ястны, шашины зэрэг "дэд соёлд" бага анхаарал хандуулсан гэж шүүмжлэгддэг. Дэд соёл нь зарим улсад нийт улс үндэсний хэмжээний соёлоос илүү нөлөөтэй байдаг ба ардчиллын өндөр хөгжлөөрөө онцлогддог Их Британи, Канад, Австрали зэрэг улсад үүнээс болж улс төрийн асуудал гарсаар байгааг нотолгоо болгодог байна.

Ардчиллын гурав дахь давалгаа болон түүний даяарших үйл явцтай холбож соёлын илүү өргөн хүрээний асуудал хөндөгдөх болсон нь ардчилал нь өрнөдийн соёлоос улбаатай тул дорно зүгийн улс орнуудад тэр нь хэр тохиромжтой вэ гэдгээс үүдэлтэй юм. Судлаач Артур Шлесингер (Arthur Schlesinger Jr.): *"Европ бол хувь хүний эрх чөлөө, улс төрийн ардчилал, эрх зүйт төр, хүний эрх болон соёлын эрх чөлөөт байдлын давтагдашгүй эх булаг мөн. ... Эдгээр нь Ази, Африк, Ойрхи Дорнодын биш гагцхүү Европын үзэл санаа юм. Бусад нь үүнийг өөртөө шингээсэн."* гэжээ.¹⁶

Ф.Фукуяма мөн энэ асуудлыг хөндөхдөө ардчиллын хөгжилд христын шашины үзүүлсэн нөлөөллийн тухай Токвиллийн дээр өгүүлсэн санааг жишээ болгожээ. *"Ардчилал ба Христын үзлийн хамаарал болон түүний дэлхий нийтийг хамрах чадамжийн асуудлууд ардчиллын ирээдүйн хувьд тулгуур ач холбогдолтой юм"* Түүний үзэж байгаагаар бол ардчилал ба хөгжлийн хоорондын хамаарлын асуудлын цаана ардчилал ба өрнөдийн христын үзлийн хоорондын хамаарал оршиж байж магадгүй ажээ. Учир нь хөгжсөн орнууд болон протестант эсвэл католик шашинтай улсууд гэдэг бол эдүүгээ бараг давхардсан ойлголт гэдэг нь тодорхой юм гэжээ.¹⁷

Самуэль Хантингтон мянга гаруй жилийн түүхтэй Өрнөд Европын соёл иргэншил хүн төрөлхтний дэвшилд асар их нөлөө үзүүлсэний дотор ардчиллын асуудал зүй ёсоор багтах ёстой гээд ардчиллын гурав дахь давалгааны үед өрнөдийн ардчиллын нийтийг хамрах (universality) чадамж баталгаажиж, бусад ялангуяа өрнөдийн бус бүс нутагт түүний түгэлт чиглэгдсэн нь тодорхой болсоныг онцлосон байна. Гэхдээ: *"Өрнөдийн бүтээгдэхүүн болох орчин үеийн ардчилал аль хүртлээ өрнөдийн бус нийгэмд түгэх бол?"* гэсэн асуултыг нээлттэй тавьжээ.¹⁸

Энэ бүгд нь **ардчиллын хөгжил ба улс төрийн соёл, түүнийг нөхцөлдүүлж буй олон асуудлын хооронд хамаарал байгааг** нотлохын зэрэгцээ хүн төрөлхтний соёл иргэншлийн асуудлыг давхар хөндөж, тухайн улс орны үүсэл хөгжил, түүхэн уламжлал, зан үйл, шашин, нийгэм дэх үнэлэмжийн систем зэрэг олон асуудлыг судалхын чухлыг харуулсаар байгаа билээ. Өрнө, Дорнын соёл, сэтгэлгээ, уламжлалтай холбоотой асуудлыг иргэншлийн хөгжилтэй холбож өөрийн тайлбар гаргасан Г.Чулуунбаатарын бүтээл энэ чиглэлийн асуудлыг судлахад арга зүйн хувьд чухал суурь болно гэж үзэж байна.¹⁹

¹⁵ Inglehart R. The Renaissance of Political Culture. American Political Science Review, 1988, 1203-1205.

¹⁶ Journal of Democracy, Oct, 1997, Volume8, #4, p. 6.

¹⁷ Francis Fukuyama. The March of Equality. Journal of democracy, Volume 11, #1, 2000, p.16-17

¹⁸ Samuel P. Huntington. Journal of Democracy, Oct, 1997, Volume8, #4, p. 6.

¹⁹ Г. Чулуунбаатар. XX,XXI зууны зааг үеийн монгол дахь иргэний нийгмийн төлөвшил хөгжил. УБ, 1999.

Ардчилал ба сонгууль: Ардчилал бол засаглалыг бүрдүүлэх, тэдгээрт хариуцлага хүлээлгэх нэгэн хэрэгсэл юм²⁰. Ардчиллаас бусад системд олон түмэнд “заяах” удирдагчид нь гарал үүсэл, эд хөрөнгө, харьяалал, томилолт зэргээр бий болдог. Ардчиллын үед удирдагч, удирдуулагч хоёр аль аль нь ижил эрхтэй. Шийдвэр гаргагчид өрсөлдөж олон түмний шударга сонголтын дүнд засаглах эрхээ тодорхой хязгаар бүхий хугацаанд олж авдаг. Энэ утгаараа **сонгууль бол ардчиллын мөн чанар юм** гэсэн ойлголт Дэлхийн II дайнаас хойш ихэд түгээмэл болж иржээ. Ардчилсан улс төрийн дэглэм бүхий улс орныг тодорхойлох нэг гол шинж бол шийдвэр гаргах эрх бүхий хүмүүс нь бүх нийтийг хамарсан, тогтмол явагддаг, шударга сонгуулиар тодорч, нэр дэвшигчид санал авахын тулд чөлөөтэй өрсөлдөх боломжоор хангагдсан байдаг оршино. Ардчиллын энэхүү “дэг жаягт” (procedural) тулгуурласан тодорхойлолтыг австри гаралтай америкийн эдийн засагч Жозеф Шумпетер (Joseph A. Schumpeter, 1883-1950) тавиад жилийн өмнө нийтлүүлсэн “Капитализм, социализм ба ардчилал” (Capitalism, Socialism and Democracy, 1942) номондоо гаргасан хийгээд үүнийг судлаачид ерөнхийд нь хүлээн зөвшөөрдөг байна.

Сонгуулийн ач холбогдлыг янз бүрээр үзэх хандлага ч бас байдаг. Тухайлбал, хүмүүс засгийн эрх баригчдыг эсэргүүцэх, шүүмжлэх, зохион байгуулах, лоббидох зэрэг бүрэн эрх чөлөөтэй юм бол сонгууль нэг их шаардлагатай зүйл биш гэнэ. Нөгөө нэг нь, нийгмийг ардчилах үйл явцад чөлөөт сонгуулиас илүү чөлөөт хэвлэл чухал гэдгийг нотлоно. Энэ бүгд нь тийм их анхаарал татахуйц онолын түвшний асуудал биш боловч ардчиллын амин сүнс нь сонгууль юм гэсэн хандлагыг туйлын утгаар нь хүлээн зөвшөөрөхөд эргэлзэж буйн илрэл гэж үзэж болох юм. Сонгуультай холбоотой анхаарал татдаг асуудлын нэг бол өрнөдийн болон өрнөдийн бус улсуудад явагддаг сонгуулийн онцлог юм. Өрнөдийн бус улсад сонгуулиар гарсан улс төрийн удирдагч эсвэл бүлэглэл эргээд ардчилалд сөргөөр нөлөөлөх хандлага сүүлийн жилүүдэд хүчтэй ажиглагдсаныг дээр дурьдсан Freedom House байгууллагын судалгаанд харуулсан байна²¹. Латин Америкийн хэд хэдэн оронд, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд орж байсан зарим улсад засгийн эрх баригчид ардчилсан бус арга замыг сонгож захиран тушаах механизмыг ашигласаар байна. Тэд Үндсэн хуульд өөрчлөлт оруулан өөрсдийн засгийн эрхэнд байх хугацаагаа сунгах зэрэг үйлдэл хийж байгаа нь үүний жишээ болно. Өрнөдийн бус улсад либерализмын уламжлал тогтоогүйн улмаас хувь хүний эрхийн асуудалд бага анхаарал хандуулах, цөөнхийг дарамтлах, хэвлэлийн эрх чөлөөнд халдах зэрэг явдал илэрдэг. Үүнээс гадна сонгуулийн явцад яс угсаа, манайхаар бол “нутгархах”, шашин, үндсэрхэг үзэл зэрэгт анхаарлаа илүү хандуулдаг нь түгээмэл болж, ингэснээр ардчиллын эсрэг чиглэсэн улс төрийн хүчнийхнийг гаргаад ирэх ч магадлал байсаар байна. Өрнөдийн соёл иргэншлийн нэг том ололт болох ардчилсан тогтолцоог өөртөө бүрэлдүүлэх явцдаа өрнөдийн эсрэг чиглэсэн хүчнийхнийг сонгуулиар гаргаад ирэх нь цөөнгүй байна. Энэ нь лалын ертөнцөд хүчтэй илэрдэг нь нууц биш юм гэж Самуэль Хантингтон тэмдэглэжээ²².

Ардчилсан бус улс төрийн системд сонгууль өөрийн тодорхой үүргээ гүйцэтгэж ирснийг социалист гэгдэж байсан улсын түүх болон өнөөдрийн Иран зэрэг улсын жишээ харуулсаар байгааг бас анхаарах хэрэгтэй. Энэ бүгдээс үзэхэд, ардчиллын нэг чухал хэмжүүр болох сонгуулийг янз бүрийн хэлбэрээр ашиглаж байгаа бөгөөд энэ нь тийм ч бас “сөрөг” үзэгдэл биш ажээ. Учир нь, үүний дараагийн логик алхам бол сонгуулийн шударга байдлыг хангах, түүнийгээ шаардах зэрэг хүний эрх чөлөөтэй холбоотой асуудлууд урган гарч ирэх магадлал өндөр байдаг байна²³.

Ардчилал ба сонгуулийн хамаарал өндөр гэдэг нь ардчиллын мөн чанар сонгуулиар л тодорхойлогдоно гэсэн үг бас биш ажээ. Үүнийг ялгаж салгах үүднээс

²⁰ А. Юндэндорж. Нийгэм иргэнлэг, ардчилсан хэв шинжийг олоход төрийн институтын гүйцэтгэх үүрэг. УБ, 2001, 57-59 дахь тал.

²¹ http://www.freedomhouse.org/nations_in_transition/.

²² Samuel P. Huntington. After Twenty Years: The Future of the Third Wave. Journal of Democracy, Oct. 1997, Volume 8, #4, p. 6-9.

²³ Larry Diamond. Is the Third Wave over? Journal of Democracy, Jun. 1996, #7, p. 20-37.

ардчиллын хөгжил, тогтворжилтийн түвшний асуудлыг гаргаж ирсэн бөгөөд энэ нь өнөөдөр ардчилалд шилжиж буй улсуудын чанарын ялгааг тодорхойлох арга зүй болоод байна.

Ардчиллах үйл явц, хөгжлийн төвшинг харьцуулах нь: Гүверийн хүрээлэнгийн улс төр судлаач Ларри Даймонд (Larry Diamond) "Journal of Democracy" сэтгүүлд бичсэн нэгэн өгүүлэлдээ²⁴ ардчилал ба сонгуулийн хамаарал, ардчиллын хөгжлийг тодорхойлоход сонгуулийн ач холбогдлыг ямар төвшинд авч үзэх тухай асуудлыг хөндөж **либерал** (liberal) **ардчилал, сонгуулийн** (electoral) **ардчиллын** ялгаа, заагийг тодорхойлох өөрийн саналаа дэвшүүлсэн юм. Ерөнхийлөн үзвэл либерал ардчилалд чөлөөт сонгуулиас гадна гүйцэтгэх эрх мэдлийн босоо ба хэвтээ хяналт, бие даасан шүүх, хувь хүний эрхийн хамгаалалт, цөөнхийн эрхийн баталгаа, засгийн эрх барьж буй намаас сонгуульд нөлөөлөх боломжийн хязгаар, цагдаагийнхний мөрдлөгийн хүрээг хуулиар тогтоосон, цензургүй байдал, хэвлэл мэдээллийг төрөөс хамгийн бага хянах зэрэг асуудал хүчтэй тавигддаг. Сонгуулийн ардчилалд засгийн газар чөлөөт, шударга сонгуулиар бий болдог боловч либерал ардчилалд байдаг шиг иргэдийн эрх, эрх чөлөөний олон баталгаа байдаггүй байна. Л. Даймондын тооцоолсноор сонгуулийн ардчилалтай улсын тоо сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц өсөж байгаа бол харин либерал ардчилалтай улсын тоо харьцангуй хэвээр байгаа ажээ. Үүнийг Freedom House-ийн судалгаа давхар нотлож байгаа ба 2000 оны байдлаар 120 орон сонгуулийн ардчилалтай байгаа хэдий ч тэдгээрийн зөвхөн 88 нь чөлөөт буюу либерал ардчилалтай гэжээ. Сонгогддог засаглалтай боловч "хагас чөлөөт" гэгдэх 32 орны дотор Орос, Украин, Турк, Бразил зэрэг том улс багтаж байна.²⁵

Сонгуулийн (electoral) ардчиллын утга санаа: Ардчиллын хүрсэн түвшнийг тодорхойлохдоо **сонгуулийн асуудлыг** суурь үзүүлэлтийн хэмжээнд авч үзэх үзлийг дэлгэрүүлэхэд Ж. Шумпетер их хувь нэмэр оруулсан тухай дээр өгүүлсэн билээ. Түүнийхээр бол ардчиллын амин сүнс болох сонгуулиас ардчилсан системийн бусад шинж чанар урган гарна гээд ардчилал бол *"өрсөлдөөний замаар ард түмний саналыг авсны үндсэн дээр тодорхой бие хүмүүс шийд гаргах эрх мэдэлтэй болж улс төрийн шийдвэрт хүрдэг"* систем юм хэмээн онцложээ.²⁶

Шумпетерийн дэвшүүлсэн үзэл санаа нь ардчилсан үйл явцын талаархи онол, баримтлалыг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан юм.

- Нэгд, ардчиллыг засаглалын бусад хэлбэрээс ялгахад хэрэглэж болохуйц *шалгуурыг* гаргаж өгсөн.
- Хоёрт, сонгодог онолд тэр болгон тодорхой бус байдаг төрийн эрх мэдлийн легитимт шинжийг нөхцөлдүүлэх *орон зайн* асуудлын чухлыг онцлон тэмдэглэсэн.
- Гуравт, нийгэм дэх өөрийн онцлог бүхий бүлгийн сонирхол, хүсэл зориг *өрсөлдөөнийг тэтгэгч* болно гэдгийг чухалчилсан.
- Дөрөвт, улс төрийн өрсөлдөөнийг тодорхойлох арга хэрэгслийн хувьд ардчилал нь өөрөө тодорхой *зөрчил агуулдаг* гэдгийг тэмдэглээд аажим аажмаар авторитар дэглэмд мөн эргэн орж болохыг тэрээр үгүйсгээгүй.
- Тавд, хувь хүн бүр эрх барихын төлөөх *өрсөлдөөнд оролцох эрхээр хангагдсан* байдаг нь засаглалын бусад хэлбэрээс ардчиллын ялгагдах гол онцлог нь болно. Ингэснээр, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон хэвлэл мэдээллийн эрх чөлөө, баталгааны асуудал зэрэг нь хангагдана.
- Зургаад, төрийн эрх мэдлийг тээгч институтыг бүрдүүлэх нь сонгогчдын гол үүрэг юм бол *эрх баригчдыг халах үүрэг* мөн сонгогчидод хамаарах ёстой хэмээн Шумпетер үзэж байв.

²⁴ Larry Diamond. Is the Third Wave over? Journal of Democracy, Jun. 1996, #7, p.20-37.

²⁵ <http://www.freedomhouse.org/2000, ratings of freedom/>

²⁶ Hans-Joachim Lieber. Politische Theorien von der Antike bis zur Gegenwart. Bundeszentrale fuer politische Bildung, Band 299, s. 709.

• Долоод, сонгодог онолд олонхийн хүсэл зоригийг нийт ард түмний хүсэл зоригтой адилтган үзэж, эсвэл хувь тэнцүүлэх төлөөллөөр хоорондын харьцааг шийдвэрлэхийг оролддог байсан бол тэрээр асуудлыг өөр өнцгөөс харахыг санал болгожээ. Гол нь, сонгогчдын саналаа өгөх нь *эрх баригчдыг сонгохтой* холбоотой учраас дээрхи асуудал чухал биш болж гагцхүү ардчилсан зарчим нь өрсөлдөж буй хувь хүн, бүлгээс илүү их санал цуглуулж, илүү дэмжлэг хүлээсэн этгээдэд төрийн эрх мэдэл шилжиж байгаад л оршино²⁷.

Ардчиллын тухай Шумпетерийн үзэл баримтлал нь ардчиллын зөвхөн эхлэлийн (minimum) шаардлагыг хангах нөхцөл юм гээд энэхүү "явцуу" буюу *минималист* үзэл баримтлал нь нийгэм дэх улс төрийн өрсөлдөөн, оролцоо хамгийн чухал зүйл учраас түүнийг бодит утгатай байлгах үүднээс л иргэд тодорхой эрх чөлөөтэй байх ёстойг голлон хүлээн зөвшөөрдөг. Сонгуулийн ардчиллын талынхан суурь эрх чөлөөний асуудлыг онцгойлон "анхаардаггүй" хийгээд иргэнд рационал хандлага эдүүгээ хүчтэй илрэх болсон тул хувийн эрх ашиг нь түүнд голлох сэдэл нь болж, улс төрийн оролцоо нь намын мөрийн хөтөлбөрийг үе үе сонгох, эс сонгохоор л хязгаарлагддаг хэрэглэгч болсон гэж үзнэ. Ийм учраас, хүний суурь эрх чөлөөний асуудлыг ардчиллын бодит хэмжүүрт багтаан харгалзахыг чухалчилдаггүйд хамаг учир оршино²⁸. Энэхүү байр суурийг тухайлбал, эдийн засагт мөн илэрдэгийг тэмдэглэж рационал хэрэглээний онолын (rational choice) чиглэл хөгжсөн байна. Шумпетерийн үзэл баримтлал нь өрнөдийн өндөр хөгжилтэй улсын өндөр албан тушаалтнуудын дунд их дэлгэрч дэмжигдэдийг ихэнхи судлаачид тэмдэглэдэг.

Сонгуулийн өрсөлдөөнийг юу юунаас чухал гэж үзсэнээр ардчиллын бусад хэмжүүрийг умартахад хүргэж болзошгүй ба хэдийгээр олон намын өрсөлдөөн бодит байгаа мэт боловч хүн амын томоохон бүлэг хэсгийг эрх мэдлийн төлөө өрсөлдөх боломжгүй болгох, сонгуульт албан тушаалтнуудын хэт хяналттай, "монополь" эрх мэдлийн хүрээнээс шийдвэр гаргах чухал, чухал асуудлыг салгаж чадахгүйд хүрдэг байна²⁹. Ардчилсан тогтолцоо бүхий улс төрийн системд сонгууль, тэр тусмаа олон нам оролцсон өрсөлдөөнт сонгууль чухал боловч сонгуулийн хооронд багагүй цаг хугацаа өнгөрдөг бөгөөд яг амьдрал дээр иргэдийн хувьд улс төрийн намуудаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн ерөнхий зарчмуудтай танилцаж улс төрд оролцох боломж л үлддэг байна.³⁰ Ардчиллын тухай минималист хандлага сүүлийн жилүүдэд нэлээд шүүмжлэлд өртөж нэг ёсны "их засварт" орох болсон билээ. Энэ нь юуны түрүүнд ардчилсан улсуудын тоонд орж ирсэн боловч сонгуулиар бий болдог албан тушаалтнуудын хяналтаас гадуур бие дааж шийдвэр гаргах эрх бүхий бүлэглэл /тухайлбал цэргийнх эсвэл шашины/ тогтсон зарим улсыг ардчилсан гэдэг ангиллаас хасч судлах шаардлага зүй ёсоор гарсантай холбоотой. Нөгөө талаас, энэ янзаар "шинэчлэгдсэн" ардчиллын тухай ойлголт нь хүн амын цөөнхи болох бага орлоготой эсвэл үндэстний, шашны зэрэг цөөнхид үзүүлж буй улс төрийн дарамтыг таниж мэдэхэд тус дөхөм үзүүлэх боломж багатай ажээ.

Уг үзэл баримтлалын төгс бус байдал нь судлаачдын зүгээс улс төрийн эрх чөлөө хэмээх чухал үзэгдлийн зарим ялгааг бие даасан төвшинд тодорхойлж, ухагдахууны хэмжээнд авч үзэх гээд байдагтай холбоотой³¹ гэж Ларри Даймонд тэмдэглэсэн байна. Тухайн улсад өрсөлдөөн бүхий сонгууль явж байгаа эсэх нь ардчиллын нэгэн хэмжүүр болж байгаатай хэн ч маргалдахгүй. Гэтэл сонгуулийн ардчилал бүхий зөвхөн тэр улсуудын хүрээнд аваад үзэхэд хувь хүн, бүлгийн хүсэл зориг, эрх ашгийг илэрхийлэх эрх чөлөө, эвсэн нэгдэж сайн дурын байгууллага байгуулж сонирхол хэрэгцээгээ

²⁷ Hans-Joachim Lieber. Politische Theorien von der Antike bis zur Gegenwart. Bundeszentrale fuer politische Bildung, Band 299, s. 710.

²⁸ Dieter Nohlen. Lexikon der Politik. Band 7, Politische Begriffe. Muenchen, 1998, s. 113-114.

²⁹ А. Юндэндорж. Нийгэм иргэнлэг, ардчилсан хэв шинжийг олоход төрийн институтын гүйцэтгэх үүрэг. УБ, 2001, 82-85 дахь тал.

³⁰ Schmitter P.C. Karl T.L. What democracy is ... and is Not. "Journal of democracy", 1991, vol.2, p. 78.

³¹ Diamond L. Is the Third Wave over? "Journal of democracy", 1996, vol.7, p.15.

нэгтгэх эрхийн төвшин өөр өөр байгааг ажиглаж болохоор байна. Тухайлбал, курд үндэстний эсрэг хүчирхийллийг хэтрүүлэн хэрэглэсэн Турк улс, Кашмир муждаа цэрэг, аюулыг хамгаалах байгууллагын хүчээр иргэдээ барьж буй Энэтхэг улс, бие даах сонирхол илэрхийлсэн Чеченийн эсрэг цэргийн хүчээр зохицуулалт хийхийг оролдож буй ОХУ болон Югослав, Колумби, Гватемал зэрэг улсыг либерал ардчилалтай улс гэж үзэхэд хүндрэл бий болж байгаа нь судлаачдыг ардчиллын асуудалд илүү нухацтай хандахад түлхэж байгаа нь тодорхой билээ. Эдгээр улсад олон нам оролцсон өрсөлдөөн бүхий сонгууль явагдаж, улс төрийн хүчнүүд засгийн эрхийг ээлжлэн барьж буйгаар ардчилсан улс гэж тооцоох нь хангалттай биш юм гэж үздэгтэй санал нийлэхгүй байхын аргагүй. Тэгвэл, асуудлыг ардчиллын зөвхөн минималист хандлагын үүднээс дээр дурьдагдсан болон үүнтэй төстэй улс төрийн нөхцөл байдал бүхий улсыг ардчилсан гэж тооцох бүрэн үндэстэй болж байгаа юм.

Харин *либерал ардчиллын* байр сууринаас буюу илүү нарийн хэмжүүр хэрэглэвэл байдал өөр болох билээ. Сонгуульт болон либерал ардчиллын хооронд оршиж буй эдгээр тод томруун ялгаа нь ардчиллын “гурав дахь” давалгааны үед хурц мэдрэгдэж эхэлсэн нь улс төрчид, судлаачдын хувьд анхаарал татах асуудал болж ирсэн байна.

Либерал ардчиллын үндсэн шинж чанар. Цаг үе улирах тусам Шумпетерийн ардчиллын тухай товч тодорхойлолт илүү баяжих шаардлагатай тулгарсан нь зүй тогтлын гэж үзэх үндэстэй. Эдгээрээс хамгийн их “боловсронгүй” болж, нэлээд өөрчлөлтөнд орон улмаар ардчиллын онолын хөгжилд чухал нөлөө үзүүлсэн нь өмнөх хэсэгт өгүүлсэн Роберт Доолын “полиархийн” үзэл баримтлал юм. Уг үзэл баримтлалаар бол ардчилал нь улс төрийн өргөн өрсөлдөөн, оролцооны зэрэгцээ үг хэлэх, хэвлэн нийтлэх зэрэг эрх чөлөөний өндөр төвшин, иргэд өөрсдийн улс төрийн хүсэл зориг, тэмүүллийг илэрхийлэх олон ургальч байдлыг нөхцөлдүүлэх учиртай байна.³² Энэхүү үзэл баримтлал нь ардчиллын хөгжлийн түвшнийг тодорхойлох арга зүйн үндэс нь болсон гэж үзэх үндэстэй бөгөөд эдүүгээ ардчилсан хэмээн нэрлэгдэж буй улсуудын дотор либерал ардчилалтай улсыг бусдаас нь ялгах шалгуурын үзэл санааны суурь болж иржээ.

Либерал ардчиллын (liberal democracy) үзэл баримтлалын үүднээс харьцуулбал улс төрийн системд тавигдаж буй шалгуур нь ардчиллын минималист хандлагаас юугаар илүү байна вэ? Энд юуны түрүүнд дараахи шинжийн ялгаа тод харагдана.

1. Чөлөөт, шударга, тогтсон цаг хугацаанд явагддаг өрсөлдөөн бүхий сонгууль хийгээд бүх нийтийн сонгох эрхийн зэрэгцээ либерал ардчиллын нөхцөлд **сонгогчдын хараа хяналтаас гадуур** үйл ажиллагаа явуулдаг эрх мэдэл бүхий улс төр, цэргийн зэрэг бүлэглэл байдаггүй.

2. Эрх баригчид **олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэг** босоо тогтолцооны зэрэгцээ төрийн албан тушаалтнууд мөн хэвтээ хяналтанд байх ба энэ нь ялангуяа гүйцэтгэх засаглалын эрх мэдлийг хязгаарлан тэнцвэржүүлж, үндсэн хуульт ёс, хуульд захирагдах, зөвшилцөх үйл явцыг хамгаална.

3. Либерал ардчилал нь иргэдийн улс төр, нийгмийн олон ургальч байдлыг хөгжүүлэх, **иргэний болон социал бүлгийн эрх чөлөөг** тэтгэх асар их боломжийг бүрдүүлсэн байна.

Энэ бүгдээс үндэслэхэд либерал ардчилал дараахи шинжээр тодорхойлогдоно.

- Төрийн бодит эрх мэдэл шударга сонгуулиар сонгогдон гарч ирсэн албан тушаалтнуудын гарт байх ба эл систем нь үндсэн хуулиар тодорхойлогдсон олон нийтийн хараа хяналтанд байхуйц улс төр, эрх зүйн тогтолцоогоор баталгаажсан байна.

³² Dahl R. A. Polyarchy: Participation and Opposition. New Haven, 1971, p. 3.

- Гүйцэтгэх засаглалын эрх мэдэл үндсэн хуулиар хязгаарлагдаж энэ нь шүүх, парламент зэрэг төрийн бие даасан засаглалын өндөрлөгийн үйл ажиллагаагаар баталгаажна.

- Либерал ардчиллын нөхцөлд сонгуулийн дүн урьдчилан мэдэгдэх боломж багатай, сөрөг улс төрийн хүчнийхэн ялах, намууд засгийн эрхийг ээлжлэн барих бодит боломжтой хийгээд үндсэн хуулийн үзэл баримтлалыг талархан дэмждэг улс төр, социал аль ч бүлэг улс төрийн зохион байгуулалтанд орох эрхээр хангагдаж сонгуульд оролцох нөхцөл бүрэлдсэн байна.

- Соёл, үндэс угсаа, шашны зэрэг нийгмийн том, жижиг гэлгүй бүхий л бүлгүүд өөрсдийн эрх ашгаа илэрхийлэх, улс төрийн үйл явцад оролцох болон өөрсдийн хэл соёлоо хэрэглэх бүрэн эрхтэй байна.

- Улс төрийн олон намын систем болон тогтмол явагдах сонгуулийн зэрэгцээ иргэд хүсэл зориг, сонирхлоо илэрхийлэх бусад олон суваг нээлттэй байна. Үүнд төрийн бус байгууллага, эвсэл холбоо, хөдөлгөөн зэрэгт чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхээр иргэд бүрэн хангагдсан байхыг ойлгоно.

- Эвлэлдэн нэгдэх эрхийн зэрэгцээ бие даасан, хэн нэгнээс хараат бус мэдээллийн эх үүсвэрүүд бодитойгоор оршин тогтнож үйл ажиллагаа явуулан иргэд мэдээллийг олж авахад улс төрийн ямар нэгэн хязгаар тогтоогоогүй байна.

- Үндсэн хуулиар иргэд хүний үндсэн эрх, эрх чөлөөгөөр хангагдаж энэ нь бодитойгоор хэрэгжих эрх зүйн орчин бүрдсэн байна.

- Хэдийгээр амьдрал дээр улс төрийн нөөц боломжийн хувьд ялгаа байх авч бүх иргэд улс төрийн хувьд ижил тэгш байж, уг эрх нь аль нэг улс төрийн хүчнээс ангид орших бие даасан, хараат бус шүүхийн тогтолцоогоор найдвартай хамгаалагдана.

- Хуулийн үйлчлэлээр иргэд аливаа нэгэн хууль бус үйлдлээс хамгаалагдаж, хувийн амьдралд үндэслэлгүй оролцох төрийн болон бусад хэн нэгний халдлагыг хориглосон байна.

Либерал ардчиллын эдгээр шинж нь ардчиллын харьцангуй өндөр хөгжлийг тодорхойлох арга зүй болж байна. Өөрөөр хэлбэл, *сонгуульт ардчилал* нь хөгжлийн ардчилсан загварын эхний нөхцлийг хангаж байгаа бол *либерал ардчилал* нь түүний чанарын дээд түвшнийг тодорхойлох хэм хэмжээг өөртөө агуулж байгаагаарай онцлогтой.

Бүхэлдээ ардчилсан дэглэмийн хөгжил, үйл явцын өрнөлтийг ойлгож мэдэхийн тулд улс төрийн дэглэмүүдийн дотор ардчиллын наад захын шаардлагыг хангаагүй боловч цэвэр тоталитар тогтолцооноос мөн ялгаатай гуравдахь төрөл бас байдгийг үүний зэрэгцээ тэмдэглэх хэрэгтэй. Эдгээр дэглэм нь (тэдгээрийг "хуурамч" (quasidemocracy) ардчилал хэмээн нэрлэдэг)³³ өөртөө электорал ардчиллын тулгуур олон шинжийг агуулсан бөгөөд сөрөг намууд хууль ёсоор оршин тогтнож болох хэдий ч ардчиллын хувьд зайлшгүй байх ёстой шинж болох эрх баригч намыг засгийн эрхээс халж чадахуйц харьцангуй шударга өрсөлдөөний талбарыг бүрдүүлж чадаагүй байдаг байна. Хуурамч ардчиллын олон хувилбар байдаг байна. Тухайлбал, эрх баригч гол нам нь сөрөг намуудыг шахан дарж, хоёрдугаар зэргийн хүчин болгох үүднээс албадлага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хяналт зэргийг өргөнөөр хэрэглэдэг "манлайлагч нам бүхий" тогтолцоо (тухайлбал 1988 он хүртэл Мексикт байсан шиг) байдаг байна. Олон нам дотроос эрх баригч нам нь ардчилсан бус засаглалыг тогтоохын төлөө мэрийдэг боловч тэр нь сул илэрдэг, мөн үүнтэй ижил төстэй бөгөөд илүү өрсөлдөөний загвар луу шилжиж буй электорал тогтолцоо эсвэл нэг хүний ноёрхол бүхий боловч институтжилтын түвшний хувьд сул (тухайлбал Казахстан) дэглэмүүдийг хуурамч ардчилал хэмээн үздэг байна³⁴.

³³ Diamond L. Is the Third Wave over? "Journal of democracy", 1996, vol.7, p.18.

³⁴ Freedom House. Freedom in the World. The Annual Survey of Political Rights and Civil Liberties. N.Y., 1991-1995, 1995-2000, Freedom Review.

Илүү хатуу тоталитар дэглэмээс хуурамч ардчилсан хэмээгддэг нь сөрөг нам оршин тогтнохыг зөвшөөрдгөөрөө ялгардаг. Энэхүү ялгаа нь онолын хувьд мөн чухал юм. Ардчиллыг хөгжлийн үйл явцын байр сууринаас, өөрөөр хэлбэл түүнийг гэнэт бус, шинж төлөв нь бага багаараа аажим үүсдэг тогтолцоо хэмээн авч үзвэл эрх мэдлийн төлөө хоорондоо өрсөлдөх, парламентад суудалтай болох бололцоогоор хангагдсан, хуулиар зөвшөөрөгдсөн улс төрийн сөрөг намуудын оршин тогтнол, түүнчлэн иргэний нийгэм хөгжих илүү өргөн орон зай (энэ нь хуурамч ардчилсан тогтолцоонд ихэнхдээ өгөгдсөн байдаг) нь хэтдээ ардчилсан хөгжлийн замд орох чухал үндэс суурь болдог ажээ. Өөрөөр хэлбэл, **хуурамч ардчилал нь сонгуулийн ардчилалд хүргэж болох магадлалтай** гэдгийг онцлон тэмдэглэх нь чухал юм.

Ардчилал тухайн улс үндэстний хэмжээнд хөгжлийн загвар болон хүлээн зөвшөөрөгдөх эсвэл хоосон тунхаглагдах хоёр өөрөө эрс тэс өөр үр дүнд хүргэдэг бөгөөд бидний судалгаанд илүү анхаарал татаж буй асуудал бол ардчиллын хөгжлийг бодит байдалд хэрэгжүүлэхийг эрмэлзэж буй практик үйл явц юм. Тийм ч учраас ардчилсан гэж өөрсдийгөө өмгөөлж буй боловч амьдрал дээр тоталитар улс төрийн дэглэм бүхий улсуудын жишээг тусгайлан энд авч үзэхийг зориогүй болно.

Ардчилал нь тухайн улсын хөгжлийг тодорхойлох үзэл баримтлал болж үндсэн хуулийн хэмжээнд тунхаглагдах нь уг хөгжлийн улс төрийн зөвхөн гарааны нөхцөлийг хангаж байгаа бөгөөд нийгмийн амьдралын бүхий л хүрээг тодорхойлох, иргэдийн улс төр, иргэний, эдийн засгийн зэрэг эрх чөлөөг хангахуйц болтлоо хөгжихөд нэлээд хүчин чармайлт шаардадгийг бусад улсын жишээ тод харуулж байна. Ардчиллын замаар хөгжиж буй улсууд, нэн ялангуяа уг үйл явцад шинэхэн хамрагдсан улс үндэстнүүд өмнөө учирч буй хөгжлийн олон бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэж буй байдлыг бүхэлд нь харьцуулахад ардчиллын дэвшлээс ухрах магадлал бас байгааг олж харж болохоор байна. Энэхүү хөгжлийн үйл явцыг илүү тодорхой судлах, харьцуулах, хөгжлийн явцад бий болж болзошгүй зөрчил, саад бэрхшээлийг урьдчилан таамаглах үүднээс ардчиллын илрэлийг ялган зааглаж, түүний хөгжлийн төвшин, тэдгээрийн онцлогийг судлах арга зүй чухал болно гэж үзэж байна.

Энэхүү хэсэгт бидний судлаж тусгасан зүйлсийг нэгтгэн дүгнэхэд, ардчиллын үнэлэмж, хэм хэмжээ, түүнд хувь хүний улс төрийн болон иргэний эрх чөлөөг ямар хүрээнд багтааж ойлгож байгаа байдлаар нь **хуурамч ардчилал** (энэ нь либерал ардчиллын хэлбэрийг шууд бий болгохгүй боловч сонгуульт ардчиллын хэлбэрт хүргэх магадлалтай байдаг), **сонгуульт ардчилал** (либерал ардчилалд хүргэх магадлал өндөртэй боловч эргээд ухрах, захиран тушаах харилцааг сэргээх магадлал мөн өндөртэй) болон **либерал ардчилал** гэсэн ардчиллын гурван хэлбэрийг ялгаж үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

Ардчиллын үнэлэмж, үнэт зүйл, хэм хэмжээ, эдгээрийг нөхцөлдүүлж буй улс төр, хууль эрхийн ерөнхий болон дэд системүүдийн үйлчлэл нь ардчилсан хөгжлийн тогтвортой байдлыг хангах бөгөөд энэ нь эргээд иргэдийн эрх, эрх чөлөөний баталгаа болдог байна. Нийгмийн амьдралын хөгжлийг тодорхойлох ардчилсан хэм хэмжээ нь нийгмийн бүхий л харилцааг харилцан хамааралтай зохицуулж байгаа болон ялангуяа нийгэмд үйлчилж буй улс төрийн ардчилсан соёл нь харьцангуй тогтвортой хөгжиж ирсэн улсуудын ардчиллыг **consolidated democracy** буюу нягтарсан ардчилал хэмээн нэрлэж байна. Энэ нь **ардчилсан хөгжлийн чанарын илэрхийлэл** болох бөгөөд ардчиллыг сонгосон улс үндэстний хувьд ерөнхий утгаараа зорьж буй зорилтын хэмжээнд ойлгогдож байгаа болно.

С.Дан-Аажав.

Профессор

Нийгмийн өөрчлөлт шинэчлэлтэд мэдээллийн хэрэгслийн үүрэг.

Улс төр судлалын ном, зохиолуудад олонтаа дурьдагдсан нэг үндсэн тодорхойлолт нь

- Улс төрийн байгууллага
- Улс төрийн харилцаа
- Улс төр, эрхийн хэм хэмжээ буюу нормууд
- Улс төрийн ухамсар ба улс төрийн соёлыг улс төрийн тогтолцооны дөрвөн гол элемент гэж үздэг билээ.¹ Улс төрийн тогтолцооны эдгээр элементүүдийн хооронд холбогчийн үүрэг гүйцэтгэж тус бүрд нь адил тэгш үйлчилдэг маш чухал институт бол Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (цаашид ОНМХ гэж нэрлэнэ) мөн гэж улс төр судлал үздэг билээ.

ОНМХ бол төрөлх шинжээрээ улс төрийн биш нийгмийн институт бөгөөд улс төрийн тогтолцоонд өөрийн өвөрмөц байр суурь эзэлдэг. Үүний төрөлх шинж буюу нийтлэг мөн чанарыг үндэслэж зарим ном, сурах бичигт: "дөрөвдэх засаглал" гэж нэрлэж байна. Энэ нь чухамдаа ардчилсан нийгмийн үед л жинхэнэ утгаараа хэрэгжих үндэстэй бөгөөд харин тоталитар дэглэм буюу улс төрийн системд лалын шашин голлосон орон, эсвэл нэг намын үзэл суртлын ноёрхлын үед дөрөвдэх засаглалын үүргийг гүйцэтгэх бололцоогүй, харин түүний үзэл суртлын зэвсэг болдог нь өнгөрсөн үеийн түүх бидэнд ойлгомжтой сургамж үлдээсэн билээ.

Харин ардчилсан тогтолцооны нөхцөлд ОНМХ нь бие даасан шинжтэй, улс төрийн тогтолцоонд нөлөөлөх, хяналт тавих бүрэн бололцоо нээгддэг байна. Гэхдээ энэ нь хууль тогтоох засаглалын зүгээс эрх зүйн хувьд эрхээ эдлэх бололцоо бий болгосон байх шаардлагатай. Гэхдээ ардчилсан тогтолцооны үед ч бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүрэн чөлөөтэй болж чаддаггүй. Учир нь: Олон эшт үзэл нийгмийн үзэл суртлын салбарт зонхилж байгаа, нөгөө талаас улс төрийн олон нам, янз бүрийн чиглэл бүхий улс төр, олон түмний хөдөлгөөн оршиж байгаа нөхцөлд ОНМХ нь яг нэг хэлбэр загвартай, цөм адилхан чөлөөтэй болж хараахан чадахгүй. Ийм учраас онолын хувьд ОНМХ бүрэн тэгш байх гэдэг нь харьцангуй ойлголт юм. Гэхдээ энэ нь ОНМХ чөлөөтэй байх бололцоогүй гэсэн үг биш. Харин ОНМХ-ийн хөгжлийн явцад янз бүрийн хэвлэл, мэдээллийн хэрэгслэлийг олон өнцгөөс харах, түүний үйл ажиллагааны практик талыг голлон анхаарах хэрэгтэй гэсэн үг.

ОНМХ нь нийгмийн системийг бүрдүүлж байгаа улс төрийн байгууллага, газар, улс төрийн харилцаа, соёл, ухамсар, эрхийн хэм хэмжээнд ямар нөлөө, үүрэг гүйцэтгэж байгаа байдлаар нь: ОНМХ-ийг **хараат бус; харъяалалтай** гэж хоёр хувааж үздэг. **Хараат бус** гэдэгт: аливаа улс төрийн нам, хөдөлгөөн, төр, засгийн байгууллага, эдийн засаг-санхүүгийн тодорхой бүлэглэлээс ангид, түүний харъяа бус хэвлэл, мэдээллийн газрууд, **харъяалалын** гэдэгт: дээрхи аль нэгэн байгууллага, газрын харъяанд, түүний хөрөнгө санхүүгийн дэмжлэгээр гардаг хэвлэл, мэдээллийн газрууд ордог.

Хараат бус ОНМХ нь улс төрийн үзэл бодлоор ялгаварлахгүй, хамгийн шударга, үнэн зөв мэдээллийг олон нийтэд хүргэх үүрэгтэй, түүнийгээ биелүүлдэг байх нь хамгийн чухал. Энэ нь ардчилсан нийгмийн тогтолцооны ОНМХ-ийн хөгжлийн үндсэн чиг үүрэг, хандлагыг тодорхойлдог байна. Харин харъяалалтай ОНМХ нь тухайн нам, хөдөлгөөн, эдийн засаг-санхүүгийн эрх ашгийг эрхэмлэн үздэг, түүний эрх ашигт харш бол аливаа улс төр, нийгэм, эдийн засгийн мэдээллийг олон нийтэд хүргэхийг сонирхдоггүй байна. ОНМХ нь дараах үндсэн үүргийг харъяалал харгалзахгүй биелүүлэх үүрэгтэй:

¹ Политология. Курс лекций. Москва. "Изд."Центр", под редакцией А.А.Радусина. с-79.

- Юуны өмнө олон нийтэд чөлөөт мэдээллийг хүргэж, олон улсын болон улс орны дотоод амьдралын чухал асуудлаар үнэн зөв, шударга мэдээлэл түгээх;

- Нийгмийн тодорхой бүлгүүдэд тэдний сонирхож байгаа мэдээллийг хүргэх, тэгэхдээ хүн амын бүтцийн онцлог, хот хөдөөгийн өвөрмөц байдлыг харгалзан уншигч, үзэгч, сонсогчдод туслах;

- Хүн амын ухамсар, боловсрол, соёл, эрхийн хэм хэмжээний талаар мэдлэг түгээх, өөрөөр хэлбэл өөрийн уншигч захиалагч, үзэгч, сонсогчдыг соёлжуулах, ШУ-ны мэдлэг түгээх;

- Төр, нам, ялангуяа эрх барьж бүхий нам, төр, засаг, эдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, улс төрийн субъектүүд, зүтгэлтэн, удирдагч, элитүүдийн ажил хэрэг, олот, алдаа дутагдал, ёс бус үйл ажиллагааг илчлэн олон түмэнд хүргэх, тэгэхдээ сэтгүүлч-сурвалжлагчдын хувийн үзэл бодлыг голлохгүй, үнэн баримттай нотолгоо сайтай байх нь орчин үеийн ОНМХ-ийн гол үүрэг болж байна;

- Олон түмний анхааралд хүргэх ноцтой, шуугиан тарихуйц мэдээллийг эрж хайж олоод түүнийгээ олон нийтэд зохистой аргаар хүргэх замаар уншигч, үзэгч, сонгогчдын оюун санааны хэрэгцээг хангаж ухамсарт нь нөлөөж байх;

- ОНМХ-ийн өвөрмөц үүрэг болох улс төр, олон нийтийн хөдөлгөөн тухайлбал, төрийн сонгууль, төрийн үйл ажиллагааны улс орны нийтлэг хөтөлбөр, түүний хэрэгжилт, улс төрийн намуудын үзэл бодлын чиглэл, ялгаа, тэднээс олон түмэнд амалсан амлалтын үнэн бодитой эсэх талаар тодорхой мэдээлэл өгөх;

- ШУ, соёл шашны чиглэлээр олон нийтийн ухамсарт туслахуйц танин мэдэхүйн мэдлэг түгээх зэрэг болно.

Эдгээр үндсэн үүргээс гадна ОНМХ-ийн өөрийн нь өвөрмөц онцлогийг тодорхойлж болдог. Жишээ нь: Хүүхдийн хэвлэл, хүүхдийн радио, телевизийн нэвтрүүлэг нь гол нь тэдний танин мэдэх гэсэн хүсэл эрмэлзэл, хүмүүжилд нь нөлөөлөх үүрэгтэй бол утга зохиол, урлагийн хэвлэл, мэдээлэл нь олон түмний оюун ухаанд нөлөөлж, нийгмийн бодит байдлыг уран сайхны дүрээр илэрхийлдэг, гэтэл улс төр, нийгмийн чиглэлийн ОНМХ нь төр засаг, улс төрийн нам, удирдагч, сонгогч олон түмний харилцаа, үйл ажиллагааны мэдээлэл түгээхэд тус тус оршдог.

Хэдийгээр бид чөлөөт хэвлэлийн талд бат зогсож байгаа боловч хэвлэл, мэдээллийг эрхлэн гаргадаг сэтгүүлчид-нийтлэгчид нь өөрөө нийгмийн улс төрийн амьдралд идэвхитэй, эсвэл идэвхгүй оролцдог бүлэг хүчний хувьд хэвлэл мэдээлэл нь хараат бус байлаа ч гэсэн түүнд ажиллагсад нь аль нэг нам, хөдөлгөөнийг дэмждэг, талархдагаас үндэслэн аль нэгэн улс төрийн хүчнийг талархдаг, дэмждэг байж болдог. Үүнийг олон улсын практикт "ерөнхийлөгчийг дэмждэг", "шинээр сонгогдсон парламентад талархалтай ханддаг", "тэр намыг талархдаг" гэх мэт утгаар нэрлэх нь бий. Ийм хандлага ардчилсан тогтолцооны үед байсаар байгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүрэн чөлөөтэй байна гэдэг харьцангуй ойлголт гэдгийг харуулж байгаа хэрэг. Ингэхлээр хэвлэл, мэдээлэл чөлөөтэй байна гэхээр тэд бүх улс төрийн нам, хөдөлгөөн, төр засгийн эсрэг сөрөг хүчин болчихдог юм шиг гэнэн ойлголтыг няцааж байгаа юм.

Одоо Монгол улсад үндсэндээ чөлөөт хэвлэл, мэдээлэл (сонин, FM-радио, хувийн болон төр, засгийн ТВ, мэдээллийн агентлагууд) бий болон төлөвлөж байна. Гэхдээ харъяаллын хувьд:

- Улс төрийн намын (UBS ТВ, "Үнэн", "Үг", "ардчилал", "Эх орон", "Улаанбаатар таймс" сонин зэрэг аймаг хотын ИТХ-ын харьяа сонин, ТВ,)

- Тодорхой эдийн засаг санхүүгийн бүлэглэлийн: ("Өнөөдөр", "Монголын мэдээ" сонин, "25-р суваг" зэрэг)

- Хувийн харъяалалгүй: ("Сэрүүлэг", "Дээдсийн хүрээлэн", "Өдрийн сонин", "Зууны мэдээ", "Хөх тобло" зэрэг олон тооны сонин FM радио долгион орно)

- Хэдийгээр хувийн харъяалалгүй, чөлөөт бие даасан гэж нэрлэж байгаа ч тодорхой нам, улс төрийн хүчин, төр засгийг дэмждэг, түүний үзэл бодлыг хатуу дэмждэг, өөр бусад нам, төр, засгийн эсрэг сөрөг хүч болсон сонин, радио, телевиз, FM зэрэг олон тооны хэвлэл, мэдээлэл байсаар байна. Жишээ нь: "Өдрийн сонин" Ардчилсан намын бодлогыг, "Зууны мэдээ" сонин одоогийн засгийн газрын үйл ажиллагааг дэмждэг, "Өнөөдөр" сонин ерөнхийлөгчийн үйл ажиллагааг дэмждэг, "Монголын мэдээ" МАШСН, "Эрэл" компанийг, "Дээдсийн хүрээлэн", "Хүмүүс", "Дээдсийн амьдрал" зэрэг олон тооны харъяалалгүй, чөлөөт гэж өөрийгөө нэрлэдэг сонинууд Ардчилсан намыг тууштай дэмжиж байгааг уншигч, сонсогч, үзэгчид ойлгож мэддэг болжээ.

Монгол улсад шинэ үндсэн хууль (1992) батлагдсан үеэс эхлэн чөлөөт хэвлэл жинхэнэ утгаараа хэрэгжиж эхэлсэн ба "Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль" (1995) батлагдсанаар ОНМХ-ийн чөлөөт байдлыг тунхаглав. Энэ бол манай улс төрийн системд гарсан ардчилсан шинэ өөрчлөлт болсон юм. Үүнд 1990 онд сайд нарын зөвлөлийн дэргэдэх хэвлэл утга зохиолыг хянах газрыг татан буулгасанаар төрөөс хэвлэл-мэдээллийн хэрэгсэлд хяналт, цинзур тавьдаг хуучин тогтолцоог устгасан нь чухал нөлөөтэй болсон юм.

Өнөө үед хэвлэл мэдээллийн хэрэгсэл чөлөөтэй болж, хэн дуртай нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл эрхлэх бололцоотой болж, ОНМХ нь юу дуртайгаа бичих, ярих, үзүүлэх болсон том ололт гэж үзэхийн хамт ОНМХ-ийн өөрийн нь нэр төр төдийлөн өсөхгүй, олон түмний зүгээс байнгын үл итгэх, өөчлөн шүүмжлэх болсон нь Монголын улс төрийн тогтолцоонд ОНМХ-ийн гүйцэтгэх үүргийг ихээхэн сулруулж, цаашид хөгжих замд нь саад тогтор тохиолдох нөхцөл бүрдүүлж байна гэхэд хилсдүүлсэн болохгүй.

Энэ юунаас болж байна вэ? Гэдэгт зөвхөн сэтгүүлчид, бичих эрх эдэлж байгаа хүмүүс төдийгүй, нийгмийн улс төрийн тогтолцоог зөв гольдролд оруулж, цаашид хөтлөн явах үүрэгтэй төр засгийн удирдлагууд нэгдсэн дүгнэлт хийх цаг болсон гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Миний ойлгож байгаагаар дээрх ОНМХ-ийн өнөөгийн хөгжлийн явц нь: *нэгдүгээрт*, нийгмийн улс төрийн тогтолцооны төлөвшлийн хэр хэмжээг илэрхийлж байна. Тухайлбал: нийгмийн харилцааны дотроос хэвлэл, мэдээлэл олон түмэн төр, засгийн гурвалсан харилцааны хэм хэмжээ тогтож хэвшиж чадаагүй энэ талаар сэтгүүлч-хүмүүс төр засгийн удирдагчдын ойлголт нэгдмэл болоогүй хэсэг бүлэг, алаг цоог байгаатай холбоотой. Сэтгүүлчид "Хэрэв ардчилсан чөлөөт хэвлэл бол хориглоогүй зүйл бүхнийг бичиж болно. Үүнээс өөр ойлголт бол ардчиллыг боомилох, эсвэл хуучинсаг ойлголт мөн. ("Өнөөдөр" сонин, 2002-04-08 №) гэж үздэг бол уншигчид нь сонин, сэтгүүл, радио, телевиз бичсэн сонсгосон, үзүүлсэн бүхэн нь үнэн байх ёстой" гэж итгэдэг, харин төр, засгийн удирдагчид нь: "хориотой нууц зүйл буюу хувь хүний амьдрал нь хэвлэл мэдээллээр бичиж, олон түмэнд дэлгэн тавих зүйл биш" гэж ойлгодог нь нийтлэг байна. Гэтэл эдгээр зөрүү ойлголтыг нэгтгэх буюу ойролцоо болгох нийгмийн харилцааны механизм буюу ОНМХ-ийн үйл ажиллагааны хэм хэмжээг ойролцоогоор тогтоосон хууль эрхийн акт байхгүй байна. Ийм болохоор тэр нь зөв, энэ нь буруу гэж зориглож хэлэх хүн алга байна. "Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай" 1995 онд УИХаар баталсан хууль бол зөвхөн зарчмын цөөхөн зүйлийг тунхагласан болохоос биш, нийгмийн харилцааны дээрх нарийн төвөгтэй үйл явцад мөрдөж, баримтлах зүйл хараахан биш юм.

Эдгээрээс үндэслэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр бичиж шуугиулж байгаа ёс бус зүйл, гүтгэлэг хувь хүний нэр төр гутаасан зүйлийг няцаах, эс бөгөөс хуулийн байгууллага авч хэлэлцлээ гэхэд "чөлөөт хэвлэлийг хавчиж байна. Сэтгүүлчдийг дарамталлаа" гэсэн шалтаг гарган, зарга үүсгэж бие биеэ өмгөөлж, хараат бус, харъяалалтай, бор, шар гэсэн нэртэй бүх хэвлэл, мэдээллийн ажилтнууд нэгдэж ажилтнууд нэгдэн тэмцдэг болов.

Энэ нь нэг талаас: хэвлэл, мэдээллийн эрх чөлөөг дээдэлсэн шинжтэй боловч нөгөө талаас өөрсдийн ёс зүйгүй байдлаа өмгөөлөн хамгаалсан шинжтэй болж байна.

Үүнээс болж төр, засгийн удирдагчид ямар ч хэвлэл, мэдээллийн ташаа буруу, ёс зүйгүй нийтлэл, нэвтрүүлгийн талаар үг хэлж, няцаасанд орвол дуугүй орхисон нь дээр гэж үздэг, нэг үгээр хэлбэл: амаа үдүүлсэн байдалтай болжээ.

Түүгээр ч барахгүй үг хэлж, няцаасны хариуд нь “Монголд ардчилал байхгүй болж, ардчилал аюулд орлоо” гэж дэлхий нийтэд зарлаж, гадаад дахь өөгшүүлэгч түншдээ эх орон, улс төрийн тогтолцооны тухай хов зөөж, өөрийгөө өмгөөлүүлсэн хариу үг хэлэхийг хошуу цорвойлгон гуйх болжээ. Энэ бол Монголчуудын зан заншлаар бол “айлын эрх хүүхэд тэнэг зөрүүд зангаараа тунирхаж байгаа” мэт харагдах аж.

Монгол улсад чөлөөт ардчилсан хэвлэл, мэдээлэл хөгжиж байгаа нь дэлхий нийтийн нэг чухал ололт Монголын газар нутагт цэцэглэж байгаа гэж мольхи би ойлгохын хамт энэхүү чөлөөт, ардчилсан хэвлэл, мэдээлэл зөв гольдрилоор хөгжөөсэй гэж хүсдэг хүний нэг.

Гэтэл өнөөдөр Монгол улсад гажиг (парадокс) гэж хэлэхүйц сэтгүүл зүй хөгжиж, энэ нь ОНМХ-ийн үйл ажиллагааны нэг ёсны хэм хэмжээ болон төлөвшиж байна. Гэхдээ бүх хэвлэл, мэдээллийн хэрэгслийг үүнд хамааруулах нь арай хавтгайруулж буруутгасан өрөөсгөл хандлага болох бизээ. Харин өнөөгийн хэвлэл мэдээллийн ихэнх нь гэж хэлэхэд нэг их дэгсдүүлсэн болохгүй. Өнөөдөр Монголд хууль зүй, дотоод хэрэг, хууль зүйн яаманд бүртгүүлснээр 1090 сонин гарах ёстойгоос 2002 оны эхний байдлаар: 180 сонин, 50 сэтгүүл, 36 радио, 31 телевиз, 9 кабелийн телевиз үйл ажиллагаагаа идэвхитэй явуулж (“монголын хэвлэл мэдээллийн мониторинг” “Өнөөдөр” сонин 2002-04-11 №87 2549 дугаарт үз) байна гэсэн албан ёсны судалгаа бий.

Үүний ихэнх нь нийтлэл, нэвтрүүлэгтээ хоосон ул мөргүй зүйлээр шуугиан тарих, (газар хөдөлнө. Шүлхий өвчин гарлаа. ДОХ-той хүн нас барав г.м) хувь хүний нэр төрд харш мэдээлэл цацах, дайрч гүтгэх, ерөнхийлөгч хятадаас олон сая доллар авчээ... Тэр мөн авгай авч байжээ... Ерөнхий сайд нэг яруу найрагчтай явалдаж байжээ... Тэр... манин юм гэнэ г.м) зэргээр ёс зүйгүй, баримт нотолгоогүй, худал хуурмаг зүйлээр шуугиан дэгдээх, цуурхал тараахад оролцож байгааг үгүйсгэх аргагүй.

Ийм нийтлэл, нэвтрүүлгийг би гажиг (парадокс) сэтгүүл зүй гэж үзэж байгаа билээ. Энэхүү гажигтай (парадокс) сэтгүүл зүй гэдэг нь:

Нэгдүгээрт, хэвлэл, мэдээлэлд ажиллаж түүнийг эрхлэн гаргаж байгаа сэтгүүлчид, нийлэлчид “сэтгүүлийн ёс зүй” гэдэг гол зарчмыг тунхагласан тэрхүү бичигдээгүй хуулийг үл хэрэгсэн, зориуд болон санамсаргүй байдлаар зөрчиж байгаа явдал;

Хоёрдугаарт, чөлөөт гэдэг нэрээр хувь хүний нэр төр, түүнийг амьралын нийтэд дэлгэмээргүй нарийн ширийн зүйлийг болон явуургүй хов жив хөөцөлдөж дур зоргоороо, ичиж зовохгүй бичиж, ярьж үзүүлэх болсон, үүнийгээ эрх чөлөө, ардчилсан ёс гэж эндүүрч ойлгож байгаа;

Гуравдугаарт, худал хэлэх, шуугиан дэгдээх, гүтгэх, доромжлох, бүдүүлэг үг хараал хэлэхийг цээрлэдэг ёс зүйт зарчмыг умартан энэ бүхнийг зориг, зүтгэл гэж андуурах болсон;

Дөрөвдүгээрт, зах зээлийн харилцаа гэдэг шалтгаар ашиг олох, мөнгөний төлөө үхэн хатан хөөцөлдөх болж, тусгай захиалгаар мөнгө авч хувь хүн, албан тушаалтан байгууллагыг гүтгэх явдал үзэгдэж байгаа;

Тавдугаарт, чөлөөт хэвлэлийн гол зарчим болсон өөрийн хяналт, өөрийн цинзурыг үл ойшоож, “Өнөөдөр л болж байвал маргааш надад хамаагүй” гэсэн

хариуцлага үл тоох зарчим баримтлах болсон зэрэг нь манайд гажиг сэтгүүл зүй хөгжих үндсэн хөрс болж байна.

Энэ үзэгдэл юунаас болж байгаад ч дүгнэлт хийх нь чухал: Миний ойлголтоор юуны өмнө ардчилал, зах зээлийн харилцааны нөхцөлд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл эрхлэх боломж олдож, түүнийг мэргэжлийн биш олон хүн эрхлэх, эзэмших болсноос жинхэнэ ардчилсан сэтгүүл зүй буюу иргэний сэтгүүл зүй төлөвшиж чадахгүй байгаа;

Нөгөө талаар: Монголд мэргэжлийн сэтгүүлчдийн байгууллага хуваагдмал байдалд орж, сэтгүүлчдийг мэргэжлийн хувьд санамж, үзэл бодлын хувьд зөрөөтэй болгож, тэд өргөн олон нийтэд биш, өөрийн үзэл бодлоороо нийгмийн хэсэг, бүлгүүдэд үйлчлэх болсон нь мэргэжлийн эрх ашиг бус, хувийн эрх ашгийг эрхэмлэх болсонтой холбоотой.

Харин 2002 оны IV сард хоёр гол сэтгүүлчдийн байгууллага нэгдсэн нь одоо энэ байгууллага нэгдсэн нь одоо энэ байгууллага мэргэжлийнхээ эрх ашигт үйлчлэх бизээ гэсэн сэтгэгдэл төрүүлэх боллоо. Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн дүрэмд: "МОНЭ нь хэвлэл, мэдээллийн эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, ардчилсан олон ургальч, ёс зүйт, хариуцлагатай, чөлөөт, хараат бус хэвлэл, мэдээлэл хөгжиж төлөвших улс төр, хууль эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэхэд туслах, гишүүдийнхээ мэргэжлийн болон хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, хамгаалах зорилготой" гэж (мөн дүрмийн 3.1 дэх зүйл) заажээ. Энд жинхэнэ "ёс зүйт", хариуцлагатай, чөлөөт хараат бус" гэсэн чухал тодорхойлолт орсон нь Монголд жинхэнэ сэтгүүл зүй цаашид хөгжих байх гэсэн найдвар төрүүлж байна.

Харин жинхэнэ сэтгүүл зүй ОНМХ-д төлөвшихөд төр, засгийн зүгээс бодитой туслалцаа, эрх зүй, эдийн засгийн шинэ орчин бүрдүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай байна.

Ялангуяа хэвлэл, мэдээллийн үйл ажиллагааны статус, зарчмыг тодорхойлсон хууль, МҮРТВ-ийг үндэсний Р, ТВ болгох тухай хууль, тогтоол гаргах, сэтгүүлчдийн эрх, эрх чөлөөг баталгаажуулах, тэднийг хамгаалах, мэдээллийг чөлөөтэй эрж хайх нөхцөл бүрдүүлэх зэрэг нэн чухал эрхийн хэм хэмжээг тогтоож өгөх нь түүнийг журамлах дэглэхэд биш, харин хариуцлагатай, ёс зүйтэй болгоход чиглэх нь мэдээж. Мөн орон нутгийн сонин, радио, ТВ-ийн статусыг ч зөв тогтоох шаардлагатай. Бас өвөрмөц мэргэжилтэй сэтгүүлчдийн нийгмийн асуудлыг шийдэх, аюулгүй байдлыг хангах засгаас анхаарч хийх ажил их байна.

Нөгөө талаар уншигч, сонсогч, үзэгчдийг иргэний сэтгүүл зүй, олон эшт үзэлд хөтлөх шаардлагатай. Өнөөгийн ОНМХ-д үл итгэх явдлыг арилгах хэрэгтэй. Үүнийг дангаараа ОНМХ хийж дөнгөхгүй, харин төр засаг, улс төрийн нам, төрийн бус байгууллагын туслалцаа нэн чухал.

Монголын нийгмийн тогтолцоонд байгаа гажиг үзэгдэл бүхнийг сэтгүүл зүй, ОНМХ-д тохож болохгүй. Учир нь: нийгмийн харилцааны нэг өвөрсөц тал болох ОНМХ-тэй холбоотой хэсэг нь улс төрийн тогтолцооны бүхийл сайн мууг төлөөлж чадахгүй. Гол нь нийгмийн харилцааг зохицуулагч хууль эрх зүйн зохистой орчинг бүрэлдүүлэх нь онголын парламент-УИХ-д бүрэн ногдоно гэж үзвэл зохистой.

Монголын нийгмийн тогтолцооны гол үүрэг гүйцэтгэгч "дөрөвдэх засаглал" гэж нэрлэгддэг ОНМХ нь нийгэм, ард иргэдэд үйлчлэх үүргээ хэр сайн биелүүлнэ, тэр хэмжээгээр манай орны нийгмийн харилцаа боловсронгуй болж, ардчилал, зах зээлийн чөлөөт харилцаа улам бүр хөгжих болно гэдэгт зөвхөн улс төр судлаачид төдийгүй ОНМХ-ийг эзэмшигч сэтгүүлч нөхөд маань бүрэн итгэлтэй байгаа нь мэдээж.

Ч.Өлзийсайхан

Магистр

Шинэ элитийн төлөвшлийн асуудалд

Улс орны нийгэм, эдийн засгийн амьдралд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байдаг нийгмийн шилдэг, удирдагч хэсгийнхний үйл ажиллагаа, зорилго чиглэл, амьдралын хэв маяг, амжилтанд хүрсэн зам, арга хэрэгслэл нь хэзээ ямагт жирийн хүмүүсийн ч, судлаачдын ч сонирхлыг татсаар ирсэн билээ. Нэг үзэл суртлыг тулган хүлээлгэсэн тоталитари дэглэмийн үед элит гэсэн ойлголтыг хүн хүнээ дарлан мөлжих явдлыг зөвтгөсөн хөрөнгөтний нийгмийн зүйл гэж тодорхойлж, түүнийг судлах явдал үндсэндээ боогдмол байдалд явж ирсэн юм. Харин ардчилал бодит зүйл болсны үр дүнд элитийн тухай асуудлыг сонирхон судлах явдал түгээмэл болж ирлээ. Улс төр судлаачид элитийн тухай асуудалд янз бүрийн байр сууринаас хандаж, санал зөрөлдөөнтэй олон дүгнэлтүүд хийж байдаг болохоор, тэдгээрийг ерөнхийд нь нэгтгэн дүгнэж үзэх нь чухал юм.

Элит гэсэн ойлголтыг дараахь байдлаар тодорхойлж болно.

1. Элит бол нийгмийн хамгийн дээд давхрага, засаглал, эдийн засаг, мэргэжил зэрэгт илүү дээд давуутай байр суурь эзэлж буй бүлэг

2. Энэ нь харьцангуй хаалттай бүлэг мөн бөгөөд түүнд орох нь хязгааглагдмал, нилээд хатуу шалгуураар зохицуулагдаж байдаг.

3. Элит бол үйл ажиллагаа, соёл, амьдралын өвөрмөц чиг баримжаа, хэм хэмжээтэй, жирийн хүн амаас тусгаарлагдсан, тэднээс мэдэгдэхүйц зайнд оршиж байдаг бүлэг юм. Элитүүдэд тавигдаж байдаг журам, хэм хэмжээ жирийн иргэдийнхээс илүү их байдаг.

Улс төр, эдийн засаг, мэргэжлийн зэрэг олон янзын элит байж болно. Өөрөөр хэлбэл нийгмийн амьдралын хичнээн салбар байна төдийчинээн олон янзын элит байна гэсэн үг. Гэхдээ эдгээрээс аль ч хүрээг нь аваад үзсэн элит нь цөөнхи хэсэг байх ба нийгмийн бусад хэсгээс ямагт хөндий байна.

Хэдийгээр элитэд орох нь шинээр нийгмийн болон мэргэжлийн статустай болох, хуучин нь статусаа алдах явдлыг харуулж байдаг ч гэсэн энэ үйл явц төлөвших нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Жишээлбэл, хэрвээ ажилчин хүн парламентад сонгогдсон бол тэр хүн өөрийн бусад олон шинжийг хадагласаар байх боловч мэргэжлээ солих нь зайлшгүй. Мөн түүнчлэн эрх баригч элитэд байр суурь эзлэхийн тулд ажил мэргэжлийн тодорхой түвшинд хүрсэн байх зайлшгүй шаардлага гардаг байна.

Мөн элитэд ороход нөлөөлж байдаг өөр нэг зүйл нь бид нэг их хэлж сураагүй боловч бодит байдал дээр үнэхээр байдаг нийгмийн гарлын асуудал юм. Тодруулж хэлбэл нийгмийн аль давхрагад харъяалагдах вэ гэдгээс элитэд хамаарагдах байдал ихээхэн шалтгаалдаг байна. Барууны орны нилээд судлаачид эрх баригч дээд хэсэгт орохын тулд тавигдах наад захын шаардлагуудын хамгийн эхэнд энэ хүчин зүйлийг оруулсан байна. Эцэг эхийн нийгмийн гарал, байр суурь харьцангуй өндөр байх нь тухайн хүний байр сууриа олоход чухал нөлөөтэй ажээ. Социологийн судалгааны үр дүн нь нийгмийн дээд давхрагаас гарч ирэгсэд нийгмийн дундаас дээш давхрагаас гарч ирэгсэдээс илүү их бололцоотой, дундаас дээгүүр түвшний төлөөлөгчид дунд давхрагынхнаас илүү их боломжтой байдгийг нотолжээ. Дундаас доод давхрагаас гаралтай хүмүүс нийгмийн шатаар хурдан дээш ахих боломж маш бага, нийгмийн доод давхрагынхны хувьд энэ бололцоо бараг тэгтэй тэнцүү байдаг байна. Гэхдээ нийгмийн гарлын энэ хүнд байдлыг дээд бүлгийн төлөөлөгчидтэй гэрлэх замаар арилгаж болдог гэдэг нь судалгаагаар нотлогдсон үнэн ажээ.

Элит бүлэгт багтаж ороход шаардагдах дараагийн чухал шаардлага нь хүмүүжлийн тодорхой хэв маяг, их сургуулийн боловсролтой хослосон байх явдал юм. Бүх нийтээрээ боловсролыг чухалчлах болсон өнөө үед энэ нь улам их ач

холбогдолтой болжээ. Эрх баригч элит бүлэгт, тухайлбал парламентын гишүүд, засгийн газрын гишүүд, яам тамгын газрын дээгүүр албаны хүмүүс, нөлөө бүхий улс төрийн хүчнүүдийн удирдлагууд зэрэгт дээд боловсролгүй хүн байхгүй гэдэгт хэн ч эргэлзэж, маргахгүй буй заа.

Мөн ямар шашин шүтдэг, эс шүтдэг юмаа гэхэд аль шашинд нь илүүтэй нааштай ханддаг зэрэг нь эрх баригч элитэд ороход нөлөөлдөг ажээ. Тодруулж хэлбэл, христосын шашинтай орнуудад лалын ч юмуу буддын шашинтай хүн хамгийн дээд түвшний эрх баригч элит болох боломж бараг үгүй, буддын шашин давамгайлсан орнуудад лал, христосын шашин шүтдэг хүн эрх баригч элитэд сонгогдох магадлал муу гэсэн үг юм. Шашны талаар хатуу бодлого баримталдаггүй манай оронд ч гэсэн буддын шашнаас өөр шашны талаар илэрхий нааштай үг хэлсэн зарим хүмүүсийг сонгуулийн сурталчилгааны үеэр буруутгах, сонгогчдын сэтгэл санааг уймруулахад ашигласан тохиолдлууд гарч байсан нь шашин шүтлэгийн асуудал элитэд үнэхээр их нөлөөтэй байж болохыг нотолж байна.

Нийгмийн эрх баригч элитэд ороход тавигдах дөрөвдэх чухал шаардлага нь нэр дэвшигч өсч хөгжих ихээхэн бололцоо олгохуйц мэргэжилтэй юмуу, эсвэл тийм үйл ажиллагаа явуулдаг байх явдал юм. Эдгээр нь бага зэргийн хэлбэрийн өөрчлөлттэй байж болох боловч орчин үед үндсэндээ элитийн нөхөгдөх нэг нөхцөл болж байна. Энэ шаардлага манай орны хувьд ч гэсэн илт мэдрэгдэж байна. Жишээлбэл, өнөөгийн парламентын бүтцийг л аваад үзэхэд хамгийн их амжилтанд хүрч байгаа мэргэжлүүдэд эдийн засагч, инженер-эдийн засагч, хуульч мэргэжлүүд орж байхад манайд хамгийн их түгээмэл байдаг багш, эмч, хөдөө аж ахуйн талын мэргэжилтнүүд төдийлөн амжилтанд хүрч чадаагүй тоон үзүүлэлт харагдаж байна. Эдгээр болон байгалийн шинжлэлийн чиглэлийн мэргэжил эзэмшсэн парламентын гишүүдэд ажиглагдаж байгаа нэг сонирхолтой зүйл нь хэн нь ч яг өөрийн торгон мэргэжлээрээ ажиллаж байгаад Улсын Их Хурлын гишүүн болоогүй ажээ. Тэд бүгд л аль нэг газар дарга, захирал, түшмэдийн байр сууриар дамжин энэ зэрэгт хүрч иржээ.

Эрх баригч элитэд тавигдах дээрхи минимум шаардлагуудыг барууны судлаачид эмпирик судалгааны үр дүнгээр тодорхой гаргасан байдаг байна. Энэ судалгаануудаас харахад эрх баригчдын хувьд дараахи бодит үзүүлэлтүүд зайлшгүй чухал болох нь харагдана. Үүнд: нас, нийгмийн гарал, боловсролын шинж, түвшин. Өндөр хөгжилтэй орнуудад элитүүдийн идэвхтэй дундаж нас 50-65-ын хооронд хэлбэлзэж байдаг бол манай орны хувьд 46,5 орчимд байгаа юм. Өндөр хөгжилтэй орнуудад элитүүдийн нас нь ийм өндөр байдаг нь нэг талаас тэдний хаагдмал, нууцлагдмал байдалтай, нөгөө талаас тэд дотооддоо маш их тогтвортой байдалтай болсонтой холбоотой байдаг бол манай орны хувьд элитүүд нь тогтвортой бус, эрх баригч элитийн байр суурийг албан ёсоор эзэлж байгаа хүмүүс нь 4 жилийн дараа эрх баригч элитэд юмуу өөр төрлийн элит давхрагад хамрагдаж үлдэх эсэх нь тодорхойгүй, баталгаагүй, нөгөө талаас элитийг сонгон шалгаруулагчид болох олон түмний санаа бодол гуйвамтгай, савалгаатай, туйлшралтай зэрэг нь үүнд илэрхий нөлөөлж байна.

Дээрхи орнуудад эрх баригч элитүүдийн тэн хагасыг нь хоёр болон түүнээс дээш дээд сургууль төгссөн хүмүүс бүрдүүлдэг, бага боловсролтой хүмүүс бараг байдаггүй, гимнази, коллежийн боловсролоор хязгаарлагдсан хүмүүс маш цөөн хувийг эзэлдэг ажээ. Боловсролын энэ байдал нь эцэг эхийн нийгмийн байдал, ялангуяа материаллаг бололцооноос их хамаарч байгааг, мөн сонгон шалгаруулах механизм үр ашигтай явагдаж байгааг харуулж байна.

Судлаачид улс төрийн элитэд хүрэх хэд хэдэн үндсэн зам байна гэж үзэж байна. Үүнд, юуны өмнө бюрократ маягийн зам. Энэ нь төр, захиргааны ямар нэг байгууллагад даруухан, түшмэлийн байр суурин дээр ажиллахаас эхэлнэ. Улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох явдал нь албан тушаалын дунд хавиас эхэлнэ. Энэ зам нь нийгмийн гарал нь нилээд доогуур хүмүүст ихэвчлэн ажиглагддаг. Хоёрдугаар зам нь соёл, шинжлэх ухаан, хууль, сурган гэх мэт үйл ажиллагаатай холбоотой эхлэх

бөгөөд энэ нь ихэвчлэн сайн дурын идэвхитэй үйл ажиллагаа нь улс төртэй хослосон байдалтай явагддаг. Энэ тохиолдолд дээшлэх зам нь мэргэжлийн хувьд ч, нийгмийн хүрээний хувьд ч зэрэг явагдана.

Дараагийн, манай оронд нэлээд түгээмэл ажиглагдаж байгаа зам бол эдийн засгийн элитээс улс төрийн элитэд орох явдал юм. Нийгмийн дээд давхрагаас гаралтай эрх баригч бүлгийнхэн улс төрийн албан тушаалынхаа өмнө эдийн засгийн салбарт ажилласан байх нь элбэг. Ер нь эдийн засгийн элитүүдийн гарч ирэх гараа нь бусад төрлийн элитүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр байх хандлага ажиглагддаг ажээ. Тэдний ихэнх нь ямар нэг үйлдвэр эзэмшигч, хувьцаа эзэмшигч, менежер, үгүй ядахдаа аль нэг корпораци, фирмд удирдах аппаратад ажиллаж байсан хүмүүс байх нь олонтоо. Манай орны хувьд тоталитари дэглэм удаан хугацаагаар ноёрхож, хувийн өмчийг үгүйсгэж байсантай холбоотойгоор эдийн засгийн элитүүд улс төрд оролцох явдлын тухай ярих нь саяхан болтол бараг утгагүй зүйл байсан бол өнөөдөр энэ нь бодит зүйл болж байна. Үйл ажиллагааны нэг салбараас нөгөө салбарт, ялангуяа эдийн засгийн салбараас улс төрийн салбарт шилжих явдал урьд нь үзүүлж байсан дэмжлэг тусламжийг өнгөлөн далдалсан үнэ хөлсний үр дүн байх нь олонтоо. Олон бизнесмэнүүдийн хувьд улс төрийн янз бүрийн албан тушаалд томилогдох явдал эрх баригч намд санхүүгийн тусламж үзүүлсний компенсаци болдог байна. Энэ нь монгол оронд ч илэрхий харагдах болжээ.

Ч.Ядамсүрэн

Доктор (PhD)

Нийгмийн иргэнлиг харилцааг Монголд төлөвшүүлэх боломж

Монгол улсын хөгжлийн ирээдүй нь иргэний нийгэм мөн. Хүн төрөлхтний соёл иргэншлийн үнэт зүйлийн нэг иргэний нийгэм орчин үед дэлхийн дийлэнх улс орнуудын хөгжил дэвшлийн зорилго болж байгаа учраас нэгэнтэйгээр бодит амьдрал, нөгөөтэйгээр онолын сэтгэлгээний эрэл хайгуулын объект болжээ. XXI зууны хөгжил дэвшлийн гол хандлага-"иргэний ардчилсан хийгээд хүмүүнлэг нийгмийг цогцлуулан байгуулахыг эрхэм зорилго болгоно" гэж Үндсэн хуульд монгол орныхоо ирээдүйг тунхаглан зарласан билээ.

Иргэний нийгмийн тухай ойлголт. Эл ойлголт улс төр судлалын шинжлэх ухааны үндсэн категорийн нэг юм. Ойлголтын дотоод бүтэц, нийгмийн бусад хэсэгтэй ямар холбоо шүтэлцээтэй зэрэг судалгаа, шинжилгээг шаардсан асуудал олон. Иргэний нийгмийн генезис анх Эртний Грекийн сэтгэгчдийн бүтээл туурвилаас улбаатай. Эртний Грекийн сэтгэгч Аристотель "Төр" гэдэг сэдвээр хийсэн ярилцлагадаа иргэний нийгэм гэдэг ойлголтыг дэвшүүлсэн байна. Аристотель: иргэний нийгэмд улс төрийн хувьд зохион байгуулагдсан хамтын нийгэмлэгийн гишүүдийн хооронд хөдөлмөрийн хуваарт байх нь хүний хэрэгцээг хангах объектив нөхцөл юм. Мөн сэтгэгч Платон "Иргэний нийгэм", "Улс төрийн төр" ойлголтуудын харьцааг тодорхойлсон байна. "Иргэний нийгэм" гэдэг ойлголт Г.Гроций, Т.Гоббс, Дж.Локк, Ж-Ж.Руссо, Ш.Л.Монтескье нарын бүтээлд улам тодорхой, томруун тусгагджээ. Сэтгэгчид иргэний нийгэм болбоос иргэн, төрийн хооронд байгуулсан гэрээнд суурилсан, иргэдийн үүсгэл санаачилгын дүнд үүссэн нийгэмлэг, нөхөрлөл, хоршоо, холбоодын харилцаа, үйл ажиллагааны тогтолцоо мөн гэж тодорхойлж байв. Нийгмийн гэрээний үзэл санаанд үндэслэсэн "төрийн гэрээний үүсэл" гэдэг онолыг бас дэвшүүлсэн нь бүх иргэд хүсэл зоригоороо оролцдог төр л хууль ёсны төр юм гэдэг ойлголтод хүргэсэн байна. Энэ үзэл баримтлал хөгжсөөр төрийн төлөө ард түмэн биш, харин ард түмний төлөө төр гэсэн орчин үеийн үзэл баримтлалын үр хөврөл болсон юм. Германы суут сэтгэгч К.Маркс иргэний нийгэм бүрэлдэх анхдагч нөхцөл нь иргэдийн эдийн засаг, нийгэм, улс төрийн амьдралын бодит хэрэгцээ юм гэж үзээд иргэний нийгэм-төрийн харилцан шүтэлцээ болон харьцангуй бие даасан шинжийг тодорхойлсон байна.

Орчин үеийн улс төр судлалын шинжлэх ухаан иргэний нийгэм төлөвшлийнхөө анхны шатанд байна. Энэ нийгэмд хүний чөлөөт байдал хуулиар баталгаажиж, улмаар хүний бүтээгч, сэтгэгч үйл ажиллагаа илрэн дэлгэгдэнэ. Олон нийтийн үүсгэл санаачлагын байгууллага, нийгэмлэг, хамт олон, хамтлаг, нөхөрлөл, хоршоо нь иргэний нийгмийн төлөвшилтийн гол шинж мөн гэж үзэж байна.

Иргэний нийгмийн хүмүүнлэг шинж. Хүнийг өв тэгш хөгжүүлэх зорилго дэвшүүлдэг нь иргэний нийгмийн хүмүүнлэг шинжийн агуулга юм. Иргэдийнхээ эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөрлөх нөхцөл, амьдралын түвшний дээшлэлт, эрх чөлөөг хамгаалах нь иргэний нийгмийг хөлсний хөдөлмөрт суурилсан капиталист мөлжлөгийг бий болгохоос хамгаалах гол шинжийн нэг юм. Чөлөөт хөдөлмөрөөрөө иргэний нийгмийг байгуулах хүн баялгийн анхдагч байх учиртай. Чингэхлээр иргэний нийгмийг хүмүүнлэг болгоно гэдэг нь энэ нийгэмд хөлсний хөдөлмөр биш, чөлөөт хөдөлмөр, өнгө мөнгөний ноёрхол биш, эрх тэгш хөдөлмөрийн хүмүүсийн харилцаа хэвшин тогтохыг хэлнэ.

Иргэний нийгмийн ардчилсан шинж. Иргэний нийгмийн ардчилсан шинж нь төрийн засаглалын эхлэл нь ард түмэн мөн гэдгийг хүлээн зөвшөөрч, тэгш эрхийн зарчимд суурилсан улс төр, төрийн байгууллын мөн чанараар тодорхойлогдоно. Төрийн хийгээд нийгмийн хэргийг удирдахад иргэдийн сонголт, хүсэл эрмэлзэл анхдагч

роль гүйцэтгэвэл ардын эрхт ёс (ардчилал) сонгодог утгаараа хэрэгжинэ. Иргэний нийгэмд эрх зүйт төр төлөвшинө. Энэ нь хуулийг дээдэлсэн төр, иргэний харилцаа, үйл ажиллагааны тогтолцоо бий болно гэсэн үг. Эрх зүйт төрийн онцлог шинж нь хуулийг дээдлэх ёс юм. Хуулийг дээдэлнэ гэдэг нь хуулийн ноёрхол тогтохыг хэлнэ. Ардчилал, төр хоёр хамт үүсэн лүгээ адил нийгмийн хөгжлийн оргил дээд шатанд төр “мөхнө”. Ардчилал ч алга болох зүй тогтолтой. Учир нь ардчилал бол төрийн байгууллын нэг хэлбэр юм. Энэ утгаар авч үзвэл ардчилал алга болно. Харин ард түмэн мөнхөд байх учир ард түмний эрх дарх, ардын эрх ёс (ардчилал) амилан хэрэгжсээр байх болно. «Ардчиллын голт зүрх нь ардын эрхт ёс, хуулийг дээдлэх ёс, ард түмний засаглал юм» (Ж-Ж.Руссо). Энэ нь чухамдаа ардчиллын альфа ба омега, мөн чанарыг ард түмний засаглалын бодит хэрэгжилтээр хэмжих хөгжлийн тийм үе шат иргэний нийгэмд биелнэ гэсэн үг юм. Засаглал хязгаартайн адил ардчилал ч бас хязгаартай. Монгол улсын хэмжээнд ардчиллын хязгаар нь Үндсэн хуулийн хүрээнд хэрэгжинэ. Газар зүй, орон зайн хувьд ардчилал нь Монгол улсын нутаг дэвсгэрт биелнэ. Энэ нь дэлхийн улс орон бүр өөр өөрийн Үндсэн хуультай, засаглалтай байдгаар тайлбарладаггүй.

Монгол оронд иргэний нийгмийг төлөвшүүлэх асуудалд. Монгол оронд иргэний нийгэм төлөвшилтийнхөө эхний шатанд байна гэдэг нь хөгжлийн процесс эхлэл, төлөвшилт, өрнөлтийн үе шаттай байдгийг иш үндэс болгож байгаа томъёолол юм. Манай улс социалист бүтээн байгуулалтын шатнаас зах зээлийн харилцаатай иргэний нийгмийг байгуулах хөгжлийн сонголт хийж замнасаар даруй арав гаруй жил болж байна.

Энэ замыг сонгохдоо капиталист мөлжлөгийн аргаар биш, нийгмийн чиглэлтэй, хүмүүнлэг аргаар иргэний нийгмийг байгуулахаар зорьсон билээ. Хөгжлийн түүхээс авч үзэхүй капиталист зах зээл нь даруй 50 гаруй жил хөгжин байж төлөвшилтийн шат туулжээ. Түүхэн эрин үе өөр байсан хэдий ч өндөр хөгжилтэй гэгдэж байсан тэр үеийн Европын орнууд хүний амьдралын бүхий л үеийг капиталист зах зээлийн харилцаанд өнгөрүүлжээ. Шинэ эрин үед манай орон зай, цаг хугацааны хувьд иргэний нийгмийг хурдан байгуулах нь бодитой хэдий ч арав хорин жилд төвлөрүүлж чадахгүй. Иргэний нийгэм нь эхлэлийн төлөвшилтийн, өрнөлтийн зохих шатуудыг дамжиж баймааж нь цогцлон байгуулагдана. Монгол орон иргэний нийгмийг байгуулах эхний шат-төлөвшилтийн шатанд хөгжиж байгааг амьдралын гол хүрээнүүдэд авч үзье. Нийгмийн хөгжиж дэвших суурь хүрээ-**эдийн засгийн тухайд бол**, манай орон төрийн зохицуулалттай, нийгмийн баримжаа бүхий зах зээлийн харилцаанд шилжиж байна. Олон хэлбэрийн өмчийн харилцаа тогтов. Эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх материаллаг үндсийг зах зээлийн харилцаанд тохирсон загвараар бий болгох зорилтыг шийдвэрлэх нь төлөвшилтийн шатны үндсэн шинж юм. **Нийгмийн хүрээнд** гэвэл, иргэдийн эрх, эрх чөлөө, амьдрал, хөдөлмөрлөх нөхцөл, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал нь хуулиар баталгаажив. Иргэдийг бүх талаар хөгжүүлэх, зорилт төрийн нийгмин бодлогын цөм, улс орны хөгжлийн зорилго, баялгийн хэмжүүр болох орчин нөхцөл бүрдэж эхэлж байна. **Улс төрийн хүрээнд** бол манай оронд парламентын засаглал тогтлоо. Олон намын тогтолцоо төлөвшиж байна. Шууд ба төлөөллийн ардчилал практикт хэрэгжиж хэвшив. Засаглалыг хуваарилах зарчмын дагуу улс төрийн тогтолцоо бүрдлээ. Томилолтын зарчим сонголтын зарчимд халаагаа өгч байна. Эрх зүйн шинэчлэл үргэлжиж байна. **Оюуны амьдрал** улам бүр либералчлагдаж, сэтгэлгээний хэвшмэл загвараас плюралист сэтгэлгээнд шилжиж байна. Дорно, Өрнийн соёл иргэншлийн харилцан нөлөөлөх, харилцан нэвтрэлцэх үйл явц манай амьдралд хэвшиж байна. Үндсэний соёл, шинжлэх ухаан, боловсрол уламжлал, шинэчлэлийн жамаар хөгжиж байна. Олон улсын харилцаанд манай улс идэвхитэй байр суурь баримталж, гадаад орон зайгаа тэлж өргөжүүлнэ. Эх газрын ба далайн чанад дахь улс орнуудтай харилцаагаа өргөжүүллээ. ОХУ, БНХАУ-тай уламжлалт найрамдал, хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлсээр байна.

Монгол оронд иргэний нийгмийг байгуулах үйл явц эхний, төлөвшилтийн шатанд байгааг тодорхойлогч хүчин зүйл нь “шилжилтийн үе” юм. Шилжилтийн үе нь зах зээлийн харилцааны төлөвшилтөөр биш, иргэний нийгмийн төлөвшилтөөр

тодорхойлогдоно. Учир нь зах зээлийн харилцааг ямар зарчмаар төлөвшүүлэхийг иргэний нийгмийн шинж тодорхойлно. Иргэний нийгмийг орон, цагийн хувьд зах зээлийн харилцаанаас түрүүлж төлөвшүүлнэ. Үүнд Монгол оронд иргэний нийгмийн төлөвших онцлог оршино. Хотол олныг боолчлолд оруулахгүй хөлсний хөдөлмөрийн гинжинд байлгахгүй, нийгмийг баян ба ядуу, дарлагч ба дарлагчдын туйлд хуваахгүй харин хүмүүнлэг, ардчилсан зарчмаар хөгжүүлж иргэний нийгэмд хүргэх нь монгол орны хөгжлийн чиг шугам юм. Глобалчлалын эринд дэлхийн улс орнуудын чөлөөт хөгжлийн мөн чанар ч үүгээр тодорхойлогдоно.

Ц.Мөнхцэцэг.

Докторант

Улс төрийн манипуляци

Эртний сэтгэгч Фукидид ихэнх хүмүүс аливаа асуудлын үнэн мөнийг олох гэж биеэ зовоодоггүй, байгаагаар нь үнэн гэж хүлээн авдаг хэмээн үзсэн байдаг. Үнэхээр ч олон нийт мэдээллийн хэрэгслүүдээр тархаж буй элдэв баримт сэлт болон ам дамжин яригдаж буй цуу яриа зэргийг тэр болгон аль нь үнэн, аль нь худал болохыг шүүн үзэж ялгаж салгах гэж оролддоггүй, сонсоод л өнгөрдөг байна. Реклам сурталчилгааны гол зарчим болох олон дахин давтаж тасралтгүйгээр нэвтрүүлсний хүчинд худал зүйл ч гэсэн эцэст нь үнэн гэж үнэмшигддэг жамтай аж. Чухамхүү олон нийтийн үйл байдлыг энэхүү зарчмын дагуу өөрт ашигтайгаар өөрчлөх явдлыг улс төр судлалд манипуляци гэсэн нэр томъёогоор авч үздэг.

Улс төрийн манипуляци (political manipulation) гэдгийг улс төр судлалд хүмүүсийн улс төрийн ухамсар үйл байдлыг өөрийн эрх ашгийн үүднээс далд аргаар удирдах явдал гэж тодорхойлдог.¹ Манипуляци нь улс төр судлал, олон нийтийн санаа бодлын социологи, улс төрийн сэтгэл зүй зэрэг шинжлэх ухааны салбаруудын аль алиний судалгаанд хамрагддаг өргөн хүрээтэй асуудал юм. Манипуляцийг эдгээр салбарууд нэлээд олон янзаар тайлбарладаг.

1. Хүмүүсийг удирдах нөлөөлөх зорилготой, далд аргаар албадлага явуулдаг улс төрийн үйл ажиллагаа.

2. Сэтгэл зүйн нууц нөлөөлөл. Энэ утгаар нь манипуляцийг сэтгэл зүйн хүчирхийлэл, нийгмийн ухамсрыг төөрөгдүүлэх, сэтгэл зүйн дайн гэх мэтээр үздэг.

3. Хүмүүсийг тодорхой үйлдэл хийлгэх, эсвэл үл хийлгэх зорилготой өнгөлөн далдлалт хийсэн арга хэрэгсэл.

Ер нь манипуляцийг ямар талаас тодорхойлсон ч уг үйл ажиллагааны дотоод мөн чанар, гаднах үзэгдэл хоёр нь ямагт зөрөөтэй байдаг гэж ойлгож болох юм.

Олон нийтийн санаа бодлыг өөрчлөн манипуляци хийх явдал нь тоталитар болон авторитар дэглэмтэй улсуудад түгээмэл гэж зарим судлаачид үздэг боловч ардчилсан улсуудад ялангуяа сонгуулийн үед намуудын сурталчилгаанд байнга хэрэглэгддэг. Намууд төдийгүй засгийн эрх барьж буй хүчин олны дэмжлэгийг тогтоон барьж байхын тулд, түүнчлэн бусад орнуудад нөлөөгөө бэхжүүлэхийн тулд гадаад бодлогод манипуляци хийх явдал түгээмэл болжээ. Ийм учраас манипуляцийн үзэгдлийг судлах нь улс төр судлалын нэгэн гол чиглэл юм.

XIX зууны дунд үеэс ятган ухуулах, албадан дагуулах зэрэг аргаар хүний сэтгэл зүйд нөлөөлөх явдлыг сэтгэл зүйн шинжлэх ухааны хүрээнд анх судлах болсон байна. Улмаар энэ чиглэл нь улс төрийн сэтгэл зүй гэсэн бие даасан шинжлэх ухаан болж хөгжсөн юм. Г.Тард, Г.Лебон, Ш.Сигель нар сэтгэл зүйн далд нөлөөлийн талаархи судалгааны хөгжилд дорвитой хувь нэмэр оруулсан байна.

XX зууны дунд үеэс улс төрийн реклам, сурталчилгаа, хүний ухамсарт үзэл суртлын эзлэх байр суурийг улс төр судлалын шинжлэх ухаан судалгааны нэгэн объект болгон авч үзэх болсон байна.

Манипуляци хийх технологи. Улс төрийн манипуляци хийх технологи олон янз байдаг бөгөөд энд ерөнхий гурван хэлбэрийг нь авч үзье.

1. Олон түмний сэтгэл зүйн шинж чанарт тулгуурлан манипуляци хийх.

¹ А.И.Соловьев. Введение в политологию М., 1996. С.262.

Улс төрийн Манипуляцийн гол зорилго бол олон түмний итгэл үнэмшилд нөлөөлөх явдал байдаг учраас сэтгэл зүйн нарийн аргуудыг хэрэглэдэг. Оросын судлаач Е.Доценко "Сэтгэл зүйн манипуляци" гэдэг бүтээлдээ хүний аюулгүй байх, хүнс орон байраар хангагдах гэх мэтийн физиологийн хэрэгцээнээс авхуулаад нэр хүндэд хүрэх, бусадтай нэгдэн нийлэх, өөрөөрөө бахархах зэрэг бүхий л хэрэгцээ нь тухайн хүний зан байдлын гол сэдэл болдог гэж үзжээ. Чухамхүү иймээс айх үзэн ядах, жигших, үймэн сандрах зэрэг сэтгэл түгшил болон эх орноо хайрлах, манайх гэж элгэмсэх, бахархах зэрэг сэтгэл хөдлөлийн хэлбэрүүдийг манипуляцийн өгөөш болгон ашигладаг.

Сэтгэл зүйн дарамт шахал үзүүлэх нь манипуляцийн гол зарчим юм. Жишээлбэл: Айх мэдрэхүй дээр үндэслэгдсэн манипуляци нь ихэнхдээ эсрэг талаа буулгах гэсэн сөрөг сурталчилгаа байдаг. Америкийн судлаач Жеймс, Фишбек нар бага зэргийн айдас агуулсан сурталчилгаа нь сонгогчдод илүү үнэмшилтэй байдаг гэж дүгнэжээ. Өөрийгөө хамгаалах, аюул ослоос зугтан зайлах гэсэн төрөлх инстинктийг өдөөснөөр үйл байдлыг нь өөрчилж болдог ажээ. Тухайлбал, нэр дэвшигч Х нийгмийн хамгаалалд зарцуулах зардлыг багасгана хэмээн хөтөлбөртөө тусгасан гэж өрсөлдөгч нь мэдэгдэхэд Х-гийн төлөө саналаа өгөх гэж байсан сонгогчид, ялангуяа тэтгэврийнхэн эргэлзээнд орж сонголтоо дахин харж үзэх болно.

2. Мэдээлэл дамжуулах арга дээр тулгуурласан манипуляци

Манипуляци хийж буй субъект мэдээлэл дамжуулахдаа олон түмэнд зайлшгүй чухал боловч өөрт ашиггүй мэдээ баримтуудыг нуун дарагдуулж, өнгөц, ач холбогдол багатайг нь мэдээлэх явдал юм. Өөрөөр хэлбэл өнгөлөн далдлалт хийсэн, гол зүйлээс анхаарлыг нь холдуулах гэсэн байр сууринаас мэдээлэл тараадаг байна. Энэ аргаар манипуляци хийхийг зарим үед "дуугүй өнгөрөх" арга гэж нэрлэдэг.

3. Мэдээллийн их урсгалаар бөмбөгдөх манипуляци

Олон нийтэд сонин хэвлэл, телевиз радио гэх мэт бүх сувгаар худал ба үнэн нь мэдэгдэхгүй үй. олон мэдээллийг дамжуулах нь тодорхой асуудлаарх байр суурь, санал бодлыг эргэлзээнд оруулах талтай байдаг. Ялангуяа сонгуулийн компанийн үер нэр дэвшигчдийн намтар, ажил үйлс, хувийн зан чанар гэх мэтийн талаар хэрэгтэй хэрэггүй их баримт материал тарааснаар тэр дунд сонгогч улс төрийн хөтөлбөр зэрэг гол зүйлээ анзаарахгүйд хүрдэг.

Мөн энд Францын судлаач Ж.Эллюлийн үндэслэсэн "Ухуулга сурталчилгаа бол байнгын бөгөөд удаан хугацаанд үргэлжлэх ёстой" гэдэг зарчмыг дурьдах нь зүйтэй юм.¹ Реклам сурталчилгаа өдөр шөнөгүй, тасралтгүй явагдаж байж сая амжилт олдог гэж Эллюль үзжээ.

Манипуляци хийх сувгууд. 1. Визуаль (харагдах) суваг. Зурагт хуудас, туг далбаа, тэмдэг, фото зураг, телевизийн нэвтрүүлэг зэрэг зүйлс мэдээлэл дамжуулах визуаль сувагт орно.

Уриа лоозон, туг далбаа, гэрэл зураг зэргийг улс төрийн тэмцэлд эртнээс ашиглаж ирсэн. Эдгээр нь хүний нүдэнд хамгийн түрүүнд өртдөг, төсөөлөлд нь удаан хадгалагдаж үлддэг бөгөөд элдэв баримт бичиг, хөтөлбөр уншихаас илүү хялбар байдаг аж.

ЗХУ-ын төрийн тэргүүний суудалд хамгийн удаан суусан Л.Брежнев төр барьсан сүүлийн хэдэн жилдээ өвчний учраас ажил үүргээ гүйцэтгэж чадахаа байсан бөгөөд Улс төрийн товчооныхон түүний өмнөөс бүгдийг хийж байсан хэдий ч үнэн байдлыг олон түмнээс нуун дарагдуулж байсан нь сүүлд илэрсэн юм. Брежневийг залуухан эрч хүчтэй хэвээр байгаагаар харагдуулахын тулд хэдэн жилийн өмнөх юмуу эсвэл ихэд засч янзалсан гэрэл зургийг сонин хэвлэл дээр тавьдаг байсан тухай түүхчид өгүүлсэн байдаг. Энд тэнд хамтралынхантай, хөдөлмөрчдийн төлөөлөгчидтэй уулзлаа гэх мэтийн телевизийн мэдээ нэвтрүүлэг нь мөн хэдэн жилийн өмнөх юмуу монтажласан бичлэг байдаг байжээ.

² Политическая реклама. М, 1999. С 185

XX зууны 50-иад оноос хүчтэй түрэн орж ирсэн өдгөө улс төрийн манипуляцийн хамгийн чухал хэрэгсэл болоод байгаа визуаль сувгийн нэг бол телевиз юм. Телевизийн нэвтрүүлэг нь визуаль болон вербаль сувгуудийг хослуулсан хэлбэр боловч судлаачдын тооцоолсноор телевизээс авах мэдээллийн 70 хувь нь визуаль, багахан хэсэг нь вербаль байдаг ажээ.

Судлаачдын үзэж байгаагаар телевизээс авсан мэдээллийг хүмүүс үнэн бодитой гажуудал ороогүй гэж итгэдэг байна.¹ Телевизийн нэвтрүүлэг нь элдэв орчуулга шаарддаггүй, тухайн улс төрч гаднах төрх байдлаа ашиглан хүмүүст нөлөөлөх боломжтой, үзэгчдэд илүү сайн тогтоогддог зэрэг давуу талтай юм.

Телевизийн энэ давуу талыг улс төрчид сонгуулийн компанидаа төдийгүй олон улсын тавцан дээр ч хэрэглэх тохиолдол бий. Жишээлэхэд, 1980-аад оны сүүлчээр хуучин ЗХУ-ын тэргүүн М.Горбачев Америкийн телевизэд шууд ярилцлага өгчээ. Ярилцлагын бүх асуулт хариултыг урьдаас бэлдсэн, бүгдэд нь шинжилгээ хийсэн байсан хэдий ч Горбачев дэлгэцэн дээр маш таагүй, дүр төрх нь хэнд ч аятай сэтгэгдэл төрүүлэхээргүй гарсан байна. Горбачевын ийм байдалд орсны учир шалтгааныг дараа нь мэргэжилтнүүд нарийвчлан шалгасан аж. Тэгтэл Тагнуулын төв газар нэвтрүүлгийг бэлдэхдээ Горбачевтэй ярилцлага хийлгэхээр нүүрний зүүн хэсэгтээ хүн эвгүйцмээр согогтой сэтгүүлчийг зориуд сонгож авсан байжээ.

Телевизийн дуран сэтгүүлчийг баруун талаас нь үзүүлсэн учир үзэгчдэд юу ч анзаарагдсангүй. Харин Горбачевт сэтгүүлчийн согогтой нүүр шууд харагдаж байж. Ингээд ярилцлага хэдийгээр хурц асуудлыг хөндөөгүй боловч харилцан ярилцагчийн аймаар төрх байдал Горбачевт нөлөөлж эхэндээ ууртай байсан бол ярилцлагын сүүлд бүр хашгичих байдалд хүргэжээ. Улмаар Горбачевын нэр хүнд Америкт унаж эхэлсэн гэж энэхүү манипуляцийн талаар Оросын сэтгэл зүйч А.П.Ситников дүгнэсэн байдаг.²

1. Вербаль (үг яриа) суваг

Радио, ном сонин сэтгүүл, засгийн газраас гаргадаг баримт бичгүүд, намуудын хэвлэл, олны өмнө үг хэлэх зэргээр мэдээлэл дамжуулах аргууд үүнд хамаарагдана.

Эдгээрээс олон түмэнд илүү хүртээмжтэй байдаг, өдөр тутмын сурталчилгаа хийх боломжтойн хувьд томоохон сонинууд манипуляци хийхэд илүүтэй хэрэглэгддэг байна. Ялангуяа хүмүүст хамгийн түрүүнд тусч уншигддаг сонины тэргүүн өгүүлэл, гарчиг зэрэгт манипуляцийн шинжтэй зүйлс орох нь түгээмэл юм. Ийм өгүүлэл, нийтлэлд гарчиг нь агуулгатайгаа тохирохгүй байх нь олонтаа. Хүмүүсийн нэлээд хэсэг нь сонин уншихдаа зөвхөн гарчгийг нь уншаад өнгөрдөг дутагдлыг улс төрд ашигладаг юм. Жишээлэхэд, УИХ-ын гишүүн С.Оюун "Та аль намд элсэх бодолтой байна" гэсэн Өнөөдөр сонины сурвалжлагчийн асуултад "Одоогоор аль ч нам элсэх бодолгүй байна гэж хариулсан атал "С.Оюун МҮАН-д элсэх бодолгүй байна" гэж илт ташаа гарчигласан байх жишээтэй.³

Олон нийтийн санаа бодлын цуврал судалгаануудаас үзэхэд улс төрчид сонгогчдод бодит байдлын талаар үнэн зөв мэдээлэл өгөх бус, засгийн эрхийн төлөөх тэмцэлдээ дэмжлэг олж авах, эрх мэдлээ хүлээн зөвшөөрүүлэх зорилготойгоор л ярьж, бичиж байдаг ажээ.

Вербаль суваг дотроос мэдээллийг хамгийн хурдан шуурхай хүргэдэг хэрэгсэл нь радио нэвтрүүлэг юм. Улс төрийн аливаа үйл явдлын талаар хамгийн түрүүнд, анхны байр суурийг илэрхийлдэг бөгөөд нэг баримтыг олон дахин давтах боломжтой суваг нь радио юм. Сэтгэл зүйчдийн судалгаагаар хамгийн анхаарал муутай сонсогч

¹ В.О.Чкуасели. Выборные технологии. М., 1999. С 71

² Интерфакс А и Ф. 1998 № 213

³ Ц.Мөнхцэцэг. Олон түмний улс төрийн үйл байдалд мэдээллийн хэрэгслийн үзүүлэх нөлөөллийн зарим асуудал. 1999. 46-р тал

хүртэл радиогоор нэг мэдээллийг хэд дахин санамсаргүйгээр сонссоны эцэст тогтоож авдаг, ухамсарт нь үлддэг болохыг сэтгэл зүйн судалгаагаар баталсан байна.¹

Үг яриа ч гэсэн хүмүүст нөлөөлөх чухал хэрэгсэл болдог.

Улсын тэргүүн, томоохон зүтгэлтэн радиогоор юмуу олны өмнө микрофоноор үг хэлэхэд сонсогчид тухайн үгний агуулгаас илүү ярьж буй төрх байдал, хоолойны өнгө зэргийг илүү анхаардаг ажээ.

Судалгаанаас үзэхэд жил ирэх тутам хүмүүс зузаан зузаан ном, сэтгүүл унших, улс төр эдийн засгийн төвөгтэй асуудлаархи нэвтрүүлгийг удаан цагаар үзэж суух нь багасч байна. Хүмүүс мэдээллийг аль болох богино хугацаанд хялбарчлан авахыг хүсэх болсон нь манипуляци хийгчдэд дөхөм болж байна. Олон нийт асуудлыг өнгөц шинжтэй үнэлж дүгнэж, сэтгэл хөдлөлийн байдлаар сонгуульд оролцох болов. 1976 онд АНУ-д сонгуулийн дараахан хийсэн судалгаагаар шинэ ерөнхийлөгч Ж.Картерын төлөө саналаа өгсөн сонгогчдын 75% нь улс төр, эдийн засгийн чухал асуудлаархи түүний байр суурийг огтхон ч мэдэхгүй байсан нь гайхал төрүүлэхүйц жишээ юм.²

Ийнхүү улс орны дотоодын улс төрийн тэмцэлд манипуляцийг өргөн хэрэглэхийн хамт олон улсын тавцан дээр бусад улс оронд нөлөөгөө бэхжүүлэх зорилгоор ч мөн ашигладаг юм.

Олон улсын тавцан дээр сэтгэл зүйн манипуляци хийхдээ улс төрийн ухуулга сурталчилгааны бүх хэлбэрээс гадна дипломат, эдийн засаг, улс төр, цэргийн гэх мэт бусад арга хэрэгслийг ч мөн ашигладаг.

“АНУ даян дэлхийн энх тайван аюулгүй байдлыг сахиулагч гол хүчин байх ёстой” гэдэг Ж. Кеннедигийн засаг захиргааны анх гаргасан номлол 40 жилийн турш тус улсын гадаад бодлогын гол зарчим болж байгаа бөгөөд мэдээллийн бүхий л хэрэгслүүд байнга үүнийг давтаж, ухуулж ирсэн бөгөөд америкчууд ч бүрэн дэмжиж ирсэн юм.

Вьетнамын дайны үед энэ номлол АНУ-ын засаг захиргааны бодлогыг зөвтгөж олон түмний дэмжлэгийг авч байсан юм. Вьетнамын дайнд оролцогчдыг үндэсний баатрын дайтай өргөмжилдөг нь өдгөө ч хэвээрээ байгаа юм.

Дээрх номлолыг чухамхүү манипуляцийн хүчинд америкийн жирийн иргэний ердийн ухамсарт гүн бат суулгаж өгсөн учраас Иран-Иракийн дайн, Персийн булан, Косовогийн хямрал зэрэг асар их хөрөнгө хүч зарсан цэрэг, зэвсгийн хүч хэрэглэх ажиллагаа явуулж буй засгийн газраа олон нийт нь дэмжиж иржээ.

80-аад оноос америкчууд Хятадад нөлөө олж авах, Зөвлөлтийн байр суурийг шахахын тулд Хятадын нийгмийг социалист үзэл суртлаас ангижруулах, Америкт ойртуулах гэсэн хоёр чиглэлээр манипуляци явуулж эхэлснийг судлаачид тэмдэглэсэн байдаг.³

Ингэхдээ дараах аргуудыг хэрэглэжээ.

-Хятадын оюутан, мэргэжил дээшлүүлэгчдийг хөнгөлөлттэйгээр АНУ-д суралцуулах

-Экспортлох барааны хэмжээг нэмэгдүүлсний үндсэн дээр Хятадын олон нийтийг Америкийн шинжлэх ухаан, технологийн ололттой танилцуулан татах

-Сэхээтнүүд, тэр дундаа сөрөг хүчний гэгдэх эрдэмтэн судлаачидтай ажил мэргэжлийн нөхөрсөг холбоо тогтоох

-Америкийн авторуудын зохиол бүтээл, киног олноор хятад хэл рүү орчуулж олны хүртээл болгох

-Хятад дахь Америкийн телевиз, радиог бүтэн цагийн нэвтрүүлэгтэй болгон чөлөөт нийгмийн сайн сайхан байдлын тухай мэдээллийн хүрээг өргөсгөх

¹ Политическая реклама . М .1999 .С 191

² Laswell.H.D. The theory of Political propaganda // Public opinion, 1996 p.116

³ Smith M; The Media Game : American politics in the television age 1993. Boston, P 234

Сүүлийн үед техник технологийн янз бүрийн нарийн ширийн арга ашиглан хүний сэтгэл зүйд нөлөөлөх аргыг улс төрд хэрэглэх болов. Хүмүүсийг цочоон сэтгэлийг нь хөдөлгөх, зарим үед тайвшруулан намжаах нөлөө үзүүлдэг микрофон АНУ-ын Ерөнхийлөгч асан Б.Клинтонд байсныг сэтгэлзүйчид нотолсон байдаг.¹

Манипуляцийг зөвхөн олон түмэнд нөлөөлөхөд төдийгүй бас улс төрчид өөр хоорондын тэмцэлдээ ашигладаг юм. Маш өндөр түвшинд системчлэгдэн боловсруулагдсан, хими, физик, сэтгэл зүйн шинжлэх ухааны хамгийн сүүлийн үеийн ололтуудад үндэслэгдсэн манипуляцийн шинэ аргууд бий болсоор байна.

ОХУ-ын Ерөнхийлөгч асан Б.Ельцин Германд төрийн айлчлал хийж байхдаа найрал хөгжмийг удирдсан, Бельгид болсон Европын Холбооны дээд хэмжээний уулзалтад оролцохоор явахдаа онгоц буух үед унтаад сэрэхгүй байсан зэрэг фактуудыг тухайн үед Оросын Ерөнхийлөгчийн имижемейкэр байсан сэтгэл зүйч оюун ухаанд нь гаднаас нөлөөлсөн гипноз маягийн манипуляцийн үр дүн гэж үзсэн байдаг.

Сэтгэхүйд нөлөөлөх эмийн бодис, тодорхой үелзэл дээр тавихад тэр орчны хүмүүсийн оюун ухааныг удирдаж болдог генератор зэргийг Өрнөдийн орнуудад бүтээсэн байна.

Тэр ч бүү хэл сэтгэл зүйн манипуляци хийх эрхийг зарим улс орнууд тодорхой субъектэд хуулиар олгосон байдаг. 1991 онд АНУ-ын Конгресс “Үндэсний аюулгүй байдлын тухай” 1947 оны хуулиндаа нэмэлт өөрчлөлт оруулж, засгийн газартаа сэтгэл зүйн нууц ажиллагаа явуулах эрх олгосон байна.²

Хилийн чанадад эдийн засаг, улс төр, цэргийн үйл ажиллагаа явуулахдаа сэтгэл зүйн нууц арга хэрэглэж болох тухай энэ хуулинд дурьдсан байдаг.

Мэдээлэл сэтгэл зүйн аюулгүй байдлын асуудал. Шинжлэх ухаан технологийн хөгжлийн хэрээр хувь хүний болон олон түмний зан байдалд гаднаас нөлөөлөх аргууд улам боловсронгуй болж байгаа нь мэдээлэл сэтгэл зүйн аюулгүй байдал гэсэн шинэ асуудлыг бий болголоо. Мэдээлэл сэтгэл зүйн аюулгүй байдал гэдгийг хувь хүн нийгмийн бүлэг, олон нийт мэдээлллийн арга хэрэгслээр сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөхөөс хамгаалагдсан байдал гэж ойлгож болно.

Хүмүүсийг сэтгэл зүйн нууц хүчирхийлэлд өртөхгүй байх нөхцлийг бүрдүүлэх нь нийт улс үндэстний төдийгүй дэлхий дахины нэгэн чухал асуудал болж байна. Ялангуяа даяарчлалын нэг хөшүүрэг болсон хил хязгаар, улс төрийн дэглэм, цаг хугацаанаас үл хамааран ямар ч саад тогтоогүйгээр нэвтэрдэг интернетийн сүлжээгээр аливаа хүчирхийлэл, ёс бус үйлдэлд уриалан дуудсан мэдээллүүд цацагдах болсон нь ихээхэн түгшүүр төрүүлж байгаа юм.

Мэдээлэл сэтгэл зүйн аюулгүй байдлын асуудлыг сөхөж тавих болсон нь дараах учир шалтгаантай.

1. Нийгмийн бүхий л салбарт мэдээллийн гүйцэтгэх үүрэг өндөрсөж “Хэн мэдээлэлтэй байна тэрээр эрх мэдэлтэй байна” гэсэн зарчим үйлчилдэг мэдээллийн эрин зуунд дэлхий нийтээр шилжин орлоо. Энэхүү мэдээлэлжсэн нийгэмд хүн аюулгүй амьдрахын тулд хуучны сэтгэлгээ, амьдрах хэв маягаа өөрчлөхөөс өөр аргагүй юм.

2. Хүний сэтгэл зүй болон мэдээлэл дамжуулж буй орчин хоёрын харилцаа нь тэнцвэргүй, мэдээлэл нь хүнийг захирах байр суурьтай болсоор байгаа тул үүнийг зохицуулах ямар нэг оптималь хувилбарыг гаргах шаардлагатай болж байна.

¹ Интерфакс А и Ф . 1998, № 201

² Бодалев. А.А. Политическая психология. М., 2001. С-718.

3. Улс төрчид болон бусад субъектүүдийн зүгээс олон түмнийг төөрөгдүүлэх, хууран мэхлэх зэрэг манипуляцийн төрлүүд улам боловсронгуй болж, технологийн иж бүрэн нууц аргуудыг хэрэглэх болсон.

Эдгээр учир шалтгааны улмаас хүнийг сэтгэл зүйн хүчирхийллээс хамгаалах асуудал нийгмийн шинжлэх ухааны өмнө тавигдаж байгаа юм.

Олон нийт манипуляцид өртөхгүй байх боломж байна уу? Олон нийтийн санаа бодлын цуврал судалгаануудаас харахад иргэд аливаа манипуляцид өртөхгүй байх боломж хязгаарлагдмал боловч нөлөөллийг нь тодорхой хэмжээгээр багасгах боломжтой нь харагдаж байна.

Манипуляцийг хязгаарлах нөхцөл бол тухайн нийгмийн улс төрийн соёлыг зохистой өндөр түвшинд хүргэх, мэдээллийн аль болох олон янзын сувгийг хүртээмжтэй болгох явдал юм. Түүнчлэн олон түмний ухамсар, хэвшиж тогтсон сэтгэлгээ (менталитет) зэрэгт ардчилсан үнэт зүйлсийг төлөвшүүлэх нь зөв юм. Эдгээрээс гадна хүмүүсийн хувийн туршлага янз бүрийн үйл явдлын дунд бүрэлдэн тогтсон, улс төрчдийн зүгээс хяналтанд өртдөггүй коммуникацийн суваг болох гэр бүл, хамаатан, танил нөхдийн хүрээний мэдээллүүд нь манипуляцид өртөхөөс хамгаалдаг байна.

Монголын өнөөгийн нөхцөл байдалд олон түмэн манипуляцид өртөх магадлал өндөр гэж үзэх үндэслэлтэй. Албан ёсны ганц үзэл суртал, мэдээллийн ганц сувагтай байснаас үлдсэн сэтгэлгээ нь олон янзын зөрөөтэй байр суурь дотроос үнэн зөвийг ялган таних дадалд сурахад саад болж байна. Мөн олон нийт уламжлалыг шүтэх, өнгөрсөн үеийн туршлагыг баримтлах зэрэг уламжлалт нийгмийн түвшний сэтгэлгээтэй хэвээр байна. Төрөө дээдэлдэг, "Төрийн минь сүлд өршөө" гэж залбирдаг үзлийг улс төрд ашигласаар байгаа юм. Иргэн нь төрдөө биш, төр нь иргэддээ үйлчилдэг нийгмийн зарчим манайд хэрэгжихгүй байгаа нь олон түмний менталитеттэй ч холбоотой байж болох юм.

Н.Лүндэндорж.

Доктор (PhD), профессор

Үндсэн хуульт төр ёсны хөгжил

Төр – ямагт хөгжиж боловсронгуй болж байдаг үзэгдэл. Нийгмийн хөгжил, хүний сэтгэлгээний төвшин эрх зүйн соёл дээшлэхийн хирээр төр хийгээд төрийн үүрэг, бүтэц, зохион байгуулалт, засаглалын мөн чанар өөрчлөгдөн хөгжинө. Үүний гол шалгуур нь төр, иргэний харилцааны шинж чанар, төрийн үйл ажиллагааны зохист байдал, хүний эрх, эрх чөлөөний баталгаажилт зэрэг болно. Эдгээр шалгуурыг үндэс болговол, төр уламжлалт үеэсээ үндсэн хуульт төр ёсноо улам бүр шилжиж байгаа нь түүний хөгжлийн ерөнхий бөгөөд тэргүүлэх хандлага болж байна.

Европын эрх зүйн соёлын уламжлалын хүрээнд дэлхийн улс орнуудын төр ёс, төрийн хөгжлийн үр дүнд эрх зүйн зарим тулгуур хууль, зарчим тэргүүлэх ач холбогдолтой байх үзэл санаа хөгжиж эхэлсэн байна. Энэ үзэл санааны онолын эх сурвалж нь жам ёсны эрхийн тухай сонгодог сэтгэлгээ юм. Төрөөс тогтоосон хуулиас дээгүүр хүчин чадалтай, төр тогтоодоггүй зөвхөн хамгаалж байдаг тийм эрхүүд байдаг тухай төсөөллийн ачаар хүмүүст / хуулийн ач, хүчээр бус / дээд хүчин чадал бүхий аксиом, зарчим болгон ашиглаж болох тэргүүлэх эрхийн тухай төсөөлөл төлөвшин хөгжжээ. Энэ бол жам ёсны эрхийн сэтгэлгээний орчин үеийн эрх зүйн номлолд үзүүлсэн том нөлөө, гавьяа мөн. Ийнхүү жам ёсны буюу эсвэл ямар нэг эрх зүй тэргүүлэх ач холбогдолтой байх тухай үзэл төсөөлөлд тулгуурлан үндсэн хуулийг дээдлэх, үндсэн хуульт төр ёсыг тогтоох үзэл санаа бий болсон байна.

Хүний жам ёсны эрхийн төсөөлөлд тулгуурласан үндсэн хуульт төр ёс нь хамгийн нэр хүндтэй хууль тогтоомжуудтай харьцуулахад ч эрх нь тэргүүлэх шинжтэй байдгийг хүлээн зөвшөөрдөг учраас бичигдмэл Үндсэн хууль байгаа явдал төрийн эрх мэдлийг эрх зүйгээр хязгаарлах зайлшгүй нөхцөл болдог. Төрийн аливаа хууль тогтоомжуудаас Үндсэн хууль тэргүүлэх шинжтэй байдаг нь гол хууль гэж тунхаглаж байгаад бус, харин эрхийн цэвэр илэрхийлэл, иргэдтэй харилцах харилцаандаа төрөөс баримтлах зарчим, үйл ажиллагаа, зохион байгуулалтын эрх зүйн хэлбэрүүдийг “тогтоож” өгсөн байдгаараа хууль зүйн дээд хүчинтэй гэж үзэх болсон байна.

Өдгөө дэлхийн бараг бүх улс үндэстэн өөр өөрийн үндсэн хуультай болжээ. Гэхдээ үндсэн хуультай байх, үндсэн хуульт ёс төлөвшиж, үндсэн хуульт төр ёс ноёрхох нь өөр өөр асуудал юм.

Төр хөгжлийн уламжлалт үедээ домгийн болон бөө мөргөл, шашны номлолд үндэслэсэн зан заншлын хэм хэмжээ, засаглагчдын дур зоргод үйл ажиллагаа нь тулгуурлаж байлаа. Харин ардчилсан улсад төрийн болон ард түмний хүсэл зориг, ашиг сонирхлыг харилцан илэрхийлсэн үндсэн хуульт ёс ноёрхоно. Төр хийгээд иргэний нийгэм харилцан тэнцвэржиж, бие биеэ хуулийн хүрээнд хянана. Урсгал байдалд тулгуурласан дур зорго биш, ухамсарт байдалд үндэслэсэн хууль ёс дээдлэгдэнэ. Төр хийгээд иргэний хооронд тэнцвэрт харьцаа тогтосноор төрийн засаглалын хууль ёсны хүлээн зөвшөөрөгдөх чанар дээшилж, төр, иргэний үйл ажиллагаа тэдгээрийн хооронд тохирсон гэрээний дагуу хэрэгжинэ. Эрх мэдэлтний дур зорго, иргэний хувийн ашиг сонирхол гагцхүү нийтлэг эрх ашгийн илэрхийлэл болсон Үндсэн хуулиар тэгш хязгаарлагдана. Хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдал, өмчлөх эрх нь мөн Үндсэн хуулиар бататгагдан хамгаалагдаж, тэр нь бодит зүйл болсон байх ёстой.

Үндсэн хуульт төр ёсны дээрх шаардлагууд нь хүн ба иргэний эрх, эрх чөлөө, бие даасан байдал, өмчлөх эрхийн баталгааг үр нөлөөтэй, боловсронгуй, өндөр төвшинд хангах, нийтлэг улс төрийн засаглалыг хүн, иргэний эрхээр бодитой хязгаарлах механизм мөн.

Үндсэн хуульт ёс дээдлэгдэнэ гэдгийг зөвхөн хуулиуд Үндсэн хуультай зөрчилдөхгүй, бүгд түүний үзэл баримтлал, зохицуулалтын хэм хэмжээний агуулгатай нийцэж байхаар хязгаарлагдахгүй, улмаар үндсэн хуулийн эрх зүйгээр хязгаарлагдаж байх тухай асуудал юм. Мөн түүнчлэн аливаа хууль үндсэн хуулинд томъёологдсон буюу тэмдэглэгдсэн эрх зүйн үндэслэлүүдийг цааш хөгжүүлж, тодруулж байдаг утгаараа ямар нэг хэмжээгээр органик шинжийг агуулж байдаг. Нөгөө талаас үндсэн хуулийн эрх зүйн эхлэлүүдийг /ялангуяа хүний, иргэний эрхийн тухайд/ агуулгын хувьд хөгжүүлж буй аливаа үйл явц бүхэн эрх зүйг тайлбарлаж буй хэрэг мөн. Харин эрх зүйг тайлбарлах нь цаг ямагт нийгэм улс төрийн тодорхой ашиг сонирхолд автаж байдаг хууль тогтоогчийн гэхээсээ илүүтэй хараат биш шүүхийн үүрэг мөн. Энэ нь эрх зүйг объективчлэх үйл явцад ардчилсан хууль бүтээх ажиллагааны гүйцэтгэх үүргийг бууруулж буй хэрэг биш бөгөөд Үндсэн хуулийн эрх зүйг хөгжүүлэх, тодруулах ажил нь юуны өмнө үндсэн хуулийн шүүхийн практикаар дамжин хэрэгжих ёстой гэдгийг цохон тэмдэглэж буй хэрэг. Тухайн хуулийг Үндсэн хуулийн эсрэг шинжтэй болохыг үндсэн хуулийн шүүх хүлээн зөвшөөрөхдөө Үндсэн хуулийн эрх зүйн эхлэлүүдийг тодорхой тайлбарлах ёстой. Үүний улмаас, эрх зүйт хуулиуд нь эдгээр нэр хүнд бүхий тайлбарлалыг харгалзан үзэж, нэгэнт боловсруулагдсан тайлбарлалуудтай органик нэгдэлтэйгээр Үндсэн хуулийн эрх зүйн эхлэлүүдийг хэрэгжүүлэх ёстой. Тэгэхлээр үндсэн хуульт төр-хууль тогтоогчоос батлан гаргаж байгаа хууль эрх зүйн актууд Үндсэн хуулинд нийцсэн эсэхийг хянадаг, тэдгээрт иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаар, иргэд болон төрийн байгууллагуудын хооронд гарсан маргааныг авч үзэх үндсэн хуулийн шүүхийн институттай байх явдлыг шаардана. Тиймээс үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуульт төр, үндсэн хуульт ёсны дээд илэрхийлэл болж байдаг ба үүнийхээ улмаас зөвхөн үндсэн хуулийг мөрдөж байгаа байдлыг хянадаг төдийгүй, мөн хамгийн тулгуур эрх зүйг хуулийн үг хэллэгийн оноолтын илэрхийллээс нь үл хамааран тайлбарлаж байдаг болохоороо амьд Үндсэн хуулийн эрх зүйг бүтээгч болж байдаг.

Үндсэн хууль дээдлэгдэх, үндсэн хуульт төр ёс бүрэлдэх үйл явц төрийн хөгжлийн харьцангуй хожуу шатанд илэрч, хөгжлийн шинэ хандлага, үнэт зүйл болов. 1650 онд английн шүүгч Эдуард Коук ерөнхий эрх зүйн зарчимд тулгуурлан Британийн парламентаас баталсан хуулийг хүчингүйд тооцсон үеэс жам ёсны болон тэргүүлэх эрх зүйд үл нийцсэн төрийн хуулийг хүчингүй болгож, өөрчилж, шинэчилж, мөн хувьсан өөрчлөгдөж байгаа цаг үеийг дагаж хууль тогтоомжийг үнэлж, тайлбарлаж байх тухай жишиг тогтож эхэлсэн байна. Энэ бол үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны түүхэн эхлэл байв. Үүнийг цааш хөгжүүлсэн улс орон бол америк байлаа.

Америк маягийн үндсэн хуульт төр ёс нь хуулийг эрх зүйн үүднээс үнэлэх ёстой гэсэн зарчимд тулгуурлаж байв. Үндсэн хууль нь хууль тогтоогчийн оноон томъёолсон ёсоор байх ёстой гэхээсээ тэдгээрийн имплицит утга санаатай илүү холбогдоно гэж үзэх болсон байна. Тогтоосон эрх зүйн өмнө онтологийн хувьд оршиж байсан эрхийн зарчмууд болон шударга ёс нь Үндсэн хуулийг бодвол илүү тэргүүлэх ач холбогдолтой бөгөөд Үндсэн хууль ердийн хуулиудын хувьд мөн дээрхийн нэгэн адил тэргүүлэх шинжтэй гэсэн үзэлд тулгуурлаж байв.

Үндсэн хуульт ёсны европ маягийн хэлбэр нь үндсэн хуулийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэдэг тусгай шүүхэд илүү ач холбогдол өгдгөөр тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл, үндсэн хуулийг болон түүний эрх зүйг тусгай байгууллага, эрх баригчдын батлан гаргаж байгаа актуудаар түүнийг зөрчихөөс хамгаална.

Төв европын орнуудад үндсэн хуульт төр ёсыг хөгжүүлэх, түүний хууль ёсны хамгаалагчийн талаар хамгийн дорвитой дуу хоолой гаргасан хүн бол Сийес юм. Тэрээр үндсэн хуулийг тусгай шүүх хамгаалж байх ёстой гэсэн үндэслэлийг: "Үндсэн хууль-нийтээр заавал биелүүлэх хууль тогтоомжийн шинжтэй дүрэм, журмуудын цогц нийлбэр юм бол тэр нь эрх мэдэл бүхий найдвартай хамгаалагчтай байх ёстой. Хэрэв тэр хамгаалагч үгүй бол юу ч биш болно. Иргэний амьдралд иймэрхүү маягийн согог нь ихээхэн тэнэг агаад учир нь үл олдох хэрэг байх байсан атал улс төрийн амьдралд үүнийг яагаад тэвчиж байна? Хууль нь ... түүнийг дагаж мөрдөхгүй байх бололцоог

өөртөө агуулж байдаг, ингэхлээр түүнийг албаар дагаж мөрдүүлэх шаардлагатай болно.”¹ гэжээ.

Дээрхийн эсрэг санаа бодол нь мөн л эрх мэдлийн хуваарилалтын үзэл санаанд тулгуурласан байдаг бөгөөд төрийн гурван “салаа мөчрийн” аль нэгийг бусдаас нь дээгүүр тавьж болохгүй юм. Үндсэн хууль болон бусад хуулиудыг сахин биелүүлэх үйл явцад тавих шүүхийн хяналтын үндсэн агуулга нь эрх зүйн соёлын уламжлалд нь харшилж байдаг улс орнуудын хувьд хууль тогтоох буюу засгийн газрын эсрэг зогсож байдаг тэрхүү улс төрийн хүчнүүдийн зүгээс шүүхийн механизмыг хортойгоор ашиглах магадлал өндөр байдаг. Гэхдээ орчин үеийн иргэний нийгэмд болон өнөөгийн ардчилсан үндсэн хуульт төрд парламентын олонхийн зүгээс ч эрх мэдлээ хортойгоор ашиглах магадлал дээрхээс багагүй байгаа нь илэрхий юм. Хэрэв 200 жилийн өмнө Аббат Сийес ямар нэг шалтгаанаас болж Үндсэн хууль бол зүгээр нэг үндсэн хуулиудын кодекс биш, харин бодгалийн, тухайлбал, парламентын эрх мэдлээс хамгаалж байгаа эрх зүйнүүдийн кодекс болох тухай бичсэний ачаар өнөөгийн европын үндсэн хуулиудад энэ тухай заалт байгаа билээ.

Аббат Сийесийн бодол эргэцүүлэл нь Үндсэн хуулийн хяналтын тухай умард америкт өрнөж байсан маргааны, тухайлбал А.Гамильтоны үзлийн нөлөөний дор бий болсон гэдэг. Тухайн байгууллагын бүрэн эрхийн утга санаатай зөрчилдсөн төрийн эрх барих байгууллагын шийдвэрийг хүчингүй гэж үзэх ёстойг тэрээр нотолсон байна. Ингэхлээр, Үндсэн хуулинд зөрчилдсөн хууль тогтоогчийн шийдвэр нь ганц энэ үндэслэлээр хүчинтэй байж чадахгүй юм. Үүнийг үгүйсгэнэ гэдэг нь бүрэн эрх олгогдсон тэрхүү шатны байгууллага нь уг бүрэн эрхийг түүнд олгосон байгууллагаас дээр байгааг батална гэсэн үг болно.

Шүүх эрх мэдлийн талаар А.Гамильтон бичихдээ: “Шүүхийн өөрийн нь зорилт бол эрх зүйг тайлбарлах явдал. Үндсэн хууль нь уг чанараараа тулгуур эрх зүй бөгөөд шүүгчид үүнийг чухамхүү ингэж үзэх ёстой. Үүний улмаас, тэдгээр нь хууль тогтоох эрх мэдлийн гаргасан эрх зүйн ямарваа актуудын утга санааг хэрхэн тогтоодгийнхоо яг адилаар Үндсэн хуулийн утга санааг тогтоох ёстой. Хэрэв хууль тогтоох актуудын хооронд шийдэж боломгүй зөрчил гараад байгаа бол хууль зүйн илүү дээд хүчинтэй, илүү өндөр түвшиний учир холбогдолтой хуулийг л баримтлах үзэх ёстой”¹ гэсэн байна.

А.Гамильтоны энэхүү үзэл санаанд үндэслэн АНУ-ын дээд шүүх Marbury v. Madison-д холбогдох алдарт шийдвэрээ гаргасан билээ. Түүнийг шүүсэн шүүгч Дж. Маршалл: “Энэхүү үндэслэл нь маргалдаад байх зүйлгүй дэндүү илэрхий юм. Нэг бол Үндсэн хууль түүнтэй зөрчилдөөд байгаа аливаа нэгэн хууль тогтоомжийн актыг, эсвэл хууль тогтоомжийн ерийн нэг акт Үндсэн хуулийг өөрчлөөд байж болох нь. Гурав дахь зам алга. Нэг бол Үндсэн хууль нь түүнийг ерийн нэг хууль тогтоомжоор өөрчилж үл болох хамгийн дээд зиндааны эрх зүй эсвэл тэр нь ердийн хуулиудтай нэгэн зиндаанд байдаг агаад бусад актуудын адилаар зохих хууль гаргаад түүнийг өөрчилж болно. Бие биеэ үгүйсгэсэн эдгээр бодомжуудаас хэрэв эхнийх нь зөв юм бол Үндсэн хуультай зөрчилдсөн хууль бол хууль биш. Хэрэв хоёр дахь бодомж нь зөв бол бичигдмэл Үндсэн хууль гэдэг нь угийн чанараараа хязгааргүй байдаг эрх мэдлийг хязгаарлах гэсэн ард түмний учир утгагүй оролдлого”² хэмээн мэдэгдсэн байдаг.

Төрийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болсон үндсэн хуульт төр ёсонд шилжих үйл явц тив дэлхийн улс орнуудад харилцан адилгүй нөхцөл байдал, үзэл маргааны дунд боловсорч, хөгжиж байснаас АНУ-тэргүүн эгнээнд хошуучилж ирснийг түүхийн судалгаа нотолж байна. 1803 оноос эхлэн АНУ-ын дээд шүүх ердийн хуулиудыг үндсэн хуулинд нийцэж буй эсэхийг хянаж эхэлснээр хүн төрөлхтний төр ёсны түүхэнд том

¹ Zit nach : Verfassungsgerichtsbarkeit in Westeuropa T.1.S.29 /Дам ишлэв/

² Haines Ch. The american doctrine of judicial supremacy. 1932. P.88 (Дам ишлэв)

³ Marbury v. Madison 1 Granch 137, 177-2. Law. Ed.U.S.60,73 (Zit nach : Verfassungsgerichtsbarkeit in Westeuropa T.1.S.30-31) /Дам ишлэв/

ялалт, агуу дэвшил бий болсон билээ. Ийнхүү үндсэн хуульт төр ёсны анхны загвар илэрсэн түүхтэй.

Энэ түүхэн нөхцөлд төв европт үндсэн хуульт төр ёсны үзэл санаа дэлгэрсэн хэдий ч улс төрийн практикт төдийлөн хэрэгжсэн нь харьцангуй хожуу юм. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулиа хамгаалж, бусад ердийн хуулиудыг түүнд нийцэж байгаа эсэхийг албан ёсоор хянан шийдвэрлэдэг субъект төрж гараагүй байв. Тэр ч байтугай Англид төрийн эрхийн практик нь парламентын бүрэн эрхээр баримжаалагдаж байв. Францад өрнөсөн улс төрийн хувьсгал Үндсэн хуулийн хууль тогтоомжийг ихээхэн тогтворжуулсан хэдий ч Үндсэн хуулийн шүүхийн асуудал танил биш байв. Германы улсуудын үндсэн хууль нь хаан болон хараахан хүчирхэгжээгүй байгаа хөрөнгөлөг хэсгийнхний харилцан буултын илрэл болсон цагдаажсан төрийн загварыг тогтоож байсны улмаас бичигдмэл Үндсэн хуулиуд нь жинхэнэ утгаараа үндсэн хууль болж чадаагүй байв. Эрх мэдлийг эрх зүйгээр бодитой хязгаарлах үүргийг хэрэгжүүлж чадахгүй байсан болохоор Үндсэн хуулийн эрх зүйг шүүхээр хамгаалах асуудал бараг тавигдаагүй байв. Түүнээс гадна, хэм хэмжээний актуудыг үндсэн хуулинд нийцсэн эсэхэд шүүхийн хяналт бий болгох нь улс төрийн харилцан буултыг ард олны төлөөллийн талд ашигтайгаар шийдэхэд хүргэх байсан нь тэр үеийн нөхцөлд сөрөг үзэгдэл болох байсан байна.

XIX зууны хоёрдугаар хагаст эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улс орнуудад хууль зүйн позитивист үзэл хүчирхэгжиж, эрх зүйн хэм хэмжээнүүдийн актуудыг Үндсэн хуулинд нийцэж буй эсэхэд шүүхийн хяналт тавьж байх онолын бололцоо няцаагдав. Хууль зүйн позитивист үзлийн үүднээс хэм хэмжээний актуудын хууль зүйн хүчин чадлын эх сурвалж нь энэхүү актыг эрх мэдэл бүхий байгууллагаас гаргасан явдал бөгөөд тэр нь төрийн албадлагаар хамгаалагдсан байх явдал мөн.

Ингэхлээр, үндсэн хуулинд нийцэх эсэхийг хянах тухай ярих боломжгүйгээр үл барам, ерөөсөө хэм хэмжээний актуудыг Үндсэн хуулинд нийцэх эсэх тухай ярих нь хууль зүйн утга учиргүй гэсэн үзэлд хүрч очсон байна.

Энэ асуудлаар хууль зүйн неопозитивист үзэл арай өөр байр суурь баримталж байв. Эрх зүйн хэм хэмжээний хууль зүйн хүчин чадал, цаашдын оршихуй нь арай өндөр зиндааны хэм хэмжээнд хэрхэн нийцэж байгаагаар тодорхойлогдох бөгөөд төрөөс тогтоосон хэм хэмжээнүүдээс Үндсэн хуулийн хэм хэмжээ нь хуулийн илүү хүчинтэй гэж үзэж эхлэв.

Үндсэн хуулийг дээдлэх үзэл европ дахинаа дэлгэрэхэд неопозитивизм чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Энэ үзлийн нөлөөгөөр европын олон улс үндэстнүүд үндсэн хуульт төр ёсонд шилжих түүхэн нөхцөл бүрдсэн. Аливаа эрх зүйн хэм хэмжээ үндсэн хуулинд нийцэж байх нь тухайн эрх зүйн актын хүчин чадал, оршихуйн асуудлаас хальж хүний эрхийн асуудал болж хувирав. Асуудал ийнхүү тавигдах болсноор эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий орнуудад үндсэн хуульт төр ёсны бодит илрэл болсон Үндсэн хуулийн шүүх, хяналтын байгууллагууд байгуулагдсан байна. Тухайлбал, Португалид 1911 онд, Австрид 1920 онд, Испанид 1931 онд анхны Үндсэн хуулийн шүүхүүд байгуулагдав.

Дэлхийн хоёрдугаар дайны дараах улс төрийн нөхцөл байдлын өөрчлөлттэй холбоотойгоор европын олон улсад иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөг бодитой баталгаажуулахад чиглэсэн Үндсэн хуулийн тусгай байгууллагууд үүсэж бий болов. Жишээ нь: 1948 онд Италид, 1949 онд ХБНГУ-д гэх мэт. Дараа нь Испани, Бельги, Туркэд Үндсэн хуулийн шүүхүүд бий болов. Францад Үндсэн хуулийн зөвлөл хэмээх эрх зүйн аливаа акт Үндсэн хуулинд нийцсэн эсэхийг урьдчилан хянах өргөн эрх мэдэл бүхий хуурмаг шүүхийн байгууллага байгуулагдав. Швейцарь, Грект Үндсэн хуулийн шүүх байдаггүй боловч Швейцарийн Холбооны дээд шүүх нь Үндсэн хуулийн хяналтын үүргийг хэрэгжүүлж эхлэв. Мөн үүний зэрэгцээ Швед, Нидерланд зэрэг оронд 70-аад онд Үндсэн хуулийн шүүхийн хяналттай болохыг эсэргүүцсэн шийдвэр ч бас гарч байлаа.

Хүйтэн дайны бодлого намжиж, өөрчлөлт шинэчлэлт эхэлсний дараа постсоциалист орнуудад Үндсэн хуулийн шүүхүүд байгуулагдаж эхлэв.

Манай орны хувьд 1924 оноос хэд хэдэн үндсэн хуулийг батлан хэрэгжүүлж, Үндсэн хуультай байсан хэдий ч үндсэн хууль төр ёс оршоогүй юм. Энэ дүгнэлтийг хийхдээ 1789 оны Францын хүний болон иргэний эрхийн тунхаглалд заасан: "төрийн эрх мэдлийг хуваарилаагүй улс оронд хэрэг дээрээ үндсэн хууль оршдоггүй юм" гэсэн алдарт үндэслэлийг иш болгов.

Монгол улс гурван үндсэн хуулийн нүүр үзэхдээ түүний хэрэгжилтэд хяналт тавих оролдлого хийж ирснийг бас тэмдэглэх хэрэгтэй.

1924 оны Үндсэн хуулийн 128-дугаар зүйлд: "Улсын бага хурал Үндсэн хуулийн ёсоор гүйцэтгэх явдлыг эрхлэн шийтгэвэл зохино" гэж заасан нь үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхийг Улсын Бага Хуралд олгосны илрэл мөн. Улсын Бага Хурал ч уг бүрэн эрхээ хэрэгжүүлэх оролдлого хийж байсан тухай архивын мэдээ бий.

Анхдугаар Үндсэн хуулийн 12-дугаар зүйлд: "Улсын Бага Хурал нь хууль, дүрэм, тогтоол, тушаал гаргах, Засгийн газар ба олон яамдын газруудыг хянан байцаах явдлыг ерөнхийлөн эрхлэх, ... Улсын Үндсэн хууль ба мөн Их Хурлын тогтоолуудыг ёсоор гүйцэтгэх явдлыг эрхлэн шийтгэвээс зохимой"¹ гэж заасан байна. Энэ үндсэн дээр Улсын Бага Хурлаас Засгийн газрын тогтоол, яамдын дүрэм гэх мэт актуудыг хянан үзэж, өөрчлөлт, нэмэлтийг оруулахдаа Үндсэн хуулийн зүйл заалттай нийцүүлж байсан баримт байдаг Энэ нь үндсэн хуулиа дээдлэх, төр засгийн аливаа шийдвэр үндсэн хуулинд нийцэж байх ёстой гэсэн итгэл, үнэмшил хэдийгээр ягштал хэрэгжээгүй боловч онол, үзэл баримтлалын хувьд байсныг харуулж буй хэрэг юм.

1940 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 10 дугаар зүйлийн зургаа дахь хэсэгт: Үндсэн хуулийн биелэлтийг хянах эрхийг төрийн эрх барих дээд байгууллагын эрхлэх ажил гэдгийг хуульчилж, улмаар түүнийгээ Бага хурлын тэргүүлэгчдийн бүрэн эрхэд шууд хамаарахаар буюу тус үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: "БНМАУ-ын Үндсэн хуулийг ажил хэрэг дээр биелүүлэх бүрэн эрхтэй болохыг хуульчилсан ба 29 дүгээр зүйлийн "а"-д Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид БНМАУ-ын Үндсэн хууль ба аливаа хуулийг хэрэгжүүлж биелүүлэх явдалд хяналт тавина гэж заасан нь анхдугаар үндсэн хуулийн үзэл санааны логик үргэлжлэл гэж үзэж болно.

1960 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн "а"-д Ардын их хурлын тэргүүлэгчид "БНМАУ-ын Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг хянана" гэж заасан байна.

Эдгээр бол монголын төр ёсны хөгжлийн явцад үндсэн хууль төр ёсны элемент соёолж, хөгжиж ирснийг нотлох үзэгдэл мөн.

Харин Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих эрх, үүрэг бүхий төрөлжсөн байгууллагын тухай ойлголт 1990 оныг хүртэл хэрэг дээрээ байгаагүй билээ.

Манай орны хувьд 1924 оноос эхлэн Үндсэн хуультай төр улсын хувьд Үндсэн хуулиудын хэрэгжилтийг хангах, гол хууль болох хувьд нь бусад хууль тогтоомж түүнд нийцэж байх ёстой гэсэн ерөнхий зарчим, эрмэлзэл оршиж байсан хэдий ч хууль ёсны хөдөлшгүй зарчим, хэм хэмжээ, үнэт зүйлс болж чадаагүй байсан юм. Энэ нь хуулиас хүчтэй улс төрийн шийдвэрийг эрх баригч нам гаргаж ирсэн тогтолцооны онцлогоор тайлбарлагдана.

¹ Улсын төв архив. Ф-№ 11, ТН1, х/н №10, 11 дахь тал

Харин 1992 оны шинэ Үндсэн хуулийн V дугаар бүлэгт Үндсэн хуулийн хяналтын институтийг /цэцийг/ төрийн эрх мэдлийн тогтолцоонд байршуулж, улмаар Монгол улсын "Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг" батлан гаргаснаар Үндсэн хуулийн хяналтын бие даасан байгууллагын улс төр, эрх зүйн статусыг албан ёсоор анх бий болгосон байна. Ингэж Монгол улс үндсэн хуульт төр ёсны тогтолцоо бүрэлдэн хөгжих улс төр, эрх зүйн үндсийг тавьсан байна.

Ж.Төртогтох.
Доктор (PhD)

Монголын үндсэн хуульт ёс: уламжлал, орчин үе

Аливаа төр улс, ард түмний хууль цаазны сэтгэлгээ тодорхой хэмжээгээр уламжлагдан залгамжлагдах, өмнөхөөсөө дараагийнх нь, хуучнаасаа шинэ нь урган гарах зүй тогтолтой.

Монголын төрт ёс нь эртнээс нааш уламжлагдан ирэхдээ дэвшилтэт болон тухайн цаг үе, нийгэм-төрийн байгуулалд нийцсэн шинж чанар, мөн манай орны өвөрмөц нүүдлийн мал аж ахуй, амьдрах нөхцөлд тохирсон онцлогоо хадгалж, харин иргэншлийн шинэ нөхцөл, хүрээнд нийцэхгүй болсон шинж чанараа аажмаар халж өнөө үеийг хүрчээ. Орчин үед Монголын төрт ёс нь дэлхий нийтийн ололт болсон ардчиллын үнэт зүйлс, хэм хэмжээнд зохицон шинэчлэгдэж, басхүү ард түмний түүх соёлын үнэт нандин зүйлсээ уламжлан авч хөгжиж байна.

1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт "төрт ёс түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж"¹ гэж заасан билээ. Монгол Улс төрт ёсны 2200 гаруй жилийн түүхэн уламжлалтай орон бөгөөд монгол газар нутаг дээр анх удаа МЭӨ 209 онд байгуулагдсан Хүннүгийн төр улсын уламжлалыг дараа дараагийн нүүдэлчид өвлөн хөгжүүлсээр 1206 онд монголчууд нэгэн их гэр бүлд нэгдэж Монголын нэгдсэн төр улсыг тунхаглажээ.

Чингис хаан монгол туургатнаа нэгтгэн Их Монгол Улс байгуулсан их үйл хэргээ үндэслэхдээ "Мөнх тэнгэр мөхөс миний биеийг зарлигдан түмэн иргэдийг захируулахаар соёрхов. Тал нутагт одоо болтол ямар ч эмх журамгүй учраас ийм зэрэгт хүрсэн ажээ. Үр хүүхэд нь эцэг эхийн үгийг авахгүй, дүү нар нь ахаа дагахгүй, эр нь эхнэртээ итгэхгүй, эхнэр нь эрийнхээ үгийг даахгүй, дагагсад нь ахлагчаа хүндэтгэхгүй, ноёд нь ард албатынхаа дотор үүрэг гүйцэтгэхгүй, баячууд нь ядуучуудаа тэтгэхгүй, газар сайгүй сэтгэл тайван суухыг бодохгүй, бидний омог аймаг, төрөл угсаатны дэг журам бүр алдагдаж, сүр сүлдгүй болоход хүрч буй. Эдүгээ хүрсэн газар болгонд дураараа авирласан хүмүүн олон. Худалч, хулгайч, урвагчид, дээрэмчид хүртэл бий болжээ. Иймээс миний бие ард олныхоо хүсэл захиасыг даган энэхүү мөчид хатуу төв чанга жам ёсоор тэд нарыг засч нэгтгэн энх амгалан зол жаргалыг энэ нутагтаа хүртээн тогтоохыг чармайх ёстой"² гэсэн билээ.

Монголчуудын улс төрийн сэтгэлгээ нь монгол төрт ёсны сэтгэлгээ, сургаалаар илэрч ирсэн байна. Аливаа улс байгуулагдмагц төрийн болон хууль цаазын тогтолцоо буюу хууль-эрх зүй, улс төрийн бодлогын зохицуулалтаа бүрдүүлдэг жамтай. Энэ нь монгол газар нутаг дээр оршин тогтнож, хөгжин цэцэглэж байсан эртний улс түмэн бүрт илэрч байсан ажээ. Тэгээд ч шинэ тулгар байгуулагдсан бөгөөд цаашдаа умард зүг Байгалаас өмнө зүгт Хятадын цагаан хэрэм хүртэл, дорно зүг Хянганы нуруунаас өрнө зүгт Алтайн чинад дахь асар уудам нутаг дэвсгэрийг эзэгнэнхэн орших болсон Чингис хааны хүчирхэг Монгол гүрний хувьд засаг төрөө бэхжүүлэх, нийгмийн амьдралын дотоод дахь олон төрлийн харилцааг зохицуулахад тохирохуйц нэгдмэл хууль цаазын тогтолцоо зайлшгүй шаардлагатай байв. Нийгмийн тийм бодит хэрэгцээ, шаардлагаар төрж гарсан Их Монгол Улсын төрийн гол, тулгуур хууль бол хаант төрөөс тогтоосон цааз, зарлиг, хэв хууль, сургаалын болон цэргийн сахилгын хэм хэмжээг тогтоосон зүйл дээр үндэслэсэн Чингис хааны "Их Засаг" хууль байлаа.

¹ Монгол Улсын Үндсэн Хууль. УБ., 1992, 3 дахь тал.

² Рашид-ад-дин. Судрын чуулган. 1-р боть, 2-р дэвтэр, 272 дахь тал.

“Монголын эрт эдүгээгийн хууль цаазны түүхийн сэдэв дэвтэр” хэмээх бүтээлд дурдсанаар: “Улс төрийн аливаа хэргийг шүүхэд монголын эртнээс инагш уламжлан ирсэн хуулийг журамлан дагаж явуулсан ажээ. Аливаа цааз хуулийг улс төрийн засаг захиргааны хэрэгт хэрэглэхгүй хэрхэвч үл болох тул хуулийн бодлого нь нэгэн адил боловч цагийг дагаж тухайн байдалд нийлүүлэн хуучин хуулийг хувьсган өөрчилжээ. Нэмэх хасах зэргээр тогтоож шинэтгэн зохиож явуулах нь эгнэгт хэв дунд тогтсон ёсон мөн тул 1206 онд Чингис хаан урьд эдүгээгийн хуулийг хянан хэлэлцэж цаг тухайн байдалд нийлүүлэн тогтоосон хууль болбоос Их Засгийн хууль хэмээн нэрийдэж мөнхүү Их Засгийн хуулийг болд самбар дээр уйгур үсгээр сийлээд хадгалсан байсан ажээ. Чингис хаан их сууринд сууж Их Засгийн хуулийг зарлаж, мөнхүү хуулийг их заргач Шигихутугт эрхлүүлэн хэргийн үнэн үндэс баримтыг олж ял хүлээсэн хүмүүн юуны учраас ял олох болсон гэрч баримтыг түүнд мэдрүүлж, ял тогтоон шударга ёсонд нийлүүлж шийтгэмүй хэмээжээ. Бас Шигихутугаас аливаа хэргийг шүүхэд хүнийг айлган цочоож эрүү тулгах зэргээр авсан өгчийг үнэн хэмээн үзэх газаргүй хэмээжээ.

Энэхүү Их Засгийн хуулийг Чингис хааны дараа залгамжилсан Өгэдэй, Гүюг, Мөнх хааны үед хүртэл журамлан дагаж аливаа хэргийг шийтгэсээр ирсэн бололтой амой”³ гэсэн байна.

Чингис хааны “Их Засаг” хууль ба сургаалуудын дотроос түүвэрлэж хэдэн зүйлийг дундад зууны үеийн Персийн эрдэмтэн Макризи, Мирховенд, Арабын Ибн-Батута, Армян улсын сударч В.Вартанг, мөн улсын гэлэн лам Махакиа, Ираны эрдэмтэн Рашид-ад-дин болон алдарт жуулчин Плано Карпини, Вильгельм Рубрук, Марко Поло, эрдэмтэн Ата Малик Жувеини нар зохиол бүтээлдээ тэмдэглэн үлдээсэн ажээ.⁴

Тухайлбал, Рашид-ад-дин бүтээлдээ: “Чингис хаан Их Хурилдайг зарлан хуралдуулж уламжлалт ёс болон хууль эрхийн шинэ тогтоомжууд орсон Засагийг батлуулж... “Их Засаг” хэмээн нэрлэтүгэй гэж зарлиг болов. Ийм шинэ хууль ёс тогтоох тухай шийдвэр анх 1206 онд гарчээ...”⁵ гэж тэмдэглэсэн байна.

Оросын эрдэмтэн В.В.Бартольд⁶, Б.Я.Владимирцов⁷, П.Попов⁸ нар хожим “Их Засаг” хуулийг нарийвчлан судалсан байна. Академич Ш.Нацагдорж, Ш.Бира, Х.Пэрлээ, эрдэмтэн С.Жалан-Аажав нар “Их Засаг” хуультай холбоотой асуудлыг өөр өөрсдийн зохиол бүтээлдээ хөндсөн төдийгүй, Монголын түүхийн гурван болон нэгэн боть зохиолуудад энэ хуулийн агуулга, ач холбогдлыг тэмдэглэсэн байдаг.⁹

Их Монгол Улсын төрт ёсонд “Их Засаг”-ийн гол ач холбогдол нь монголчуудын ёс суртахуун, зан заншлын шилдэг үнэт зүйлсийг системчлэн хууль цаазын шинж чанартай болгосон явдал юм. “Их Засаг” хуулийн үнэ цэнэ, онцлог нь төрийн гол хууль болох Үндсэн хуулийн шинжээр тодорхойлогддог талаар энэ хуулийг дагнан судалсан Америкийн эрдэмтэн, түүхч Жорж Вернадский: “Их Засаг” бол хэв хуулийн үндсэн дээр шинэ тутам тогтсон төрийн засаг захиргаа, цэрэг, иргэн, эрүү шүүлт, худалдаа, хэв заншил зэрэг олон төрөл зүйлийг багтаасан бүрэн төгөлдөр Их хууль мөн гэж тодорхойлжээ.¹⁰ Вернадскийн энэ дүгнэлтийн гол санаа нь монголчууд Чингис хааны

³ Дэндэв нарын. Монголын эрт эдүгээгийн хууль цаазны түүхийн сэдэв дэвтэр. /монгол бичгээр/.

⁴ Vernadsky George. The Yasa of Chingis Khan: A code of honor, dignity and excellence. Columbia University Press, 1994, Juvaini. The history of the World Conqueror. Manchester, 1961.

⁵ Рашид-ад-дин. Судрын чуулган. 1-р боть, 2-р дэвтэр, 185 дахь тал.

⁶ Бартольд В.В. История изучения Востока в Европе и России. 2-е издание Л., 1925.

⁷ Владимирцов Б.Я. Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм. Л., 1934.

⁸ Попов П. Яса Чингис-хана и уложение монгольской династии Юань-чао-дянь-чжан. Зап. ВОРАО, т. XVII, вып. 4.

⁹ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх. Гурван боть. УБ., 1966-1969, Жалан-Аажав С. Халх журам бол Монголын хууль цаазны эртний дурсгалт бичиг мөн. УБ., 1958, Нацагдорж Ш. Чингис хааны цадиг. УБ., 1991, Пэрлээ Х. Хувьсгалын өмнөх Монголын түүх бичлэгийн асуудалд. УБ., 1958.

¹⁰ Vernadsky George. The Yasa of Chingis Khan: A code of honor, dignity and excellence. Columbia University Press, 1994.

үед төрийн тулгуур хуулиар улс төр, нийгмийн байгууллага чиглүүлэн залж байсан болохыг харуулж байгаагаараа онцгой ач холбогдолтой мэт санагдана.

“Их Засаг” хуулийн дараагаар Монголд “Юан гүрний нэвтэрхий хууль”, “Арван буянт номын цагаан түүх, шашин төрийн хууль цааз”, “Хутагтай Сэцэн Хун Тайжийн цааз”, “Алтан хааны цаазын бичиг”, “Халхын цааз эрхэмжийн бичиг”, “Монгол Ойрдын хууль”, “Халх журам”, “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” зэрэг хууль цааз түүхийн янз бүрийн цаг үед тухайн үеийн нийгэм улс төрийн харилцааг зохицуулж байв.¹¹ Энэ бүхэнд монголчуудын анхны төрийн байгууллын зохицуулагч болж байсан “Их Засаг” хуулийн нийгэм улс төр, хууль цаазын үзэл санаа туссан нь дамжиггүй билээ.

Тухайлбал, “Монгол Ойрдын хууль”-ийн агуулга нь монгол ба ойрдын хоорондын мөргөлдөөнийг зогсоож дотоодын эв нэгдлийг бататгах, харьяат ардыг чангалан захирах, шарын шашныг нийт монголын төрийн шашин болгож бөө мөргөлийг эсэргүүцэх, гадаадын дайсны эсрэг хамтран тэмцэх, тусгаар тогтнолоо сахин хамгаалах зэрэг үзэл санааг илэрхийлсэн байдаг. Монголчуудын ажил, амь зуулгын гол зүйл болж байсан мал аж ахуй, туслах чанарын зүйл болох ан гөрөөний хэрэг, өртөөний алба, засаг захиргааны журам, иргэний хууль цаазад холбогдох тэр үеийн нийгмийн аж байдлийн олон чухал харилцаа энэ хуулиар зохицуулагдсан ажээ.¹² 1640 оны Монгол Ойрдын хууль нь төр улсын тусгаар тогтнолыг алдахгүй байх, ойрд, монголын ард түмнийг айх аюулгүй, амар түвшин амьдруулахыг эрмэлзэн бүтээгдсэнээрээ алдартай юм. Тухайн үедээ Монголчуудын эв нэгдлийг бэхжүүлэх, үндэсний тусгаар тогтнолыг хангах, хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэсэн энэ хуулийн нийгэм-улс төрийн ач холбогдол, бусад зүйлс уламжлагдах ёстой.

XIX зууны сүүлчээс манж Чин улсын хүч сулрах үед тэд Европын интервенц, дотоодын хямралаас зайлсхийхийн тулд зарим шинэтгэл хийхийг оролдохдоо Монголын талаар “Шинэ засгийн бодлогыг” 1901 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна. Үүний шууд үр дагавар болж Монгол газар нутагт хятадууд нэвтрэн орж газар хагалж, тариа тарих, ард түмний шашин шүтлэг, зан заншил ч хөндөгдөх болсон нь монголчуудын дургүйцлийг төрүүлж бүх нийтийн зүй ёсны эсэргүүцэлтэй тулгарчээ.

Монголын үндэсний тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхт байдлын төлөө тэмцэл идэвхижиж, үүний үр дүнд гарсан Үндэсний хувьсгалын үрээр Монгол орон Манж Чин улсаас тусгаарлан салж, 1911 оны 12 дугаар сарын 29-нд Богд Жавзандамбыг “Монгол Улсын эзэн, шашин төрийг хослон баригч, наран гэрэлт хаан” хэмээн өргөмжилжээ.

Ийнхүү 1911 онд Монгол Улс хаанаа өргөмжлөн залсны дараагаар олон хууль, дүрэм гаргаж, улсын хурал байгуулах, үндсэн хуулийг зохион гаргах санаа сэдэж байсан байна.

Монголын шинэ тулгар төр сэргэн байгуулагдсанаар нийгмийн амьдралд чанарын эргэлт, үндэсний сэргэн мандалтын шинэ үе эхэлсэн байна. Энэ нь төрийн байгуулалтанд тусгалаа олж, төрийн зохион байгуулалтыг орчин үеийн байдалд нийцүүлэх шаардлагатай болгожээ. Тухайлбал, шашин төрийг хослон барьсан Богд хааны Засгийн газар анхлан Дотоод, Гадаад, Цэргийн, Сангийн, Шүүхийн гэсэн таван яамнаас бүрэлдэж байсан ба 1912 онд Гаалийн яамыг нэмэн байгуулжээ.

Ингэж Монголын шинэ төр өдөр тутмын албан ажил хөтлөх яамнаас гадна өөртөө тамга тэмдэг, сүлд далбаа батлан, нийслэл хотоо сонгон тусгаар улсын шинж чанарыг олж байсан нь үндэсний төрт ёс шинэ цаг үеийн ээдрээтэй түүхэн нөхцөлд сэргэж эхлэсний илрэл байв.

¹¹ Авирмэд Э., Дашцэдэн Д., Совд Г. Монгол хууль. УБ., 1997.

¹² Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил. /МЭӨ III-МЭ XX зуун/. Тэргүүн боть. УБ., 1995, 72 дахь тал.

1914 онд Да лам Цэрэнчимэдийн санаачилгаар “улс төрийн аливаа хүнд хэргийг бүгдээр нийлж шүүмжлэн хэлэлцэж олны бодлогыг нийлүүлэх хурлыг нээн шийтгэх” зорилгоор Улсын дээд, доод хурал гэсэн хоёр танхим бүхий төрийн хувьд /буюу хааны хувьд/ зөвлөх эрхтэй байгууллага бий болгожээ. Хоёр танхимын аль алин нь ерөнхийлөн захирах яам буюу засгийн газарт шууд харьяалагдах ба тэдгээрийн гишүүдийг Богд хаан зарлигаараа томилно. Улсын хэмжээнд гүйцэтгэх ажлыг Доод Хурлаар хэлэлцүүлээд Дээд Хурал баталбал хүчин төгөлдөр болох ба эхний хэлэлцэх асуудлыг Дээд хурал алгасуулан хэлэлцэх учиргүй. Зөвхөн Дээд буюу Доод хурлаар асуудлыг хэлэлцдэг, хоёулаа хамтран хуралдаж шийд гаргадаг журам ч байжээ.

1911 оны үндэсний хувьсгалын шууд үргэлжлэл болсон 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын ялалтын үр дүнд ардын эрхт, хэмжээт цаазат хаант засаг тогтсон билээ. 1921 онд Богд хаан Ардын байнгын Засгийн газрын бүрэлдэхүүнийг баталснаар улс оронд нэгдмэл нэгэн төр засаг байгуулагдаж, нийгмийн амьдралын бүх салбарыг шинэчлэхэд чиглэсэн дотоод, гадаад бодлого, улс төрийн амьдралыг ардчилахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхэлжээ. Үүний нэг нь Ардын засгийн газар 1921 оны долдугаар сард “Улсын Түр Цагийн хурлын дүрэм”-ийг баталсан явдал байв. Улмаар мөн оны аравдугаар сарын 28-нд нээгдсэн Улсын Түр Цагийн Хурал 1924 он хүртэл ажиллажээ.

Уг хурлын үйл ажиллагаанд Засгийн газрын ерөнхий сайд, яамдын сайд, эрхэлсэн түшмэл төлөөлөгчийн эрхтэйгээр оролцож байв. Улсын Түр Цагийн Хурал нь бүгд найрамдах засгийг тунхаглах чухал бэлтгэл үе болсон гэдэг түүхч, судлаачдын үзэл, саналыг зохиогч дэмждэг.

Улсын Түр Цагийн Хурал нь хууль тогтоох бус зөвхөн зөвлөх, хууль санаачлах эрх эдэлж, засгийн газрын үйл ажиллагаанд туслах зорилго бүхий байгууллага байсан бөгөөд Ардын засгийн газар хууль тогтоох, гүйцэтгэн захирамжлах, шүүн таслах дээд эрхийг эдэлж байжээ. Энэ нь зарим талаар Богд хаант Монгол улсын төрийн тогтолцооны хэлбэр шинжийг уламжлан, ерөнхий зарчмыг тусгаж байсныг харуулж байна.

Хэмжээт цаазат хаан ба Засгийн газрын харилцааны асуудал тухайн үеийн төрийн тогтолцооны нэг онцлог талыг харуулж байв. 1921 оны 11 дүгээр сарын 1-нд Ардын засгийн газрын хуралдаанаар түүхэнд “Тангаргийн гэрээ” хэмээн алдаршсан “Богд хаан ба Засгийн газрын хоорондох холбогдлыг илэрхийлсэн тангараг дүрэм” баталжээ. Энэхүү дүрэмд Богд хаан шарын шашны эзэн болох тул улс төрийн хэрэгт холбогдолгүй, зөвхөн шашны бүх хэргийг хязгааргүй эрхлэх бөгөөд улсын аливаа хэргийг гагцхүү засгийн газраар дамжуулан гүйцэтгүүлэх болно хэмээн зааж, Засгийн газар, Богд хаан хоёрын харилцааны хэм хэмжээг тодорхойлжээ. Мөн хэмжээт засагт Монгол Ард Улсын үндсийг батлан боловсруулах, ард түмний ашиг тусыг батлан дэлгэрүүлэх хууль дүрмийг Засгийн газраас Богд хаанд сонсгон айлтгахад тэрээр нэг удаагаас илүү буцаан хэлэлцүүлэх эрхгүйгээс гадна дотоодын самуун үүсэх үед засгийн газраас аливаа чухал хууль шийдвэрийг Богд хаанд үл айлтган батлан явуулж болохыг тогтоожээ.

Богд хааны гол роль, нөлөө нь улс төрийн тогтвортой байдлыг хангахад оршиж, харин өмнө өгүүлсэнчлэн төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх онцгой эрхэнд хамаарах асуудлыг гагцхүү засгийн газар эцэслэн шийдвэрлэж байжээ. Засгийн газрын ийм онцгой эрхийг 1922 оны гуравдугаар сарын 3-нд батлагдсан “Монгол улсын Ардын засгийн газрын хурлын түр зуурын дүрэм” –ээр хуульчлан баталгаажуулжээ.

1921-1924 онд орон нутгийн засаг захиргаа, төрийн тогтолцоог өөрчлөн байгуулах алхмуудыг хийсэн байна. Тухайлбал, 1923 онд “Монгол улсын нутгийн захиргааны дүрэм”, “Засаг ба засаг бус ван гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм” зэргийг Ардын засгийн газраас батлан гаргасан нь орон нутагт шинэ засгийн тогтолцоог буй болгох эрх зүйн үндсийг бүрдүүлжээ. Орон нутгийн засаг захиргааг өөрчлөн байгуулах ажлыг

явуулж арван гэр, сум, хошуу, аймагт Ардын хурал, түүний гүйцэтгэх байгууллагыг байгуулжээ.

Ийнхүү үндэсний ардчилсан хувьсгалын ялалтын үр дүнд Монгол орны нийгмийн амьдралд бий болсон улс төрийн зарим шинэчлэлтийн үр дүнд Монгол оронд бүгд найрамдах засаг тогтох утгар нөхцөл бүрэлдсэн байна.

“Бүгд Найрамдах Бүрэн Эрхтэй Монгол Ард Улсын дээд эрхийг хадгалах улсын анхдугаар их хурлын бичиг”-т: “... богд Жавзандамба хутагт хаан нэгэнт таалал төгссөн тухайд жинхэнэ ард улсын ёсонд нийлүүлэн, Бүгд Найрамдах засгийг явуулан, улсын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалуулахаар тогтоон... тусгайлан ухуулах бичиг гаргаж нийтээр сэнхрүүлэн ухуулав”¹³ гэжээ.

— Ийнхүү төрт ёсныхоо түүхэнд анх удаа төрийн засаглалын бүгд найрамдах хэлбэрийг сонгон авч хэрэглэх болсноор засгийн энэхүү хэлбэр бүхий төр улсын эрх зүйн харилцааг зохицуулах гол хэм хэмжээ болсон Үндсэн хуулийг /бичмэл/ батлан гаргах зайлшгүй шаардлагатай болсон байна.

1924 оныг хүртэл Монгол Улсад Ардын засгийн газраас батлан гаргасан хууль эрхийн актууд Үндсэн хуулийн зохицуулалтын үүргийг гүйцэтгэж байжээ. Үндсэн хуулийн ач холбогдол бүхий хууль эрхийн хэм хэмжээг агуулсан тэдгээр актуудын тоонд: “Монгол Ардын Намын нэгдүгээр их хурлын тогтоол” /1921.3.1./, “Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хурлын тогтоол” /1921.3.23./, “Ардын түр засгийн газрыг байгуулсан тухай Монгол Ардын Намын Төв Хорооны тогтоол” /1921.3.26./, “Газрыг хувийн өмч болгохыг устгасан тухай Ардын түр засгийн газрын тогтоол” /1921.5.21./, “Засгийн газрын төлөөлөгчдийн дүрэм” /1921.9.20./, “Ардын засгийн газар ба Богд хаан хоёрын хооронд байгуулсан тангаргийн гэрээ” /1921.11.1./, “Хамжлагат ёсыг халах тухай гаргасан тогтоол” /1922.1.25./, “Хошууны тушаалд тайж, ардыг ялгаварлахгүйгээр томилох тухай тогтоол” /1922.5.26./, “Нутгийн захиргааны дүрэм, засаг ба засаг бус ван, гүнгийн эрх хэмжээний дүрмийг баталсан тогтоол” /1923.1.5./, “Монгол улсын захиргааны дүрэм” /1923.3.22./, “Орон нутгийн хамжлагыг устгасан тухай тогтоол” /1923.4.20./, “Хошууны дарга сонгох ба аймгийн хаадын тамгыг хураах тухай тогтоол” /1924.3.7./, “Орон нутгийн захиргааг байгуулж дуусгах тухай тогтоол” /1924.3.21./, “Намын Төв Хорооны бүгд хурлаас Бүгд найрамдах засгийг байгуулах тухай гаргасан тогтоол” /1924.6.7./ зэргийг оруулж болно.

Монголчууд төр засгаа хаан буюу тодорхой бие хүнээр төлөөлөн ойлгож байснаар хааны зарлиг, бичмэл бус хэм хэмжээ давамгай байдалтай болж, энэ нь уламжлалт төрт ёсны онцлог шинж болж байв. Иймээс үндсэн хуулийг батлан гаргах болсон тэр үеийн онцлог нь анх удаа бичмэл хэм хэмжээнд улс төр, эрх зүйн харилцааны зохицуулалтыг чиглүүлэх болж буйгаар илэрч байгаа юм.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын ялалтын үндсэн дээр хэрэгжсэн улс төрийн шинэчлэлт, бусад олон арга хэмжээний үр дүнд 1924 оны арваннэгдүгээр сарын 26-нд Улсын Анхдугаар Их Хурлаар Монгол Улсын анхны үндсэн хууль батлагдсан билээ. Үүгээр манай улсад үндсэн хуульт байгууллын эрх зүйн үндэс, үндсэн хуульт ёсны улс төрийн зарчим буй болсон, түүний үндсэн дээр төр, хууль цаазын шинэ тогтолцоо бүрэлдэх үйл явц өрнөсөн байна.

Улсын Анхдугаар үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн нэгдүгээр зүйлд “бүх Монгол Улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах Бүрэн эрхтэй Ард Улс гэж... нэрлэнэ”¹⁴ гэж тунхагласан нь Бүгд найрамдах засаг байгуулагдаж оршин тогтнох чухал үндэслэл

¹³ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын их, бага хурлын тогтоол * үндсэн хууль * тунхгууд. УБ., 1956, 27-28 дахь тал.

¹⁴ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын их, бага хурлын тогтоол * үндсэн хууль * тунхгууд. УБ., 1956, 30 дахь тал.

болсон байна. Мөн "Харьяат улсад Бүгд Найрамдах Ардын Засгийг явуулж, да жунтан гэдэг ерөнхий даргыг сонгохгүй, улсын бүх дээд эрхийг Улсын Их Хуралд ба мөн хурлаар сонгогдсон Засгийн Газраа хадгалахаар"¹⁵ тогтжээ.

Анхдугаар үндсэн хууль бол үндсэн хуулиар баталгаажсан төр засагтай болохын төлөө нийгмийн алсын хараатай, эх оронч, дэвшилт үзэлтэй төрийн шударга зүтгэлтэн, шашны төлөөлөгчид, эгэл жирийн олон монголчуудын олон жилийн шантрашгүй тэмцлийн үр дүн, Монголын сэргэн мандалтын эхийг тавьсан 1911 оны үндэсний хувьсгалын болон 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын анхны жилүүдэд гарсан өөрчлөлт, шинэчлэлт, ололт амжилтын тухайн үеийн оргил, баталгаа байв.

Анхдугаар үндсэн хууль нь монголчууд хэзээнээс нааш төр засагтай байж, түмэн олон түүндээ харьяалагдан захирагдаж, төрийн хууль цаазыг ёсчлон дагаж мөрдөж биелүүлдэг төрт ёсны уламжлалыг өвлөж авсан боловч төрийн эрх мэдлийг язгууртан дээдэс угсаа залгамжлан барьдаг бурангуй ёсыг эцэс болгож, төрийн хууль, эзний зарлиг, тушаалыг ямар ч үг дуугүй биелүүлэгч "амьд" эрэг шураг, номхон зарц боол гэгдэж байсан ард иргэдийг төр улсын эрх чөлөөт иргэн харьяат, төр засгийн эрхийг барилцагч субъектын зиндаанд өргөмжлөн дэвшүүлсэн юм. Монголын түүхэнд урьд өмнө улс төрийн тийм том үйл явдал хэзээ ч гараагүйг санахад Анхдугаар үндсэн хуулийн асар их түүхэн ач холбогдол аяндаа тодорхой болно. Анхдугаар үндсэн хуулийн гадаад ач холбогдол нь Монгол Улс олон улсын харилцааны тавцан дээр "Бүгд Найрамдах Бүрэн эрхтэй Монгол Ард Улс" гэдэг нэрээр хууль ёсны байр суурь эзлэх болсон явдал юм. Тэрхүү байр суурийн бэхжилт одоо манай улс дэлхийн 141 улстай дипломат харилцаатай, олон улсын нэр хүнд бүхий 50 гаруй томоохон байгууллагын гишүүнээр ажиллаж байгаа баримт батлан харуулж байна.

Анхдугаар үндсэн хуулийн зорилго хэрэгжиж биелсэн, нийгэм хөгжлийн илүү дээд шатанд дэвшсэн, түүний өмнө шинэ томоохон зорилго тулгарсан, үндсэн хуульт төрийн тогтолцоог улам төгөлдөржүүлэх шинэ томоохон зорилго тулгарсан нь дараачийн үндсэн хуулийг боловсруулан гаргаж, дагаж мөрдөх шаардлагыг буй болгосон байна.

1940 оны зургадугаар сарын 30-нд Улсын VIII их хурлаар хоёрдугаар Үндсэн хуулийг баталсан байна. Уг Үндсэн хуулийг ардын хувьсгалын анхны шат үндсэндээ төгсгөж, ардчилсан хувьсгалаас социалист хувьсгалд аажмаар дэвшин орохын төлөө Монголын ард түмний тэмцлийн дүнг бататгасан хууль хэмээн үнэлж ирсэн бөгөөд эл Үндсэн хууль социалист хэв маягт багтах ангийн шинж чанартай хууль байсан юм.

БНМАУ-ын Ардын Их Хурлын дөрөв дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулганаар 1960 оны долдугаар сарын 6-нд БНМАУ-ын гурав дахь Үндсэн хуулийг баталжээ. 1960 оны Үндсэн хууль нь социалист хэв маягийн хууль байсан бөгөөд Монгол Улсын үзэл сурталжсан түүхэнд уг Үндсэн хуулийг улс орноо капитализмыг алгасан социализм өөд хөгжих замд олсон ололтыг бататгасан хууль гэж үнэлж ирсэн билээ.

Дээрх гурван Үндсэн хуулиудыг шинжлэн дүгнэж үзэхэд улс орны түүхэн хөгжлийн тухайн цаг үеүүдэд тавигдаж байсан нийгэм-улс төрийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн агуулга, шинж, ач холбогдолтой байсан нь харагдаж байгаа юм. Гэвч улс төрийн түүхэн нөхцөл байдлаас шалтгаалан монголын төрт ёсны өв уламжлал, зан заншлаасаа ихээхэн хөндийрч үндэсний язгуур ашиг сонирхлоо харгалзан үзэлгүйгээр социалист онол, ангич үзэлд тулгуурласан нийгэмд нийцэн үйлчилж байсан нь тодорхой юм. 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиуд гол төлөв Монголын үндэсний ардчилсан хувьсгалын болон социалист нийгмийг байгуулах шатны үндсэн зорилтуудыг хуульчлан баталгаажуулахад илүүтэй чиглэгдэж байсан нь харагддаг.

1989 оны эцэс, 1990 оны эхээр Монгол оронд ардчилсан хувьсгалаар улс төрийн хуучин тогтолцоо халагдаж, хөгжил дэвшлийн шинэ үе эхэлж, монголчуудын үндэсний

¹⁵ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын их, бага хурлын тогтоол * үндсэн хууль * тунхгууд. УБ., 1956, 29 дэх тал.

ухамсар сэргэн төрт ёсны түүхэн уламжлалаа дээдлэн хадгалж, өвлөх гэсэн эрмэлзлэл, сэтгэлгээ өрнөсөн билээ. Энэ нь монголчуудын төрт ёсны түүхэнд гарч буй улс төрийн сэтгэлгээний түүхэн эргэлт, ардчилсан төр-нийгмийн байгуулал бүхий төрт ёсны шинэ байгууламжийн эхлэл болжээ.

1990 оны гуравдугаар сарын 23-нд МАХН-ын онц эрхтэй холбогдсон заалтуудыг 1960 оны Үндсэн хуулиас хасч, Монголд олон намын тогтолцоо байхыг хүлээн зөвшөөрсөн заалтыг түүнд шинээр оруулсан нь улс төрийн харилцааг шинэчлэх, үндсэн хуулийн үзэл баримтлалыг эрс өөрчлөх эхлэл болсон юм.

Улмаар 1990 оны тавдугаар сард Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль гаргаж, олон ургальч үзэл, олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрсөн, хууль тогтоох болон гүйцэтгэх дээд байгууллагын тогтолцооны гол шинж, үйл ажиллагааны зарчмыг шинэчилсэн зэрэг өөрчлөлтийг 1960 оны Үндсэн хуульд оруулжээ. Энэхүү Үндсэн хуулийн нэмэлт хуулиар төрийн эрх барих уламжлалт дээд байгууллага-Ардын Их Хурал, парламентат ёсны шинэ байгууллага-Улсын Бага Хурал, Төрийн тэргүүн-Ерөнхийлөгчийн институтыг бий болгож, тэдгээрийн хоорондын эрх мэдлийн харилцан хамаарал, түүнийг зөв тэнцвэртэй хуваарилах зарчмыг гол болгосон байна.

Хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрх бүхий төрийн эрх барих дээд байгууллага-Улсын Бага Хурал парламентат ёсыг жинхэнэ утгаар нь бүрдүүлэн тогтоох гол үүргийг гүйцэтгэх болжээ. Улсын Бага Хурлын дарга Улсын Бага Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг бүхэлд нь уялдуулан зохицуулахаас гадна БНМАУ-ын дэд Ерөнхийлөгч байна. Улсын Бага Хурлын гишүүдийн дөрөвний гурав нь Ардын Их Хурлын депутатуудын дотроос сонгогдсон байхаар хуульчлан тогтоожээ. Улсын Бага Хурал Ардын Их Хурлын эрх хэмжээнд хамаарагдахаас бусад төрийн дотоод хийгээд гадаад бодлогын ямар ч асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болох бөгөөд үйл ажиллагаагаа Ардын Их Хуралд тайлагнана.

Шинэ Үндсэн хууль батлах хүртэлх үеийн шилжилтийн төрийн шинж чанарыг дээрх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт харуулж байдаг. Нийгмийн амьдралд гарсан ардчилсан өөрчлөлтийн явцад бий болсон төрийн ардчилсан шинэ тогтолцоог улам бэхжүүлж, улс орны хөгжлийн баталгааг хууль зүйн гүнзгий үндэстэй болгох шаардлагын үүднээс Улсын Бага Хурал 1990 оны аравдугаар сарын 4-нд "Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комисс"-ыг шинээр байгуулсан байна. Уг комиссын удирдан боловсруулж, нийт ард түмнээр хэлэлцүүлсэн "Монгол Улсын Их Цаазын төслийг" Ардын Их Хурлын 12 дахь удаагийн сонгуулийн II хуралдаан 70 гаруй хоног хэлэлцэж, 1992 оны нэгдүгээр сарын 13-ны өдөр "Монгол Улсын Үндсэн хууль" нэртэйгээр батлан гаргаснаар хуучин байгууллыг үндсээр нь халж, Монголын төр, нийгмийн байгуулал, үндсэн хуульт ёсны ардчилсан зарчмуудыг тогтоох улс төр, эрх зүйн хэм хэмжээний үндэс суурийг тодорхойлжээ.

Шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулах явцад төр, намуудын удирдагчид, хуульч, эдийн засагч, улс төр судлаач, түүхч, хэл шинжлэгч зэрэг эрдэмтэд, мэргэжилтнүүд оролцсоноос гадна АНУ, Австрали, Австри, ХБНГУ, Франц, ОХУ, Польш, Япон гэх мэт гадаад орнуудын төлөөлөгчдийн болон НҮБ-ын Хүний Эрхийн Олон Улсын Хороо, Олон Улсын Парламентын Холбоо, Олон Улсын Өмгөөллийн Байгууллага зэрэг олон улсын байгууллагын өндөр мэргэжлийн шинжээчдийн санал бодлыг өргөн хүрээтэй сонсож тусгасан байна.¹⁶ Мөн шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулахдаа тус улсын 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулийн зэрэг, сөрөг тал хийгээд 1990 онд батлагдсан Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн үзэл санааны чиг хандлагыг харгалзан үзсэн байна. Энэ үүднээсээ 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хууль бол үндсэн хуулийн тухай шинжлэх ухааны орчин үеийн ололтод

¹⁶ БНМАУ-ын АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн II хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл". 3-р боть. 1991.11.13. 98 дахь тал.

тулгуурлан, ардчиллын олон жилийн уламжлалтай өндөр хөгжилтэй орнуудын болон олон улсын нэр хүнд бүхий байгууллагын мэргэжилтнүүдийн санал зөвлөмжийг Монголын онцлогт тохируулан тусгаж боловсруулсан орчин үеийн ардчилсан үндсэн хууль болсон билээ.

Монголын түүхэн дэх төрт ёс, хуультай болон үндсэн хуультай ёсны үеүдтэй харьцуулж үзэхэд Монгол Улсын шинэ Үндсэн хууль асар их ач холбогдол, онцлогтой юм. Үүнд энэхүү Үндсэн хууль:

Нэгдүгээрт, Монгол Улс тоталитар дэглэмийг бүрмөсөн халсан, олон улсын үндсэн хуультай ёсны шаардлага, зарчимд нэгдсэн, ардчилал, зах зээлийн харилцаанд шилжиж, "хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм" байгуулах зорилгыг тунхаглан баталгаажуулсан.

Хоёрдугаарт, засаглал хуваарилах зарчмыг төвдөө тавьсан үндсэн хуультай төр засгийн ардчилсан тогтолцоог бүрдүүлж, түүний зохион байгуулалт, дэглэмийг тодорхойлж өгсөн.

Гуравдугаарт, төр олон нийт /сонгогчид/-ийн хяналтанд байх, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдал, эв нэгдлийг дээдлэн зөвхөн иргэдийн тусын тулд үйлчлэх, хэнд ч бус гагцхүү хуулинд захирагдах, жирийн иргэнээс эхлэн төрийн тэргүүн хүртлэх бүх иргэд, бүх хүмүүс хуулийн өмнө адил тэгш байх ёс, зарчмыг тогтоосон.

Дөрөвдүгээрт, хүнийг нийгмийн социал бодлогын төвд тавьж, түүний тал бүрийн хөгжлийг хүмүүнлэг ёсны биелэлд тооцож, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан.

Тавдугаарт, олон улсын хамтын нийгэмлэгт Монгол Улсын эзэлсэн зүй ёсны байр суурь, түүний нээлттэй гадаад бодлогын зорилго, зарчмыг эрх зүйн баталгаатай болгосон юм.

Д.Содномгомбо.
Профессор

Монголын уламжлалт төр ёс, түүний шинэчлэлийн зарим асуудал

Манай Монголчууд өнө эртний соёл иргэншилтэй билээ. Тэдгээрийн салшгүй хэсэг нь төр ёс, улс төр, улс төрийн соёл юм. Хэрэв соёл хүнтэй хамт, түүний мэдлэг, төсөөлөл, арга-дадал, туршлагын нэгдэл болон үүсэн тогтнож, төлөвшин хөгжсөн бол хүн төрөлхтөн соёлыг бүтээж, түүний ололт амжилтын аяс, ач гавъяагаар дэгжин дээшилж хөгжиж ирсэн. Нөгөө талаар соёл, иргэншил тухайн үеийн орны хүн ам, иргэдийг эмхлэн цэгцэлж, зохион байгуулах зүй ёсны шаардлагаар буй болжээ. Хүн төрөлхтөний түүхэн дэх ангит нийгэмд, иргэдийг улс төрөөс өөрөөр нэгтгэн зохион байгуулах аргагүй билээ. Учир нь хүн төрөлхтөн хэзээ ч захиргаагүйгээр оршин тогтнож ирээгүй, оршин тогтнож чадахгүй. Хэрэв хүй нэгдлийн нийгэм ёс суртахууны хууль, зарчимд тулгуурладаг байсан бол хүй нэгдлээс хойших үе шатуудад ёс суртахууны зэрэгцээгээр гол төлөв эрхийн хүчин зүйлд дулдуйдан оршиж ирсэн байна. Энэ утга санаагаар Платон "улс төрийг хүмүүс хамтарч амьдрах урлаг буюу арга ухаан мөн", Аристотель "хүнийг улс төржсөн амьтан мөн" гэсэн сургаал дэвшүүлжээ.

Энэхүү жам ёс, зүй тогтлоор Монголын соёл, иргэншил замнаж иржээ. Хэрэв соёл иргэншлийг бүхэл гэж үзвэл улс төр түүний бүрдэл хэсэг юм. Аливаа хэсэг холбогдох бүхэлдээ харъяалагдан захирагдаж, түүнээс хараат байдаг болохоор Монголын улс төр нийт хүн төрөлхтний хийгээд өөрийнхөө улс-үндэс угсааны соёл иргэншлийн хууль, зүй тогтлын дагуу үүсэн тогтож, өөрчлөгдөн хөгжиж ирсэн нь маргаангүй.

Түүхэнд тэмдэглэснээр м.э.ө хоёр мянган жилийн тэртээ байсан монголын анхны гарал аймаг хүннү нарын нийгмийн байгуулал анхны хүй нэгдлээс ангит нийгэмд шилжих үед бүрэлджээ. Түүнээс гадна Хүннү, Сяньби, Жужан, Түрэг, Уйгар, Кидан зэрэг Монголын аймгууд улс төр, төр ёстой байсан бөгөөд тэдгээр нь жам ёсоороо өөрчлөгдөн шинэчлэгдэж, үеэ өнгөрөөсөн нь үгүйсгэгдэн орхигдож, дэвшилттэй нь өвлөгдөн уламжлагдаж ирсэн байна. Монголын улс төрийн шинэчлэлийн түүхэнд Чингисийн үе онцгой байр суурь эзэлнэ. Чингис хааны байгуулсан хаант Монгол улс XIII зууны эхний үеийн Монгол оронд л мэндэлж чадахаас биш, өөр цаг үе, өөр оронд байж болшгүй билээ. Нэг үгээр хэлбэл тэр үеийн Монголын нийгмийн байгуулал даруй хаант улсын үндсэн суурь болж өгсөн байна. Үүнд гурван гол хүчин зүйл нөлөөлжээ.

Нэгдэх нь эртний уламжлалт "Хуучин Монгол улс" болно. Чингис хаанаас өмнө бүх Монголын нэгдмэл төр гэж байгаагүй. Гэвч Монголын том аймгуудад XI зууны сүүлч буюу XII зууны эхээр тус тусынх нь төрийн дээд байгуулал "хаан" гэгч ноёрхогч буй болжээ. "Хамаг Монголыг Хавал хаан захирч" байсан тэр үеэс хойш Хотла хаанд хүртэл "Хаан" ноёнттой, цэрэгтэй, засагтай /анхны/ "Хамаг Монгол улс" гэсэн ийм нэгэн нийгмийн ба улс төрийн хэлбэр бүхий "нургуун Монголчууд" "Гол нуруу болсон Монголчууд" буюу "Хуучин Монголчууд" байжээ. Сайтар судлагдаагүй боловч "Хуучин Монгол улс"-ыг захирч байсан ноёрхох байгуулал нь аймгийн холбоо гэдэг овгийн байгуулал мөн бөгөөд тэр нь аймгийн холбоо гэдэг овгийн байгуулалын сүүлчийн хэлбэрээс цааш нэг алхам урагшлан хөгжсөн хэлбэр байжээ. Тэр үед "хуучин монгол улс"-ыг захирч байсан ноёрхох байгуулал нь "нуруу монголчуудын язгууртнаас түрүүчийн хааны гэрээс буюу уламжлалт хууль ёсоор сонгон гаргасан "хаан" болно. Тэр нь цэрэг дайн, ан гөрөө ба нийгмийн үйлдвэрлэл, хуваарилалт зэрэг нийгмийн чанартай үйл ажиллагааны хамгийн дээд удирдагч юм. Бас "хаан"-ынхаа зарлиг, захиаг биелүүлэх эл овог аймгийн түрүү /тэргүүн/ ба ноёд буй болжээ. Эдгээр нь улс төрийн гүйцэтгэгч байгууллагыг бүрдүүлдэг байжээ. Түүнийг улс төрийн эрхэт байгууллага-хамт овгийн гишүүдээр бүрэлдсэн хуралтайгаагаар сонгон гаргана. Тэр үед божигд тайчууд мэт Боданцарын төрлийн хамт овогтой тийм эрхэт байгууллагатай байжээ. "Хуучин монгол улс"-ын ноёрхох эрхийн бас нэгэн суурь бол "нуруун монголчуудын

ахмад овог /баарин-оос эрхэлдэг" сахиулын эрх үүнээс гадна "шашны дээд хэргэмтэн"-ий оролцдог "Бахь" байсан болно. Дээрхээс үзэхэд "Нуруун монголчууд" нь Хавал хааны үеэс эхэлж аймгийн нийтийн эзэн "хаан"-тай болсноор барахгүй, бусад монгол хэлтэн аймгуудад, тухайлбал Хэрийд Татаарт нэгэн адил холбогдоно.

Чингис хааны гардан байгуулсан хаант монгол улс жижиг "хаант улс"-уудыг нэгтгэн төвлөрүүлж, тэдгээрийн төрт ёсыг дээд хэлбэрээр уламжилсан байна.

Хоёрдох нь адил бус хөгжилтэй аймгууд болно. Чингис хааны нэгтгэсэн аймаг угсаатны тоог янз янзаар тэмдэглэдэг байна. Тэдгээр нь үндсэндээ нэгд Боржгин, Тайчууд зэрэг "Нуруун Монголчууд"-ын олон овогтон болон Хонхэрээд, Горлис зэрэг "Нуруун Монголчууд"-ын олон овогтнууд болно. Энэ бол Монгол үндэстний гол цогц юм. Хоёрт Хэрийд, Найман, Мэргэд зэрэг нь Уйгар, Хэгийз мэтээр Түрэк төрлийн үндэстнүүдтэй нягт холбоотой байсан, мөн Түрэк гаралтай гэж нэрлэгддэг Монгол хэлтэй, соёлын талаар нилээд өндөр хөгжилтэй байжээ. Тиймээс тэдгээр аймгууд хаант Монгол улсын төрийн байгууламжид их ач холбогдолтой юм.

Гуравт, Онгууд, Татар мэтийн Алтан улстай харилцаа холбоотой байсан аймгууд болно, Эдгээр аймгууд Хятадын феодалын байгууллын нөлөө Монголд нэвтрэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна.

Гуравдугаар үндсэн суурь нь Чингисийн өөрийн нь хүч, түүгээр удирдуулсан цэргийн зохион байгуулалт, хүчин чадал болно.

Хаант Монгол улсын байгуулалын дээд хэлбэр бол эзэн хааны харьцуулшгүй эрх болно. "Хуучин монгол улс"-ын үе дэх олон жижиг "хаант Хэрийд газар, харьяат газар"-тай онцлох эрхийг эдэлж байсан бол одоо Чингис хаант Монгол улсын энэхүү эрх нь хэдэн арван аймаг угсааг хамарсан бүх Монголын хэмжээний туйлын их дээд эрх болжээ.

Монголын нийгэм бол нэгэнт нүүдэлчний нийгэм болох учраас энэхүү нийгмийн өвөрмөц орчин ахуйд оршин тогтнож, хөгжин улирч ирсэн монгол үндэстэн нь өөр улс үндэстэн лүгээ адилгүй, өвөрмөц өв уламжлал ба зан заншилтай байсан ажээ. Энэхүү онцлогийн төвлөрөнгүй илрэл бол Монголын хуралдайн дүрэм ажээ. Энэхүү "Хуралдай" нь "хурал зөвлөлгөөн" гэсэн Түрэк гаралтай үг юм. Овгийн гишүүд бүрмөсөн эрх тэгш байдал дор овгийн доторх чухал асуудал овгийн ахлагчийг эрх дэвээрээ сонгох ба огцруулах, жич үйлдвэрлэл, хуваарилалд холбогдох асуудлыг шийдвэрлэх нийгмийн байгуулал болох юм. Гэвч энэхүү "хуралдай" нь монголын нийгмийн хөгжлийг дагалдаж, агуулгын талаар хувьссаар ирсэн нь бас тодорхой байна.

Жишээ нь хуралдай бол Монголд овгийн байгуулал задарсны дараах үзэгдэл юм. Ялангуяа Монголын нийгэмд "хан"-тай болсноос хойш түүний чанар нь бүр хувирчээ. Чингисийн үед том чухал асуудлыг шийдвэрлэхэд олонхдоо хуралдайгаар ярилцдаг байжээ. "Нууц товчоо" зэрэг тулгуур бичигт тэмдэглэснээр Чингисийн үед долоон хуралдай болсон байна. Үүнд: 1189 онд Тэмүүжинг "Чингис хаан"-д өргөмжилсөн, 1202 онд Татвар иргэний асуудлыг хэлэлцсэн, 1204 онд Наймантай байлдах тухай зөвлөлдсөн, 1206 онд хаант Монгол улсыг байгуулсан, 1216 онд харьяат газар, улс иргэнийг хуваасан, 1216 онд Түмэд иргэний асуудлыг хэлэлцсэн, 1204 онд Наймантай байлдах тухай зөвлөлдсөн, 1216 онд харьяат газар, улс иргэнийг хуваасан, 1216 онд Түмэд иргэний бослогыг дарангуйлахаар Борхулыг томилсон, 1219 онд хаан өв залгамлагчийг тогтоох их хуралдай хийжээ. Хуралдай нь зөвлөх, шийдвэрлэх хоёр бүлэгтэй, ардчиллын шинжтэй явж иржээ.

Монгол үндэстэн нилээд эртнээс хуультай байжээ. Бүр Хавал хааны үеэс хуультай болсон байна. Тэр үеийн хууль ард иргэдийн эсэргүүцэл дайсан этгээдийг дарангуйлах үүрэгтэй байжээ. Чингисийн үед эрүүгийн хууль улам боловсронгуй, тодорхой болсон байна. Чингис хаан шинэхэн байгуулсан монголын хаант улсыг бэхжүүлэхийн төлөө улс төрийн ноёрхлоо бататгахын төлөө, нийгмийн ёс дэглэмийг тогтоож, энэхүү төрөлх

“асар, зэрлэг, дүрэм ёсгүй” нүүдэлчин үндэстнээ хуулиар засахын төлөө монголын ёс дүрмийн их товчоог тогтоож, үсэг бичгээр анх удаа тэмдэглэсэн хууль цаазын бичиг “Их засаг”-ийг байгуулан, бүх улсын заргач томилжээ. Жишээлбэл энэ үед занчих, цөлөх, хорих, алах ба ураг угсаагаар нь сөнөөх /хүйс тэмтрэх/ мэтийн эрүүгийн ялыг хэрэгжүүлж байжээ.

Чингис хааны “Их засагийн бичиг” гэдэг нь гол төлөв түүний сургаал үг, зар зарлиг, цэргийн сахилга, албан дүрмийг тэмдэглэн дэвтэрлэж уламжилсан зүйл болно. Энэ хууль 1206-1218 онд зохиогдсон байна. Тэр цагаас нааших Монголын улс төр ёсны түүхэн замналыг өнгөц, хийсвэрээр эртний тархай бутархай монгол аймгуудын төр ёс, түүний дараах хаант улсуудын төр ёс /Чингис хаанаас/ 1206-1227, Лигдэн хутагт хаан /1604-1634/ хүртэл 400 гаруй жил оршсон 35 хаант улсын төр ёс, (Монголын хаад, төр засгийн тэргүүн нарын нэрсийн жагсаалтын хавсралтаас үз.) манж хятадын ноёрхлын үе дэх Монголын төр ёс, Өрнөдийн улс төрийн модернизацийн онолынхны үздэгээр уламжлалт нийгмээс орчин үеийн нийгэмд шилжих /1911 оноос одоо хүртэл/ үеийн төр ёс гэж үечилж болмоор санагдаж байна. Дурьдсан үеүд дотроо тодорхой мөчлөг буюу шатуудтай нь ойлгомжтой. Жишээ нь сүүлийн шилжилтийн үеийн төр ёсыг теократизм /1911-1924/, уламжлалт ардчилсан шинжтэй засаглал /1921-1924/, ардчиллаас гажиж, социалистчилагдсан засаглал буюу авторитаризм, өрнөдчилөгдсөн ардчиллын төр ёс гэх мэтээр шаталж болох байна.

Монголын энэ их урт удаан түүхтэй, гүнзгий агуулгатай баялаг хэлбэртэй улс төр, төр ёсны мөн чанарыг өчүүхэн миний бие хоромхон зуурын ганцхан өгүүлэл мэтэд байтугай нь шинжлэх ухааны бүхэл хамтлаг үнэн мөнөөр нь илтгэн дүгнэхэд бэрхшээлтэй юм.

Энд улс төрийн шинжлэх ухааны үүднээс монголын төр ёсны шинэчлэлийн зарим асуудлыг дараах байдлаар товчхон өгүүлэхийг оролдлоо.

Манай Монголчуудын улс төрийн ухамсар мал аж ахуйн тулгуур үндэс болсон газар дэлхийн үр өгөөж, хайр хишиг, хор хөнөөлийг мэдрэх, заяаны чадвар буюу зөн билэгтэй холбоотойгоор үүсэн төлөвшиж ирсэн байж болох юм. Жишээ нь монголчууд тэнгэр, газар, бурхан, төрийн сүлдээ адилхан дээдэлж, хүндэтгэж шүтэж ирсэн заншилтай байна. Дурьдсан санаагаар өгүүлбэл эртний болон хожмын монголчуудын улс төрийн ухамсар танин мэдэхүйн онолын хувьд тулж ажиглах буюу мэдэрч мэдэхүйн төвшинд, нийгмийн ухамсрын бүтцийн талаар нийгмийн сэтгэл зүйн хүрээнд төлөвшиж ирсэн байдалтай байна. Энэ нь өдөр тутмын мал маллагаа, газар тариалан, ан агнуур зэрэгт шууд холбоотой гэж тооцогддог. Үүгээрээ ч тийм ач холбогдолтой нар, сар хиртэх, од мичид гариг тохиох, нар гуравлах, мал сүрэг, ан амьтны зан төрх, хэлбэр дүрсээ хувиргах зэргийг ажиглан аж амьдралаа зохицуулахаас эхлэн жилийн өнгөөр улс төрийн байдлыг, хаад, ноёдын намба төрхөөр улс орныхоо одоо, хойчийг төсөөлөх байдлаар илэрч ирсэн байна. Ялангуяа төрийн тэргүүн, түшмэл даамал, түшмэлүүдийг шалгаруулж олох шинж тэмдгийн талаар эртний Дорнын арга ухааныг манай монголчууд мэдэж, ашиглаж ирсэн байна. Харин энэ нь хүртэмжийн хувьд явцуу ба нийтлэг шинжтэй бишээ. Энэ бол улс төр, төр ёсны тухай монголчуудын үзэл ба үзэл санаа онолын өвөрмөц түвшинд боловсорч, үеэс үед уламжлагдаж ирснийг үгүйсгэж буй хэрэг биш юм.

“Монголын нууц товчоо”-ноос эхлэн “Хөх судар”, “Хөх Монголын хөх туг”, “Алтан товч” зэрэг алдарт сурвалж бүтээлүүдэд эртний монголчуудын төрийг үзэх үзэл тусгагдан хадгалагдаж ирсэн байна.

Эдгээрт зан авирын дүрмийн үндсэн дээр төр улсыг жолоодох нь чухал гэсэн үзэл санааг дэвшүүлээд хэрэв нийгэмд ёс суртахууны дүрэм журам алдагдвал “захирагч захирагч биш, хүү нь хүү биш болж хувирна” гэсэнтэй адил төстэй санааг өгүүлжээ. Жишээ нь “Нууц товчоо”-нд Чингисийг хаан ширээнд залсантай холбогдуулан :

Тэмүжин хөвүүний минь хаан болгосон нь маш зөв. Монголчууд хаангүй байж яаж болно.

Энэ шийдвэрээ эвдэхгүй

Эв зангиагаа таслахгүй

Эх захаа алдахгүй эгнэгт журамтай бай гэж өгүүлжээ. /"Монголын нууц товчоо"/ УБ., 1990, 78-р тал/

"Их засаг хуулийн "Ерөнхий хууль буюу үндсэн хууль" гэсэн нэгдүгээр хэсгийн 3-р зурваст ноёд, түшмэл, цэрэг, байлдагч жич хөтөч зарц хүртэл тус тусын тушаалаа гүйцэтгэн чадваас мөнх тэнгэрийн дор их үйлс бүтэх ажгуу. Өвөл, зундаа нүүдэллэн малжваас мал тарган, идэш элбэг, цэрэг хүчирхэг болно. Тиймээс миний сургаалыг мянган онд хувиргалгүй, түмэн үедээ өөрчлөлгүй ургийн ургаараа мөрдөн журамлатугай" гэж сургажээ. Энэ нь угтаа Чингис хааны өөрийн нь сургаал мөн. /Сайшаал Чингис хааны товчоо. Дээд дэвтэр Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 492-р тал/

Юан улсын төр засах хөтөлбөр "Арван буянт номын цагаан түүх" хэмээх сударт номын сургаал, хааны зарлигийг хоёр засаг гэж нэрлээд: "Ерд хоёр засгаар эс явбаас буян, хэлэнц хоёр, цагаан хар хоёр, хүнд хөнгөн хоёр, үнэн худал хоёр, сайн муу хоёр, жаргал зовлон хоёрыг улс, аймаг тус бүр мэдтүгэй. Тэгвэл үнэн номын засаг хэвийн занхиа мэт алдаршгүй. Хүнд хааны засаг алтан бугалга мэт эвдэршгүй. Хоёр ёсныг холилгүй тус бүр сайтар хичээсүгэй" гэж өгүүлсэн байна. /"Арван буянт номын цагаан түүх" Хөх хот, 86-р тал/

Төрийнхөө сүр сүлдийг дээдлэх, төрд тэрслэхээс цээрлэх нь эртний монголчуудын ёс суртахуунтай нягт холбоотой улс төрийн ухамсрын нэг онцлог байжээ.

1921 оноос өмнөх түүхийн урт хугацааны туршид Монголын улс төрийн ухамсар гол төлөв үндсэний зан заншил, ёслол, уламжлал, ихэс, мэргэд, эцэг эхийн айлтгал, сургаалд тулгуурлан гэр ахуйн нөхцөлд үндсэндээ урсгал байдлаар төлөвшиж ирсэн онцлогтой бөгөөд түүнд шашин чухал үүрэг гүйцэтгэж байжээ. Энэ талаар монголын домог, үлгэр, мэргэн сургаал, зүйр цэцэн үг зэргийн ач холбогдлыг онцлон тэмдэглэх нь чухал.

Бусад аль ч нийгмийнхтэй адилхан Монголын улс төрийн харилцаа нь төр, засаг ба иргэдийн, хүн амын янз бүрийн бүлгүүдийн улс төрийн ашиг сонирхолтой холбоо бүхий харилцааны илрэл болж ирсэн байна. Гэхдээ нүүдэлчний соёл иргэншил, аж төрөх ёсны ололт, амжилтын хэсэг болсон монголын улс төрийн харилцаа Дорнын суурьшмал орнуудынхаас, нэн ялангуяа Өрнөдийн орнуудынхаас эрс ялгаатай юм. Төрийн эрхийг тэнгэрээс гаралтай, дээд язгуурын-цагаан ястангууд барьдаг, тэд төрийн хэргийг шийддэг, хаад, ноёдыг угсаа залгамжлуулдаг байсан болохоор монголд овог, аймгийн байгуулал задарч, феодалын байгуулал тогтсон цагаас 1920-д он хүртэлх хугацаанд зарц-боолууд гэж нэрлэгддэг байсан жирийн ард иргэд улс төрийн харилцаанд гүнзгий оролцох, төрийн хэргийг шийдвэрлэх болоцоо буюу ёс бараг байсангүй. Харин ч тэд улс төр ба төрөөс хөндийрөх, зугатах хандлага зонхилох байдалтай байжээ. Үүнтэй холбоотойгоор ноёдтой сөргөлдвөл толгойгүй, нохойтой уралцвал хормойгүй болно гэсэн зүйр үг гарсан байж магадгүй юм. Үүнийг ард иргэдийн үсэг бичгийн боловсролтой холбож үзэх нь зүйтэй юм. Тэдний улс төртэй харьцах харилцаа үндсэндээ төр, засаг болон засаг ноёд, засаг бус феодалуудад биеэр зарцлагдах, эд мөнгө, малаар алба гувчуур төлөх, цэрэг, харуулын алба хаах зэргээр илэрч байжээ. Сайн эрсийн хулгайн хэргийг улс төрийн харилцааны нэг илрэл, эсэргүүцэл тэмцлийн хэлбэр байсан гэж үзэж болно. Харин 1921 оноос хойших хугацаанд Монголын нийгмийн ухамсарт механик үгүйсгэл, албадлага, аялдан дууриах зэрэг бэрхшээл завхрал тохиолдсон боловч агуулга, хэлбэр, арга барилын талаар шинэ чухал дэвшил гарсан байна.

Нийгмийн улс төрийн харилцааг хууль, зарлигаар зохицуулж иржээ. Эзэн, харъяатын ёсыг бэхжүүлэх зорилгоор Чингис хааны гаргасан "Их засаг" хууль

Монголын улс төрийн ухамсрын цаашдын хөгжил, төр ёсны уламжлалд маш их чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Монголын улс төрийн байгууллага хүй нэгдлийн овог, аймгийн байгууллагаас эхлэн одоо хүртэл оршин тогтнохдоо асар их өөрчлөгдөн шинэчлэгдэж ирсэн байна. Монгол аймгууд харилцан байлдах, нэгдэх, нэг хаант их гүрнээ байгуулж засан тохинуулах, харь орныг байлдан дагуулах, эзлэгдсэн улс орнуудаар алба төлүүлэх, тэднийг эсэргүүцэлгүй барьж байх, хүн амынхаа удмын санг хадгалах, мал аж ахуйгаа хөгжүүлэх зэрэг үүрэг, шаардлагаар иргэн цэргийн хэргийг нэгтгэн хосолсон орон нутгийн засаг захиргааг аравт, зуут, мянгат, түмтийн системээр баруун, зүүн гэх мэтээр гарууд болгон зохион байгуулж байсан байна.

Түүхэнд хүннү нарийн төрийн хэлбэрийг цэргийн ардчилал гэж нэрлэжээ. Цэргийн ардчилал, зонхилогчдийн зөвлөл, Чингис хаант монгол улсын болон түүний дараах хаадуудын үеийн хуралдайнууд бол хууль тогтоодог биш, харин зөвлөдөг байгууллага юм. Хуралдайн ёс Хубилай хааны үед арга буюу зөрчигджээ. Тэгээд Богд хаант Монгол улсын үед 1914 онд дээд, доод хурлын хэлбэрээр сэргээгдсэн байна. Энэ хоёр хурал бол парламент биш, ердөө л зөвлөх эрхтэй, Богдын тааллаар хуралддаг буюу завсарладаг байжээ.

Манжийн эзлэн түрэмгийллийн үеийг хамааруулахгүйгээр авч үзэхэд Монголын улс төрийн байгууллагын бүтэц, үүрэг маш энгийн байжээ. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засгийн эрх мэдэл хаад ноёд, түүний баруун, зүүн гарын түшмэд, туслах түшмэдүүдийн гарт төвлөрч байжээ. Түүний өөр нэг онцлог нь 1921 он болтол улс төрийн нам, төрийн бус байгууллагууд байгаагүй явдал мөн. Төр, сүм хийд хоёр бие биесдээ харилцан хүндэтгэлтэй ханддаг, нэг нэгнийхээ дотоод хэрэгт хөндлөнгөөс дур мэдэн оролцдоггүй байсан нь Монголын улс төрийн байгууллагын өөр нэг онцлог гэж үзэх үндэслэлтэй юм. Манжийн дарлалд байх үе /1696-1911/-д феодалын үе залгамжлах ёс уламжлагдаж, алдагдаж байжээ. Хошуу ноёдын чуулган, чуулган дарга бие даасан эрх мэдэлгүй, зөвхөн зуучлах үүрэгтэй, хэлбэрийн хувьд хуралдайн уламжлалт үргэлжлэл байжээ. Манж нар Монголын засаг захиргааны хуваарийг устгаж, цөмийг хошуу болгосон. "Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яам" хувааргүй ноёрхож, Монголын цэрэг, засаг захиргаа, улс төрийг манжийн амбан /сайд/ хэбэй- амбан /зөвлөх сайд/ хянаж байжээ. Манж нар Монголын төр ёс, үндэсний ухамсарыг устгахыг оролдсон. Гэвч Монголчууд төр ёс, үндэсний хэл, түүх, соёл, зан заншил, уламжлалаа хэвээр хадгалж, үндэс угсаагаа уусгалгүй авч үлдсэн нь нүүдлийн соёл иргэншлийн ач, давуу тал, монгол хүний улс төрийн болон үндэсний ухамсрын өсөлтийн илрэл юм. Үүний тодорхой жишээ бол засагийн эргэлт хийхээр ноёд, дээд лам нарын байгуулсан түр ерөнхийлөн шийтгэх газраас 1911 оны 12-р сарын 1-нд Монголын ард түмэнд гаргасан тунхаглан зарлах юм. Түүнд: "Манай монгол язгуураасаа тусгай улс байгуулж явсан учир эртний хуулийг мөрдөж, тусгаар улсыг байгуулж, бусдад захирагдахгүй, өөрөө захирах эрх бүхий тулгар төрийг тогтоосон тул бидний монголчууд Манж, Хятадын ноёрхлыг устгаж, тэдэнд захирагдахгүй болсон учрыг тунхаглав." гэжээ. /БНМАУ-ын түүх. УБ., 1966, 242-р тал/

1911 оны 12-р сарын 16-нд Хүрээний Зүүн Хүрээний Газар шарын шашны тэргүүн Богд гэгээнд шашны төрийг хослон баригч хаан цол өргөн хаан ширээнд залах ёслол хийж, оны цолыг "Олноо өргөгдсөн" гэж зарлажээ. Засгийн газрыг ерөнхий сайд, Гадаад, Цэрэг, Сан, Шүүх яамтайгаар байгуулжээ.

Ингэснээр Монголчууд үндэстнийхээ төр ёсыг сэргээн тогтоож, улмаар манай улс уламжлалт нийгмээс орчин үеийн нийгэмд шилжих харьцангуй удаан хугацааны шилжилтийн үе эхэлжээ. Богд хаант Монгол улсын үед Манжийн засаг захиргааны хуваарь уламжлагдан үлдсэн, туслагч, захирагч, мэйрэн, залан гэдэг түшмэдүүд ард олныг захирч байсан байна. Энэ үе нь нэг талаас шинэ тулгар төр улсаа хамгаалж үлдээх гэсэн үндэсний эх оронч дэвшилт хүчнүүд, нөгөө талаас харийн зэвсэгт түрэмгийлэгчдийн хоорондын ширүүн тэмцэл өрнөсөн, жирийн ард иргэд улс төрийн

тэмцэлд өргөнөөр татагдан оролцох болсон зэргээр онцлог юм. Энэ нь монголчуудын улс төрийн хийгээд үндэсний ухамсрын өрнөлтийн үе байлаа.

Үүний үр дүнд ардын хувьсгал ялж, 1921 оны 7-р сарын 16-нд ерөнхий сайд, гадаад, цэрэг, сан, шүүх, дотоод яамны бүрэлдэхүүнтэйгээр шинэ засгийн газар байгуулжээ. Дотоод яамыг нэмж байгуулсан байна. Тэр нь цаашдын зохисгүй хэрэг явдлын өрнөлтөнд нөлөөлжээ.

Монголд манай парламентын анхны хэлбэр хууль тогтоох засаг гэж үзэж болох улсын бага хурал байгуулагдсан, цаашдаа Ардын Их Хурал, Улсын Их Хурал, Улсын Бага Хурал гэдэг нэрээр өөрчлөгдөн, уламжлагдаж иржээ.

Урьдах бүх үеийн төр хуучнаа уламжлан хадгалах үүрэг гүйцэтгэж цаг үеийн шаардлагаар агуулга, хэлбэрээ хувьсган шинэчилж ирсэн бол ардын төр, засаг хуучныг эвдэх, шинийг бүтээн байгуулах үндсэн хоёр талтай үүрэг гүйцэтгэж байсан байна.

Гэтэл энэ хоёрын диалектик алдагдсан. Үгүйсгэлийн үгүйсгэлийн хуулиар хуучны үеэ өнгөрөөсөн шинж, тал харилцаа зэргийг халах ёс механик үгүйсгэл буюу устгалт болж хувирсан, хуучны хамаг зохистойг уламжилж авах ёсыг алдагдуулсан. Энэ нь монгол орныг феодализмаас капитализмыг алгасуулан ардчилсан хийгээд социалист үе шаттайгаар социализмд дэвшүүлэх гэсэн “онол”-ын буруу чиглэл, түүнийг ягштал баримталсан бөгөөд Коминтерн, ЗХУКН-ын заавар, зөвлөлгөөнийг үг дуугүй дагасан, юм бүхэн дээр зөвлөлтийн социализмын загварыг механикаар хуулж мөрддөг байсан МАХН улс төрийн талаар хуваарьгүй ноёрхож, аливаа асуудлыг хэт ангичилж, намжуулж үзэл сурталчилж байсантай шууд холбоотой юм. Энэ мэт нь нийгэм орон зай, газар зүйн байршил, цаг хуацааны хувьд түүхэн гарцаагүй байдалд орсонтой холбоотойг тэмдэглэе. Тэгээд манай оронд 1940-өөд оноос 1990 он хүртэл авторитаризм ноёрхож ирсэн юм.

Улс төрийн авторитар дэглэмийн зуршмал шинжүүд нь Засгийн эрхийг нэг буюу бүлэг хүн барьдаг, олон түмэн төр, засгаас хүнийсгэгдэг, засаглал хязгаарлагддаггүй, иргэдэд хянагддаггүй, засаглал хүчинд тулгуурладаг, хүч хэрэглэхийг урьтал болгодог, засаг ба улс төрийн монополчлол ноёрхдог, улс төрийн оппозици, улс төрийн хараат бус ил үйл ажиллагааг хориглодог, нам, төрийн дээд албан тушаалыг өмчилдөг, томоохон албан тушаалыг дээрээс өөрсдийн дур хүслээр сонгон томилох аргаар улс төрийн элитийг бүрдүүлдэг явдал юм.

Дотоодын самуун, гаднын оролцоо, шахалт, түлхээсээр социализм дэлхийн систем, олон улсын хамтын нөхөрлөл, нийгэм-эдийн засгийн формацийн хувьд сүйрсэн, гаднын шалтгаан, дотоодын эдийн засаг, социал, улс төр, оюун санааны салбарын хуримтлагдсан гүнзгий зөрчлийн улмаас монголд авторитар дэглэм устсан юм. Ингэж Монголын нийгэм-улс төрийн байгуулалд ардчилсан шинж чанарын гүн гүнзгий өөрчлөлт гарсан учраас түүнийг хувьсгал гэж үзэх үндэстэй юм.

Нийгмийн энэхүү том өөрчлөлтийг зөвлөлтийн сургуультай оросжиж, европчилагдсан сэтгэл зүйтэй залуучууд санаачилж, эхлүүлсэн юм. Өнгөрсөн 70 жилд нийгэм-улс төрийн ухамсар нь эрс дээшилсэн бөгөөд улс орноо ардчилан шинэчилж, хөгжүүлэхийг зорьсон ард түмэн дэмжсэн учраас улс төрийн уг өөрчлөлт түргэн хугацаанд харьцангуй тайван өрнөж хэрэгжсэн билээ. Монголын түүхэнд нийгмийн байгуулал, төр ёс ингэж түргэн, хялбархан солигдож байсан удаагүй.

Улс төрийн ардчилсан хөдөлгөөний үеэр эерэг сөрөг үзэл, зорилготой улс төрийн гурван хүч тодорсон юм. Тэдний нэгдэх нь Дорнын нүүдэлчдийн уламжлалт соёл, иргэншил, төр ёстой Монгол улсыг Өрнийн суурьшмал соёл иргэншилтэй хэлбэрийн төдий адилтгах, тийм орнуудыг дууриах, бусдын жишгээр улс орноо хөгжүүлэхийг зорьсон мэт боловч дэлхий дахины хөгжлийн нийтлэг үлгэр жишээ, туршлагыг үндсэнийхээ өвөрмөц онцлогт тохируулан ашиглах онолын бэлтгэлээр маруухан

бөгөөд тодорхой баримтлалгүй учраас сөрөг хүчнүүдийн хооронд гуйвж дайвах, эцсийн бүлэгт эрх мэдэл, албан тушаал, нэр төр, ашиг завшааныг эрхэм болгосон, итгэж боломгүй хүч юм.

Хоёрдох нь цаг үеийн үймээнийг зориуд дэвэргэн хөөргөж, овжин ашиглаж төр, засгийн эрхэнд гарч, нийгмийн эмх цэгцийг алдагдуулан, түүнийг хяналтгүй болгож, үндсэний тусгаар тогтнолд тэрс аргаар хувийн эрх мэдэл, ашиг тусын үүднээс нийгмийг завших гэсэн далдуур хорон санаатай хүч; *гурав дахь нь* Өрнийн соёл, иргэншлийн ололт, туршлагатай Монгол орны нүүдлийн соёл, иргэншлийг холбох онолын бэлтгэл, үзэл баримтлалтай, Монгол улсыг ардчилал, зах зээлийн харилцааны жам, хуулиар хөгжүүлэн мандуулах чин зорилготой, түүндээ хүрэхийн тулд олон түмний хүчин чармайлт, итгэл найдвар, дэмжлэгт тулгуурлан тэднийг нэгтгэн зохион байгуулах, цаг үеийн хандлага, шаардлага, хэтийн төлөвийг мэдэрч хувьсах, төр засгийг жолоодох харьцангуй мэдлэг, туршлагатай, эх орныхоо нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, төрийн тусгаар тогтнол, үндсэний язгуур эрх ашиг, ирээдүйд үнэнч шударга, үндэсний-эх оронч үзэл, ухамсартай хувьсгалт, ардчилсан хүч юм.

Улс төрийн эдгээр хүчнүүд хэн вэ гэдгийг өнгөрсөн түүхэн ахар богино хугацаанд болсон үйл явдлын өрнөлт батлан харуулсаар байна. Энэ нь олон түмний улс төрийн ухамсрын өөрчлөлт, улс төрийн шинэ шингэчлэлтийн хөгжилд ихээхэн нөлөөлсөөр байгааг тэмдэглэх нь чухал юм.

Ийм ээдрээтэй нөхцөлд улс төрийн хуучин тогтолцооны халаа болсон Улсын Их Хурлын гишүүдэд дээрх гурван хүчний аль алины нь төлөөлөгчид сонгогдсон. Тэдний гол гавьяа бол Монгол Улсын Шинэ Үндсэн хуулийг тунгаан хэлэлцэж баталсан явдал мөн.

Энэ үеэр төр, засгийн тэргүүлэх, албан тушаалд дээр дурьдсан улс төрийн хоёрдох хүч орсон. Тэдний зориуд санаатай үйл ажиллагааны уршгаар улс орны эдийн засаг, оюуны үйлдвэрлэл сүйрсэн, нийгмийн дэг журам алдагдсан. Түүнийг далимдуулагчид хүний заяаны болон иргэний эрх, эрх чөлөөг элдвээр зөрчиж бахаа хангаж ирсэн, улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдал дээсэн дөрвөн дээр дэнжигнэхэд хүрсэн. Үүнийг тэд улс орон зах зээлийн харилцаанд шилжих үеийн "зүй тогтол" бүхий зайлшгүй бэрхшээл гэх мэтээр цэцэрхэн тайлбарлаж, олон түмний сэтгэл зүйгээр тоглож, тэднийг элдвээр хууран мэхэлж байсан юм.

Монголд төрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний язгуур эрх ашиг, ирээдүй үеийн хувь заяа гэсэн дөрвөн зүйлийн шүтээний нэгдэл байдаг. Үүнийг мэдэрдэг, ухаалаг, хүндэтгэдэг манай монголын насанд хүрсэн ихэнх иргэд Улсын Их Хурлын сүүлчийн сонгуульд ардчилсан хөдөлгөөний үеийнхээс өөрөөр хандсан, түүний дараагийн улс төрийн үйл явдлуудад ч улс төрийн ухамсар, буурь суурьтай-ухаалаг хандаж ирсэн билээ. Энэ бүхний ачаар бүрэлдэж тогтсон төр, засаг орчин үеийн /өрнөдийн гэгддэг/ нийгмийнхэд хэлбэрийн хувьд дөхөж очоод байна.

Одоогийн төр, засагт хуучнаас ялгаатай шинэ зүйл нилээд буй. Тэр нь бүтэц, үүрэг, үзэл санааны гэсэн талуудтай юм. Бүтцийн хувьд Монголд анх удаа Ерөнхийлөгч буй болсон, засгийн эрх мэдлийг хуваадаг ёс тогтсон. Одоо Монгол улсын улс төрийн системд төр, засгаас гадна улс төрийн намууд, төрийн бус байгууллагууд багтаж байна. Монголын төр хэзээнээс нааш төр улсынхаа тусгаар тогтнол, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдал, үндэснийхээ эрх ашиг, нэр төрийг хамгаалж ирсэн. Эдгээр үүрэг одоогийн төр, засагт уламжлагдаж үлджээ. Монголын түүхэн аль ч үед иргэний төлөвшил төрийн анхааралд байжээ. Гэхдээ ардын хувьсгал хүртэл иргэнийг төлөвшүүлэх үүргийг үндсэндээ гэр бүл гүйцэтгэдэг байжээ. Монголын эрт, урьдын төр албан татварыг эс тооцвол эдийн засгийн амьдралд бараг оролцдоггүй байсан байна. Энэ ёс төвлөрсөн төлөвлөгөөт зохицуулалттай эдийн засгийн үед бүрмөсөн зөрчигдсөн. Өрнөдийн улс төр судлаачдын нэг хэсэг нь төр эдийн засагт оролцох, зохицуулах ёстой, эс тэгвэл эдийн засаг унах, нийгэм сүйрэхэд хүрнэ, нөгөө хэсэг нь

төр эдийн засгийн амьдралд оролцвол хүний эрх, эрх чөлөө алдагдаж, ардчилал, зөрчигдөнө гэж үздэг байна.

Манай төр, засгийн үйл ажиллагаанд эдгээр хоёр хандлагын аль аль нь байх шиг байна. Ер нь асар их уудам нутагт хөдөөгийн хүн ам тархаж амьдардаг, нүүдлийн ба суурин соёл иргэншил хосолсон, мал аж ахуй, газар тариалан бүхэлдээ байгалиас хараат байдалтай манай оронд зөвхөн эдийн засгийн төдийгүй, бусад олон асуудлыг төр, засгийн оролцоогүйгээр шийдвэрлэхэд төвөгтэй юм.

1921 оноос өмнөх үеийн Монголын төрд ард иргэдэд тэтгэвэр тэтгэмж олгох, тусламж дэмжлэг үзүүлэх үүрэг байсангүй. Гэтэл өнгөрсөн 70 жилд ард олонд үзүүлдэг төрийн "хайр ивээл" хэмжээнээс хэтэрч, улмаар тэдний хөдөлмөрийн идэвхи, санаачлага, бүтээлч сэтгэлгээний хөгжилд саад болж, тэднийг улсын гар харах, бэлэнчлэх муу зуршилтай болгоход хүргэсэн. Нийгмийн хуучин тогтолцоо нэгэнт устчихаад байхад өнөөгийн хүмүүсийн бэлэнчлэх сэтгэлгээ янз бүрийн хэлбэрээр илэрсээр байна. Одоо үед бэлэнчлэх сэтгэлгээ, суурин соёл иргэншил, зах зээлийн харилцаа гурав хүмүүсийг төв рүү татах хүчин зүйл болсон байна. Хэдүй тийм боловч бэлчээрийг дагаж мал адгуулдаг, малаа дагаж малчин амьдардаг, мал аж ахуйгаас нийгмийн бусад салбарууд шууд ба дам шалтгаалдаг. Хүн ам эмхрэхээс задрах, захирагдахаас чөлөөтэй, дур зоргоороо байх нүүдэлчний соёл иргэншил, аж төрөх ёсны нэг өвөрмөц ёс заншил, уламжлал одоо болтол Монголд хадгалагдаж илэрсээр байна. Энэ бол гагцхүү Монголын үндэсний үзэгдэл биш, ер нь нүүдэлчин улс түмний өнө эртний онцлог юм. Эндээс хүн амыг нэгтгэн зохион байгуулах шаардлагаар төр үүссэн гэж үзэх үзэл ч гарсан байж болох талтай юм.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудыг ажиглахад үндсэний онцлогоо сайтар харгалзан улс төрийнхөө уламжлалт шилдэг шинж чанарыг нандигнан хадгалж иржээ. Энэ талаар хэлбэр, бэлэгдлийн талыг их чухалчилдаг байна. Харин олон улсын төр ёсны хөгжлийн хандлагыг судалж харьцуулан харгалзсаны үндсэн дээр улс төрийнхөө үүрэг, үйл ажиллагааны арга барил, туршлагыг үндэсний онцлог, дэлхий дахины жишигт нийцүүлж байнга шинэчилж байдаг байна. Гэтэл манайх одоо улс төрийн хэлбэрийн хойноос хэт их хөөцөлдөж байна.

Монгол бол цөөхөн хүн амтай, тэр нь улс төрд харьцах уламжлалт онцлог арга заншилтай орон юм. Ийм учраас манай улс ардчилал ба албадлага, захирах ба хүндэтгэх ёсыг ухаалаг хослон нийгмийн үйл явцыг удирдах зохицуулах чадвартай, авсаархан, боловсронгуй бүтэцтэй төр, ерөнхийлөгчийн засаглалтай байх шаардлагатай байна. Ёс суртахууны нийгмийн үүргийг умартаж, нийгмийн харилцааг дан ганц хуулиар зохицуулах гэсэн хандлага, оролдлогыг ч хянаж үзүүштэй юм. Төвлөрсөн хүчтэй засаглал ба ёс суртахууны хүндэтгэл Монголын улс төр, төр ёсны чухал уламжлалт шинж чанар юм.

Дээр дурьдсанаас үзэхэд монголын эртний улс төр, төр ёс байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж иржээ. Тэр нь 1) Улс гэрээ засан тохинуулах дотоод шалтгаан, гадагшаа харилцах буюу гадаад ертөнцөд хувьсан зохицох, тухайлбал дайтах ба найрамдах, худалдаа наймаа хийх, хамтарч ажиллах гэх мэт гадаад шалтгаанаар нөхцөлдөж ирсэн байна. 2) Монголын улс төрийн шинэчлэл халагдах, уламжлагдах ёсыг хосолж иржээ. Халагдахаасаа хадгалагдах уламжлагдах тал нь удаан хугацаанд давамгайлж ирсэн бололтой. Жишээ нь хүннүгийн үеийн зонхилогчдийн зөвлөлөөс Чингисийн үеийн их бага хуралдай, Богд хаант монгол улсын дээд, доод хурлаас одоогийн Улсын Их Хурал хүртэлх хуралдайн ёс уламжлагдсаар ирсэн гэж үзэх үндэстэй юм. Нэг хаан буюу эзнээр толгойлуулсан төвлөрсөн төр, засаг ч уламжлагдсаар иржээ. Харин өнгөрсөн 70 жилд улс төрийн диалектик үгүйсгэл буюу хадгалагдах ёс механик үгүйсгэлээр ноцтой зөрчигджээ. 3) Монгол улс том гүрний нөлөөнд автах үед түүний улс төр эрс шинэчлэгдэж ирсэн түүхтэй байна. Энэ талаар төв рүү татагдах ба төвөөс зугатах буюу зөрчил ба нэгдлийн хууль үйлчилж ирсэн нь мэдээж. Энд зөрчлөөс нэгдлийг гол болгох нь их гүрэнтэй зохицон харилцах мэргэн ухаан, уран аргын илрэл юм. Ингэхгүйгээр

нэгдлийг дагнавал аяндаа их гүрэнд уусах, зөрчлийг туйлшруулбал хүйс тэмтрүүлэх байсан нь мэдээж билээ. Монголчууд их гүрний нөлөөнд байхдаа түүний нааштай зохистойг нь ашиглаж, сурч ирснийг үгүйсгэж боломгүй юм. 4) Монгол улс улс төрөө шинэчлэхдээ үндсэний язгуур уламжлал, онцлог ба Дорно, Өрнөдийн харьцааны диалектикийг төв үзэл, бэлэг гэдэг утгаар ухаалаг оновчтой ашиглаж ирсэн удаатай. Энэхүү диалектикийг алдагдуулснаас болж өнгөрсөн 70 жилд улс төрөө хэтэрхий европчилж, зөвлөлтжүүлсэн байна. Өнөөгийн улс төрийн нэг сул тал нь түүнийг мөн л европчилах, америкжуулах оролдлого мөн. 5) Манайх одоогийн өөрчлөлт шинэчлэлтийг онолын нэгдсэн чиг баримжаагүйгээр яаруу сандруу, барин тавин хийж эхэлсэн. Улс орнуудыг уламжлалт нийгмээс оновчтой нийгэмд шилжүүлэх онол-үзэл суртал болсон улс төрийн модернизацийн үүднээс хэрэв социалист л биш бол тоталитаризм, авторитаризм, ардчиллын алин байхыг чухалчилдаггүй, харин эдийн засгийг хөгжүүлэх, үндэсний онцлогт тохирсон арга, хэлбэрийг боловсруулж ашиглахыг чухалчилдаг ёстой юм байна. Үүнтэй холбогдуулж хэлэхэд манай нийгмийг зах зээлийн харилцаанд оруулах үйл явцын нэг гол дутагдал нь зорилго ба түүнд хүрэх аргын хоорондын зөрчилд л байх шиг байна.

Хүний эрх, эрх чөлөө бол ардчилсан улс төрийн хамгийн гол үнэт зүйлс мөн. Нийгэмд зон олон сайн сайхан аж төрөх эдийн засгийн болон оюун санааны бололцоо бүрдээгүй цагт хүний эрх, эрх чөлөө хэзээ ч хангагдахгүй, баталгаажихгүй. Хүний эрх эрх чөлөөг хангахгүйгээр ардчилал хоосон мөрөөдөл, хуурамч тунхаглалаас хэтрэхгүй. Хүн эрхээ эдлэхийн тулд үүргээ биелүүлдэг, хариуцлага хүлээж чаддаг байх ёстой. Энэ нь хүн амаас өндөр соёл, боловсрол ажилч хичээнгүй чанарыг шаарддаг байна. Энэ шаардлагыг хангаагүй цагт ардчилал нь анархизм болж хувирдагийг манай орны одоогийн бодит байдал харуулж байна.

Аливаа шинэ юм саад бэрхшээл, зөрчилгүйгээр аяндаа ялдаггүй нь диалектикийн хууль юм. Монголын улс төрийн шинэчлэл янз бүрийн саад бэрхшээлтэй тулгарч байгаа ч гэсэн урьд өмнөхтэй зүйрлэшгүй нийгэм-улс төр, эдийн засаг, оюун санааны цоо шинэ үндэс суурин дээр өрнөж байгаа болохоор дэлхийн тэргүүний орны зиндаанд хүрэх итгэл, найдвартай.

Монголын хаадууд

1. Чингис хаан 1206-1227 он.
2. Өгөөдэй хаан 1228-1241 он.
3. Гүлэг хаан 1246-1248 он.
4. Мөнх хаан 1251-1259 он.
5. Хубилай хаан 1260-1294 он.
6. Өлзийт Төмөр хаан 1294-1307 он.
7. Хайсан хүлэг хаан 1307-1311 он.
8. Аюур Балбад уянт хаан 1311-1320 он.
9. Сидэвлэн гэгээн хаан 1320-1323 он.
10. Есөн төмөр хаан 1323-1328 он.
11. Асочибуу заяат хаан 1328-1329 он.
12. Хутагт хаан 1329 оны дөрвөн сард хаан суув.
13. Төв төмөр заяат хаан 1329-1332 он.
14. Ринцэнбал ирчмэл хаан 1332 онд хорин өдөр хаан суув.
15. Тогоон төмөр хаан 1332-1370 он.
16. Билэгт хаан 1370-1378 он.
17. Усхал хаан 1378-1388 он.
18. Энх Зоригт хаан 1388-1391 он.
19. Элбэг Нигүүлсэгч хаан 1394-1399 он.
20. Гүн Төмөр хаан 1399-1402 он.
21. Өлзий Төмөр хаан 1402-1410 он.
22. Дэлбэг хаан 1411-1415 он.
23. Уяртай хаан 1415-1425 он.
24. Адай хаан 1426-1438 он.
25. Тайцун хаан 1439-1451 он.
26. Махгөрөөс хаан 1452 онд нэгэн жил хаан суув.
27. Молон хаан /Мулан/ 1453-1462 он.
28. Мандуул хаан 1463-1467 он.
29. Баянмөнх болох жонон хаан 1467-1460 он.
30. Батмөнх Даян хаан 1470-1543 он.
31. Бодь Алаг хаан 1544-1547 он.
32. Тарайсан Гүдэн хаан 1548-1557 он.
33. Түмэн засагт хаан 1558-1592 он.
34. Буян цэцэн хаан 1503-1602 он.
35. Лигдэн /хаан/ хутагт хаан 1604-1634 он.

Д.Болд-Эрдэнэ.

Доктор (PhD)

Төрийн засаглалын тогтолцоон дахь ерөнхийлөгчийн институт

Монгол улс Үндсэн хуулиараа төрийн засаглалын онцгой бүрдэл болох Ерөнхийлөгчийн институтыг бий болгон түүний засаглалын системд эзлэх байр суурь, үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн баттай үндсийг тавьсан билээ. Өнгөрсөн хугацаанд Монгол улсын Ерөнхийлөгч төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх хийгээд нийгмийг ардчилах үйл хэрэгт зохих ёсоор оролцон нөлөөлж, Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ дагуу идэвхтэй ажиллаж ирлээ.

Гэвч түүний үйл ажиллагаа, нөлөөллийн механизмыг цаг үеийн байдал, нийгмийн ардчиллын үйл явцын гүнзгийрэлттэй холбоотойгоор улам төгөлдөржүүлэх шаардлага, хэрэгцээ байсаар байна. Энэ хэрэгцээг бодитой хангах анхдагч үндэс нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн институтын үүрэг, үйл ажиллагаа, түүний эзлэх байр суурь засаглалын хүрээнд нөлөөллийн онцлогийг зөв танин мэдэх, энэ салбарт хуримтлагдсан шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлуудыг бодитой оношлон хариу өгөх явдал мөн билээ. Үүнтэй холбоотойгоор төрийн засаглалын эрх мэдлийн систем дэх Ерөнхийлөгчийн оролцоо, тэдгээрийн харилцан хамаарал, сонгон гаргаж ирдэг механизм, бүрэн эрхийн тогтолцоо, үүрэг, үйл ажиллагааны онцлогтой уялдсан онолын хийгээд практик шинжтэй зарим асуудлын талаар тойм боловч тодруулан үзэх нь ач холбогдолтой юм.

Төрийн тэргүүн, засаглалын эрх мэдлийн харилцан хамаарал. Төрийн тэргүүний асуудал нь улс төр, эрх зүйн шинжлэх ухааны хүрээнд өнөө хэр төдийлөн нэг мөр шийдэгдээгүй онолын томоохон зангилаа асуудлын нэг юм. Тухайлбал төрийн тэргүүн хэрэгтэй эсэх, засаглалын ямар субъектыг төрийн тэргүүнд тооцох, засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх үйл явцад оролцох түүний оролцооны шинж байдал, байр суурь, гүйцэтгэх үүргийн талаар судлаачид санал зөрж, мэтгэлцсээр иржээ.

Төрийн тэргүүн асуудлыг бодитой авч үзэхэд засаглалын хэлбэрийн асуудал чухал учир холбогдолтой байдаг. Ерөнхийлөгчийн засаглалтай улс орны хувьд гүйцэтгэх засаглалын тэргүүн нь Ерөнхийлөгч гэдэг утгаар шууд ойлгогддог. Харин парламентын засаглалтай орны тухайд бол төрийн тэргүүний асуудлыг хуулиар нарийвчлан заагаагүй тохиолдолд маргаантай юм. Харин манай улсын хувьд Үндсэн хуулиараа "Монгол улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн..."¹ гээд шууд заачихсан учраас төрийн тэргүүн гэж хэн бэ? гэдэг асуудал дээр төдийлөн маргаан гарахгүй байх. Хэдий тийм боловч төрийн тэргүүн засаглалын эрх мэдлийн аль бүтцэд хамаарах, энэ нь эрх мэдэл бүхий хувь хүн, албан тушаалтан эсвэл засаглалын бүхэл бүтэн институт мөн эсэх асуудал дээр манай судлаачдын дотор янз бүрийн санаа бодол байсаар байгаа юм.

Дэлхийн улс төрийн амьдралын нийтлэг жишгээс үзвэл "Төрийн тэргүүн гэдэг бол төрийн байгууллагуудын тогтолцоонд дээд байр суурь эзэлж буй албан тушаалтан буюу байгууллага мөн бөгөөд энэ нь бас улс орны дотоодод болон гадаадад төрийн дээд төлөөлөл болохын хамт улс үндэстний (ард түмэн ба төрийн) эв нэгдлийн билэгдэл болдог"² гэдэг утгаар ойлгодог юм байна. Манай судлаачид "төрийн тэргүүн бол Ерөнхийлөгч", "төрийн тамгыг Монгол улсын Ерөнхийлөгч барина" гэсэн Үндсэн хуулийн тодорхой заалтуудыг иш үндэс болгон төрийн тэргүүн бол байгууллага (институт) биш, харин албан тушаалтан юм гэсэн байр суурийг илэрхийлдэг.³ Гэвч

¹ Монгол улсын Үндсэн хууль, УБ., 1992, 30-р зүйлийн заалт.

² "Конституционное (государственное) права зарубежных стран" М., 1993, т.2, стр 251-252.

³ Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал, товхимол I УБ., 1999, 92-р тал.

төрийн тэргүүн ард түмний сонголтоор сонгогдож гарч ирдэг, тэдний нийтлэг эрх ашиг, сонирхлыг илэрхийлэгч гэдэг талаасаа тодорхой албан тушаалтан, хувь хүн мөн боловч засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох оролцоо, эрх мэдлийн хуваарилалтанд гүйцэтгэж байгаа үүрэг, нөлөөллийн хувьд түүнийг **засаглалын онцгой нэгэн институт** гэж үзэхээс өөр аргагүй юм.

Засаглалын онолын нийтлэг жишгээс үзвэл төрийн тэргүүнийг хувь хүн гэдэг талаас нь бус харин байгууллага, институт гэдэг талаас нь түлхүү ойлгож, засаглалын эрх мэдлийн хуваарилалтанд түүний оролцох оролцоо нөлөө, эрх үүргийн асуудлыг үнэлж цэгнэдэг байна. **Энэ үүднээс авч үзвэл Монгол улсын ерөнхийлөгч бол засаглалын эрх мэдлийн хэрэгжүүлэх үйл явцад хуулиар заагдсан тодорхой эрх, үүрэгтэй оролцон нөлөөлөгч засаглалын онцгой субъект, байгууллага (институт) юм** гэж бүрэн үндэстэй хэлж болох юм.

Улсын Ерөнхийлөгчийг засаглалын эрх мэдлийн аль бүтцэд хамааруулах асуудал дээр нилээд маргаан өрнөдөг. Үүний гол шалтгаан нь нэг талаас манай Ерөнхийлөгч төрийн эрх мэдлийн аль ч байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй нөлөө үзүүлэх эрх зүйн статустай субъект болж байдаг; нөгөө талаас Үндсэн хуулинд Ерөнхийлөгчийн институт төрийн эрх мэдлийн аль салбарт хамаарахыг тодорхой зохицуулж өгөлгүй нээлттэй орхисон зэрэгтэй холбоотой юм.

Улс төрийн практикаас үзвэл төрийн тэргүүнийг нэгд, засаглалын эрх мэдлийн альч салаа мөчирт хамааруулдаггүй, хоёрт, хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн аль алинд нь хамааруулан үздэг, гуравт, зөвхөн гүйцэтгэх эрх мэдэлд багтаан үздэг зэрэг янз бүрийн жишиг тогтсон байдаг. Манай судлаачдын дотор дээрхийг онолын хувьд үндэслэсэн байр суурь тодорхой илэрч байна. Тухайлбал сүүлийн үед Ерөнхийлөгчийг хууль тогтоох хийгээдгүйтгэх засаглалын аль алинд ч хамаатуулан үзэх хандлага ажиглагдах болов. Тэд энэ байр сууриа илэрхийлэхдээ Монгол улс засаглалын хэлбэрийн хувьд парламентын засаглалыг сонгосон хэдий ч тухайн хэлбэрт нь зохицоогүй өргөн хэмжээний бүрэн эрхийг төрийн тэргүүнд Үндсэн хуулиараа олгосон. Түүнчлэн төрийн тэргүүний хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлтэй харилцах харилцаа тэдгээрийн хүрээнд эдэлдэг эрх хэмжээг авч үзвэл ганцхан гүйцэтгэх эрх мэдэлд түүнийг хамааруулж болохгүй гэж үзэж байна.¹

Гэтэл Ерөнхийлөгчийн институтыг төрийн засаглалын хууль тогтоох хийгээд гүйцэтгэх эрх мэдлийн аль алинд нь хамааруулж үзсэн тохиолдолд Ерөнхийлөгчийн төрийн засаглалын системд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэгтэй холбоотой маргаантай гэж хэлж болох олон ээдрээтэй асуудал бий болохоос гадна төрийн засаглалын дээд "оргил", онцгой институт гэж ойлгоход хүрч болзошгүй. Хэрвээ ингэхэд хүрвэл засаглалын хэлбэрийн асуудал тэр дундаа парламентын засаглалын статус, онцлгийн асуудал бүрхэгдэхэд хүрч болохоор байгаа юм.

Монгол улсын Үндсэн хуулинд Ерөнхийлөгчийг засаглалын аль салаа мөчирт хамаарахыг тодорхой зохицуулаагүй нээлттэй орхисон байдаг ч Ерөнхийлөгчтэй холбогдох Үндсэн хуулийн үзэл баримтлалтай нарийвчлан танилцаж үзэхэд түүнийг засаглалын гүйцэтгэх эрх мэдэлтэй илүү ойр байж болохоор томъёолсон нь ойлгогдохоор байдаг. Ер нь улс төрийн амьдарлын практикт ч Ерөнхийлөгчийг их төлөв төрийн засаглалын гүйцэтгэх эрх мэдэлд хамаатуулан үздэг нь нийтлэг шинжтэй зүйл юм. Үүнийг ихэнх судлаачид хүлээн зөвшөөрдөг аж. Тухайлбал Оросын судлаач А.А.Мишин бичихдээ: "Төрийн тэргүүн ихэвчлэн гүйцэтгэх эрх мэдлийг агуулагч гэж үзэгддэг"² гэсэн байна. Ингэхлээр Монгол улсын Ерөнхийлөгч нь төрийн засаглалын хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл явцад үндсэн хуулиар олгогдсон өөрийн эрх хэмжээний дагуу идэвхтэй оролцон нөлөөлж байдаг хэдий ч **түүний статусыг засаглалын гүйцэтгэх эрх мэдэлтэй илүү холбогдуулан үзэх нь** зүйд нийцмээр санагдана. Ингэж үзэх нь хэд хэдэн бодит үндэс байгаа юм. Энэ

¹ Д.Лүндээжанцан. "Монгол улс дахь эрх мэдлийн хуваарилалт" Уб., 2001 он, 171-р тал.

² А.А.Мишин. "Конституционное государственное право зарубежных стран. М., 1998, стр178.

нь **нэгдүгээрт**, Манай Үндсэн хуулинд “Монгол улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэж тов тодорхой заасан байдаг. Энэ заалтаас үзвэл хууль тогтоох эрх мэдлийг УИХ-аас өөр ямар нэг засаглалын субъект тухайлбал Ерөнхийлөгч болон засгийн газар хуваалцахгүй гэдэг нь ойлгогдож байна. **Хоёрдугаарт**, Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгогдсон бүрэн эрхийн шинж байдлаас үзвэл түүний бүрэн эрхийн сиситемийг гүйцэтгэх эрх мэдэлд илүү хамаарах эрх үүргүүд үндсэндээ бүрдүүлдэг. Харин зарлиг, захирамж, илгээлт зэргийг эс тооцвол хууль тогтоох шинжтэй эрх үүрэг Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн системд бараг байхгүй юм. **Гуравдугаарт**, Парламент болон засгийн газар, шүүх засаглалтай харилцах Ерөнхийлөгчийн инсититутын харилцаа, нөлөөллийн шинж байдлаас үзвэл гол төлөв гүйцэтгэх эрх мэдэлд хамаарч болох засгийн газарт чиглэл өгөх, парламентын шийдвэрт хориг тавих, Ерөнхий шүүгч болон бусад шүүхийн шүүгчдийг томилох зэрэг харьцангуй гүйцэтгэх эрх мэдлийн шинжтэй эрх үүрэг зонхилж байдаг. **Дөрөвдүгээрт**, Ардчиллын нийтлэг жишгээс үзвэл төрийн тэргүүн, Ерөнхийлөгч нь гол төлөв гүйцэтгэх засаглалын хүрээнд багтаж, хуулиар гүйцэтгэх эрх мэдэл бүхий статустай байдаг зэрэг юм.

Энэ бүхнээс үзвэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн институт бол гүйцэтгэх засаглалын эрх мэдлийн хүрээнд хамаарагдах төрийн засаглалын өвөрмөц бүрдэл болох нь тодорхой байна.

Сонгох онцлог: Ардчиллын жишгээр Ерөнхийлөгчийг сонгох тогтолцоо нь нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, баталгаажуулах гэсэн үндсэн хэсгээс бүрддэг. Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх үйл ажиллагаа нь тухайн улс орны онцлогтойуялдан өвөрмөц шинжтэй байдаг. Тухайлбал АНУ-д гэхэд нэр дэвшүүлэх үйл ажиллагаа сонгуулийн хамгийн хариуцлагатай хэцүү үе байдаг. Учир нь АНУ-д Ерөнхийлөгчид нэрээ дэвшүүлэх сонирхолтой хүмүүс эртнээс олон түмэнд өөрийгөө зарлаж, нэрээ дэвшүүлэхийн төлөө тэмцэлд оролцдог. Ингэхдээ “праймири” хэмээх тусгай сонгуулийн санал хураалтаар болон зарим муж улсад намын орон нутгийн хурал буюу “кокеc”-оор олонхийн дэмжлэг авах хэрэгтэй болдог. үүний дараагаар тус тусын намуудын их хурлаар хэлэлцэн шүүгдэж Ерөнхийлөгчийн сонгуулийн тэмцэлд оролцох албан ёсны эрхээ олж авдаг.

Гэтэл манайд орон нутгийн намын байгууллага гишүүд, дэмжигчдийн саналыг харгалзан намуудын бага хурал, чуулганаар намын өмнөөс сонгуульд нэр дэвшин өрсөлдөх хүнээ тодруулдаг. Харин сүүлийн үед манай зарим нам тухайлбал МАН-Ерөнхийлөгчдөд нэр дэвших хүнээ намын доторхи тусгай сонгууль болох “сунгаа”-гаар тодруулан гаргаж ирдэг болсон нь ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх Америк маягийн загварыг өвөрмөцөөр хэрэгжүүлсэн монгол хувилбар гэж ойлгогдохоор байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар УИХ-д суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлнэ гэж заасан байдаг. Энэ заалтанд олон түмний нилээд хэсэг нь шүүмжлэлтэй ханддаг нь нууц биш билээ. Тэд Монгол Улсын Ерөнхийлөгчийг ард түмэн мэдэж нэр дэвшүүлэх учиртай атал хүн амын багахан хэсгийг төлөөлж буй парламентад суудалтай цөөхөн хэдэн нам энэ эрхийг нь булаан авсан нь зүйд нийцэхгүй. Ядаж парламентын бус намууд нэр дэвшүүлэх боломжгүй байгаа нь хачирхалтай гэсэн үндэслэлийг гаргаж тавьдаг. Гэтэл нөгөө хэсэг нь Үндсэн хуулийн дээрх заалтыг хүлээн зөвшөөрдөг. Тэд засаглалын чухал институт болох намууд нэр дэвшүүлэх ажлыг гартаа авах нь зүйтэй. Тэр тусмаа төрийн шийдвэр гаргах үйл явцад оролцдог, парламентад суудалтай намуудад энэ эрх байх ёстой. Ингэхгүй бол нэр дэвшүүлэх ажил учир замбараагаа алдана гэсэн байр суурийг иш үндэс болгодог. Ардчиллын онолын үүднээс хандвал энэ байр суурьд үнэний хувь байж болох талтай юм.

Монгол улсын Ерөнхийлөгчийг сонгодог манай зарим өөрийн онцлогтой. Яагаад гэвэл Ерөнхийлөгчийг бүх ард түмний шууд сонгуулиар гаргаж ирдэг. Тэгэхдээ нийт ард түмнээс санал авсан нэр дэвшигчийг УИХ Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн

эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргадаг. Энэ нь Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь шат болдог. Сүүлийн үед Ерөнхийлөгчийн сонгуулийн үе шатны асуудлаар нилээд шүүмжлэлтэй байр суурь ажиглагдах боллоо. Тухайлбал Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн хуулийг сонгуулийн шат гэж үзэх аргагүй. Ингэж үзсэнээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль эхлээд шууд дараа нь төлөөллийн шинжтэй явагдаж байж л нэгдмэл бүхэл сонгууль болж байна гэсэн эдүгээгийн бодит байдалд үл нийцэх дүгнэлт хийхэд хүргэж байна. Ийм байдал нь Монгол улс парламентын засаглалтай гэдгийг харуулах гэснээс юм уу эсвэл Үндсэн хуульд заасан "Ерөнхийлөгч УИХ-д ажлаа хариуцна" гэсэн заалтыг үндэстэй болгохын тулд Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай гээд механикаар хуульчилсан мэт сэтгэгдэл төрүүлж байна гэж манай зарим судлаачид нотолж байгаа юм.¹ Тэр ч байтугай Ерөнхийлөгчид бие даан нэрээ дэвшүүлэх бололцоог хуульчилж өгөх болон Ерөнхийлөгчийг сонгон гаргаж ирж байгаа одоогийн энэ механизмыг ч эргэж харах хэрэгтэй гэсэн бодол санаатай судлаачид цөөнгүй байна. Тэд Ерөнхийлөгчийг сонгох одоогийн арга нь Үндсэн хууль болон засаглалын тогтолцооны олон асуудлыг бодитой авч үзэхэд бэрхшээл учруулдаг гэж үзэж байгаа юм.² Иймд манай орны хувьд Монгол улсын ерөнхийлөгчийг бүх ард түмнээс сонгон гаргаж ирдэг одоогийн энэ механизмыг зайлшгүй өөрчлөх хэрэгтэй болж байгаа юм. Харин үүний оронд парламентын засаглалтай улс орны нийтлэг жишигтэй нийцүүлэн Ерөнхийлөгчийг парламентаас сонгож гаргаж ирдэг болчихвол өнөөгийн манай Ерөнхийлөгчийн бодит эрх үүрэг, статустай нийцэж тохирно гэж үзэж байна.

Гэвч энэ мэт олон янзын бодол санаа байдаг ч одоохондоо Монгол Улсын Үндсэн хуулиар Ерөнхийлөгчийг бүх ард түмний шууд сонгуулиар сонгоно гэдгийг хуульчилж, энэ нь өнөө үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нөхцөлд дээрх санаа дүгнэлт нь амьдралд байж болох зохистой санал, төсөөлөл л үлдэх нь мэдээж юм.

Бүрэн эрхийн тогтолцоо: Парламентын засаглалтай Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх эзэн хаан буюу Ерөнхийлөгчийн зааглалтай улсуудынхтай харьцуулахад нилээд хумигдмал байдаг нь олон улсад хэвшиж тогтсон хэм хэмжээ болжээ. Гэхдээ засаглалын парламентын хэлбэртэй улсуудад Ерөнхийлөгчийн эрх мэдэл, байр суурь нь тухайн улс орны улс төрийн амьдралын онцлог байдалтай уялдан их, бага харилцан адилгүй байдаг байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Үндсэн хуулиар тодорхой зааж өгсөн байдаг. Одоогийн байдлаар Монгол улсын гуч гаруй хуулиар Ерөнхийлөгчийн институтын эрх үүрэг, үйл ажиллагааг тодотгон зохицуулж өгсөн байна. Манай судлаачдын дийлэнх хэсэг нь Ерөнхийлөгчийг сулавтар эрх мэдэл бүхий институт гэж үздэг. Үүнтэй холбоотойгоор Ерөнхийлөгч төрийн тэргүүний хувьд асуудал шийдвэрлэх талаасаа сул эрх эдэлж байгаа нь хуулийн хүч чадлыг сулруулж байна гэсэн дүгнэлтэнд хүргэдэг. Үндсэн хууль, бусад хууль үйлчилж буй практикаас үзэхэд Ерөнхийлөгч төрийн тэргүүн гэсэн статусаар албан ёсны шийдвэр гаргах механизм дутмаг байдаг нь тодорхой харагддаг. Энэ нь төрийн тэргүүний статус, Ерөнхийлөгчийн эрх мэдэл хоёр зохистой нийцэн шүтэлцэж чадахгүй байгааг харуулж байна гэж судлаачид үздэг юм.¹

¹ Д.Даш-Ёндон. "Төрийн тэргүүн, парламентын засаглалтай улсын Ерөнхийлөгчийн институт" илтгэл, "Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал" эрдэм шинжилгээний хурлын материал, УБ., 1999, 106-р тал.

² Д.Болд-Эрдэнэ. "Ерөнхийлөгчийн эрхийг ингэж нэмэгдүүлье", "Ардын эрх", 1997. 05.09, № 102.

¹ Иргэний нийгмийн онол практикийн асуудал, шинэ Үндсэн хууль, иргэний нийгэм, хамтын бүтээл /ред Д.Чулуунжав, УБ., 1997/; Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар. Монгол улсын Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2000, Г.Чулуунбаатар. XX-XXI зууны зааг үеийн Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, хөгжил, УБ., 1999, Д.Чулуунжав. онголын төрийн тогтоцлоо түүний хууль эрхийн үндсүүд дэх согог дутагдалтай асуудлууд, УБ., 1999, "Монгол улсын төрийн байгууллагуудын чадавхи: ардчилсан засаглалыг төгөлдөржүүлэх шаардлага, боломж", УБ., 1998 гэх мэт.

Судлаачдын тэмдэглэж байгаагаас үзвэл Монгол улсын Ерөнхийлөгчийн институтын бүрэн эрхийн системийн бүрдлийг үүрэг, үйл ажиллагааны агуулга талаас нь дараах 4 үндсэн хэв маягт зааглан үзэж байгаа нь нийтлэг ажиглагдаж байсан. Үүнд: 1. Төрийн байгуулал, улс орны удирдлагын талаархи бүрэн эрх; 2. Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалах бүрэн эрх; 3. Гадаад харилцааны талаархи бүрэн эрх; 4. Ерөнхийлөгчийн бусад бүрэн эрх эдгээр болно.¹

Манай Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн системийг нэгд, ерөнхийлөгчийн онцгой бүрэн эрх; *хоёрт*, тусгай бүрэн эрх; *гуравт*, ёслол хүндэтгэлийн гэсэн гурван хэсэгт зааглан үзэж болохоор байдаг юм.²

Ерөнхийлөгчийн **онцгой бүрэн эрхийн** хүрээнд УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих, ерөнхий сайдад нэр дэвшүүлэх болон засгийн газыг огцруулахад тодорхой үүрэгтэй оролцон нөлөөлөх, гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж УИХ-тай зөвшилцөн Монгол улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах, уучлал үзүүлэх, Монгол улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх, Монгол Улсын зэвсэгт хүчний Ерөнхий командлагч байх, бүх нийтийн хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах, улс орны нийт нутаг дэвсгэрт эсвэл зарим хэсэгт шаардлагатай нөхцөлд онц болон дайны байдал зарлах, цэрэг хөдөлгөх захирамж өгөх, бүх шатны шүүгчийг томилох зэрэг асуудлыг хамруулан үзэж болох юм.

Харин **тусгай бүрэн эрх** гэдэгт Ерөнхийлөгчийн өөрийн бүрэн эрхт хамаарах асуудлаар засгийн газарт чиглэл өгөх, Монгол улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөчийн газрын тэргүүнийг томилох буюу эргүүлэн татах, Монгол улсын харъяат болох, харъяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх, УИХ-ын чуулганд өөрийн тааллаар оролцох, мэдээлэх, саналаа илэрхийлэх, ард түмэндээ хандан илгээлт гаргах зэрэг эрхийг багтааж болно.

Ёслол хүндлэлийн эрхийн хүрээнд Монгол улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх жуух бичгийг хүлээн авах, улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон медалиар шагнах зэргийг хамруулдаг.

Ерөнхийлөгчийн бүрэн эрхүүд засаглалын бусад субъекттэй харилцах тэдгээрийн тэнцэл зохицлыг хангах механизм болж үйлчлэх явцдаа Ерөнхийлөгчийн засаглалын тогтолцоон дахь үйл ажиллагааны онцлог, түүний хүчтэй хийгээд сул талын илэрхийлэл болж байдаг.

Сүүлийн үед Монгол Улсын Ерөнхийлөгчийг билэгдлийн шинжтэй институт гэж үзэхээс зайлсхийж, харин ч энэ Үндсэн хуулиар олгогдсон зохих ёсны эрхээр хангагдсан харьцангуй хүчтэй институт гэж үзэх хандлага газар авах болов. Үүнтэй уялдан Монгол улсыг Ерөнхийлөгч бүхий парламентын засаглалтай орон" гэх юм уу эсвэл засаглалын энэхүү хоёр хэлбэрийн аль алиных нь шинж, элементийг агуулсан засаглалын хосолмол хэлбэртэй улс, тэр ч байтугай "хязгаарлагдмал эрхтэй Ерөнхийлөгчийн БН улс" гэх мэтээр үзэх хандлага ажиглагдаж байгаа нь анхаарал татаж байна.

Гэвч ардчиллын онолын жишгээр авч үзвэл **манай Ерөнхийлөгчийн бүрэн эрх парламентын засаглалтай орны Ерөнхийлөгчийн хүрээнд хамаарах сулавтар шинжтэй. Харин Монгол орныхоо хувьд бас ч чамгүй эрх мэдэлтэй гэж хэлж болохоор байдаг.** Гэвч цаашдаа амьдралын шаардлагатай уялдан Ерөнхийлөгчийн эрх мэдлийг өргөжүүлэх хэрэгцээ зүй ёсоор гарч ирж буйг анхаарахгүй байж болмгүй байна.

¹ Ж.Болдбаатар, Д.Лхүндээжанцан. "Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал", УБ., 1997, 359-360-р тал.

² Д.Болд-Эрдэнэ. Ерөнхийлөгчийн эрхийг ингэж нэмэгдүүлье, "Ардын эрх", 1997-05-09, №102.

Тухайлбал энд хууль тогтоох засаглалтай харилцах Ерөнхийлөгчийн эрх мэдлийг засаглал хуваарилах онолын дагуу өргөжүүлэн улам тодорхой болгох шаардлагатай байгаагийн дээр засгийн газартай ажиллах бололцоо нөхцөл, арга механизмыг улам сайжруулж, парламентаас гарч буй хуулийг батламжилдаг болх, Ерөнхийлөгчийн аж ахуйн болон мөнгө санхүүгийн захиран зарцуулах эрхийг нэмэгдүүлэх нь зүйд нийцэх юм.

Түүнчлэн тодорхой шаардлагатай тохиолдолд хуулийн хүчинтэй шийдвэрийг ерөнхийлөгчийн зүгээс гаргаж УИХ-ын шийдвэр гарах хүртэл хугацаанд улс орны хэмжээнд мөрдүүлэн ажиллуулах бодит бололцоотой байх нь зүйтэй юм шиг санагдана. Энэ нь үнэн чанартаа Үндсэн хуулинд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн системд хууль тогтоох чиглэлийн шинэ эрх, үүргийг нэмж суулгаж өгнө гэсэн үг юм.

Татах хүчний төв цэг: Үндсэн хуулийн 30-р зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол улсын Ерөнхийлөгч бол... Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн” гэж заасан байдаг. Энэ утгаараа улсын Ерөнхийлөгч нь нийгэм дэх олон янзын ашиг сонирхол, үзэл бодлын тэнцвэрийг барьж, тэдгээрийг төрийн бодлогод жигд тусган хэрэгжүүлэхэд хамгийн нөлөөтэй оролцогч засаглалын субъектын үүрэг гүйцэтгэдэг.

Ерөнхийлөгч нэгэнт бүх ард түмний төлөөлөгч тул засаглалын тогтолцоон дахь түүний үйл ажиллагаа **тэнцвэржүүлэх** шинжтэй байх нь зүйн хэрэг юм.

Тэнцвэржүүлэлтийн асуудал нь төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилах онолын гол мөн чанар “амин сүнс” нь болдог. Энэ үзэл санаа сонгодог ардчиллын онолын “эцгүүд” гэгдэх Платон, Аристотелийн үеэс үүсэн тэрлэж, XVII-XVIII зууны Английн улс төрийн философич Джон Локк, Францын сэтгэгч, эрх зүйч Шарль Луй Монтескье нарын бүтээлч сэтгэлээр цэгцрэн боловсорсон үзэл санаа юм. Ш.Л.Монтескье 1748 онд бичсэн “Хуулиудын утга санаа” гэдэг бүтээлдээ энэ асуудлын онолын үндсийг бүрэн төгс боловсруулан томъёолсон байна. Монтескьегийн үзэл санаа 1787 оны АНУ-ын, 1791 оны Францын Үндсэн хуулийн онолын үндэс төдийгүй 1789 оны “Хүн, иргэний эрхийн тунхаглал”-ын гол үзэл санаа болон хөгжсөн юм. Энэ үеэс эхлэн төрийн засаглалын эрх мэдлийг тэнцвэржүүлэх үзэл санаа нь ардчилсан Үндсэн хуульт нийгмийн гол шалгуур, үндсэн шинж болон төлөвшсөн юм. Энэ утгаараа энэ үзэл санааг улс төрийн философийн онол төдийгүй ардчилсан улс төрийн үйл ажиллагааны зарчим гэж ойлгох учиртай юм.

Төрд тэнцвэр хэрэгтэй бөгөөд энэ нь эхний ээлжинд парламентын хүрээнд дараа нь төрийн засаглалын институцуудын хоорондын харилцааны хүрээнд бодитой хэрэгжих учиртай юм. Харамсалтай нь манайд болон төрийн засаглалын институцуудын хоорондын харилцааны хүрээн дэх тэнцвэрийн ялгаа заагийг бүрхэгдүүлж үүнээс болж Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны тэнцвэржүүлэх үүргийг дутуу үнэлэх эсвэл өрөөсгөлөөр хэтрүүлж тайлбарлах явдал байсаар байна.

Парламентын засаглалтай орны хувьд эрх мэдлийн тэнцвэр зөвхөн парламентын хүрээнд хангагддаг болохоор Ерөнхийлөгчийн энэ чиглэлийн зохицуулах үүрэг бараг байхгүй гэж үздэг хандлага байсаар байна. Улс төрийн намуудын хүчний тэнцвэр парламентын хүрээнд шийдэгддэг гэдгийг хүлээн зөвшөөрч болох боловч энэ нь үнэн хэрэгтээ зөвхөн хууль тогтоох засаглалын хүрээн дэх хүчний тэнцвэрийн асуудал юм. Энэ нь мэдээжээр парламентын засаглалтай манай орны хувьд маш чухал учир холбогдолтой гэдэг нь ойлгомжтой.

Гэвч энд «парламентын хүрээн дэх улс төрийн нам, эвслийн хүчний тэнцвэр», «засаглалын субъектүүдийн эрх мэдлийн тэнцвэр» гэсэн хоёр ойголтын агуулгыг зааг ялгаатай авч үзэх ёстой юм. Эхний ойлголт нь парламент дахь улс төрийн хүчнүүдийн хоорондын харилцааны хүрээнд илэрч үйлчилж байдаг бол дараах нь засаглалын гурван үндсэн, өндөрлөгүүдийн хүрээнд тэдгээрийн хоорондын харилцааны явцад илэрч хэрэгжиж байдаг юм.

Энэ утгаараа төрийн тэнцвэр байх ёстой бөгөөд харин түүнийг манай хүмүүсийн ярьж, сурталчилж байгаагласан засаглалын аль нэг субъект нэн ялангуяа төрийн тэргүүн тодорхой нэг намын байр сууринаас аль нэг улс төрийн үзэл бодол, хандлагын үүднээс засаглалыг хэрэгжүүлэх үйл явцад зориудаар оролцсоны үр дүнд хангагдчихдаг биш юм.

Манайд болж өнгөрсөн Ерөнхийлөгчийн сонгуулийн туршлагаас ялангуяа 2001 оны сонгуулийн сургамжаас үзвэл Ерөнхийлөгчийн сонгуульд оролцогч нэг тал нь: засаг барьж буй намаас, өөр намын нэр дэвшигч Ерөнхийлөгчөөр сонгогдвол өнөөгийн нөхцөлд юу ч хийх бололцоогүй. Харин засгийн эрх барьж байгаа намын хүн сонгогдвол санасан бүгдийг нь гүйцэлдүүлэх бололцоотой гэх юм уу эсвэл МАХН-аас өөр намын нэр дэвшигч ялсан нөхцөлд засаглалын хүрээн дэх эрх мэдлийн тэгш бус байдал арилж төр тэнцвэржих учиртай гэсэн үнэн хэрэгтээ нэг ижил агуулгатай бүхий хоёр өөр сурталчилгаа хүчтэй явагдаж байсан нь төрийн эрх мэдлийн тэнцвэрийн асуудлыг олон түмэнд механикаар хялбарчлан ойлгуулахад нэрмээс болж байлаа.

Энэ хоёр зөрөө бүхий байр суурийг нягтлан үзвэл төрийн тэргүүний тэнцвэржүүлэх үүргийг нийгэм дэх олон янзын эрх ашгийг харилцан улс орны нийтлэг язгуур ашиг сонирхлын үүднээс бус харин Ерөнхийлөгч нэр дэвшүүлсэн намынхаа үзэл бодлогыг үйл ажиллагаандаа түлхүү баримтлах үндсэн дээр бодитой хэрэгжүүлэх бололцоотой юм гэсэн нэгэн агуулга бүхий логик дүгнэлтэнд эрхгүй хүргэж байсныг нуугаад яахав.

Гэтэл Ерөнхийлөгчийн тэнцвэржүүлэх үүрэг нь түүний хуулиар тогтоогдсон бүрэн эрхийн хүрээнд засаглалын бусад институцүүдтэй харилцах харилцаа, зохистой харилцан нөлөөлөл, эрх мэдлийн бодитой хуваарилалт, үр нөлөөтэй хяналтаар дамжин хэрэгжих учиртай юм. Хэрвээ асуудалд энэ утгаар хандвал парламентын засаглалтай орны Ерөнхийлөгчийн тэнцвэржүүлэх үүрэг нь багагүй учир холбогдолтой болохыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болдог.

Засаглалын эрх мэдлийн тэнцвэрийг хангах Ерөнхийлөгчийн үүрэг нь дараах хоёр гол орчин нөхцөлд хэрэгждэг онцлогтой. Үүний эхний нөхцөл нь **улс төрийн тайван тогтвортой орчин, нөхцөл** юм. Энэ нөхцөлд тэрээр Үндсэн хуулиар олгогдсон эрх үүргийнхээ дагуу их төлөв чиглүүлэн удирдах үйл ажиллагааны цогц механизмаар дамжуулан тэнцвэржүүлэх үүргээ ханган хэрэгжүүлдэг. Энэхүү механизмын гол агуулга нь Ерөнхийлөгчийн зүгээс парламентын шийдвэрт бодитой хандах, шаардлагатай үед зөв зохистой хориг тавих, ухаалгаар зөвшилцөн ойголцох, хамтран ажиллах, засгийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх, оновчтой чиглэл өгөх, сонгогч олон түмэн, чөлөөт хэвлэл мэдээлэлтэй илүү ойр дөт байж, бодлого, үйл ажиллагаагаа олон түмэнд хүртээмжтэй ойгуулан сурталчлах, ил тод байх зэргээр тодорхойлогддог.

Ерөнхийлөгчийн тэнцвэржүүлэх үүргээ ханган биелүүлэх дараагийн нөхцөл нь **улс төрийн тогтворгүй, ээдрээтэй нөхцөл байдал** юм. Улс төрийн амьдралаас практикаас үзвэл Ерөнхийлөгчийн тэнцвэржүүлэх үүрэг чухамхүү энэхүү нөхцөлд хурц тодорхой, бүгдэд ойлгогдон мэдрэгдсээр илэрч байдаг нь сонирхолтой юм.

Энэхүү улс төрийн тогтворгүй, ээдрээтэй нөхцөл хэрхэн ойлговол зохих вэ? Энэ нь нэгд, парламентаас гарч буй шийдвэр ард түмний олонхийн санаа бодолтой үл нийцэж, тэдний Үндсэн хуулиар олгогдсон эрх болон амьдралын баталгаанд харшаар нөлөөлж болох тохиолдолд; хоёрт, парламент дахь улс төрийн хүчнүүд хамтран шийдвэр гаргах болоцоогүй болж, тэдний хооронд хэл амаа олоцохгүйгээс үүдэн төр хямралын ирмэгт тулж ирсэн тохиолдолд; гуравт, засаглалын институцуудын хооронд харилцаанд үл ойлголцох байдал газар авч, тэдгээрийн сөргөлдөх хандлага илрэх болсон нөхцөлд; дөрөвт, цөөнхийн илтэд зөрчигдсөн нөхцөлд; тавд, парламентын олонхи өөрийн хүч боломжоо хэтрүүлэн дураар аашлан, шударга ёс илт алдагдах болсон нөхцөлд; зургаад, улс төрийн тэмцэл парламентын хүрээнээс хальж, гудамжинд гарсан гэх мэт

тодорхой нөхцөлүүдтэй холбоотой юм. Энэ нөхцөлд Ерөнхийлөгчийн тэнцвэржүүлэх үүрэг, нөлөөлөл илүү бодитой ажил хэрэгч байдлаар илрэх учиртай юм.

Ерөнхийлөгч засаглалын тэнцвэрийг хангах үүргээ дангаараа хэрэгжүүлэх ямар ч бололцоогүй юм. Харин тэрээр УИХ, засгийн газартай ямар ч нөхцөлд зөвшилцөн ажиллаж, засаглалын тэрхүү субъектуудын дэмжлэг тусалцаатайгаар сая тэнцвэржүүлэгч үүргээ гүйцэтгэх бололцоотой юм. Түүнээс биш дан ганц сөргөлдөх, ямагт шүүмжлэгчийн байр сууринаас хандах юм уу эсвэл олонхийн санаа бодлыг дэмжиж байгаа нь энэ гээд аялдан дагалдах, тал засах, өөрөөсөө зайлуулах замаар Ерөнхийлөгч тэнцвэржүүлэгч үүргээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй юм.

Ер нь Ерөнхийлөгчийн тэнцвэржүүлэх үүргээ ханган биелүүлж чадаж байгаа эсэхийн гол шалгуур нь нэгд, төр, засгийн аливаа шийдвэр улс орон ард түмний язгуур, нийтлэг эрх ашигт нийцэн тохирч буй байдлын төвшингөөр; хоёрт, улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа бүрэн бодитой хэрэгжиж байгаа байдлын төвшингөөр; улс төрийн тогтвортой байдал, засаглалын өндөрлөгүүдийн хоорондын харилцааны зохистой харьцааг алдагдуулахгүй байх улс төрийн таатай уур амьсгал, нөхцөл бололцоо бүрдэж буй байдлын төвшингөөр; дөрөвт, ерөнхийлөгчийн үйл ажиллагаанд хандаж байгаа олон түмний үзэл хандлага, дэмжлэг тусалцааны төвшингөөр; тавд, төрийн үйл ажиллагаатай холбогдон гарч байгаа шүүмжлэл, дургуйцлийн шинж байдлын төвшингөөр тус тус илэрч, үнэлэгдэж байдаг юм.

Монгол улсын ерөнхийлөгчийн үйл ажиллагааны тэнцвэржүүлэгч шинжээс түүний **зохицуулагч** шинж урган гардаг. Түүний үйл ажиллагааны зохицуулагч шинж нь:

- Үүсэн бүрэлдсэн асуудлын мөн чанарын бодитой задлан шинжилж, нэгтгэн дүгнэх чадвар;

- Улс төрийн нам, хүчин засаглалын институцуудын аль алиных нь үзэл бодол, байр суурийг жигд анхааран харгалзах;

- Улс төрийн байр суурийн уян хатан байдал, өндөр мэдрэмж;

- Нийгэм дэх олон янзын эрх ашиг, сонирхол, үзэл бодлын солбилцлын зөв тэнцвэрийг барьж шийдвэр гаргах;

- Нэгэнт гаргасан байр суурь, шийдвэртээ тууштай эзэн болох, түүнийгээ улс төрийн нам, хүчин, засаглалын субъектүүдэд итгүүлэн ойлгуулж, ухуулан сэнхрүүлэх чадвар;

- ямар ч нөхцөлд ээдрээтэй асуудлын учгийг олж, засаглалын субъектуудын хооронд зөвшилцлийн уур амьсгал бүрдүүлэх;

- Түүний шийдвэр гаргах үйл ажиллагааны гол цөм нь зөвшилцлийн механизм байдаг зэрэг тодорхой шалгуур шинжүүдээр илэрч байдаг юм.

Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны дараагийн чухал шинж нь **чиглүүлэн удирдах** үүргээр тод илэрдэг. Түүний чиглүүлэн удирдах шинж нь Ерөнхийлөгчийн гаргаж буй шийдвэрийн төгс бодитой байдал, хэрэгжин биелэх баталгааны шинж байдал, нөлөө оролцооны үлгэр жишээ, биеэ авч явах соёл, зохион байгуулах чадвар, удирдан жолоодох урлаг зэргээс шууд хамаарч байдаг.

Манай хүмүүсийн дотор Ерөнхийлөгчийг зарим үед тодорхой байр суурь баримталдаггүй дэндүү "бөөрөнхий" үйл ажиллагаа явуулдаг гэж шүүмжилдэг. "Бөөрөнхий" гэдэг нь манай улс төрийн хэллэгт төдий л нийцтэй үг биш. Манай хүмүүсийн ойлгож байгаа "бөөрөнхийлөх" гэдэг нь үнэн хэрэгтээ Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны тэнцвэржүүлэн зохицуулж, удирдан чиглүүлэх үүргийн бодит агуулгыг ердийн ухамсрын төвшинд өнгөцхөн ухварласны тусгал болж байгаа юм.

А. Жамбал.

Ислам шашин ба хүчирхийлэл, терроризм

I

Агуу их гүн ухаантан Гегель “Түүхийн философийн лекцүүд” хэмээх алдарт бүтээлдээ “Христос шашинтай гүрнүүдийн өрсөлдөөний улмаас одоо үед Ази ба Африк руу түрэгдэж шахагдсан, Европын зөвхөн нэг л буланд тэсэн тогтож буй ислам шашин нь дэлхий дахины түүхийн тавцангаас аль хэдийнээ буун зайлж, дорно дахины нам гүм, хөдөлгөөнгүй байдалд дахин эргэж оржээ” хэмээн бичсэн байдаг.¹ Гэтэл их сэтгэгчийн аж төрж сэтгэн бясалгаж байсан XIX зууны үеийн ислам шашны тэрхүү нам гүм, хөдөлгөөнгүй байдал удаан үргэлжилсэнгүй, тэр нь түр зуурын байжээ. Энэ шашин дэлхий дахины түүхийн тавцанд XX зуунд дахин хүчтэй гарч ирж олон арван улс орны амьдралд идэвхитэй нөлөөлөх болжээ.

Ислам өнөөдөр зөвхөн шашин шүтлэг төдийгүй иргэншил, нийгэм, соёлын нэгэн том хэв маяг, аж төрөх ёс, уламжлал, ёс заншил, үнэт зүйл, ертөнцийг үзэх үзэл болж байгаа билээ. Үүнтэй холбогдуулж дараах зарим тоо баримтыг дурдъя. Ислам шашныг одоо дэлхийн 172 оронд 1 тэрбум 300 сая хүн шүтдэг, дэлхийн 35 оронд мусульманчууд хүн амын дийлэнх олонхи нь болдог, 28 оронд (Египет, Саудын Арави, Марокко, Кувейт, Иран, Ирак, Пакистан гэх зэрэг) ислам төрийн албан ёсны шашин болж баримтлагдаж байна.² Ислам шашныг шүтэгчдийн тоо эгнээ түргэн өсч байна. Британий нэвтэрхий толийн тоо баримт ёсоор 1987 онд мусульманчууд 860 сая байсан бол одоо 15 жилийн дараа тэд 1,3 тэрбум болж өсчээ. Энэ байдалд мусульманчуудын өөрсдийнх нь жам ёсны өсөлтийн зэрэгцээ эл шашинд шинээр элсэн орогчдын тоо ч өссөөр байгаа явдал нөлөөлж байгаа ажээ. Мусульманчуудын тоо сүүлийн зуун жилд 13-аас 19,5 хувь өссөн байна.³

Ислам шашин орчин үед олон улсын амьдралд, ялангуяа ислам шашинтай орнуудын амьдралын бүх салбарт хүчтэй нөлөөлж байна. Түүний энэхүү нөлөө, гүйцэтгэж буй үүрэг нь дэлхийн бусад шашнуудын нэгэн адилаар ээдрээ зөрчилтэй, нэг талаар эерэг чухал, дэвшилттэй, шаардлагатай, нөгөөтэйгүүр сөрөг, төвөг бэрхшээлтэй байгааг эрдэмтэн судлаачид зааж тэмдэглэж байна. Ислам шашинд нийт хүн төрөлхтний шинжтэй түгээмэл, хүмүүнлэг үнэт зүйл ба хуучирч хоцрогдсон, түүхэн тодорхой нөхцөл, цаг үеийг тусгасан, өвөрмөц онцлогтой зүйлийн аль нь ч агуулагдаж байгаа билээ. Эдгээр нь хүн ард, ялангуяа өөр шашин, өөр уламжлал, ёс заншил, амьдралын өөр хэв маягтай хүмүүс ислам шашин ба түүгээр нөхцөлдсөн мусульманчуудын аж амьдрал, соёл, уламжлал, ёс заншлын талаар сайнтай муутай, үнэн зөв ба буруу, гажуудсан янз бүрийн төсөөлөл, ойлголттой болох үндэс шалтгаан болдог. Түүнчлэн ислам шашны нийгэм дэх үүрэг, сургаал номлол, шинж чанарын талаархи ойлголт, түүнд хандах байдал, үнэлэмж түүхэн тодорхой нөхцөл байдал, цаг үе, ямар нэг томоохон үйл явдалтай холбогдож эерэг, эсвэл сөрөг шинжтэйгээр түргэн өөрчлөгддөг тохиолдол ч гардаг.

Орчин үед дэлхийн олон нийтийн анхаарлыг татаж хурцаар тавигдаж буй тийм асуудлын нэг бол ислам шашны улс төрийн номлол, тэр дотор олон улсын харилцаа, зарим бүс нутаг дахь хурцадмал байдал, хүчирхийлэл, алан хядах үйл ажиллагаа нь ислам шашинтай үнэхээр холбоотой юу, ислам үнэхээр хүчирхийлэл, аллагыг зөвтгөдөг хатуу харгис шашин мөн үү гэсэн асуулт мөн болно. Энэ асуулт нэн ялангуяа 2001 оны 9-р сарын 11-нд АНУ-д болсон үйл явдлаас хойш улам хурц, хүчтэй тавигдах болов.

¹ Гегель Г.В. Ф. Лекции по философии истории. Перевод А. М. Водена. Санкт-Петербург, 2000. С.377.

² Основы религиоведения. Под ред. И. Н. Яблокова. 2-е изд., М., 1998. С.204.

³ Кудряшова И. В. Фундаментализм в пространстве современного мира. —Политические исследования. —2002, №1.

Энэ талаар эрдэмтэн судлаачдаас гадна улс төрчид, янз бүрийн мэргэжил, боловсрол, шашин шүтлэгтэй жирийн хүн ард ч эргэцүүлэн бодож эсрэг тэсрэг, зөрчилтэй, янз бүрийн хариу тайлбар, үзэл бодолтой болж байна. Тиймээс эл асуултыг шинжлэх ухааны үүднээс тусгайлан авч үзэж үнэн бодитой хариу тайлбар өгөх шаардлага гарч байгаа юм. Энэ нь тухайн асуултанд ислам шашныг шүтэж дээдэлдэг мусульман хүний, эсвэл эл шашинд сөрөг байдлаар ханддаг өөр шүтлэгтний байр сууринаас биш харин үнэнийг эрхэмлэж эрж хайсан судлагчийн бодитой байр сууринаас хандахыг шаардана.

II

Шашин бол түүхийн тодорхой нэг үед, хүний нийгмийн тодорхой нөхцөлд үүсэж бий болдог, сургаал, номлол, зан үйл, үнэт зүйл ба бусад бүрдэл хэсэг нь төлөвшиж аажмаар канон буюу хэвшмэл зүйл, уламжлал болж тогтдог үзэгдэл мөн. Тийнхүү нэгэнт хэвшиж тогтсон шашныг дараа дараачийн үеийнхэн уламжлан авч нийгэм-түүхийн шинэ нөхцөлд шүтэн баримталж, хадгалан хамгаалж, бас зарим талаар шинэтгэж үргэлжлүүлэн авч явдаг. Үүнтэй уялдаж аливаа шашин нийгэм-түүхийн шинэ үе, нөхцөлд ямар шинж чанар, үүрэгтэй байх нь нэг талаас түүний уг шинж, уламжлалт догм сургаал, хэвшиж тогтсон зан үйлээс шалтгаалахын зэрэгцээ нөгөөтэйгүүр тухайн шашныг шүтэн баримталж буй үндэстэн, хүн ардын соёл, ухамсар, менталитет, нийгэм ба улс төрийн байгуулал, түүний хөгжлийн түвшин, түүнчлэн тухайн цаг үеийн болон олон улсын харилцааны байдлаас багагүй шалтгаална. Үүнийг иш үндэс болгож аль ч шашны нийгмийн үүрэг, орчин үеийн асуудлыг авч үзэж судлахдаа нэг талаас түүхийн үүднээс, нөгөө талаас орчин үеийн тодорхой нөхцөл байдал, шашинд шууд ба дам байдлаар нөлөөлж буй нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын олон янзын хүчин зүйлтэй холбож тавих хэрэгтэй. Арга зүйн энэ хандлага ислам шашны орчин үеийн асуудлууд, тэр дотор бидний энд хөндөж буй асуудлыг авч үзэхэд мөн нэгэн адил ач холбогдолтой болно.

Ислам шашин бурхны ба христос шашнаас бүр хожуу үед VII зууны эхний хагаст одоогийн Саудын Аравын нутагт үүсчээ. Эл шашин түүхэн богино хугацаанд үзэл номлол, зан үйл, зохион байгуулалтын хувьд төлөвшин тогтож арабуудын байлдан дагууллын явцад Хойт Африк, Сири, Иран, Египет, Палестин, Византи, Дундад Ази, Испани, Энэтхэг ба Хятадын баруун хойд зах хязгаар хүртэл нэвтрэн дэлгэрч дэлхийн гурав дахь том шашин болсон байна.

Ислам нь Аллах хэмээх ганц бурхныг шүтэхийг номлодог сонгодог хэлбэрийн монотеист шашин мөн. Аллахаас өөр бурхан тэнгэр огт үгүй, Мухаммад түүний элч төлөөлөгч гэсэн товч хураангуй томъёолол бол ислам шашны догм сургаал, ертөнцийг үзэхүйн тулгуур үндэс, зарчим мөн болно. Энэ үзэл санаа ислам шашны ариун судар болох Кораны бүх бүлэг зүйлийн утга агуулгад нэвт шингэсэн байдаг.

Ислам шашны бусад шашнуудаас ялгагдах нэгэн том ялгаа, өвөрмөц онцлог бол тэрээр цэвэр шашны догм сургаалын зэрэгцээ нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүй, олон улсын харилцаа, дайн байлдаан, энх тайван, найрамдал, гэрээ хэлэлцээр, ёс суртахуун, хүн ба гэр бүл, хүмүүсийн аж төрөх ёс, ёс заншил зэрэг нийгмийн амьдралын бүх хүрээ салбарын үзэгдэл, үйл явдлуудын талаархи үзэл санаа, ерөнхий ба тодорхой заалт, хэм хэмжээнүүдийг шашны утга агуулгатай болгож, зааж номлосон үлэмж өргөн агуулга багтаамжтай байдаг оршино. Энэ нь Мухаммад ба түүний хамтран зүтгэгчид урьд нь тархай бутархай байсан арабын олон арван овог аймгуудыг хатуу зөөлөн аргыг хослон хэрэглэж нэгтгэж арабын нэгдсэн халифат төр улсыг үүсгэж байгуулсан нийгэм-улс төрийн түүхэн үйл явдалтай ислам шашин үүсэж бүрэлдэх үйл явц орон зай, цаг хугацааны хувьд яв цав давхцаж нэгэн зэрэг явагдсантай холбоотой байв. Энэ үед шинээр үүсэн төлөвшиж байсан ислам шашин нь мөн шинээр бүрэлдэн байгуулагдаж байсан халифат төр улс, аравын нийгмийн амьдралын бүхий л харилцаа, хүрээ салбарыг зохицуулагч хэм хэмжээ, хэрэгсэл болж олон талтай үүрэг гүйцэтгэж байжээ. Энэ үүрэг нь хожмын үед улам хүчтэй болж уламжлал болж тогтсон ба исламын ертөнцийн орнуудад төр, улс төрийн бодлого ба сүм хийд, нийгэм ба шашин

нь хоорондоо салшгүй холбоотой нэгэн нэгдмэл бие организм мэт болж харилцан нягт холбогдож тогтжээ. Энэ байдал өнөөдөр ч хэвээр байна. Исламын ертөнцийн орнууд, нэн ялангуяа арабын орнуудад ислам шашин нийгмийн амьдралын бүх хүрээнд асар их нөлөөтэй байна. Гэхдээ энэ нь хүч, албадлагаар биш харин эл шашны мянга гаруй жилийн нүүр үзсэн уламжлал, нэр хүнд, оюун санаа, соёлын нөлөөгөөр, мусульманчуудын итгэл үнэмшил, үйл ажиллагаагаар дамжин хэрэгжиж байгаа нь сонирхолтой.

Ислам шашны догм сургаал, номлол нь исламын орнуудын нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдрал, хууль, эрхийн харилцааны оюун санааны үндэс болж байна. Ислам шашны нийгмийг нэгтгэж нягтруулах, нийгмийн харилцааг зохицуулах үүрэг нь бусад шашныхаас илүү хүчтэй байна. Ийм нөхцөлд исламын орнуудын нийгмийн амьдралын аливаа үйл явдал, өөрчлөлт, тавигдаж хэрэгжих зорилтууд нь ихэвчлэн шашны хэлбэрээр, шашны нэрийн дор илэрч, шашны шинж чанартай болдог.

Ислам шашны догм сургаал, нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн номлол нь Коран сударт бичигдэж томъёологджээ. Исламын ертөнцөд Кораныг Алладын үнэн үг, айлдал сургаал тэмдэглэгдэж буусан хөлгөн их ариун судар хэмээн үзэж дээдэлдэг. Коран судрын одоогийн нийтээр хүлээн зөвшөөрч, албан ёсоор баримталж буй цорын ганц бичмэл, хэвшсэн эхийг 644-656 онд арабын халифат улсын хаан суусан Османы даалгавраар Зейд ибн Сабит тэргүүтэй бичиг номын хүмүүс тэр үед хэрэглэгдэж байсан үндсэн дөрвөн янзын хувилбарыг хооронд нь харьцуулан тулгах, зөрчил, алдаа мэдгийг нь нь арилгах замаар эмхтгэн бичиж бусад хувилбарыг хууль бус, алладын үнэн үг, сургаал биш хэмээн зарлаж устгасан түүхтэй. Энэ үеэс хойш Коран судрын бараг нэг ч үг, үсэг, тэмдэг ч өөрчлөгдөөгүй.

Гэтэл VII зуунд бичигдэж хэвшмэл догм болсон Коран судрын үзэл санаа, ерөнхий болон тодорхой заалт, ялангуяа түргэн өөрчлөгддөг нийгмийн амьдралын үзэгдэл, үйл явдлуудын талаархи сургаал, заалт нь нийгэм-түүхийн өөрчлөлт хөгжлийн явцад хуучирч бодит амьдралтай тохирохгүй зөрчилдөх болжээ. Нөгөөтэйгүүр Коран судрын зарим заалт, зүйлүүд утга санаа, агуулгын хувьд хоорондоо зөрчилтэй, нэг нь нөгөөгөө үгүйсгэсэн байдаг. Эрдэмтдийн судалж тогтоосноор Коранд тийм 225 зөрчил бий ажээ.

Дурьдсан эдгээр ээдрээтэй асуудал, зөрчлийг Коран судрын ерөнхий үзэл санаа, нэгэнт хүлээн зөвшөөрөгдөж хэвшмэл болсон ганц хувилбарын бичлэг, томъёоллыг огтхон ч өөрчилж засварлахгүйгээр зөвхөн утга санааны талаас нь шинэчилж тайлбарлан ойлгох уян хатан арга, тусгай тайлбар бүхий тафсир буюу Кораны тайлбарыг зохион хэрэглэх замаар шийдвэрлэх болсон байна. Кораны тайлбар бүхий тафсир нь үүгээр хязгаарлагдсангүй мөн хоорондоо утга санаа зөрчилдөж бие биеэ үгүйсгэсэн аят буюу зүйлүүдийг хооронд нь харьцуулан тулгаж тэдгээрийн заримыг үнэн зөв бөгөөд хүчин төгөлдөр (насих), заримыг нь хүчин төгөлдөр бус, халагдсан (мансук) аят хэмээн зааж тайлбарлажээ. Орчин үед Кораны дөч гаруй бүлэгт тийм хүчин төгөлдөр бус, халагдсан аят бүхий заалт, зүйлүүд бий. Тийм учраас мусульманчууд орчин үед Кораны бүх бүлэг зүйл, заалтуудыг аль эртний VII зуунд бичигдсэн байдлаар нь хатуу баримталж мөрдлөгө болгодог, исламын орнуудын амьдрал зөвхөн Коран судрын үзэл санаа, заалтаар хатуу зохицуулагддаг хэмээн ойлговол дэндүү өрөөсгөл хэрэг болно.

Ислам орчин үед дэлхийн бусад шашны адилаар нэг талаас өөрийнхөө суурь шинжтэй догм сургаал, зарчим, уламжлал, үнэт зүйлээ хэвээр нь хадгалахын хамт нөгөөтэйгүүр орчин үеийн амьдралын хэрэгцээ шаардлагаар өөрчлөгдөж шинэчлэгдэж байна. Ялангуяа ислам шашны нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн номлол, тэр дотор дайн, хүчирхийллийг үзэх үзэл санаа, практикийн баримтлал нь багагүй өөрчлөгдөж иржээ.

Ислам шашны талаар бидний дээр дурьдсан ерөнхий санаа бодол, зүйл нь эл шашны улс төрийн номлол, тухайлбал дайн, хүчирхийллийг үзэх үзэл, түүний хувьсал, өөрчлөлтийн тухай тодорхой асуудлыг авч үзэх ерөнхий суурь дэвсгэр болж өгнө. Ислам шашны тухай тийм ерөнхий ойлголтгүйгээр, онол, арга зүйн зохих тавил, чиг баримтлалгүйгээр түүний улс төрийн номлол, дайн, хүчирхийллийн талаархи үзэл санаа, заалтуудын агуулгыг үнэн бодитойгоор илрүүлэн гаргахад ихээхэн бэрхшээлтэй болно.

III

Ислам шашны догм сургаал ёсоор газар дэлхий дэх хүний нийгэм, түүний эдийн засаг, хувийн өмч, улс төрийн байгуулал, засаглал, нийгмийн ялгаа, захирах захирагдах харилцаа зэрэг үзэгдэл, бодит байдал бүгд Аллах бурхны тогтоосон зорилго зохицолдлогоотой дэг журам мөн болно. Нийгмийг бүрдүүлж аж төрдөг хүн хэмээх амьтны уг шинж угаасаа зөрчилтэй. Аллах бурхан уг нь хүнийг "хамгийн сайн хэмжээ зохицолтой болгож бүтээсэн" боловч⁴ хүн бол олон янзын муу муухай юм шүглэсэн гэм нүгэл үйлдэх хүсэл сонирхолтой, эд баялаг, алдар хүндэд хэтэрхий шуналтай, харамч, хувиа хичээсэн, Алладын ач тус, ивээл хайрыг хүртдэг хэрнээ түүнийг дорхноо мартдаг, өөрөө бие дааж нүгэл ба буян, сайн ба муу, зөв ба буруу, шударга ба шударга бус, ариун ба бузрыг ялгаж чаддаггүй амьтан.

Түүнчлэн нийгэм доторхи хүмүүсийн бүлэг, давхраанууд ч хоорондоо олон зүйлээр ялгаатай, зарим талаар эсрэг тэсрэг шинжтэй байдаг. Газар дэлхий дэх олон янзын угсаатан, ард түмэн, тэдний байгуулсан төр, улс орнууд ч хөгжил, хүч чадал, хэр хэмжээгээрээ хоорондоо ялгаа зөрөөтэй. Ийм байдлаас болж хүмүүсийн хооронд, нийгмийн бүлэг, давхрааны хооронд, бас угсаатан, улс гүрнүүдийн хооронд зөрчил, өрсөлдөөн, тэмцэл, өширхөл, дайсагнал бий болдог. Тиймээс нийгэмд төр, засаглал, хууль цааз, эрх зүй, ял шийтгэл, сайшаал шагнал зайлшгүй шаардлагатай. Аллах бурхан үүнийг хангаж биелүүлэх зорилгоор төр, улс төрийн дотоод ба гадаад бодлого, олон улсын харилцаа, хамтын амьдрал, тэдгээрийн арга хэрэгсэл, зарчим, хэм хэмжээ, гэрээ хэлэлцээр зэргийг өөрийн хүсэл зориг, тааллаар тогтоон бий болгожээ.

Аллах бурхан газар дэлхийд засаг төрийг шашин ба төрийн дээд эрх мэдлийг хослон барьсан Халифат төрийн хэлбэрээр тогтоосон ажээ. Тиймээс сүсэгтэн олон мусульманчууд аллах ба түүний элч төлөөлөгч, бүх шатны засгийн эрх баригчдад захирагдах ёстой.⁵

Ислам шашны сургаал ёсоор хүн төрөлхтөн анхны хүн болох Адамын үр сад бөгөөд эхэндээ олон янзын угсаатан, үндэстэн, улс гүрэн болж хуваагдаагүй, нэгдмэл, тэгш байдалтай, нэг төрлийн байв. Хожим нь хүн ард үржин өсөж олон янзын ялгаа, өвөрмөц онцлогтой үй олон үндэстэн, угсаатан болж салбарлаж тархсан ба өөр өөр соёл, уламжлал, шашин шүтлэг, газар нутаг, ёс заншилтай болсон ажээ. Дэлхийн тэдгээр үй олон улс орон, ард түмнүүд Алладын хүсэл зориг, зааснаар хоорондоо харилцаа холбоотой, хамтын ажиллагаатай болжээ. Тэгэхдээ Аллах тэдгээр ард түмэн, улс орны заримыг нь илүү, давуу талтай, хүчирхэг, хөгжилтэй, нөгөө хэсгийг нь дутуу, хүч сул, бага буурай болгожээ. Эдгээр ялгаа, тэгш бус байдал ирээдүйд ихсэх ажээ. Энэ нь дэлхийн олон улс орон, ард түмний хүчирхэг чадалтай зарим нь буурай доройгоо захирч эрхшээлдээ байлгах, удирдаж авч явах үндэс шалтгаан болно.

Хүн төрөлхтөн, дэлхий нийтийн түүх Алладын хүсэл зоригор мандах буурахын жамаар явагдана. Аливаа улс орон, ард түмэн мандаж дэвших, хөгжих, эсвэл буурч доройтох, мөхөх тодорхой цаг хугацаа, хувь тавилантай байдаг. Цаг нь болоогүй бол ямар ч ард түмэн дэвшиж мандахгүй, бас цагаасаа түрүүлж унаж доройтохгүй.⁶

⁴ Ислам. Энциклопедический словарь. М., 1991. С.95.

⁵ Ислам. Энциклопедический словарь. М., 1991. С.59.

⁶ Куран Карим. (Казахша магына жане тусиниги). Медине, 1991. (Коран. Казахчилсан утга ба тайлбар. Араб хэлнээс орчуулсан Халифа Алтай, Медина хот). С.35.

Дэлхийн ард түмэн, угсаатнуудын хооронд олон янзын ялгаа, онцлог байх боловч тэдгээрийн дотроос хамгийн гол ялгаа бол шашин шүтлэгийн ялгаа мөн гэж ислам үздэг. Исламыг шүтэгч мусульманчууд болбоос Аллахын заасан зөв зам мөрөөр замнагсад мөн. Бусад шашинтанууд бол төөрөгдсөн, Аллахын үг сургаал, заасан зөв зам мөрийг ухаарч ойлгоогүй хүмүүс юм. Ислам шашин ялангуяа өөр угсаатны олон бурхантай шүтлэгтнүүдэд бүхэлдээ тааламжгүй ханддаг боловч "шашин шүтлэгт албадлага үгүй" гэсэн зарчмыг баримталдаг.

Ислам христос ба иудейн монотеист (ганц бурхантай) шашин, тэдгээрийг шүтэгсдийг "бичиг номын хүмүүс" хэмээн нэрлэж хүндэтгэлтэй ханддаг уламжлалтай. Коран сударт бурхны шашны талаар нэрлэж заасан тодорхой зүйлгүй юм.

Ислам шашин үүссэний дараа хүрээгээ тэлж бэхжихийн төлөө тэмцэх явцад юуны өмнө тухайн үеийн олон бурхан шүтдэг арабын олон овог аймгуудыг ислам шашинд оруулах, энэ талаар тэдэнтэй хэрхэн яаж харилцах асуудалд илүү их анхаарал хандуулж энэ тухай Коран судрын олон бүлэг зүйлд тодорхой заасан байдаг.

IV

Ислам шашин үүсэж төлөвших үеийн нийгэм-түүхийн ээдрээтэй нөхцөл байдал, энэ үед болж байсан томбоохон үйл явдлуудын тусгал, нөлөөгөөр өөрийн улс төрийн номлолдоо дайн, байлдаан, хүчирхийлэл, энх тайван ба энхийн гэрээ хэлэлцээрийн асуудалд ихээхэн анхаарал хандуулсан байна.

Ислам шашин үүсэхээс өмнө арабын олон овог аймаг нийгэм, улс төрийн зохион байгуулалтын хувьд тархай бутархай, шашин шүтлэгийн хувьд олон жижиг бурхан шүтээнтэй байв. Тухайлбал энэ үед арабуудын дотор 360 янзын бурхан шүтээн, 8 янзын мөргөлийн төв бүхий сүм дуган байжээ. Ийм нөхцөлд нэгдсэн төр улс байгуулах, нэг бурхантай ислам шашныг үүсгэж арабуудыг түүнд оруулж шүтүүлэх үйл хэрэг ихээхэн бэрхшээл саад, хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан байна. Нийгэм-улс төрийн ба шашны энэхүү давхар, түүхэн зорилтыг хэрэгжүүлэгч Мухаммад, түүний хамтран зүтгэгчид, талархаж дэмжигсэд ба тэдний эсрэг талынхны хооронд 624, 625, 627, 629, 630 онуудад зэвсэгт мөргөлдөөн, байлдаан болж тэдгээрийн нэгний үеэр (625) Мухаммад шархдаж байсныг түүхчид тэмдэглэж бичсэн байдаг. Мөн хоёр тал хоорондоо хэд хэдэн удаа энхийн гэрээ хэлэлцээр хийж түүнийг Мухаммадын эсрэг тал итгэл эвдэж удаа дараа зөрчиж байв. Эдгээр үйл явдлын тусгал нөлөөг Коран судрын бүлэг зүйлүүд, ислам шашны нийгэм-улс төрийн номлолоос олж ойлгоход төвөгтэй биш. Тухайлбал дайн, байлдаан, хүчирхийлэл, энх тайван ба энхийн гэрээ хэлэлцээр, түүнийг баримтлах ба зөрчих, энэ тохиолдолд хэрхэн хандах зэрэг асуудлын талаар Коран судрын янз бүрийн бүлэг зүйлд барагцаалбал 200 орчим тооны заалт бүхий зүйл бий.

Ислам шашны хүчирхийлэл, дайн ба энхийг үзэх үзэл нь Жихадын тухай сургаалд тусгагдаж боловсрогдсон байна. Жихад хэмээх араб үг нь чармайлт, хичээл зүтгэл, мэрийлт гэсэн утгатай. Гэтэл энэ үгийн илэрхийлэх утга санаа, хэрэглээ нь хөгжлийн явцад өөрчлөгдөж шашны агуулгатай ойлголт, нэр томъёо болж хувирчээ. Ислам шашинд эхэн үед жихадыг эл шашныг энх тайван аргаар хамгаалах, олон бурхантай арабуудын дотор нэвтрүүлж дэлгэрүүлэхийн төлөө хүчин чармайлт, зүтгэл гэсэн утгаар ойлгож хэрэглэж байв. Гэтэл тухайн үед шинээр үүсэн дэлгэрч буй ислам шашин хүчирхийлэл, зэвсэгт эсэргүүцэл, хатуу хавчилт шахалттай тулгарч үүний улмаас өөрийгөө мөн зэвсгийн хүчээр хамгаалах болжээ. Үүнтэй холбогдож жихад нь ислам шашин, Аллах бурхны төлөө шударга, ариун дайн гэсэн шинэ утга агуулгатай болсон түүхтэй.

Коран сударт жихадыг исламын төлөө ариун дайн, шударга тэмцэл гэсэн утгаар нь ойлгож хэрэглэсэн бүлэг зүйлүүдэд түүний утга агуулга, зорилго, зарчим, шинж чанар, болзолт нөхцлүүдийг дараах байдлаар зааж томъёолсон байдаг. Үүнд:

-дайн, хүчирхийлэл, ер нь хүний амь нас, энх тайвны эсрэг чиглэгдсэн аливаа үйлдэл, үйл ажиллагаа бол Аллах бурхны хатуу хориглож цээрлэсэн хамгийн хүнд нүглүүдийн нэг мөн;

-дайн бол гал түймэртэй адил бөгөөд түүнийг нэн даруй унтраах ёстой;

-мусульманчууд ямар нэг сэдэл санаа, зорилгоор өөрснөө санаачилж дайн гаргаж болохгүй;

-Аллах бурхан мусульманчуудад зөвхөн хориглох, ислам шашнаа хамгаалах дайныг л зөвшөөрнө;

-олон бурхан шүтэгчид, мөн өөр шашин шүтлэгтэнгүүдтэй сөргөлдөж болохгүй, тэднийг ислам шашинд зөвхөн тайван арга замаар "Коран судрын хүч нөлөөгөөр л" татан оруулах хэрэгтэй, учир нь "шашин шүтлэгт хүчирхийлэл, албадлага байж болохгүй";

-Ислам шашин, мусульманчуудын эсрэг тэмцэж дайн байлдаан, хүчирхийлэл, хавчилт шахалт, мөрдөлт мөшгилт өдөөж үнэнхүү дайсан болохоо харуулсан этгээд, түүнчлэн дайсанд тусалж дэмжигсэдтэй шашны ариун саруудаас бусад хугацаанд хэзээ бол хэзээ, хаана бол хаана дайтан байлдах, алж устгах, олзолж авах хэрэгтэй;

-хэрэв дайтагч тал энхийн гэрээ байгуулах, дайн байлдааныг зогсоох санал гаргавал түүнийг дуртайяа хүлээн авч тодорхой хугацаагаар энхийн гэрээ байгуулах хэрэгтэй;

-дарангуйлал, хэрцгийллийн эсрэг тэмцэгчид, тэдгээрээс авран хамгаалахыг хүсэгчид нь хэрэв мусульманчуудад өөрснөө хандаж тусламж хүсвэл тэдэнд бүх талаар, тэр дотор цэрэг зэвсгийн хүчээр ч туслах, тэдний талд байлдах хэрэгтэй;

-мусульманчууд өөрийгөө хамгаалж хориглосон шударга, ариун дайн хийх явцад дайны үйл ажиллагаа, үйлдлээс өөр хэрээс хэтэрсэн, зүй бус үйлдэл хийж болохгүй, тухайлбал хүүхэд, эмэгтэйчүүд, хөгшид, тахир дутуу хүмүүсийг дормжлох, албадаж хүчирхийлэх, амь насыг нь хороох, ашиг хонжоо хайж дээрэм тонуул хийх, дайны олзыг зүй бусаар хувьдаа завшихыг хатуу хориглоно;

-хэрэв мусульманчуудын хоёр бүлэг, хэсэг бие биетэйгээ дайтвал тэдгээрийг хооронд нь эвлэрүүлэх ёстой, хэрэв тэдний нэг тал нь нөгөөдөө шударга бусаар хандаж түрэмгийлэн дайтаж байгаа бол түүний эсрэг дайтаж шударга талд туслах хэрэгтэй;

-шашны ариун дайнд оролцогчид эрэлхэг, зоригтой, үнэнч шударга байх ёстой, хэрэв дайны талбарыг орхиж зугтвал хатуу шийтгэгдэнэ;

-өөрийн гэсэн зэр зэвсэг, бусад эд хэрэгсэлгүй хүмүүс, шашны зүтгэлтэн, эрдэм номын хүмүүс, эцэг эх нь дайнд оролцохыг зөвшөөрөөгүй хүмүүс, бусдад өр зээлтэй бөгөөд зээлдүүлэгч нь дайнд оролцохыг зөвшөөрөөгүй хүмүүс шашны төлөө ариун дайнаас албан ёсоор чөлөөлөгдөнө.⁷

Коран сударт тусгагдсан жихадын тухай заалт, үзэл санаа шашны сэтгэлгээний хөгжлийн явцад гүнзгийрэн баяжиж, бас шинэчлэгдэж исламын улс төрийн ба эрх зүйн номлолын нэн чухал бөгөөд харьцангуй бие даасан хэсэг, үзэл баримтлал болж хөгжжээ. Үүний үр дүнд орчин үеийн исламын нийгмийн сэтгэлгээ жихадыг ислам шашин, исламын соёл, иргэншил, тэдгээрийн ариун шударга, дэвшилттэй аливаа үйл хэргийн төлөө, тэдгээрийг биелүүлэх, хөгжүүлж мандуулахын төлөө мусульманчууд өөрийн оюун ухаан, зүрх сэтгэл, дуу хоолой, хэл яриа, гар бие, хүч хөдөлмөрөө зориулах, хэрэв шаардлагатай бол зэвсэг барьж хамгаалах, тэмцэх өргөн агуулгатай нийгмийн хичээл зүтгэл, хөдөлгөөн тэмцэл хэмээн ойлгож байгаа юм.

Исламын сэтгэлгээ жихадын тухай ойлголтыг нарийвчлан боловсруулж түүнийг дотор нь 1/. Зүрх сэтгэлийн жихад, 2/. Хэл ярианы жихад, 3/. Гар биеийн жихад, 4/. Илд сэлэмний жихад гэсэн төрөлд хувааж ангилжээ.

Зүрх сэтгэлийн жихад гэдэг нь мусульман хүн ислам шашны сургаал, үнэт зүйлс, зан үйл, хэм хэмжээнд харшлах аливаа нүгэл, гэмт үйлдэл, муу зуршил бүхнээс

⁷ (Эдгээр заасан зүйлүүдийг Коран судрын дараах бүлэг зүйлээс үзнэ үү. үүнд: 2:190-194, 216-217; 4:74-77; 8:39-40, 56-75; 9:1-8; 7:28; 16:92-95; 22:40-41; 60:7-9; 25:54; 49:9-11. Энд эхний тоогоор Кораны бүлгийн дугаар, хоёр цэгийн дараах тоогоор уг бүлгийн зүйл-аятын дугаарыг тэмдэглэсэн болно).

сэтгэл санаа, оюун ухаанаа хамгаалж ариун байлгах, буян, шударга ёс, зөв зам мөрөөр замнахын төлөө чармайж тэмцэх, нэг үгээр хэлбэл өөрөө өөрийгөө жинхэнэ хүн болгож хүмүүжүүлэхийг хэлнэ. Хэл ярианы жихад гэдэг нь ач буян, сайн үйл, үлгэр дууриалалтай бүхнийг магтаж сайшаах, бусдад айлдаж зааж сургах, нүгэл, гэм буруу, муу бүхнийг зэмлэж буруушаахыг хэлнэ. Гар биеийн жихад гэдэг нь гэмт хэрэг, нүгэл үйлдэгсэд, ёс суртахууны зөрчил гаргагсдыг яллаж шийтгэх, зэмлэж буруушаах, засаж хүмүүжүүлэхийн төлөө тэмцэл, үйл ажиллагаа юм. Илд сэлэмний жихад гэдэг нь ислам шашин, мусульманчуудад дайсагнаж халдаж түрэмгийлэгчидтэй зэвсэг барьж тэмцэхийг хэлнэ.

Дурьдсан эдгээр жихадыг ерөнхийд нь их ба бага жихад гэсэн хоёр том хэсэгт хуваана. Ислам шашин, исламын соёл, иргэншил, исламын төр улс, нийгмийг бүх талаар хөгжүүлж бэхжүүлэх, мусульман хүнд байх ёстой ариун нандин чанарыг өөртөө шингээж эзэмших, өөрийгөө оюун ухаан, ёс суртахууны талаар төгс төгөлдөр болгохын төлөө хичээл зүтгэл гаргаж үнэнч шударгаар хөдөлмөрлөх, хийж бүтээхийг хамгийн чухал буюу "их жихад" гэнэ. Харин исламын эсрэг түрэмгийлэгч дайсантай мөн адил зэвсэг барьж дайтаж тэмцэхийг "бага жихад" гэнэ.

Ислам шашин дайн, чухамдаа түрэмгий, шударга бус, гэрээ хэлэлцээр, итгэл эвдсэн дайн, хүчирхийлэл, аллага бол мусульманчуудын зорилгодоо хүрэх арга, хэрэгсэл огт биш гэж зааж сургадаг. Гэвч ислам шашин хамгаалах, хориглох дайныг бас огт үгүйсгэхгүй. Исламын энэ байр суурь, үзэл санаа Коран сударт "Дайн бол мусульманчууд та нарын хувьд хүсмээргүй жигшүүрт гэмт хэрэг мөн боловч бас зайлшгүйн эрхээр та нарт үүрэг болж оногдоно" гэж илэрхийлэгджээ.⁸ Ислам шашин ерөөс хүн, гэр бүл, нийгэм, нийт хүн төрөлхтний энх тайван, амар амгалан амьдрал, тогтвортой хэвийн хөгжил дэвшлийг дээдлэн эрхэмлэнэ. Энэ нь мусульманчуудын бие биетэйгээ болон бусад шашинтантай мэндлэх хэвшиж тогтсон мэндчилгээнээс өгсүүлээд (мусульманчууд: "ас-салам алейкум" буюу "энх амгалан тантай хамт байх болтугай" хэмээн мэндлэнэ) нийгэм, төр улсын амгалан тайван байдлыг эрхэмлэж сахих нийгэм-улс төрийн үүрэг, зорилго хүртэлх бүхий л үйл ажиллагааны тулгуур зарчим болно. Тухайлбал ислам шашин хэн хүн бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж түгшээх, хэрүүл зодоон үүсгэх, нийгмийн хэв журам, төрийн хууль цаазыг зөрчих, үймээн самуун, бослого дэгдээх, төрийн эргэлт хийх зэрэг хүчирхийллийн ажиллагааг хамгийн хүнд нүгэл, гэмт хэрэг хэмээн үзэж хатуу цээрлэж, шийтгэл хүлээлгэдэг.

Жихадын тухай сургаал ислам шашинтай үндэстэн, улс орнуудын амьдрал, түүхийн янз бүрийн үед олон талтай, харилцан адилгүй үүрэг гүйцэтгэж байв. Тухайлбал эл ойлголт VIII-IX зууны үед арабын халифат гүрэн бусад оронтой харилцах гадаад бодлого, олон улсын харилцааны үзэл санааны үндэс болж байв. Энэ үед **дар аль-ислам** буюу исламын ертөнц, исламын газар нутаг; **дар аль-харб** буюу харийн, дайны газар нутаг; **дар аль-ахд** (дар ас сулх) буюу завсрын, гэрээ хэлэлцээрийн газар нутаг гэсэн ойлголтууд бий болжээ.

Исламын газар нутаг гэдэг нь хүн ам нь ислам шашинтай, исламын төр улс байгуулагдсан улс орон юм. Исламын бус, дайн байлдаантай газар нутаг гэдэг нь хүн ам нь өөр шашинтай, өөр маягийн засаг төртэй, дотроо байгаа мусульманчуудын цөөнхийг ялгаравлаж, хавчин гадуурхаж, хүчирхийлж, үүнээс болж дайн болж байдаг улс орон гэж үзэж байв.

Исламын ба исламын бус газар нутаг бүхий орнууд хоорондоо дайсагнаж бие биедээ түрэмгийлэхгүйгээр энхийн гэрээ хэлэлцээр хийж, тэр дагуу энх тайвнаар зэрэгцэж орших ёстой. Ийм гэрээний дагуу исламын бус улс орны төр засаг, улс орны хүн амын олонхи бүхий өөр шашинтай үндэстэн дотор байгаа мусульманчуудын цөөнхийг ялгаварлаж хавчихгүй, ислам шашныг чөлөөтэй шүтэх, тодорхой хэмжээний улс төрийн эрх эдлэхийг нь хангах, нөгөө талаар түүнийг нь исламын төр улс дипломат

⁸ Васильев Л. С. История религий Востока. 3-е изд., М., 1998. С. 216.

харилцаа, гэрээ хэлэлцээр зэрэг энхийн аргаар давхар хангаж хамгаалах ёстой. Ийм газар нутаг бүхий орныг завсрын буюу гэрээ хэлэлцээрийн газар нутаг хэмээн нэрлэж байв. Эдгээр ойлголт, үзэл санаа хожим нь "исламын олон улсын эрх зүйн" онолын үндэс, үзэл баримтлал болж хөгжсөн юм.

XIX-XX зууны зааг үед ислам шашинтай ихэнх орон (Египет, Судан, Алжир, Сири, Тунис, Сомали, Ливи, Ливан, Индонез, Малайзи гэх мэт) бусдын хараат колони орнууд болсон байв. Исламын орнуудад XX зууны эхэн, ялангуяа түүний II хагаст колонилол, хараат байдлын эсрэг үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөө, хөгжлийн өөрийн гэсэн бие даасан зам, сонголтын төлөө хөдөлгөөн, тэмцэл хүчтэй өрнөж амжилтанд хүрсэн юм. Энэ үед жихадын тухай сургаал энэхүү хөдөлгөөн тэмцлийн үзэл суртал, оюун санааны үндэс, лоозон нь болж байв. Жихадын үзэл санаа мусульманчуудын үндэсний ба улс төрийн ухамсар, өөрийн ухамсар бүрэлдэх, хөгжиж дээшлэхэд асар их үүрэг гүйцэтгэж, тэднийг үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө тэмцэлд хөтөлж дайчилсан юм.

Колонилол, хараат байдлаас чөлөөлөгдсөн дорно дахины орнууд, тэр дотор ислам шашинтай орнуудын цаашдын тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн зам, сонголт нь амар хялбар, дардан байсангүй. Хуучны колонилогч хүчирхэг орнууд эдийн засаг, цэрэг зэвсгийн хүчин чадал, улс төр, соёлын давуу байдлаа ашиглаж чөлөөлөгдсөн орнууд, тэр дотор ислам шашинтай орнуудад нийгмийн амьдралын зохион байгуулалт, хөгжил, соёл, аж төрөх ёсны барууны загвар, Америкийн нийгмийн эрхэмлэл, үнэт зүйл, хэм хэмжээг тулган хүлээлгэхийг зорьж байв. Энэ бодлого одоо ч үргэлжилж байгаа билээ.

Барууны орнуудад либерализмын зарчим, үнэт зүйлс ноёрхсон, хүмүүс нь хуулиар хориглоогүй бүхнийг үйлдэх эрх, эрх чөлөөтэй, нийгмийн харилцаа, хүмүүсийн аж төрөх ёс, амьдралд ёс заншил, уламжлал, ёс суртахууны нүгэл ба буян гэх зэрэг хэм хэмжээ төдийлөн нөлөө үүрэгтэй биш, бүхнийг хуулиар зохицуулдаг онцлогтой. Гэтэл исламын орнуудад үүний эсрэгээр нийгэм ба бие хүний амьдрал, хүмүүсийн хоорондын харилцаанд уламжлал, ёс заншил, ёс суртахуун, ялангуяа шашны зохицуулагч үүрэг, хэм хэмжээ чухал бөгөөд идэвхитэй үүрэг гүйцэтгэдэг. Шашин, уламжлал, ёс заншлаа тууштай баримталдаг исламын орнуудын амьдрал нь барууныханд хатуу, хэт хуучинсаг, эрх чөлөөгүй, хүн тэсэж амьдрахын аргагүй мэтээр санагддаг бол араб, мусульманчуудад барууны нийгэм, хүн ардын амьдрал, ялангуяа түүний орчин үеийн хэм хэмжээ, шинж чанар, үзэгдлүүд нь эх захгүй, задарсан, хүнийг эвдэж уналт доройтолд хөтлөн оруулдаг хорт нөлөөтэй мэтээр төсөөлөгдөж санагддаг талтай. Шашин, ёс уламжлалаа хатуу баримталдаг мусульманчууд АНУ-ыг заримдаа "Том шулмас" гэж нэрлэдэг.

Ийм эрс тэс ялгаатай нөхцөлд ислам шашинтай орнууд, мусульманчууд барууны нийгэм, иргэншил, соёлын гаж буруу, хор холбогдолтой нөлөөнөөс ихээхэн сэрэмжлэн тэдгээрт хаалт хамгаалалт тавьдгийн учир шалтгааныг ойлгоход хэцүү биш. Исламын ихэнх орнуудад хэрэв барууны соёл, иргэншлийн одоогийн үнэт зүйл, хэм хэмжээг чөлөөтэй тавьж хүлээж авбал ислам шашин, исламын соёл, иргэншил, уламжлал, ёс заншил, хөгжлийн үндэсний загвар, зам алдагдаж бусдад уусна, хүн эвдэрч доройтно гэсэн үзэл ойлголт түгээмэл байна. Эдгээрээс сэрэмжилж исламын соёл, иргэншил, мусульман хүний шинж чанарыг хэвээр нь хадгалж чадах чухал хэрэгсэл, хаалт хамгаалалт бол "их жихад" мөн гэсэн үзэл санаа баримтлагдаж байгаа юм.

Гэвч үүнийг исламын орнууд, мусульманчууд барууны соёл, иргэншил, шинжлэх ухаан, техник, технологи, хотжилт, харилцаа холбоо, тээвэр, мэдээллийн хэрэгслийн орчин үеийн ололт амжилт, нийтэд түгээмэл үнэт зүйлийг эрс эсэргүүцдэг, үеэ өнгөрөөсөн, хоцрогдож хуучирсан бүхэнтэй зууралдаж байдаг мэтээр өрөөсгөлөөр, эсвэл зориуд гуйвуулж ойлговол өнөөгийн бодит байдалд огт нийцэхгүй. Ислам шашинтай, хөгжил дэвшилтэй өнөөгийн орнуудад барууны соёл, иргэншил, шинжлэх

ухаан, техникийн тэргүүний ололт амжилт аль хэдийнээ нэвтрэн дэлгэрч нийгэм, бие хүний амьдралын өдөр тутмын хэрэгсэл болж хэвшжээ.

Ү

Гэвч исламын соёл, иргэншилд шинэчлэгдэх хандлагаас консерватив шинж чанар илүү байгааг хүлээн зөвшөөрөх ёстой. Орчин үед исламын орнуудад шашин, соёл, уламжлал, ахуй амьдрал, үнэт зүйлсийн хувьд хуучныг баримталсан, шинэ дэвшилт зүйлийг эсэргүүцсэн үзэл санаа, үйл ажиллагаа, нийгмийн хөдөлгөөн хамгийн хурц бөгөөд нийгэмд ихээхэн хор уршигтайгаар илэрч хэрэгжиж буй хэлбэр бол шашны тулгуур үзэл, байр суурь болох исламын фундаментализм мөн болно. Гэвч шашны фундаментализм зөвхөн исламд байдаг, анх түрүүн исламд үүссэн зүйл биш бөгөөд тэрээр одоо ихэнх шашинд байдаг, бас эртний гарал үүсэл, түүхтэй болохыг эрдэмтэд судлан илрүүлж тэмдэглэсэн байна.⁹

Шашны фундаментализм гэдэг нэр томъёог анх АНУ-д XIX зууны II хагаст евангелийн сүмийн ортодокс төлөөлөгчид, ялангуяа кальвинистууд, пресвитерианчууд, баптистуудын хөдөлгөөн, үйл ажиллагаатай холбоотойгоор гаргаж хэрэглэсэн түүхтэй. Эрдэмтэд үүнээс хойш эл үзэгдлийг бусад олон янзын шашинтай холбон авч үзэж судалжээ. Орчин үеийн шашны фундаментализмын гол шинж бол шашны тулгуур үзэл санаа, эрхэмлэл, үнэт зүйлийг туйлшруулж орчин үеийн амьдрал, шашин шүтлэгийн хэмжүүр, үлгэр жишээ хэмээн үзэх, тухайн шашны үүсэл хөгжлийн аль нэг түүхэн тодорхой үеийг “алтан үе” гэж үзээд түүнд эргэж орохыг сурталчлах, тухайн шашны гол сударт мөнхийн үнэн, шударга ёс, зөв зам мөр, ирээдүйн бүх зүйл бичигдсэн мэтээр үзэх итгэл үнэмшил, түүнийг бусдад сурталчлах, тулгаж хүлээлгэх оролдлого, үйл ажиллагаа, шашны хөдөлгөөн, тэмцэл хэмээн үзэж байгаа юм. Шашны фундаментализмын субъект нь фанатик сүсэгтэн бүхий бие хүн, нийгмийн хэсэг бүлэг, нийгэм-улс төрийн аль нэг хүч, нийгэмлэг, фронт байж болдгийг орчин үеийн амьдрал харуулж байна. Шашны фундаментализм нь зөвхөн үзэл санаа, итгэл үнэмшил байх төдийгүй түүнийг шашин-улс төрийн аль нэг тодорхой хүч нийгэмд тулгах, амьдралд хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа, тэр тусмаа зэвсэг, засаг төрийн хүч албадлагад тулгуурласан зохион байгуулалттай хөдөлгөөн, улс төрийн бодлого болж хувирдагт түүний боломжит ба бодит аюул оршино.

Шашны фундаментализмын ийм ерөнхий шинж исламын фундаментализмд ч нэгэн адил бий. Орчин үед ислам шашны нэртэй холбогдож, эл шашны доторхи аль нэг урсгал чиглэл, хөдөлгөөн тэмцлийн хэлбэрээр гарч буй хүчирхийлэл, аллага, бусад экстремист үйл ажиллагаа исламын фундаментализмтай ямар нэг байдлаар холбоотой байдгийг үгүйсгэх аргагүй. Нөгөө талаар ислам шашинтай нэр холбогдож, мусульманчууд үйлдсэн хэмээн үзэж мэдээлсэн, зарласан хүчирхийлэл, аллага, бусад түгшүүртэй үйлдэл бүхний гэм буруутан нь ислам шашин гэж үзэх ч аргагүй. Гарч буй хүчирхийлэл, аллага, сөргөлдөөн, тэмцлийг тодорхой авч үзэж судлах, тэдгээр нь үнэхээр шашны зорилго, сэдэл шалтгаантай, субъект нь шашны байгууллага байна уу эсвэл шашны нэрийг барьсан, шашныг халхавч, бамбай болгосон улс төр, цэрэг, бизнес, алан хядагч хүч, бүлэглэлүүдийн бодлого, үйл ажиллагааны илрэл байна уу гэдгийг судалж ялган салгаж тогтоох хэрэгтэй.

Орчин үед дэлхийн ихэнх оронд төр ба сүм хийд, шашин ба улс төрийн бодлогыг хооронд нь хуулиар тусгаарлан салгасан байгаа билээ. Гэтэл бодит амьдрал дээр тэдгээр нь хоорондоо нягт холбоотой, бие биеэ тус бүрийнхээ зорилгодоо хэрэгсэл болгон ашиглах, төр, улс төрийн бодлого “шашинжих”, шашин, сүм хийд нь “улс төржих” хандлага буурахгүй, харин ч зарим талаар өсөж, арга хэлбэр, харилцан нөлөөлөл нь нарийсаж байна. Үүний дагуу улс төрийн янз бүрийн үйл явдал, тэмцэл, зөрчил нь шашны хэлбэр, өнгө аястайгаар, харин шашны үйл хэрэг, зорилго, хөдөлгөөн нь улс төрийн шинж чанартай болж илэрч хэрэгжих явдал цөөнгүй болжээ.

⁹ Кудряшова И. В. Фундаментализм в пространстве современного мира. – Политические исследования. – 2002, №1.

Энэхүү нийтлэг байдал нь төр, улс төрийн бодлого ба шашин, сүм хийд хоорондоо угаасаа нягт холбоотой, бие биедээ ихээхэн нөлөөтэй явж ирсэн ислам шашинд улам тод, хурцаар илэрч байгаа юм. Исламын түүхэнд эл шашны дотор цэвэр шашны ба шашин-улс төрийн янз бүрийн урсгал чиглэл, бүлэглэлүүд чөлөөтэй гарч ирж үйл ажиллагаа явуулж байсан ба энэ нь орчин үед ч хэвээр байна. Орчин үед ислам шашинтай орнуудад засгийн эрхийн төлөө ба зах зээл, бизнес, нийгэм дэх аль нэг нөлөө ноёрхлын төлөө тэмцэл, угсаатан хоорондын сөргөлдөөн, салан тусгаарлах, өөрийн бие даасан улсыг байгуулах, гадаадын, ялангуяа АНУ, барууны бусад орнуудын зарим таатай бус бодлого, нөлөө, эрх ашгийн түрэлт шахалтыг эсэргүүцэх, улс орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдал, хөгжлийн үндэсний зам, загварыг сонгох, түүнийгээ хамгаалж замнах зэрэг нийгэм-эдийн засаг, цэрэг-улс төр, олон улсын харилцааны янз бүрийн үйл явдал, зорилтууд нь ислам шашны асар их нөлөө, нэр хүндийг ашиглах үүднээс эл шашны үзэл санаа, уриа лоозон, хөдөлгөөн тэмцлийн хэлбэрээр илэрч хэрэгжиж байгаа юм.

ҮІ

Ислам бол хүн хэмээх ээдрээ зөрчилтэй, уг шинж нь тодорхойгүй амьтныг хүн болгох, элдэв нүгэл, гэм буруу, бузраас хол, ангид байлгах, буяны зөв зүйтэй цагаан зам мөрөөр замнуулахыг эрхэмлэж гол болгосон дэлхийн хүнлэг, нэр хүндтэй, хүч нөлөөтэй шашнуудын нэг мөн. Тиймээс жинхэнэ, сонгодог ислам шашин нэг өөр, түүний нэрийн дор үнэн дүр төрхөө нуун далдалж, түүнийг ашиглаж, түүнд тэрсэлсэн гэм нүгэл, хүчирхийлэл, аллага, халдлага, дайн самуун дэгдээж үйлдэгчид нэг өөр юм. Өөрийгөө "аллахын үнэнч боол, аллахын эрэлхэг дайчин, жинхэнэ мусльман" хэмээдэг зартай илүүн хядагч Осама Бен Ладен, түүний дайчид (харамсалтай нь Осама Бен Ладен нь хүмүүний эрх, эрх чөлөө, шударга ёс, энх тайван, сайн сайхан бүхний өлгий нутаг, өмөг түшиг болсон АНУ-ын тусгай албаны оролцоотойгоор хүчирхийлэл, аллага, үймээн самуун дэгдээж үйлдэх аргад суралцаж гаршсан ажээ), Афганистанд исламын төр улс, жаргалын нийгэм байгуулна хэмээн зарлаж, хэрэг дээрээ энэ орныг нурсан дээр нь улам сүйрүүлж, хүүхэд, эмэгтэйчүүд, хөгшид, энгийн номхон хүн ардыг хүчирхийлж, үй олноор нь алж хядсан, мусульманчуудаас "газрын хөрснөөс арчигдаасай" гэсэн хараал зүхэл сонсож тэдний эсэргүүцэл тэмцэлтэй тулгарсан талибууд, ОХУ-ын бүрэлдэхүүнээс салж тусгаар улс болох нэрээр хэрэг дээрээ ваххабизмын балар бүдүүлэг, бурангуй ёс журам, дэглэмийг тогтоох зорилготой, орос болон бусад үндэстэн, угсаатан, өөр шашинтныг Чеченээс айлган сүрдүүлж хөөж гаргах зорилгоор бараг гэмт хэрэг хийгээгүй, ёс журам алдсан төдий эр эм хоёрыг шариат хуулийн нэр барьж олны нүдэнд буудаж хороосон (1997 он), үй олон хүнийг барьцаалж, тамлан зовоож, алж хядсан чечений зэрлэг догшин дайчид, тэднийг өөгшүүлсэн бохир улс төрчид зэрэг ислам шашны нэр барьсан хэрцгийчүүд олон байгааг нэрлэж баршгүй.

Зөвхөн шашин шүтлэг, итгэл үнэмшил, үзэл бодлын хувьд фундаменталист байх явдал нэг оор, харин тийм үзэл бодлыг бусдад тулган хүлээлгэх, үүний тулд хүч хэрэглэх, илүүн хядах, олон түмнийг түгшээх нь шал өөр юм. Америкийн нэрт улс төр судлаач, барууны үзэлтэй З. Бзежински "Исламын фундаментализм" гэдэг нь оновчтой бус төдийгүй хорлонтой тодорхойлолт юм. Терроризмыг хүлээн зөвшөөрдөггүй исламын тулгуур үзэлтнүүд үй түмээрээ байна шүү дээ. Мусульманчуудаас үүдэлтэй терроризмыг дан ганц шашны фанатизмтай холбон ойлгож болохгүй. Энд бас улс төрийн шалтгаанаас үүдэлтэй үзэн ядах үзэл ихээхэн нөлөөтэй юм...Терроризмтай хийх дайныг исламтай хийх дайн болгож хувиргахгүй байх ёстой. Энэ бол хамгийн гол асуудал..."¹⁰ гэжээ.

Мусульманчууд христос шашинд, тэр тусмаа бурхны шашинд хэзээ ч дайн зарлаж байгаагүй. Мусульман л бол ямар угсаатан, үндэстэн, ямар улсын харъяат иргэн байх нь хамаагүй алж хядна гэсэн үзэл ойлголт нэлээд тархмал байдаг. Энэ бол зөөлөн

¹⁰ Бзежински З. Америкийн гадаад бодлогод өөрчлөлт оруулах цаг ирлээ. —"Үг" сонин. —2001 оны 9-р сар. №021.

хэлбэл дэндүү гэнэн, хатуухан хэлбэл тэнэг л үзэл ойлголт. 2001 оны 9-р сарын 11-ний үйл явдлын дараа манай монголын зарим хэвлэл мэдээлэл, мэдлэг боловсрол нимгэн зарим сэтгүүлч Монгол дахь мусульманчууд бүхий казахууд Монгол Улсын аюулгүй байдалд хохирол учруулж алан хядах үйлдэл, үймээн самуун дэгдээхгүй байгаа даа” гэсэн асуудал дэвшүүлэн тавьж түүнд нь монголын дипломат ажилтнуудын дотроос араб хэл, соёл, ислам шашнаар сайн боловсрол олж бэлтгэгдсэн туршлагатай дипломатч Кадырын Сайран “Манай казахууд хэзээ ч тийм юм хийхгүй гэдэгт би зуун хувь итгэдэг. Яг өнөөдөр болоод ойрын ирээдүйд исламын талаас юм уу Монголд байгаа мусульманчуудын зүгээс улсынхаа аюулгүй байдал, эрх ашигт харшилсан ямар нэг үйлдэл гаргахгүй гэдгийг би батлан хэлж чадна” гэж өөрийн эргүй тангараг тавьж батлан даалт гаргахад хүрчээ.¹¹

Ийм асуулт тавих нь нэг талаас сэтгүүлчдийн сониуч зан, бас ч гэж бодож болгоомжлох зүйл болохыг ойлгож болох юм. Нөгөө талаас Монгол Улсаас ч гэсэн “исламын” нэртэй алан хядагчдыг, фундаменталистуудыг олж илрүүлэх, тэгснээрээ АНУ, барууныхны өмнө гавъяа байгуулж баатар болох, тийм арга замаар улс төрийн дэмжлэг олох, унаж гүйцсэн нэр хүндээ дээшлүүлэхийг санаархсан улс төрийн тодорхой бүлэг байгааг ч үгүйсгэх аргагүй.

Өнөөдөр дэлхийн олон оронд байгаа “исламын фундаменталистууд”, “исламын алан хядагчид” гэгдэж буй бодит тодорхой хүчнүүд, бүлгүүд бол ЗХУ ба АНУ тэргүүтэй хоёр систем хоорондоо сөргөлдөж “хүйтэн дайн” нүүрлэж байх үед нэг талаас Алжир, Турк, Иордан, Египет, Израиль зэрэг олон орон тийм тулгуур үзэлтэн, алан хядагчдыг өөгшүүлэн дэмжиж, бэлтгэж ЗХУ-ын ба социализмын нөлөөний эсрэг цохилтын хүч, хаалт хамгаалалт болгож ашиглаж байсныг, нөгөө талаар түүнийг АНУ тэргүүтэй барууны орнууд шууд дэмжиж санхүүжүүлж, бэлтгэж байсныг эрдэмтэд нэгэнт судлан тогтоож нотолжээ[9]. Одоо тэрхүү фундаменталист, алан хядах хүчнийхний хорлон сүйтгэх үйл ажиллагаа тэдний өөрсдийнх нь эсрэг чиглэгдэж, тэд нэг орны хүрээнээс халин гарч олон улсын хүч болж хувирчээ.

Үзэл санаа, сэтгэл зүй, зохион байгуулалт, алан хядах, хорлон сүйтгэх арга техникийн хувьд олон жил бэлтгэгдсэн фанатик террористууд ислам шашныг ариун тунгалаг байлгах, хөгжүүлж дэвжүүлэхийг огтхон чинээ бодохгүй байгаа бөгөөд тэдний үзэн ядалт, дайсагнал нь дээр дурьдсан тодорхой нөхцөл, шалтгаануудын дагуу өнөөдөр барууны нийгэм, нэн түрүүнд Америкийн эсрэг чиглэгдэж байгаа нь шашны уг сурвалж, шинж чанартай биш, чухамдаа улс төр, эдийн засаг, геополитикийн шинж чанартайг эрдэмтэд судлан нотолж хүлээн зөвшөөрч байна.¹²

Гэтэл өнөөгийн олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, улс төрчдийн зарим нь, жинхэнэ эрдэмтэн судлагч биш дилетантууд ислам шашин нь одоо гарч буй аллага, хүчирхийлэлд буруутай, эл шашин нь дайн, хүчирхийлэл, бурангуй ёс журам, эмэгтэйчүүдийг дарангуйлахыг зөвтгөж номлодог хатуу харгис шашин мэтээр дүрсэлж гүтгэсэн, гуйвуулж гутаасан, буруутгасан худал хуурмаг үг яриа дэлгэсээр, ислам шашны тухай үнэн тодорхой төсөөлөл, ойлголтгүй хүмүүсийн үнэмшил, сэтгэл зүй тэр дагуу бүрэлдэж төлөвшсөөр байгаа нь нэн харамсалтай.

Дэлхий дахиныг донсолгож түгшээсэн 2001 оны 9-р сарын 11-ний үйл явдал өмнөх үед хэвшиж тогтсон олон зүйлийг эргэн харж шинэ байдлаар үзэж ойлгох, олон зүйлд шинээр хандаж харилцахыг шаардав. Харин дэлхийн тэрбум гаруй энгийн номхон хөдөлмөрч хүн ардын шүтлэг бишрэл, ертөнцийг үзэл үзэл, аж төрөх ёс журам нь

¹¹ Сайран. К. Манай казах түмэн хэзээ ч тийм үйлдэл хийхгүй гэдэгт би итгэдэг (Исламын терроризм ХХ зууны улс төрийн бодлогын гай). –“Өдрийн сонин” сурвалжлагчид өгсөн ярилцлага. –“Өдрийн сонин”. –2001. 09. 26. №228. Сайран. К. Манай казахууд лалын шашны аядуу урсгалыг дагадаг тул улсдаа хэзээ ч хохирол учруулахгүй. –“Үг” сонины сурвалжлагчид өгсөн ярилцлага. –“Үг” сонин. –2001 оны 9-р сар. №021.

¹² Кудряшова И. В. Фундаментализм в пространстве современного мира. –Политические исследования. –2002, №1. С. 9.

болсон жинхэнэ, сонгодог “ногоон” ислам ба (ногоон өнгө нь исламын хувьд амьдрал, энх тайван, хөгжиж дэвшихийн бэлгэдэл юм) нөгөө талаас исламын нэр барьсан, орчин үеийн соёлт ертөнц, нийт хүн төрөлхтнийг өөртөө турхирч халз тулалдаанд дуудсан алан хядагчид, балмад хэрцгийчүүд, тэднийг ашиглаж өөгшүүлэн дэмжсэн бохир улс төрчид нь хоорондоо эрс тэс ялгаатай, өөр өөр зүйл болох тухай ислам судлагч эрдэмтэд, үнэнч шударга, жинтэй том улс төрчид, буян, үнэнийг эрхэмлэсэн шашны зүтгэлтэн хуврагууд ба эрүүл саруулаар бодож сэтгэгч үй түмэн шударга хүн ардын үзэл бодол, ойлголт үнэн зөв болох нь улам нотлогдож байгааг эл өгүүллийн төгсгөл болгож тэмдэглэе.

ИШ ТАТСАН НОМ БҮТЭЭЛ

1. Бзежински З. Америкийн гадаад бодлогод өөрчлөлт оруулах цаг ирлээ. – “Үг” сонин. – 2001 оны 9-р сар. №021.
2. Васильев Л. С. История религий Востока. 3-е изд., М., 1998.
3. Гегель Г.В. Ф. Лекции по философии истории. Перевод А. М. Водена. Санкт-Петербург, 2000.
4. Ислам. Энциклопедический словарь. М., 1991.
5. Коран. Перевод с арабского языка акад. И. Ю. Крачковского. М., 1990.
6. Кудряшова И. В. Фундаментализм в пространстве современного мира. – Политические исследования. – 2002, №1.
7. Куран Карим. (Казахша магына жане тусиниги). Медине, 1991. (Коран. Казахчилсан утга ба тайлбар. Араб хэлнээс орчуулсан Халифа Алтай, Медина хот)
8. Максуд Р. Ислам. Перевод с англ. В. Новикова. М., 2001.
9. Мирский Г.И. “Политический ислам” и западное общество. – Политические исследования. – 2002, №1.
10. Основы религиоведения. Под ред. И. Н. Яблокова. 2-е изд., М., 1998.
11. Сайран. К. Манай казах түмэн хэзээ ч тийм үйлдэл хийхгүй гэдэгт би итгэдэг (Исламын терроризм ХХ зууны улс төрийн бодлогын гай). – “Өдрийн сонины” сурвалжлагчид өгсөн ярилцлага. – “Өдрийн сонин”. – 2001. 09. 26. №228.
12. Сайран. К. Манай казахууд лалын шашны аядуу урсгалыг дагадаг тул улсдаа хэзээ ч хохирол учруулахгүй. – “Үг” сонины сурвалжлагчид өгсөн ярилцлага. – “Үг” сонин. – 2001 оны 9-р сар. №021.
13. Фадеева И. Демократия в мусульманском мире: реальность и перспективы. – Азия и Африка сегодня. – 2001, №8.

Д.Цолмон. Доктор (PhD), профессор

А.Амарсанаа. Магистр

Олон улсын харилцааны онолын сургууль, шинэ чиг хандлага

Хүйтэн дайны төгсгөл, ЗХУ, социалист системийн задрал, Югославын сарнин бутрал зэрэг нь гэнэтийн бөгөөд санамсаргүй үйл явдал болсон мэт боловч түүний уг сурвалж нь эдийн засаг, улс төр, үзэл суртал, үндэсний онцлог, ашиг сонирхолтой холбоотой эрт орой нэгэн цагт дэлбэрэн гарч ирэх магадлалтай байсны нотолгоо мөн. Томоохон стратегич, өрнөдийн зарим онолчид коммунизм явуургүй гэдгийг сануулсаар л байсан. Эдгээр үйл явдлын цаг хугацааг урьдчилан тааж эс чадсан олон улсын харилцааны онолын үндсэн сургуулиудад эрдэмтэн, судлаачид эрс шүүмжлэлтэй хандах болж онолын суурь судалгаа, үндсэн ойлголтууд, аргазүй, онтолог, эпистемологи зэргийг эргэн харах ёстой гэсэн хандлага түгээмэлжив. Ийнхүү хүйтэн дайн төгссөнөөр олон улсын харилцааны онолыг үндсээр нь шинэчлэн өөрчлөх дохио өгсөн юм.¹ Үүний зэрэгцээ, хамгийн нэр төртэй томоохон онолын сургууль болох реализмын талаарх эрдэмтэн судлаачдын хурц маргаан, мэтгэлцээн өрнөх тутам хүйтэн дайны үед үл тоомсорлогдож байсан, уламжлалт биш онол, сургуулиуд харин хүчтэй хөгжих болов. Энэ нь геополитикийн үзэл баримтлалыг ч нэгэн адил хөндөх болов.

“Шинжлэх ухааны түүхээс харахад, аливаа онол ирээдүйд няцаагдах магадлалтай,” гэж Карл Поппер тэмдэглэсэн агаад ОУХ-ны судлалд ч гэсэн онолууд хоорондоо “ноёлохын” төлөө эцэс төгсгөлгүй тэмцэлдэн мэтгэлцдэг байна. Ямар ч болов, уламжлалт хуучин арга барил ач холбогдлоо алдаж онолын шинэ нэгдэл, шилжилт, хөдөлгөөн, “их зөвшилцөл” өнөөдөр ажиглагдаж байна. Шинэ синтезийн хамгийн сүүлийн үеийн тод жишээ бол конструктив онол болно.

Онолын хөгжлийн сүүлийн үеийн нөхцөл байдал ямар байна вэ, ирээдүйд цаашдаа яаж хөгжиж олон улсын харилцаа, дэлхий нийт хүн төрөлхтөнд ямар хувь нэмэр оруулж чадах вэ гэдэг нь нарийн судалгаа шаардсан олон улсын харилцааны судлалын орчин үеийн тулгамдсан асуудлуудын нэг болж байгаа юм. Эндээс үүдэн, энэхүү өгүүлэлд олон улсын харилцааны онолын сүүлийн үеийн байдал, цаашдын чиг хандлагыг олон улсын харилцаан дахь Англи, Америкийн эрдэмтэдийн байр суурь, онолын түүхэн хөгжлийн онцлогтой холбон тайлбарлах, үүнд бусад орны эрдэмтэн судлаачид яаж ханддагийг зарим нэг баримтаар харуулах оролдлого хийв. Олон улсын харилцааны судлалын онцлог. Өнөөг хүртэл эрдэмтэд олон улсын харилцааны судлал гэж яг юу болохын талаар нэгдсэн ойлголтонд хүрэлгүй явж ирсэн бөгөөд улс орон бүр өөр, өөрийн өвөрмөц онцлогийн үүднээс олон улсын харилцааг үзэх хандлага түгээмэл байдаг. Өөрөөр хэлбэл, олон улсын харилцааны судлалын нэг чухал өвөрмөц тал нь субъектив хүчин зүйлээр тайлбарлагдаж ирэв. Англи, Америкийн эрдэмтэдийн “ноёлох” байр суурьтай судлал өөрөө энэ асуудал дээр санал хуваагдан өргөн ба явцуу утгаар олон улсын харилцааг дараах байдлаар тайлбарладаг байна.

XX зууны сүүл, XXI зууны эхээр олон улсын харилцаа нь нийт хүн төрөлхтөнд хамаатай түгээмэл, асуудлуудыг өргөн хүрээнд авч үздэг “олон судлагдахуунт” нийгмийн ухааны томоохон салбар болон өргөжиж, социологи, антропологи, эдийн засаг, газарзүй, улс төр судлал, сэтгэл судлал, гүн ухаан, түүх судлал, байгалийн шинжлэх ухаантай уялдаа, холбоотой болсон гэдэг өргөн утгаар Английн судлаачид нотолдог. Зарим нь олон улсын харилцааг бүр “шинжлэх ухааны салбар хоорондын судлал” (interdiscipline) хэмээн тайлбарладаг байна.

Их Британы Уэльсийн их сургуулийн профессор Стив Смит Англи,

¹ Gaddis 1993, 10.

Америкийн эрдэмтдийн судалгаа хоорондоо хэрхэн ялгаатай, зөрүүтэйг тодорхой харьцуулалтаар нотлох оролдлого хийсэн байх юм (хүснэгт 1-ийг үз). Их Британы судлаачид АНУ-ыг бодвол илүү “эрүүл саруул”, бодитой, ач холбогдолтой судалгааг явуулдаг гэсэн дүгнэлтийг хийжээ.²

Хүснэгт 1. Америк ба Английн судалгааны харьцуулалт

	Америкийн эрдэмтэд	Английн эрдэмтэд
ОУХ ба шинжлэх ухааны бусад салбар	Улс төрийн шинжлэх ухаантай холбож үздэг	ОУХ-г нийгмийн бараг бүх салбаруудтай холбон тайлбарлаж, “шинжлэх ухааны салбар хоорондын судлал” (interdiscipline) гэж үздэг
Дэлхийн ОУХ-ны судлал	Америкийн “дэлхийн” судлалд бусдыг хамруулан нэгтгэх хийгээд С.Хоффманы “ОУХ бол Америкийн нийгмийн ухаан” гэдэг үгийг хүчинтэй хэвээр хадгалах оролдлого хийдэг	Америкийн судлалаас тусдаа бие даасан ОУХ-ны судлалыг хөгжүүлэхийн хамт Европын эрдэмтэдтэй ойр, дотно байхыг эрмэлздэг
Онолын хөгжил, чиг хандлага	Зохистой ба зохисгүй, шинжлэх ухаанч ба шинжлэх ухаанч бус онол байдаг хэмээн пост-позитивизм, рефлексивизмыг “ялгаварлан гадуурхадаг” бөгөөд нэг эсвэл хоёр урсгал, чиглэлийн давамгайллыг л хүлээн зөвшөөрдөг	Онолын сургуулиудын аль нэгийг нь онцгойлон үзэхгүйгээр олон ургальч үзлийг хөхиүлэн дэмжиж онолуудын жигд, тэнцвэртэй хөгжлийн чиг хандлагыг хүлээн зөвшөөрч онолын сургуулиудын “ардчилалыг” тогтоохын төлөө байдаг
Эпистемологи, аргазүй	Бихейворизм, позитивизм их нөлөөтэй	Пост-позитив хандлага түгээмэл

Түүнчлэн Стив Смит-ийн үзэл бодлыг хуваалцдаг эрдэмтдийн нэг Роберт Кроуфорд (Robert Crawford) Америк, Английн олон улсын харилцааны судлалууд хоорондоо тэс өөр юм гэсэн байдаг.³ Цаашилбал, Английн томоохон эрдэмтэд, тухайлбал, Барри Бузан, Ричард Литтл нар “Англи Сургууль”⁴ хэмээх олон улсын харилцааг судлах тусгай бүтэц, зорилтот хөтөлбөрөөр олон улсын харилцааг Америк биш арга, замаар хөгжүүлэх оролдлого хийж эхэлсэн юм. Үүний эхлэлийг 1950-аад оны сүүлээр үүсгэн байгуулагдсан Олон Улсын Улстөрийн Онолын Британы Хороо тавьсан гэж үзэж болох юм.

Анх 1977 онд Стэнли Хоффман олон улсын харилцааг Америкийн ба бусад орнуудын эрдэмтдийн судалгаа хэмээн хуваан ангилж үзжээ. Түүний “Америкийн Нийгмийн Ухаан: Олон Улсын Харилцаа” гэдэг өгүүлэлд⁵ Америкийн эрдэмтдийн давамгайлах байр суурийг тодорхойлж олон улсын харилцааг “Америкийн нийгмийн ухаан” хэмээн овоглосон юм. Зарим эрдэмтдийн нотолж буйгаар энэ байдал өнөөг хүртэл хадгалагдсаар байгаа болно. К.Холсти, О.Уивэр¹ нар олон улсын харилцааны онолын сэтгүүлүүдэд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэлүүдийг задлан шинжилж үзэхэд нийт өгүүлэл бичигч эрдэмтэн нарын дийлэнх нь Америкийн судлаачид болохыг тогтоосон байна.

Бид дээр Англи, Америкийн эрдэмтдийн судалгааны онцлог, ялгаатай талыг авч үзлээ. Тэгвэл бусад орны эрдэмтэдэд Америкийн давамгайллыг эсэргүүцсэн хандлага түгээмэл ажиглагддаг. Тухайлбал, Францын эрдэмтэд олон улсын харилцааны судлалын “зах хязгаар” болохыг үл хүсэн, бие даасан тусдаа судалгаа явуулдаг гэж Франц судлаач А. Ж. Грүүм үзэж байхад “Францийн сургууль” буюу “Олон улсын

² Smith 2000, 396-399.

³ Crawford & Jarvis 2001, 239.

⁴ Hoffmann, S. 1977: “An American Social Science: International Relations,” *Daedalus*, vol. 106, no. 3, pp. 41-60, reprinted in *Janus and Minerva. Essays in International Theory and Practice*.

⁵ Waever, Ole, 1998, ‘The sociology of a not so international discipline: American and European developments in international relations.’ *International Organization* 52: 687-727, Holsti, Kalevi, 1985, *The Dividing Discipline: Hegemony and Diversity in International Theory*. London: Allen & Unwin.

харилцааны социологи” (францын нийгэм судлалын сургууль) гэсэн судалгаа хөгжиж буй тухай Оросын судлаач Цыганков өөрийн “Олон улсын харилцаа” хэмээх номондоо өгүүлсэн байна. Ийнхүү олон улсын харилцааны судлал субъектив хүчин зүйлээр хуваагдан задарснаар, олон үндэстэн, соёл иргэншлийн практик, онцлогт тулгуурласан олон ишт, элдэв янзын үзэл, санаа оноо хуримтлагдаж олон улсын харилцааны талаарх “тэнцвэржсэн” мэдлэг бүрэлдэх таатай хөрс суурь буй болж байгаа бөгөөд орчин үеийн онолын чиг хандлагыг тодорхойлоход үүнийг харгалзан үзэх онцгой чухал баримжаа болж өгч байгаа юм.

Олон улсын харилцааны онолын түүхэн хөгжлийн онцлог. Онолын түүхэн хөгжлийн асуудлыг авч үзэх нь орчин үеийн онолын чиг хандлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Учир нь олон улсын харилцааны судлал, онолын үүсэл гарал, түүхийг эхнээс нь явцуурхан, ерөөсгөл байр суурьнаас зохион бичснээс болж зарим онол, сургууль олон улсын харилцаанд ач холбогдолгүй болж “ялгаварлан гадуурхагдах” эрсдэлд ордог тухай Стив Смит анхааруулсан байна.⁷

Олон улсын харилцааны судлал, онолын үүслийн түүхийг ерөнхийдөө явцуу ба өргөн гэсэн хоёр хэсэгт хувааж үзвэл; нэгдүгээрт, он дарааллаар (chronology) зонхилж байсан байдлаар, дэлхийн нэгдүгээр дайны дараа идеализм, дэлхийн хоёрдугаар дайнаас хойш реализм тус тус давамагайлж байгаад, онолын олон чиг, хандлага үүсэн бүрэлдсэний эцэст 1980-аад оны үед нео-либерализм, нео-реализмын маргаан, мэтгэлцээн ид өрнөсөн. Харин 1990-ээд он гэхэд уг мэтгэлцээн намжиж хоёр нео-онол зөвшилцөн эвлэрэх хандлагатай болсон гэдэг. Олэ Уивэр 1990-д оны зөвшилцлийг “нео-нео синтез”⁸ хэмээн томъёолжээ.

Хоёрдугаарт, онолын түүхэн хөгжлийг хойно хойноосоо цуварсан “их мэтгэлцээний” үүднээс тайлбарладаг (Maghroori and Ramberg 1982; Ole Waever 1996). Ийнхүү түүхэн хугацаагаар нь дараалан жагсаавал, 1930-д онуудад “нэгдүгээр мэтгэлцээн” (реализм ба идеализм), 1960-аад онуудад “хоёрдугаар мэтгэлцээн” (уламжлалт ба бихейворист арга), 1980-аад онуудад “гуравдугаар мэтгэлцээн” (реализм, либерализм, марксизм) буюу парадигм хоорондын (Waever, 1996; Viotti and Kauppi, 1993), 1990-ээд оноос өнөөг хүртэл “дөрөвдүгээр мэтгэлцээн” рационализм (Уиверийнхээр бол “нео-нео нийлэл”) ба рефлексивизмын (Lapid, 1989) хооронд явагдсаар иржээ.

ХҮСНЭГТ 2. ДӨРВӨН МЭТГЭЛЦЭЭНИЙГ ХАРЬЦУУЛЖ ҮЗЭХ НЬ

	Улс төр	Философи	Эпистемологи (танин мэдэхүй)	Онтолог (ОУХ-ны ахуй)	Арга зүй
Нэгдүгээр мэтгэлцээн	XXX	XX		X	
Хоёрдугаар мэтгэлцээн			XX	X	XXX
Гуравдугаар Мэтгэлцээн	XX			XXX	X
Дөрөвдүгээр мэтгэлцээн		XXX	XX	X	

Жич: XXX= мэтгэлцээний гол сэдэв, XX= хоёрдугаар зэргийн сэдэв, г.м.
(source: Ole Waever 1996, p.157)

Орчин үеийн онолын чиг хандлага: Онолын хөгжлийн түүхэнд реализм давамгайлагч байр суурьтай ирсэн бөгөөд эрдэмтэн судлаачид, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт хамгийн их нөлөөлдөг онол юм. АНУ, Английн нэртэй улс төрчид, төр засгийн тэргүүн асан Черчилль, Трумэн, Рейган нарын гадаад

⁷ Smith 2000, 376-379.

⁸ Waever, 1996, pp.163-164

бодлогын номлол эл онолд голлон тулгуурлаж байв. Өнөөдөр ч гэсэн реализмын энэхүү зонхилох байр суурийг үгүйсгэхэд бэрх байна. Гэхдээ, С.Смит (2000), Р.Кэохэйн (1989), О.Уивэр (1996) нар бидний дээр авч үзсэн Англи, Америкийн ноёлол, Олон улсын харилцааны судлал, онолын түүхэн хөгжлийн онцлогийг харгалзан үзсэний үндсэн дээр орчин үеийн онолын сургуулиуд дараах хоёр үндсэн бүлэг, ангид хуваагдан онолын маргаан, мэтгэлцээн өрнүүлж байна хэмээн дүгнэжээ: (1) неореализм, неолиберализмыг өөртөө багтаасан рационализм буюу Уиверийн тодорхойлсноор “нео-нео синтез”; (2) рационализмтай сөргөн мэтгэлцсэн рефлексивизм. Түүнчлэн, сүүлийн үед дээрх хоёр анги, бүлэгт конструктивизм гэдэг онол нэмэгдэж байгаа юм.

Рационализм. Рационализм бол угтаа Америкийн ОУХ-ны онолын судалгааны гол шинж, чанар болдог бөгөөд АНУ-д хамгийн их өргөн хүрээтэй судлагддаг байна. Стив Смит-ийн үзсэнээр Америкийн судалгаа угаасаа эмпирик судалгааны материалд тулгуурласан танин мэдэхүй, позитивист аргазүйг өргөн ашигладаг учир онтологийн хувьд “рационалист” юм гэжээ.

Рационализм гэдэг нь, “rational” буюу “оновчтой, тооцоотой, зүй зохистой” гэдэг утгатай үгнээс гаралтай бөгөөд олон улсын харилцаа оновчтой, тооцоотой үйл байдалд суурилагдана гэж үздэг. Рационализмыг бүтцийн хувьд авч үзвэл, неореализм, неолиберализмыг өөртөө агуулдаг тухай бид дээр цухас хөндсөн билээ. 1980-д оны турш неореализм, неолиберализм хоёр хоорондоо ширүүн маргаж байсан ч гэсэн эдүүгээ харилцан буулт, зөвшилцөлд хүрч чадсны гол учир нь хоёр онол нэг л танин мэдэхүйн аргаар олон улсын харилцааны ахуй, мөн чанарыг (онтологийг) ухааран хүлээж авдаг байна.

Энэ онолын зөвшилцөл, синтезийг эрдэмтэн судлаачдын ихэнх нь түүхэн том үйл явдал хэмээн нааштайгаар хүлээн авсан юм. Давид Болдвин неореализм, неолиберализм тус, тусдаа байснаас хоёул хамт судлагдвал олон улсын ахилцааны онолын хөгжилд ихээхэн ач холбогдолтой гэж тэмдэглэсэн байдаг.⁹

Гэсэн хэдий ч, олон улсын байгууллага, хамтын ажиллагаа ба анархи шинжтэй харилцаа, оролцогчийн ашиг сонирхол харьцангуй юу, туйлын шинжтэй юу гэдэг дээр хоёр нео-онол одоог хүртэл санал нэгдээгүй байна.

Рефлексивизм. 1988 онд АНУ-ын Олон Улс Судлалын Холбооны (ISA) ерөнхийлөгч байсан Роберт Кэохэйн¹⁰ “рационализм” ба “рефлексивизм” гэсэн хоёр урсгалын мэтгэлцээн олон улсын харилцааны онолын орчин үеийг тодорхойлж байна гэж эрдэм шинжилгээний илтгэлдээ тэмдэглэн тэдгээрийн олон улсын байгууллага, хамтын ажиллагааны судлал дахь хувь нэмэр, ач холбогдлыг өндөрөөр үнэлсэн юм. Тэр үед Кэохэйны дүгнэснээр рефлексивизм нь “өрсөлдөгчөө” бодвол шинжлэх ухааны үүднээс, судалгааны хувьд бүрэн боловсрогдож хараахан “амжаагүй” байв. Гэтэл өнөөдөр “рефлексивизм” ОУХ-ны судлалд тодорхой байр суурь эзэлсэн орчин үеийн томоохон урсгал болж чадсан байна. Ялангуяа, Европын орнуудын эрдэмтэд рефлексивизм, пост-позитивизмд ихээхэн анхаарал хандуулан өргөн судалгаа явуулдаг юм.

Бүтцийн хувьд авч үзвэл, рефлексивизм нь С.Смитийн тодорхойлсноор “бүрэлдүүний онол” (constitutive theory) болж байгаа юм. Өөрөөр хэлбэл, рефлексивизм нь рационализмыг сөрж, марган мэтгэлцсэн олон онолын “элементүүдийг” өөртөө хамруулсан онолын “цуглуулга” болж байгаа юм. Шүүмжлэлийн онол, пост-модернизм, феминизм, түүхэн социологи, норматив онол зэргийг рефлексивизмын хүрээнд багтаан үздэг боловч, эдгээр нь хоорондоо тун адилгүй, зарим тохиолдолд тэс ондоо, бие биентэйгээ сөргөлдсөн үзэл онол байдаг ажээ. Хэдий тийм боловч, рационализмыг

⁹ Smith 2000, 382.

¹⁰ АНУ-ын эрдэмтэн Р.Кэохэйн бол “цогцолбор харилцан хамаарлын” онолын үндэслэгч бөгөөд неолиберализмын хамгийн том төлөөлөгч юм.

сөрсөн, эсэргүүцсэн байр суурь тэднийг нэгтгэн нэгэн хүрээнд авч үзэж олон улсын харилцааны судлалын орчин үеийн байдлыг тайлбарлахад дөхөмтэй болж ирж байгаа юм.

Рационализм, рефлексивизм хоёр хоорондоо ямар асуудлаар маргадагийг Олэ Уивэрийн тодорхойлсон "дөрвөн мэтгэлцээний" (хүснэгт 2-ыг үз) үүднээс авч үзвэл бидэнд дөхөмтэй болно. Эдгээр хоёр урсгал, чиглэл философи, танин мэдэхүй, онтолог г.м. асуудлуудаар буурах дарааллаар санал зөрөлдөж байна. Рационализм, рефлексивизм хоёр нь философийн үүднээс нэг нь позитив, нөгөө нь пост-позитив гэсэн зөрөөтэй байр суурьтай учир хооронд нь харьцуулан үзэж, мэтгэлцээний хоёр тал болгох үндэслэл байхгүй хэмээн үздэг эрдэмтэд ч байдаг. Үүнээс гадна, эпистемологийн үүднээс рационалистууд рефлексивизмд хамаарах онолуудыг "шинжлэх ухаанч бус", "зохисгүй", "хууль бус" онол хэмээн шүүмжлэн буруушаадаг хандлага, ялангуяа АНУ-д элбэг тохиолддог байна.

Конструктивизм. Идеалчилсан объект, хэрэгтэй мэдлэг, шинэ зарчим ашиглах замаар онол боловсруулах "конструктив" арга шинжлэх ухааны судалгааны арга зүйд түгээмэл байдаг билээ. Тухайлбал, алдарт эрдэмтэн, физикч А.Эйнштейн харьцангуйн онолоо Ньютоны онол дээр түшиглэн "конструктив" аргыг ашигласан гэж үздэг. Конструктивизм нь "барьж байгуулах, цэгцлэх" хэмээх үгнээс гаралтай бөгөөд нөхөн сэлбэх замаар онолыг баяжуулан "шинэ байшин" барих арга ч гэж тодорхойлж болно. Конструктивизм нь онол уу, эсвэл арга уу гэдэг нь эрдэмтдийн хувьд нээлттэй асуудал хэвээр байгаа хэдий ч, Ж.Чэккел "...конструктивист эрдэмтэн судлаачдын хувьд гол асуудал нь бол онол боловсруулах асуудал юм,"¹¹ гэжээ.

Конструктивизм нь АНУ-д нилээн өргөн хүрээнд нарийн судлагдаж байна. АНУ-ын мэргэжлийн томоохон сэтгүүлүүдийн нэг болох *International Organization* сэтгүүлийн 50 жилийн ойн тусгай дугаарт Роберт Кэохэйн, Стивэн Кразнер, Питер Каценштайн нар ОУХ-ны судлалыг эргэн дүгнэж түүнд дорвитой үнэлэлт, дүгнэлт хийсэн байна (Katzenstein, Keohane, and Krasner, 1998). Эдгээр эрдэмтний үзсэнээр 1990-ээд оноос хойш рационализм, конструктивизмын хоорондын мэтгэлцээн ОУХ-ны онолын хөгжилд томоохон байр суурь эзэлсээр байгаа бөгөөд ойрын ирээдүйд энэ байдал хадгалагдан үлдэнэ гэжээ. Түүнчлэн Томас Рисс (2000) нийгмийн конструктивизм ба рационал сонголтын хоорондын маргаан ОУХ, харьцуулсан улстөр судлалын хамгийн сүүлийн үеийн гол мэтгэлцээн болж байна хэмээжээ.

Конструктивизм өнөөдрийн байдлаар үндсэн хоёр урсгал, хувилбараар хөгжиж байна. Нэг талаас, Жэффри Чэккел, Иммануэль Адлер, Александр Уэндт зэрэг эрдэмтэд конструктивизмыг рефлексивизмээс тусад нь авч үзэх оролдлого хийж байхад, нөгөө талаас Ник Онуф, Фридрих Кратчвилл нар рационализмын позитивист аргазүйгээс татгалзаж пост-позитивист хандлагатай ажээ. Конструктивизмын энэ урсгалыг рефлексивизмын хүрээнд хамааруулж болох юм. Үүний зэрэгцээ Александр Уэндтын боловсруулсан "нийгмийн конструктив" (social constructivism) онолоор рационализм, рефлексивизм хоёрыг холбосон "гүүр" болгох оролдлого хийж байна.

Энэхүү өгүүлэлд орчин үеийн ОУХ-ны онолын шинэ чиг хандлагыг тоймлон судлах оролдлого хийсний дүнд онолын хөгжлийн орчин үеийн дараах дүр зураг харагдаж байна. Нэг талд, тодорхой хэмжээнд зөвшилцөлд хүрсэн неореализм, неолиберализмыг багтаасан рационализм, нөгөө талд, түүнтэй мэтгэлцсэн, эрс ондоо онолын "цуглуулга" болох рефлексивизм, харин дунд нь хоёр тийшээ хандсан конструктивизм байна. Конструктивизм бол сүүлийн үеийн онолын харилцан огтлолцол, нийллэгийн хамгийн тод жишээ болж байна.

Харин олон улсын харилцааны судлалын орчин үеийн ерөнхий чиг хандлагыг авч үзвэл, дотроо санал хуваагдсан Англи, Америкийн эрдэмтдийн уг судлал дахь давамгайлах байр суурь, түүнийг нь эсэргүүцсэн Америк биш судлаачид гэж байна. Тухайлбал, Оросын олон улс судлалын гол төвүүд Москвагийн ОУХС, Дипломат

¹¹ Checkel 1998, p.325.

академийн эрдэмтэд нэгэн үе хаалттай, эсвэл байнга шүүмжилж ирсэн онолыг эдүгээ нэлээд эрчимтэй судлаж зохиол бүтээлдээ өргөн ашиглах болсон байна. Тэгэхдээ эдгээр үзэл номлолыг Оросын өөрийн байр суурь, стратеги сонирхолтой холбон онолын Оросын сургууль, Оросын геополитиктой уялдуулан тайлбарлаж байна. Энэ нь хуучин их гүрнийхээ байр суурийг сэргээх ангийн тэмцлийн тухай марксист сургаалиасаа татгалзаж реалист сургууль, геополитикт гол анхаарлаа чиглүүлж байгаагийн тод илрэл юм.

Түүнчлэн, томоохон онолууд нэгдэл, синтез үүсгэж, урьд нь үл тоомсорлогдож байсан онолууд анхаарал татах болсноор ОУХ-ны онолын судлал “ардчилагдаж” байна. Үүнийг тухайн салбар дахь томоохон хувьсал гэж үзэхээс өөр аргагүй юм.

Түүний хамт, олон улсын харилцааны судлал нь өөрөө “шинжлэх ухаанч” болох явц ажиглагдаж, “Америкийн олон улсын харилцааны судлалаас” илүү түвшинд хөгжсөн, илүү олон ургальч, илүү эрүүл, даяршилд илүү тэсч үлдэх тийм нийгмийн салбар хоорондын томоохон судлал болох явц ажиглагдаж байна.

Хэдийгээр АНУ-ын олон улсын харилцааны судлал позитивизмын “хүлээснээс суллагдаж” чадалгүй, дэлхийн олон улсын харилцааны судлалыг “Америкийн” болгох санаархал өнөөдрийг хүртэл бат бөх хэвээр байгаа ч гэсэн, онолын судалгаа улам гүнзгийрч, объектийн хамрах хүрээ тэлэн өргөжиж “мета-онолын” түвшний судалгаа эрчимжиж байна гэж С.Смит үзжээ.

Олон улсын харилцааны онолын хөгжлийн ирээдүйг зориглон төсөөлбөл, неореализм, неолиберализм зөвшилцөлд хүрсэн шиг конструктивизм нь рационализм, рефлексивизмын хоорондын санал зөрөөтэй асуудлыг шийдэж “эвлэрүүлж” болох юм. Тэгвэл онолын хөгжлийн түүхэн дэх агуу их синтез, нэгдэл, хувьсал өрнөж “цогцолбор” онол боловсоргдон бүрэлдэж болох юм. Харин энэхүү үйл явц өрнөхөд эрдэмтэдийн зүгээс хийгээд онолын судалгааны түвшинд хир зэрэг бэлтгэл хангагдсан бол?

Аль ч улс, ялангуяа, олон улсын харилцааны мэргэжилтэн бэлтгэдэг сургууль (МУИС, ОУХС), эрдэм шинжилгээний эл чиглэлийн төвүүдэд олон улсын харилцааны өнөөгийн чиг хандлагыг судлах шаардлагатай бөгөөд манайх шиг жижиг улсууд ийм судалгаа шаардлагагүй гэж үзэх хандлага байж болохгүй. Дэлхий дахины олон харилцааны онол, практик, геополитикийг мэдэж, мэдэрч баймааж нь харилцаанд идэвхтэй оролцох болно.